- Төмөр: Цэхэр, Өлзий-Овоо, Тамирын гол
- Зэс: Цахир толгой, Сангийн далай, Саран уул
- Молибден: Мандал, Салхитын ам, Зуун мод
- Гянтболд: Өлзийт, Арцат
- Нүүрс: Могойн гол, Овоот, Зээгт, Хотгор зэрэг нийт 21 орчим орд сонгож урьдчилсан уламжлалт үнэлгээг өгч эхлээд байна.
- Газрын ховор элемент: Мушгияа худаг, Лугийн гол

Г. Зүүн бүсийн урьдчилсан байдлаар сонгосон ордууд

Зүүн бүсийг төлөөлөх ордуудыг сонгохдоо мөн ижил нөхцөлөөр нийт 224 орчим ордоос нөөц, ашигт агуулга болон дэд бүтэц зэрэгт тулгуурлаж 30 орд сонгосон.
Эдгээрт:

- Алт: Цагаан чулуут, Өлзийт, Алтан цагаан овоо
- Молибден: Цагаан чулуут, Арын нуруу, Лам чулуут
- Уран: Нэмэр, Мардайн гол, Дорнод, Мардай, Гурван булаг
- Цагаан тугалга: Цав, Улаан, Дээд кумэйр
- Ванади: Салаа, Егүзэр, Егүзэр зүүн
- Цайр: Баян уул, Төмөртэйн овоо (Салхит)
- Мөнгө: Мөнгөн өндөр, Баян уул
- Хар төмөр: Навчит гол, Ширэн овоо, Цахиурт овоо
- Бусад: Дээд кумэйр бүлэг орд, Баянмөнх толгой, Нарсын хөндлөн, Тал булаг, Салхитын бор толгой, Төмөртэйн овоо, Бүрэнцогт, Эрвэйн хошуу

Зарим голлох ашигт малтмалын нөөцийн судалгаа

ҮҮХҮЯ-ны мэдээгээр алтны шороон ордын нөөц 27.6 тн, үндсэн ордын нөөц 224.2 тн, алт агуулсан бусад металлын ордын нөөц 1101.3 тн, нийт 2000 гаруй тн алтны нөөц бүртгэгдсэн.

Хүснэгт 6 Алтны үндсэн ордууд, аймгаар

№	Аймаг	Үндсэн ордын тоо
1	Сэлэнгэ	18
2	Төв	13
3	Өмнөговь	10
4	Дорнод	6
5	Ховд	5
6	Өвөрхангай	3
7	Баянхонгор	3
8	Завхан	3
9	Говь-Алтай	2
10	Сүхбаатар	2
11	Дорноговь	2
12	Хэнтий	2
13	Баян-Өлгий	2
14	Дархан-уул	1
15	Дундговь	1
	Нийт	74

Эх сурвалж : Ашигт малтмалын газар, 2018

Монгол Улсад алтны 600 орчим шороон орд илэрч нөөц бүртгэгджээ. Эдгээрийн 20 орчим хувьд алтны олборлолтын үйл ажиллагаа явагдаж, ихэнх ордын ашиглалтын нөөц нь дуусч, зарим алтны ордууд уул геологийн нөхцөл хүнд, олборлолтын өртөг, зардал өндөр зэргээс шалтгаалан олборлолт одоогоор явагдахгүй байна.

Мөн алт агуулсан бусад металлын ордуудад зэс, хар тугалга болон цайрын орд орж байна.

Хүснэгт 7 Алт агуулсан бусад металлын ордууд

№	Ордын нэр	Агуулга, г/тн	Алтны нөөц, кг		Нийт, кг
			Балансын нөөц	Баланс бус нөөц	
1	Улаан	0.24	7,122.00	-	7,122.00
2	Цав	66	2,219.00	-	2,219.00
3	Баян Айраг	0	27,905.00	-	27,905.00
4	Оюу толгой	0.30	1,185,000.00	718,000.00	1,896,000.00
5	Цагаан суварга	0.05	11,127.00	-	11,127.00
6	Номинт	0.27	4,302.50	-	4,302.50
7	Будаг толгойн	0.2	681.29	-	681.29
8	Саран уул	0.097	4,575.00	4,585.40	9,160.40
9	Салхит	0.005	9.34	10.46	19.80
10	Цахир толгой	0.12	1,800.00	-	1,800.00
11	Нарийн худаг	0.07	698.00	753.00	1,451.00
12	Оюут Улаан	0.38	4,022.00	246.00	4,268.00
13	Манхан уул	0.182	1,539.40	-	1,539.40
14	Эрдэнэтолгой	0.06	862.49	-	862.49
15	Хадат гүн	0.004	3,339.28	-	3,339.28
16	Салхит (Зүүн)	0.407	1,160.00	-	1,160.00
17	Улаан худ	0.04	1,905.22	-	1,905.22
	Бүгд		1,101,268.00	815,594.90	1,916,862.90

Эх сурвалж: Ашигт малтмалын газар, Алт-2 хөтөлбөр, 2018

Хайлуур жоншны нөөц

Монголын хайлуур жоншны гол бүс Дорнод аймгаас Хэнтий, Сүхбаатар, Дорноговь, Төв, Дундговь, Өмнөговь хүртэл байрладаг

Өнөөгийн байдлаар “Монголросцветмет” ХХК-ийн Бор-Өндөрийн Уулын баяжуулах үйлдвэр, “Монголчехметалл” ХХК-ийн Чулуутцагаан дэл, Тэвшийн баяжуулах үйлдвэр болон Айраг, Хажуу-Улаан, Өргөн зэрэг хайлуур жоншны 20 үйлдвэр байгаагаас 9 нь ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй, бусад аж ахуйн нэгжүүд зөвхөн баяжуулах үйлдвэр барьж ашиглалтад оруулаад байна.

“Монголросцветмет” ХХК-ийн Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэр, Өргөний уурхай, “Монголчехсловакметалл” хамтарсан үйлдвэрийн Чулуут цагаан дэлийн болон Бэрхийн уурхай нь үйлдвэрлэлийн аргаар хүдэр олборлож боловсруулах ажлыг илүү зохион байгуулалттайгаар гүйцэтгэж байна. Мөн Адаг, Зүүн цагаан дэл, Бор-хужир зэрэг ордын ил уурхайгаар ашиглаж болох нөөц дуусч цаашид ордын үлдсэн нөөцийг далд уурхайгаар ашиглах асуудал тавигдаж байна.

Монголд хайлуур жоншны илрүүлсэн орд 50 , ирээдүйтэй байж болох илрэц 60 орчим байдаг.

Хүснэгт 8 Монголын жоншны томоохон ордууд, нөөц /мян.тн /

№	Орд газар, уурхай	Хүдрээр	
		Батлагдсан	Прогноз
1.	Бор-Өндөр	5724.43	1030.70
2.	Адаг	2855.80	314.00
3.	Өргөн	3797.96	615.70
4.	Зүүн цагаан дэл	4478.00	
5.	Айраг /Борхужир/	613.40	84.40
6.	Хөх дэл	1181.24	
	Нийт	18650.83	2044.8

Эх сурвалжс: "Монголросцветмет" ХХК, 2018 он

Монгол Улс хайлуур жоншны нөөцийн хэмжээгээр Мексик, БНХАУ, ӨАБНУ-ын дараа дэлхийд дөрөвдүгээрт ордог.

Ашигт малтмал, газрын тосны газрын мэдээлснээр металургийн баяжмал үйлдвэрлэл буурч, флотацийн баяжмал болон хүдрийн хэмжээ өсч 2013-2017 онд буюу 5 жилийн хугацаанд 1,5 сая тн жонш экспортолсноос флотацийн баяжмал 187 мян тн буюу 12%, металургийн баяжмал 1,1 сая тн буюу 73%, хүдэр 219 мян тн буюу 15%-ийг түүнд эзэлж байна.

Цаашид хайлуур жоншны нөөцөд түшиглэсэн хими-технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх үндэс суурийг тавих, тэргүүн ээлжинд хайлуур жоншны баяжмалыг боловсруулан фторт нэгдлүүдийг гарган авах арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлэх нь чухал байна. Мөн жоншны салбарт байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, экспортын нэг цонхны бодлогыг хэрэгжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зэрэг асуудлыг цогцоор нь шийдвэрлэх шаардлагатай байна.

Төмрийн хүдрийн нөөц

Манай оронд эрэл хайгуулын ажлыг хийж нөөцийг нь тогтоосон төмрийн орд бүхий гурван бүс нутаг байдаг. Эдгээрийн хоёр нь төвийн болон.govийн бүс нутагт байрладаг. Үүнд Дархан-Сэлэнгэ, Дундговь-Дорноговийн район ордог. Эдгээр район нь дэд бүтэц сайтай. Говийн бүс нутагт хийсэн эрэл-үнэлгээний ажлын үр дүнд Дарцагт, Эрээн болон Чандмань уулын орд илэрсэн.

Сүүлийн жилүүдэд Таяннуур, Худаг байшинт, Элстэй, Харганат, Алтайнхүдэр болон Бортолгойн ордууд нээгдсэн.

АМГТГ-ын 2018 оны мэдээгээр манай улсад төмрийн 91 орд бүртгэлтэй байна. Тус ордууд нь 1.0 тэрбум гаруй тоннын төмрийн хүдрийн нөөц баялагтай .

Хүснэгт 9 Монгол орны төмрийн ордуудын нөөц

Д/д	Ордын нэр	Нийт хүдрийн нөөц, сая тн	Дундаж агуулга(хувиар)		
			Fe	S	O_5
1.	Төмөртэй	B+C=229.3	52.0	1.31	0.05
2.	Төмөртолгой	B+C=25.0	51.1	1.26	0.05

3.	Хуст уул	B+C=12.3	46.6	1.59	0.09
4.	Төмөртэйн гол	B+C=16.4	48.4	0.56	0.08
5.	Баянгол	B-66.2, C-16.1,	46.53	1.68	0.12
6.	Баргилт	B+C+P=45.0	32.1		
7.	Алтайн хүдэр	B+C=30	48		
8.	Тамир гол	B+C=4.5, P-56.0	41.0	0.01-4.05	0.55-3.12
9.	Худаг байшинт	B+C=7.1	45.0		
10.	Харганат	C-3.7, P-2.6	45.0		
11.	Таян нуур	B-6.4, C-10.0	40		
12.	Элстэй	B+C=7.2	40.9-49.8	0.13-0.14	0.01-0.02
13.	Эрээн	C-33.6, P-48.09	34.0	0.11	0.29-0.34
Дүн		B+C=438.2 P-288.3	-	-	-

Эх сурвалжс: Ашигт малтмал, газрын тосны газар, Экспортлогчдын холбоо 2018 он

Эдгээрийн дотор В, С1, 2 бодитой болон боломжит зэрэглэлээр 438,2 сая тонн нөөц байна.

Харин Архангайн Тамирын голын орд дэд бүтэц муутай. Төмрийн хүдрийн найрлагад фосфорын агуулга өндөртэй.

Газрын тосны нөөц

Монгол Улсын нутаг дэвсгэрт 2017 оны байдлаар 18 талбайд газрын тос, уламжлалт бус газрын тосны эрлийн гэрээ (газрын тосны 10, нүүрсний давхаргын метан хийн 5, шатдаг занарын 3), 25 талбай (газрын тосны хайгуулын 22, ашиглалтын 3)-д бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ)-ний дагуу газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж байна.

Газрын тосны эрэл хайгуул


Монгол Улсын нутаг дэвсгэрт газрын тосны хайгуулын 33 талбайг бэлтгэж , 27 талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ/БХГ/-нүүдийг гадаадын болон үндэсний хөрөнгө оруулагчидтай байгуулан ажиллаж байна.

2018 оны 9-р сарын 20-ны өдрийн байдлаар, БХГ-ний дагуу 22 талбайд газрын тосны хайгуулын, 3 талбайд газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж байна.

БХГ-ний дагуу 1993-2017 ондууд олон улсын болон үндэсний компаниуд нийт 3,7 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийж, дараах ажлуудыг гүүцэтгэсэн байна.Үүнд:

- Хүндийн хүчиний судалгаа 1:200000 масштабаар 272890 km^2 талбайд,
- Соронзон хайгуул 77630 km^2 талбайд,
- Пассив сейсмийн судалгаа 210 физик цэгт,
- Магнито-теллурын судалгаа 180 физик цэгт,
- 2 хэмжээст чичирхийллийн судалгаа 34683 тууш км,
- 3 хэмжээст чичирхийллийн судалгаа 6474 km^2 талбайд,
- Агаарын бүрэн хэмжээст градиометрийн судалгаа 21990 км хийж;
- Хайгуул, үнэлгээ, олборлолтын 1641 цооног /үүнээс 400 хайгуулын, 1241 үнэлгээ, олборлолтын цооног/ өрөмдсөн.

Петрочайна дачин тамсаг ХХК нь 2018 он хүртэл 1461 цооног өрөмдөж, 3.05 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн. Харин Доншен газрын тос (Монгол) ХХК нь 111 цооног өрөмдөж, 269.5 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн.



Зураг 2. Газрын тосны нөөц, сяа.тн

УУХҮЯ-ны мэдээгээр газрын тосны эрэл, хайгуулын ажлын үр дүнд 332.6 сая тонн газрын тосны баталгаат нөөц, 43.2 сая тонн ашиглалтын баталгаат нөөцийг тогтоож, Монгол Улсын ашигт малтмалын нөөцийн нэгдсэн санд бүртгэсэн байна. /Зураг 2/

1.2.1. Монгол Улсын эрдсийн түүхий эдийн баазын хөгжлийн цаашдын төлөв байдал

Аливаа улс гүрний Үндэсний аюулгүй байдлыг тодорхойлдог үзүүлэлт нь тухайн улсын эрдсийн түүхий эдийн баазын хөгжлийн төвшин байдаг. Энэ зарчим техник технологи, эдийн засгийн өндөр хөгжилтэй АНУ-д мөрдөгдөж байна. Аж үйлдвэрийн өндөр хөгжилтэй ОХУ-д ч ийм байна. Монгол Улсад ч ийм байх ёстай.

Энэ зарчимд тулгуурлан цаашид баримтлах чиглэл:

I. Геологийн салбарт

1. Эрдсийн түүхий эдийн баазыг бэхжүүлэхийн тулд хайгуулын ажилд гадаадын хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн орчин нөхцлийг тогтвортой байлгаж, орд нээсэн тохиолдолд түүнийг ашиглах асуудлыг тухай бүрд нь жич шийдвэрлэж байх бодлогыг баримтлах;
2. Эрдсийн түүхий эдийн салбар нь ойрын 15 жилд Монгол Улсын эдийн засгийн суурь салбар хэвээр байна гэж үзэж ашигт малтмалын боловсруулалтын түвшинг дээшлүүлж нэмүү өртөг шингээсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цогцолборуудыг байгуулах;
3. Улсын төсвөөс геологийн эрэл үнэлгээний болон зураглалын ажилд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг өсгөж, 1:50000-ны масштабын геологийн зураглалын ажилд зарцуулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх;
4. Манай улс нүүрс, зэс, хайлуур жоншны хүдэр болон уран зэрэг ашигт малтмалын илрүүлсэн нөөц баялгийн хэмжээгээр дэлхийн тэргүүлэх 10 орны тоонд орж байна. Төмрийн хүдэр, газрын ховор элемент болон хөнгөн цагаан зэрэг ашигт малтмалын эрэл хайгуулын ажлыг эрчимжүүлэх шаардлагатай;

- Бүс нутгийн хөгжлийг тэнцвэржүүлэх үүднээс геологи болон уул уурхайн салбарын зохицуулалтыг хийх, бүс нутаг ба аймгийн байршлыг оновчтой тогтоох, геологийн хэтийн бодлогод анхаарах. Ашигт малтмалын нөөцийн нөхөн үйлдвэрлэлийг ашиглалтаас түрүүлүүлэх бодлогыг хатуу баримтлах;
- Улсын геологийн албыг олон улсын сайн жишигт тулгуурлан бүтэц зохион байгуулалт, гүйцэтгэх ажлын чиглэл, санхүүжилтийн зарчмыг оновчтой тогтоох, одоо байгаа уул уурхайн салбарын үйл ажиллагааг тогтвортой хөгжлийн шаардлагатай уялдуулах механизмыг боловсруулж хэрэгжүүлэх;
- Томоохон ордуудын үйлдвэрлэлийн нөөцийг өсгөх хайгуулын ажлыг ордын гүнд хийх бодлогыг хэрэгжүүлэх;
- Хайгуул нь хийгдсэн, нөөц нь тогтоогдсон ашигт малтмалын ордуудыг олон улсын нөөцийн ангиллын стандартанд шилжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах ажлыг эрчимжүүлэх;
- Геологийн төв лабораторийн эрдсийн дээжийн шинжилгээний чадавхийг сайжруулах, геологийн мэдээлэлийн дижитил хэлбэрт шилжүүлэх боловсруулалтын хэмжээг нэмэгдүүлэх, үндэсний геологид болон геологийн байгууллагуудын хүчин чадлыг бэхжүүлэх, геологийн албаны боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах зэрэгт олон улсын донор байгууллагуудын хөрөнгийг түлхүү ашиглахад анхаарах зэрэг болно.

II. Уул уурхайн аж үйлдвэрийн салбарт

Уул уурхайн салбар нь ойрын 15 жилд Монгол Улсын эдийн засгийн суурь салбар хэвээр байх учир ашигт малтмалын олборлолт, боловсруулалтын түвшинг нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цогцолборуудыг байгуулах зорилтод чиглэгдэнэ.

Уул уурхай-өнгөт төмөрлөгийн цогцолбор байгуулах

- Эрдэнэт, Оюу толгой, Цагаан суварга зэрэг зэс-молибден, зэс-алт, зэсийн ордыг түшиглүүлэн засийн хүдэр олборлох-баяжуулах-зэс хайлуулах үйлдвэрийн цогцолбор байгуулах;
- Агуулга багатай, исэлдсэн балансын бус зэсийн хүдрийг гидрометаллургийн аргаар боловсруулж катодын зэс үйлдвэрлэх;
- Алтны үндсэн ба шороон ордыг ашиглан алт цэвэршүүлэх үйлдвэрт цэвэршүүлэх;
- Молибдений баяжмал боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх;
- Ураны хүдрийг гидрометаллургийн аргаар олборлож боловсруулж “шар нунтаг” үйлдвэрлэж экспортлох;
- Цайрын олборлолт-боловсруулалтыг металлургийн түвшинд хүргэж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх;
- Хайлуур жоншины олборлолт, боловсруулалтыг эцсийн бүтээгдэхүүний түвшинд хүргэх;
- Газрын ховор элементийн судалгааг гүнзгийрүүлж олборлох-боловсруулах технологийг нэвтрүүлж баяжмалын болон металлын түвшинд хүрсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх;

Уул уурхай-хар төмөрлөгийн цогцолбор байгуулах

9. Төмрийн хүдрийг олборлох-баяжуулах-боловсруулах Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолбор байгуулж ширэм, ган, туйван, ган утас зэрэг бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангах;
10. Кокс-төмөрлөгийн цогц үйлдвэр байгуулах боломжийг судлаж хэрэгжүүлэх. (Металлургийн кокс үйлдвэрлэх);

Түлш-эрчим хүчний цогоцолбор байгуулах

11. Түлшний хувийн зарцуулалт багатай (251гр/кВт.ц) технологи бүхий их хүч чадлын цахилгаан станц, улс хоорондын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам (ЛЭП) дэд станцуудын хамт байгуулж цахилгаан экспортлох;
12. Таван толгойн коксжих нүүрсний ордын нүүрсийг баяжуулж өрсөлдөх чадвартай чанар бүхий нүүрсийг экспортлох;
13. Говийн болон зүүн бүсийн нүүрсний ордуудыг түшиглүүлэн кокс-химийн үйлдвэрийн цогцолбор байгуулах;
14. Нүүрсийг энерго-технологийн аргаар боловсруулж хагас кокс, термобрикет хий, цахилгаан дулаан үйлдвэрлэх;
15. Нялга-Чойрын нүүрсний ордуудыг түшиглэн нүүрс хийжүүлэх үйлдвэр байгуулах;
16. Нүүрснээс метан олборлох технологийг нэвтрүүлэх;
17. БНХАУ-ын баруун бүсийн коксжих нүүрсний зах зээлийн эрэлтэд нийцүүлж Хөшөөтийн уурхайн нүүрс олборлолт-баяжуулалт-тээвэрлэлт ложистикийн цогцолборыг хөгжүүлэх;
18. Монгол Улсын түлшний балансын бүтцийг сайжруулахын тулд газрын тос боловсруулах үйлдвэрийг байгуулж, авто бензин, дизелийн түлш, мазут зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх;
19. Нефть-химийн үйлдвэрлэлийг зохион байгуулах;
20. Нефтийн түүхий эдийн баазыг бэхжүүлэхийн тулд нефтийн хайгуулын ажилд гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
21. “Petro Matad” компаний “Цэн тогоруу” ордын хайгуулыг эрчимжүүлэх;

Уул уурхайн аж үйлдвэрийг хөгжүүлэх зөвлөн дэд бүтцийн тогтолцоонд хийгдэх ёстой ажил гэвэл:

22. Тээвэр, холбооны барилгын салбарыг хөгжүүлэх;
23. Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох татварын орчныг тогтвортой мөрдөх;

Хөрөнгө оруулалтыг татах сонирхолтой нөхцөл бүрдүүлэх

24. Уул уурхайн олон бүтэц бүхий аж үйлдвэрийн салбарын нарийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд онцгой анхаарч улсаас хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай.

Эцэст нь: Дээр дурдсан зорилтууд нь уул уурхайн аж үйлдвэрийн сонгодог суурь бүтцийн хүрээнд тодорхойлсон зорилт гэдгийг тэмдэглэе.

Аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгалын үе дэх уул уурхайн аж үйлдвэр

25. Тоон эдийн засгийн зарчмыг дагаж хиймэл оюун шингэсэн үйлдвэрлэл үйлчилгээг нэвтрүүлэх;

26. Дижитал систем, эд зүйлсийн интернет, робот техник, гиперфизикийн систем нэвтрүүлж уулын ажил, экологийн мониторингийн хяналтыг дроноор гүйцэтгэх, ухаалаг цооногийн өргөгчийг газрын доор уусган олборлох (ГДУО) технологид хэрэглэх, жолоочгүй хүнд даацын авто тээврийг нэвтрүүлж, туузан дамжуулагч тээврийн удирдлагыг дижиталчлах гэх мэт.
27. Эд зүйлсийн интернетчлэл, робот техник зэрэг гиперфизикийн системүүдийн олон төрлийн датчик, элементийн үйлдвэрлэлийг дагнах хорших аргаар гүйцэтгэж Индустрى-4.0 хөтөлбөрийг идэвхтэй хэрэгжүүлэгч орон болж хиймэл оюун ухааны үйлдвэрлэлд тэргүүлэх эгнээнд хүрэхийг зорих хэрэгтэй байна.


1.3. Эрдсийн түүхий эдийн цогцолборын хөгжлийн үндэсний эдийн засагт үзүүлж буй нөлөөллийн түвшний үнэлгээ, урт хугацааны хэтийн өсөлт (10 жилээр)

Уул уурхайн үйлдвэрлэлийн таваарын бүтээгдэхүүний урьдчилсан тооцоог хийх, хэтийн төлөв

Энэхүү судалгаагаар манай улсын ДНБ-ний дийлэнхи хувийг бүрдүүлж байгаа уул уурхайн салбарын дунд хугацааны үйлдвэрлэлийн таамгийг гаргаж бүс нутаг тус бүрийн таваарын бүтээгдэхүүний тооцоог хийлгээ

Монгол Улсын ДНБ-ий бодит өсөлт 2018 оны байдлаар 6.8 хувьтай гарсан нь эдийн засгийн өсөлт хурдтай байгааг харуулж байна. Энэ өсөлтийн 2,1 хувийг аж үйлдвэр, барилгын салбар, 3,3 хувийг үйлчилгээний салбар, 1.4 хувийг хөдөө аж ахуй эзэлсэн ба барилгын салбарт төрөөс дэмжлэг үзүүлж байгаа нь өсөлтөд голлох нөлөө үзүүлсэн байна.

Азийн Хөгжлийн Банкны тайланд Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2018 оны 6.9 хувиас бага зэрэг буурч 2019 онд 6.7%, 2020 онд 6.3% болно хэмээн таамагласан байна. Энэ өсөлтөд “Оюу Толгой” ХХК гүний уурхайн бүтээн байгуулалт, бусад уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалттай холбоотойгоор гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр уул уурхайн салбарын өсөлтөд голлох нөлөөлөл үзүүлэхээр байна.



Зураг 3 Монгол Улсын ДНБ болон уул уурхайн үйлдвэрлэлийн 2025 он хүртэлх төсөөлөл (эх сурвалж: УХГ, Засгийн тогтвортой хөгжлийн 2018-2025 оны төсөөлөл)

Жил бүр Сангийн Яам болон Уул Уурхайн Яам богино хугацааны ирэх 2-3 хүртэлх жилийн уул уурхайн бүтээгдэхүүний урьдчилсан тооцоог хийж төсвийн орлого

бүрдүүлэлтийн таамгийг гаргадаг бөгөөд голлох ашигт малтмалууд болох нүүрс, алт, зэс, төмрийн хүдэр зэргийг төсөөллийг дараах байдлаар гаргасан байна.

Хүснэгт 10 Голлох эрдэс түүхий эдийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дунд хугацааны төсөөлөл

Эрдэс бүтээгдэхүүн	2018, гүйц	2019, төс	2020, төс	2021, төс
Нүүрс, сая тн	28	34.7	38.8	40.8
Зэсийн баяжмал, мян.тн	1366.0	1387.2	1447.2	1452.2
Төмрийн хүдэр, мян.тн	7500.0	7513.7	7521.7	7680.0
Жонш, мян.тн	280,8	320.5	325.6	328.2
Алт, монгол банкинд, тн	21.0	21.0	21.0	22.0
Газрын тос, мян. бар	8100.0	8110.8	8160.8	8260.8

Мөн түүнчлэн уул уурхайн салбарын 2018-2025 оны хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэл Уул уурхайн салбарын дунд хугацааны хөгжлийн бодлогын тэргүүлэх чиглэлийг “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030”, “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого” зорилтуудтай уялдуулж, гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээг Үндэсний хөгжлийн газраас дараах байдлаар тооцоолсон байна.

Монгол Улсын тогтвортой хөгжил, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх үүднээс Уул уурхайн үйлдвэрлэлийн цаашдын олборлолтыг нэмэгдүүлэх боломжийг сайжруулснаар 2025 он гэхэд эрдэс түүхий эдийн үйлдвэрлэл дараах байдлаар өсөх боломжтойг үндэсний хөгжлийн газрын мэргэжилтнүүд тооцоолсон байна. Үүнд:

Хүснэгт 11 Эрдэс түүхий эд үйлдвэрлэлийн 2025 он хүртэлх зорилт

Уул уурхайн бүтээгдэхүүний олборлолтын хэмжээ:	2018 оны зарим эрдэс түүхий эдийн үйлдвэрлэл	2025 оны зорилт
Нүүрс, /сая.тн/	25.1	65.0
Алт, /тн/	17.3	41.7
Төмрийн хүдэр, /сая.тн/	7,583.2	21,029.8
Зэсийн баяжмал, /мян.тн/	1,511.4	2,407.6
Жонш, /мян.тн/	-	-
Молибдений баяжмал /тонн/	5,230.5	7,867
Газрын тоц /мян.баррель/	9,915.7	13,373.7


Мөн ижил төстэй тайланг харахад Дэлхийн банк болон ОУВС-аас гаргасан судалгаа тайланд ДНБ-ний 20 орчим хувийг бүрдүүлдэг уул уурхайн салбарын өсөлтийг тооцоолж үзэхэд 2020 оноос уул уурхайн салбарын өсөлт дундаж үзүүлэлтээ хадгалж 2023 оноос Оюу Толгойн далд уурхайн үйлдвэрлэл эхлэхтэй холбогдуулан дээд цэг буюу 9 хувиар өсөхөөр байна.

Монгол Улсын Уул уурхайн салбар нь улс орны эдийн засагт зонхилох байр суурийг эзэлж буй гол салбар болж байгаа өнөө үед шинээр нээгдэж буй ашигт малтмалын ордууд, тэдгээрийн ашиглалт ба дагалдах бүтээн байгуулалтын их ажил хийгдэж байна.


Монгол улсад одоогийн байдлаар нүүрс, зэс, молибден, алт, хайлуур жонш, төмрийн хүдэр, цайр, гянтболд зэрэг ашигт малтмалыг голлон олборлож байна.

1.3.1 Зэсийн үйлдвэрлэлийн өсөлт

Монголын зэсийн үйлдвэрлэл нь “Эрдэнэт” үйлдвэр, “Оюу Толгой” уурхайн дээр явагдаж байна. Зэсийн хэтийн үйлдвэрлэлийг гаргахдаа “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын урт хугацааны үйлдвэрлэлийн төлөвлөгө болон Оюутолгойн ТЭЗҮ-ийн тоон үзүүлэлтийг ашигласан бөгөөд 2017-2021 онд 600 мян.тн, 2022-2027 онд 1.5 сая тн, “Эрдэнэт” үйлдвэр жилд 500 гаруй мян.тн баяжмал үйлдвэрлэнэ. Харин “Цагаан суварга”-ын ордоос жилд дунджаар 310 мян. тн тонн олборлох бөгөөд Монгол Улсын зэсийн үйлдвэрэлийн хэмжээг доорх графикт харуулав.




Зураг 4 Зэсийн баяжмал үйлдвэрлэлийн хэтийн төлөв



Зураг 5 Эрдэнэт үйлдвэрийн бүтээгдхүүн үйлдвэрлэлийн үзүүлэлт¹

1.3.2 Монгол Улсын алтны салбар

Ашигт Малтмал Газрын Тосны Газар (АМГТГ)-ын үзэж буйгаар Монгол улсын алтны үйлдвэрлэл ойрын ирээдүйд өсөж, 2025 он гэхэд 47 тонн болох төлөвтэй байна (Зураг 6). Энэ өсөлтөд 2021 оноос эхлэх Оюу толгойн далд уурхайн үйлдвэрлэл гол нөлөө үзүүлэх бөгөөд, алтны нийт үйлдвэрлэлд Оюу толгой уурхайн оруулах хувь нэмэр 2025 он гэхэд 38 хувь болтлоо нэмэгдэнэ хэмээн хүлээж байна.




Зураг 6 Монгол улсын алтны үйлдвэрлэлийн төсөөлөл (тонн)²

Дараах зурагт Монгол Улсын 2010-2016 оны цэвэр алтны экспорт, АМГТГ-ын гаргасан 2025 он хүртэлх алтны экспортын төсөөллийг харуулж байна. Алтны экспорт 2025 он гэхэд 2 дахин нэмэгдсэн байхаар байна. Үүнд Оюу толгой төсөл голлох нөлөөг үзүүлэх бөгөөд 2021-2025 оны хооронд нийт экспортын 25-44 хувийг бурдүүлэхээр байна.

¹ COAL&METALS MONGOLIA-2016” чуулганы илтгэлээс “Зэсийн баяжмал хайлцуулах, цэвэршүүлэх үйлдвэрийн төсөл”, Илтгэгч Б.Алтангэрэл, Эрдэнэт Үйлдвэр ХХК

² Эх сурвалж: Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн (2018)



Зураг 7 Монгол Улсын алтны экспортын төсөөлөл (тонн)³

Алтны дотоодын зах зээлийн гол худалдан авагч нь Монгол банк бөгөөд худалдан авсан алтны хэмжээ сүүлийн жилүүдэд дотоодын санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх зорилгоор алтны худалдан авалтаа эрчимтэй нэмэгдүүлж байна. Ялангуяа 2014 онд огцом өсөж эхэлсэн нь “Ашигт малтмалын тухай хууль”-нд орсон өөрчлөлт Монгол банканд алт тушаах үйл ажиллагааг эрчимжүүлсний үр дүн байсан.⁴ Цаашлаад Монгол банк нь Засгийн газрын баталсан “Алт-2” хөтөлбөртэй уялдуулан 2017-2020 онд жил бүр 20-25 тонн алт худалдаж авахаар төлөвлөж байгаа тул алт худалдан авалт ойрын ирээдүйд улам өсөх төлөвтэй байсан.⁵ Гэсэн хэдий ч 2019 он хүртэл Монгол банкинд тушаасан алтанд ногдуулах АМНАТ-ын хэмжээ 2.5% байсныг 2019 он гарсаар цуцалж, бусад ашигт малтмалын адил 5% болгохоор хуульчилсан. Энэ нь алт олборлогч ААН-үүдийн хувьд татварын ачааллыг нэмэгдүүлэх төлөвтэй байна.


1.3.3 Нүүрсний салбар

Ойрын 5-10 жилийн Одоогийн дэд бүтцийн нөхцөл байдалд үндэслэж нүүрсийг зөвхөн БНХАУ-руу гаргах боломжтой гэж үзэн сүүлийн жилүүдийн БНХАУ-ын импортын эзлэх хувь хэмжээ болон Хятад улсын эдийн засаг болон нүүрсний хэрэглээний өсөлттэй уялдуулж Монгол улсын нүүрсний салбарын хэтийн төлөвийг доорх Зурагт тодорхойлов.

³ Эх сурвалж: Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн (2018)

⁴ Дэлгэрэнгүйг Ашигт малтмалын тухай хуулийн 2014.01.24-ний өдрийн нэмэлт өөрчлөлтөөс харна уу.

⁵ Дэлгэрэнгүйг Алт-2 хөтөлбөрийн 3.1.11, 3.3.11 болон 4.1.8 заалтуудаас харна уу.



Зураг 8 Нүүрсний салбарын үйлдвэрлэлийн хэтийн төлөв

1.3.4. Ирэх 10 жилд шинээр хэрэгжих боломжтой төслүүд

Баруун бүсэд шинээр бий болох уул уурхайн таваарын бүтээгдэхүүний судалгаа

Баруун бүсийн хувьд бизнесийн орчин таатай байх нөхцөлд ирэх 3 жилд 14 ширхэг шинэ уул уурхайн төсөл үйл ажиллагаагаа эхлүүлэхээр хүлээгдэж байгаа бөгөөд ихэнх нь төмөр, зэс, вольфрамийн төсөл юм. Эдгээр төслүүдийн хүлээгдэж буй нийт хөрөнгө оруулалт нь 1.8 тэрбум ам.долларт хүрэх юм. Жишээ байдлаар баруун бүсийн томоохон ордод тооцогддог төмрийн Таяннуур ордын үзүүлэлтийг дор харуулж нэгдсэн нийт ордуудын тооцооллыг хүснэгтээр харууллаа.

- Таяннуур: жилд дунджаар 310 мян.тн
- Хөрөнгө оруулалт: 89.8 тэрбум төгрөг
- Бүтээгдэхүүн: Төмрийн баяжмал
- Агуулга: 61%
- Ажлын байр: 1598


Хүснэгт 12 Баруун бүсэд уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа ААН-ҮҮД

Бүс	2014	2015	2016	2017	2018
Баруун	13	18	18	21	24

Хүснэгт 13 Баруун бүсэд шинээр нэмэгдэх уул уурхайн төслүүд, таваарын бүтээгдэхүүнээр

Ордын нэр	АМ-ын төрөл	Нөөц	Ашиглалтын дундаж хугацаа, жилээр	Жилийн хүчин чадал, тонн/жил
Балин толгой	Алт	1,392,000	6.9	202,628
Улаан хажуу	Алт	9,756,000	11.2	872,818
Ямаат	Алт	166,030	4.0	41,125
Таяннуур	Төмөр	101,800,000	20.1	5,067,349
Түргэн	Төмөр	70,314,000	18.3	3,839,294

Харганат	Төмөр	21,327,000	13.6	1,569,160
Бор аг	Зэс	12,685,600	11.9	1,062,804
Хадат гүн	Зэс	84,690,000	19.2	4,414,120
Хараат	Зэс	1,906,150	7.4	256,500
Цүнхэг	Вольфрам	485,820	5.3	92,008
Ховд гол	Вольфрам	156,850	4.0	39,408
Уудав	Вольфрам	219,000	4.3	50,618
Халзан бүрэгтэй	ГХЭ	268175530	25.6	10,478,144
Бортолгой	ГХЭ	245,526,900	25.0	9,807,184
Хөх Адар	Cu	37,836	2.8	13,564
Хөшөөт	Нүүрс	120,205,000	20.9	5,740,000
Нүүрст хотгор	Нүүрс	120,205,000	20.9	5,740,000



Зураг 9 Баруун бүсэд шинээр бий болох боломжтой Уул уурхайн төслүүд

Хангайн бүсэд шинээр бий болох уул уурхайн таваарын бүтээгдэхүүний судалгаа

Хангайн бүсийн хувьд бизнесийн орчин таатай байх нөхцөлд ирэх 3-5 жилд 13 ширхэг шинэ уул уурхайн төсөл үйл ажиллагаагаа эхлүүлэхээр хүлээгдэж байгаа бөгөөд ихэнх нь алт, зэс, молибдений төслүүд юм. Эдгээр төслүүдийн хүлээгдэж буй нийт хөрөнгө оруулалт нь 2.5 тэрбум ам.долларт хүрэх юм. Жишээ байдлаар Аспайр Майнинг Лимитед компанийн Овоот ордын үзүүлэлтийг дор харуулж нэгдсэн нийт ордуудын тооцооллыг хүснэгтэд харууллаа.


- Овоот 227 сая тонн нүүрсний нөөц
- Хүчин чадал 8,000 мян.тн
 - 2021: 1.2 сая тн баяжмал (хүчин чадал бага үе);
 - 2022-2030: 1.5 сая тн (3.0-4.7 сая тн);
 - 2031-2040: 8.0 сая тн (бүрэн хүчин чадлаараа ажиллах үед).

Хүснэгт 14 Хангайн бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүд

	2014	2015	2016	2017	2018
Хангайн бүс	59	58	63	78	160

Хүснэгт 15 Хангайн бүсэд шинээр нэмэгдэх уул уурхайн төслүүд /таваарын бүтээгдэхүүнээр/

Ордын нэр	АМ-ЫН ТӨРӨЛ	НӨӨЦ, ТОНН	Ашиглалтын жил	ЖИЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ, ТОНН/ЖИЛ
Тавт	Алт	714,200	5.8	122,839
Өрхөт	Алт	46,046,000	16.5	2,794,885
Харгуй ширийн ам	Алт	2,041,000	7.6	269,993
Цэнхэр	Төмөр	3,024,000	8.3	362,582
Өлзий-Овоо	Төмөр	87,693,000	19.4	4,530,996
Тамирын гол	Төмөр	53,015,000	17.1	3,106,484
Цахир толгой	Зэс	15,501,640	12.5	1,235,245
Сангийн далай	Зэс	1,433,110	6.9	207,100
Саран уул	Зэс	47,197,580	16.6	2,847,146
Өлзийт	Вольфрам	42,000	2.9	14,669
Арцат	Вольфрам	141,000	3.9	36,382
Мандал	Молибедин	294,949,000	26.2	11,253,308
Салхитын ам	Молибедин	35,271,000	15.4	2,288,407
Зуун мод	Молибедин	372,460,000	27.8	13,405,399
Могойн гол	Нүүрс	4,060,000	9.0	452,235
Овоот	Нүүрс	330,700,000	27.0	12,261,558
Зээгт	Нүүрс	93,000,000	19.6	4,735,133
Хотгор	Нүүрс	158,881,587	22.5	7,075,794
Бүрэн хаан	Фосфор	192,240,000	23.6	8,163,057



Зураг 10 Хангайн бүсэд шинээр нэмэгдэх боломжтой уул уурхан төслүүд
Төвийн бүсэд шинээр бий болох уул уурхайн таваарын бүтээгдэхүүний судалгаа

Төвийн бүсийн хувьд бизнесийн орчин таатай байх нөхцөлд ирэх 3-5 жилд 34 ширхэг шинэ уул уурхайн төсөл үйл ажиллагаагаа эхлүүлэхээр хүлээгдэж байгаа бөгөөд алт, зэс, нүүрс зэрэг голлох ашигт малтмалын ихэнх төлөөлөл үүнд орохоор байна. Эдгээр төслүүдийн хүлээгдэж буй нийт хөрөнгө оруулалт нь ойролцоогоор 3.8 тэрбум ам.долларт хүрэх юм (энэ хөрөнгө оруулалтад Оюу Толгойн болон Тавантолгой бүлэг ордын бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт ороогүй болно.)


Хүснэгт 16 Төвийн бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүд

Бүс	2014	2015	2016	2017	2018
Төвийн	66	54	60	60	123

Хүснэгт 17 Төвийн бүсэд шинээр нэмэгдэх боломжтой уул уурхайн төслүүд

Ордын нэр	АМ-н төрөл	Нөөц, тонн	Ашиглалтын дундаж хугацаа, жилээр	Жилийн зохимжтой хүчин чадал, тонн/жил	Өдрийн дундаж бүтээмж, тонн/өдөр
Хармагтай	Алт	18,031,260	13.0	1383533.123	4,612
Эрээн	Алт	12,850,080	12.0	1073122.691	3,565
Гацуурт	Алт	14,056,510	12.2	1147831.486	3,788
Баян-Өндөр	Алт	7,252,860	10.4	698798.5179	2,299
Төмөртэй	Төмөр	25,033,100	14.1	1769522.055	5,802
Зүүн цагаан хошуу	Төмөр	4,293,400	9.1	471596.9833	1,541
Хуст Уул	Төмөр	13,146,790	12.0	1091653.468	3,556
Эрээн	Төмөр	63,298,440	17.8	3548254.478	11,520
Баянгол	Төмөр	150,433,200	22.1	6791688.749	21,980
Оюу толгой	Зэс	5,812,003,000	55.2	105248127.2	339,510
Эрдэнэт	Зэс	1,574,463,060	39.8	39520220.69	127,075
Цагаан суварга	Зэс	251,997,670	25.2	10000400.62	32,053
Шанд	Зэс	21,017,900	13.5	1552072.469	4,959
Онгон хайрхан	Молибедин	7,423,400	10.4	711086.0377	2,257
Их хайрхан	Молибедин	268,800	4.6	59025.8096	187
Их хайрхан	Гянтболд	631,610	5.6	112022.8848	352
Тавантолгой	Нүүрс	6,400,000,000	56.6	113137085	352,452
Нарийн сухайт	Нүүрс	229,000,000	24.6	9307790.853	28,906
Шивээ овоо	Нүүрс	2,708,700,000	45.6	59366396.06	183,797
Салхит	Мөнгө	2,773,133	8.2	339780.1694	1,049
Баянжаргалан	Литий	1,034,200	6.4	162152.4087	499
Зөөвч овоо	Уран	234,422,000	24.7	9472590.856	28,968
Хайрхан	Уран	11,791,800	11.7	1006132.28	3,067
Хараат	Уран	28,086,350	14.6	1929041.105	5,863
Дулаан уул	Уран	25,106,200	14.2	1773396.073	5,374
Бүргэд хар Уул	Мангани	15,872,850	12.6	1257364.483	3,799
Үнагад	Мангани	4,157,320	9.0	460341.4648	1,387
Хүрэн толго	Мангани	1,753,680	7.3	240953.2376	724

Баян-Овоо	Жонш	1,630,400	7.1	228134.3226	683
Дай уул	Жонш	13,478,100	12.1	1112222.074	3,320
Чулуут цагаан дэл	Жонш	5,926,300	9.9	600561.8334	1,787
Хотгор	ГХЭ	39,751,090	15.9	2503120.665	7,428
Мушгия худаг	ГХЭ	24,432,580	14.1	1737588.771	5,141
Баруун лугийн гол	ГХЭ	35,100	2.7	12821.83966	38
Хар морьт	Цагаан тугалга	637,700	5.7	112832.008	332



Зураг 11 Төвийн бүсэд шинээр нэмэгдэх боломжтой төслүүдийн тоо

Зүүн бүсэд шинээр бий болох уул уурхайн таваарын бүтээгдэхүүний судалгаа

Зүүн бүсийн хувьд бизнесийн орчин таатай байх нөхцөлд ирэх 3 жилд 42 ширхэг шинэ уул уурхайн төсөл үйл ажиллагаагаа эхлүүлэхээр хүлээгдэж байгаа бөгөөд ихэнх нь алт, жонш, ховор металлын төсөлүүд байна. Эдгээр төслүүдийн хүлээгдэж буй нийт хөрөнгө оруулалт нь 2.5 тэрбум ам.долларт хүрэх юм.


Хүснэгт 18 Зүүн бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүд

Бүс	2014	2015	2016	2017	2018
Зүүн	16	20	19	19	21

Хүснэгт 19 Зүүн бүсэд шинээр нэмэгдэх уул уурхайн төслүүд, таваарын бүтээгдэхүүнээр

Ордын нэр	АМ-н төрөл	Нөөц, тонн	Ашиглалтын дундаж хугацаа, жилээр	Жилийн зохимжтой хүчин чадал, тонн/жил	Өдрийн дундаж бүтээмж, тонн/өдөр
Алтан цагаан овоо	Алт	14,013,000	12.2	1,145,166	3,792

Хөмөг гол	Алт	350,100	4.9	71,964	238
Үрдийн Овоо	Алт	875,040	6.1	143,051	471
Уртын хөндий	Алт	1,374,020	6.8	200,662	658
Өвөлжөөний хөндий	Алт	459,890	5.2	88,300	289
Бухт Уул	Алт	1,318,550	6.8	194,555	634
Гутай	Алт	553,610	5.5	101,478	329
Өвөлжөөт	Алт	385,000	5.0	77,280	250
Өвөр баян	Молибедин	24,729,390	14.1	1,753,396	5,656
Нэмэр	Уран	5,338,200	9.6	555,285	1,785
Доонод	Уран	2,913,200	8.3	352,572	1,130
Гурван булаг	Уран	15,865,800	12.6	1,256,946	4,016
Нарсын хөдлөн	Цагаан тугалга	918,500	6.2	148,347	472
Онон	Цагаан тугалга	3,060,200	8.4	365,833	1,161
Баянцогт	Гянтболд	281,115	4.6	61,043	193
Егзөр-Зүүн	Гянтболд	7,142,400	10.3	690,801	2,172
Өндөр цагаан	Гянтболд	134,630	3.8	35,142	110
Арбаян	Гянтболд	31,601	2.7	11,851	37
Югүзэр	Гянтболд	21,578	2.4	8,902	28
Егүзэр	Гянтболд	12,180	2.1	5,797	18
Салхитын Бор толгой	Цайр	21,314,330	13.6	1,568,461	4,856
Төмөртэйн овоо	Цайр	7,689,400	10.5	730,112	2,253
Цав	Цагаан тугалга	6,676,000	10.2	656,685	2,021
Навчit гол	Төмөр	33,272,220	15.2	2,190,440	6,719
Ширэн Овоо	Төмөр	27,700,000	14.5	1,909,105	5,838
Цахиур овоо	Төмөр	87,972,140	19.4	4,541,809	13,847
Дэлгэрхаан	Жонш	1,323,400	6.8	195,092	593
Маль	Жонш	1,902,000	7.4	256,081	776
Баруун сүүж	Жонш	1,219,190	6.6	183,452	554
Бүдүүн Ухaa	Жонш	193,640	4.2	46,155	139
Арын нуур	Зэс	37,223,900	15.6	2,382,794	7,156
Сүүл өндөр	Зэс	3,751,200	8.8	426,185	1,276
Мухар	Холимог	10,764,700	11.5	939,662	2,805
Улаан	Холимог	38,095,900	15.7	2,424,536	7,216
Эрдэнэ толгой	Холимог	10,881,850	11.5	947,321	2,811
Цагаан залаат	Нүүрс	1,141,000,000	36.8	31,040,895	91,566
Адуун чулуун	Нүүрс	423,800,000	28.7	14,768,647	43,310



Зураг 12 Зүүн бүсэд шинээр нэмэгдэх боломжтой уул уурхайн төслүүдийн тоо

БҮЛЭГ 2. УУЛ УУРХАЙН КОМПАНИУДЫН ХӨГЖЛИЙН СТРАТЕГИЙН ЗУРАГЛАЛЫГ ХАНГАХАД ЧИГЛЭГДСЭН ҮНЭЛГЭЭНИЙ АРГЫГ БОЛОВСРУУЛАХ

Дэлхий зах зээлийн бүтцээс хараад цаг үеэ дагаад аливаа бараа бүтээгдэхүүний чанар, стандартуудад тасралтгүй өөрчлөлт орж байна. Үүнтэй холбоотойгоор нэг талаас, уул уурхайн бүтээгдэхүүнд тавигдах шаардлагууд ч өөрчлөгдөж байгаа бол нөгөө талаас, ашигт малтмалын ордыг иж бүрэн ашиглах хуулийн заалтын дагуу баяжуулах үйлдвэрийн технологийн сайжруулалт байнга хийгдэнэ. Үүнийг бид төдийлөн анзаарагүй өнгөрч байна.

Тухайлбал, Ашигт малтмалын зах зээлийн үнийн өсөлтөөс шалтгаалан бага агуулга хүдэр, бохирдол ихтэй нүүрсний орд ашиглалтыг эдийн засгийн эргэлтэнд оруулахад баяжуулах үйлдвэрийн технологийн горимын оновчлол хийгдэхэд зардал, үр ашгийн хэмжээ шууд тооцогддог.

Нүүрсийг олборлоод шууд хэрэглэгчид хүргэдэг байсан бол өнөөдөр дэлхий нитийн асуудал болсон агаарын бохирдол, дэлхийн дулаараг, хүн амын эрүүл мэнд болон бусад хүчин зүйлтэй уялдуулах хэрэглэгчийн шаардлага гарсан. Мөн дэлхийн томоохон улс орнуудын хэрэглээний бүтэц өөрчлөгдсөнөөс хамаараад экспортын бүтээгдэхүүнд тавигдах шаардлагууд өөрчлөгдөж, эхэлж байна. Үүний цаана бид дэлхийн зах зээлд нийлүүлэх бүтээгдэхүүнээс олох орлогын хэмжээг бууруулахгүй байх үүднээс нүүрсийг зайлшгүй баяжуулах, улмаар боловсруулах шаардлага гарч ирж байгаа юм.

Зэсийн баяжмал дээр л гэхэд манай улс зах зээлээс үнэ хүлээн авагч гэдгийг мартах учиргүй. Үнэ бүтээгдэхүүний чанарт тулгуурлан тогтоно. Иймд бүтээгдэхүүний чанарыг борлуулах түвшинд хүргэж л борлуулалтын орлогыг хадгалах, ялангуяа экспортос орж ирэх валютын нөөцийг бүрдүүлэхэд манай салбар гол үүргээ гүйцэтгэнэ.

Баяжуулалтын техник технологийн дэвшил гэдэг нь ялангуяа ордын дундаж агуулгын бууралт, уул геологийн болон бусад үзүүлэлтүүд нь хүндэрч байгаа нөхцөлд баяжмалынхаа стандарт шаардлагыг хангах бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологийг тасралтгүй боловсруулж байх туршилт судалгааны ажлын үр дүнд гарч байдаг. Мөн ижил төстэй орд түшиглэсэн үйлдвэр ашиглалтад орж байгаа тохиолдолд, олон улсад шинээр бий болж байгаа дэвшилтэй технологийн хүрээнд бүтсэн тоног төхөөрөмжүүдийг шилжүүлэн нутагшуулахад онцгой анхаарах зайлшгүй шаардлага байна. Үүнийг алтны шороон ордын зарим энгийн технологитой хольж ойлгох нь зохисгүй.

Энд зардлыг хэмнэх, илүү өндөр үр ашигтай, байгаль орчинд аль болох сөрөг үр дагавар багатай, тогтвортой хөгжлийн зармыг баримталсан, техник тоног төхөөрөмжийг нутагшуулах шаардлага байнга тавигдана.

Ийм учраас МАМБХолбоо гадаад харилцааны тал дээр анхаарч, баяжуулагч инженерүүдийнхээ ур чадварыг дээшлүүлэх, техник – технологийн хөгжилтэй зэрэгцэн алхах бодлого барьж ажилласаар ирлээ.

2.1 Баяжуулах, боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх шаардлага

Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй зэсийн баяжуулах үйлдвэрүүд 0,2-1,0%-ийн анхдагч агуулгатай хүдрийг баяжуулан 19-23%-ийн агуулгатай зэсийн баяжмал буюу 8, 9-

р зэрэглэлийн баяжмалыг тогтмол экспортолдог. Катодын зэсийн үйлдвэрүүдийн хувьд 99,9995%-ийн зэс үйлдвэрлэж байна.

Хүснэгт 20 Зэсийн баяжмалын стандарт

Бүтээгдэхүүний зэрэг	Cu баагүй, %	Хольц нь ихгүй, %			
		Pb	Zn	MgO	As
1	30			5	0.3
2	29			5	0.3
3	28			5	0.3
4	27			5	0.3
5	26			5	0.3
6	25			5	0.3
7	24	6	9	5	0.4
8	23	6	9	5	0.4
9	22	6	9	5	0.4
10	21	6	9	5	0.4
11	20	6	9	5	0.4
12	18	7	10	5	0.5
13	16	7	10	5	0.5
14	14	8	10	5	Хэлэлцэж шийднэ
15	12	8	10	5	Хэлэлцэж шийднэ

Эдгээр баяжмалыг худалдан авах хэрэглэгч нь “Хайлах, цэвэршүүлэх үйлдвэр”. Бараа бүтээгдэхүүний өртөгт баагүй хувь эзлэх тээврийн зардал ашигт шууд нөлөөлнө. Иймээс ордын ашигт эрдэсийн зүй тогтол, түүний өөрчлөлт, хэрэглэгч хүртэлх газарзүйн байршил нь технологийн зардалд шууд нөлөө үзүүлэх үзүүлэлтүүдийн нэг болж байна.

Технологийн нөхцөлд одоо үйлдвэрлэж байгаа баяжмалын чанарыг бууруулах замаар металл авалтыг нэмэгдүүлэх, баяжмалын гарцыг өсгөх, дагалдах элементийн агуулгыг удирдах төрөл бүрийн асуудал бидний өмнө тулгарч байна. Энэ бүгдийг цогцоор шийдвэрлэх стратегийг цаг алдалгүй боловсруулж баримлах нь баяжуулах, боловсруулах үйлдвэрийн өхгжлийн чиг хандлагыг тодорхойлох гол баримт болно гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Үүний нэгэн адилaaар нүүрсний хэрэглээний чиг хандлагыг авч үзье. Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн тухай 2015 оны Парисын хэлэлцээрээс хойш дэлхийн улс орнууд нүүрсний талаар тус бүрдээ болон хамтарсан олон янзын шийдвэрүүд гаргажээ. Тухайлбал, Франц, Их Британи, АНУ, Итали, Герман, Япон, Канад зэрэг их долоогийн орнууд экологи, цаг уур, хүрээлэгч орчны сайд нарын 2021 оны 5 дугаар сарын 23-ны уулзалтаараа нүүрсийг түлшинд хэрэглэхээс татгалзахаар шийдвэрлэсэн байна [8].

Парисын гэрээгээр энэ зууны 20-иод оноос нүүрсийг эрчим хүчний гол эх үүсвэр байхыг хязгаарлаж, дэлхийн дулаарлын өсөлтийг 1.5°C байхаар тогтоосон нь эрчим хүчний эх үүсвэрийн бүтцийг өөрчилж хүлэмжийн хийн хэмжээг бууруулахын тулд нүүрсний хэрэглээг хязгаарлах шийдвэр болсон гэж үзэж байна.

Эрчим хүчний эх үүсвэрийн дэлхийн үйлдвэрлэлийн талаар Дэлхийн эрчим хүчний төв, олон улсын хавсрата болон системийн судалгааны институтын (WEC/IIASA) хамтын

судалгааны дүнгээр 2050 он гэхэд эрчим хүчний эх үүсвэрийг “Сэргээгдэх эрчим хүч” тэргүүлэх бөгөөд атомын станц удаалж, өнөө цаг үеийн гол эх үүсвэр болсон нүүрс 3-р байранд эрэмбэлэгдэхээр болжээ.

Хүснэгт 21 Эрчим хүчний хэрэглээний эх үүсвэрийн өөрчлөлт

№	Эрчим хүчний эх Үүсвэр	2020		2050	
		Эрэмбэ	Хэмжээ млр.т (жишигэл түлишээр)*	Эрэмбэ	Хэмжээ млр.т (жишигэл түлишээр)*
1.	Нүүрс	I-байр	4.5	III-байр	5.5
2.	Нефть	II-байр	3.7	IV-байр	2.0
3.	Байгалийн хий	III-байр	2.6	V-байр	1.8
4.	Атомын станц	IV-байр	2.4	II-байр	6.1
5.	Сэргээгдэх эрчим хүч	V-байр	2.1	I-байр	7.5
6.	Усан станц	VI-байр	1.1	VI-байр	1.2

* - 1 кг түлиний дулаан гаргах доод чадвар буюу илчлэг нь $Q_i^r = 7000$ ккал/кг=29,33 МДж/кг илчлэгтэй түли (MNS 5919 : 2008)

Эх сурвалж: П.Очирбат “Нүүрсний аж үйлдвэрийн тогтвортой хөгжлийн шинэ чиглэл”, 2022 он

Энэхүү судалгааны үр дүн нь Парисын гэрээний зарчимтай дүйж байгааг харж болно. Дэлхийн дулаарлыг бууруулна гэхээр нүүрсний ордуудыг эдийн засгийн эргэлтээс бүрэн гаргана гэсэн санаа огт байхгүй.

Энд шинээр бий болох эрчим хүчний хэрэглээний өсөлтийг тооцох шаардлагатай ба энэ нь дээрх хүснэгтэд үзүүлсэн жишигэл түлишээр илэрхийлсэн тоон дүнгээс тодорхой харагдаж байна.

Нэгэнт хэрэглээ өссөөр байх тохиолдолд нийлүүлэлт байхаас өөр гарцгүй. Харин шавхагдах нөөцийн хувьд, нэг талаас:

- хаягдал бохирдолтыг хамгийн бага хэмжээнд байлгах;
- олборлолтын явцад үүссэн хөрсний болон газрын хэвлийн эвдрэлийг нөхөн сэргээлтийн техникийн болон биологийн иж бүрэн системийн хүрээнд гүйцэтгэх;
- экотехнологийг үйлдвэрлэлийн дамжлага бүхэнд нэвтрүүлэх;
- уурхайчдын экологийн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх;
- нүүрсний чанарыг дээшлүүлж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг арилгахад чиглэгдэх болно [8].

Нөгөө талаас байгаль орчны бохирдолтыг бууруулах, хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй дэлхийн дулаарлын эсрэг авах арга хэмжээний хүрээнд хэрэглээний стандарт шаардлагад томоохон өөрчлөлт гарч байна.

Үүнийг тогтвортой хөгжлийн хоёрдох үндсэн чиглэл гэж үзэж, цахилгаан дулааны үйлдвэрлэлийн эх үүсвэр болгон хэрэглэхдээ анхдагч нүүрсийг баяжуулах, боловсруулах технологийг боловсронгуй замаар хүлэмжийн хий нэмэгдүүлэх гол хольцыг бууруулах шаардлага үүссэн.


Иймд манай орны хувьд анхдагч нүүрсийг шууд хэрэглэх, экспортлох нь орд ашиглалтын үр ашигтай хувилбар байх боломжийг хязгаарлаж байгаа тул аливаа төслийн хөрөнгө оруулагчид олон улсын стандартад нийцсэн техник- технологийн түвшинд судалгаа хийж, эрсдэлээ бууруулах шаардлага үүсч байна.

Энэ судалгааг төмрийн хүдрийн болон жоншны ордыг түшиглэн хийж болох бөгөөд төмрийн хүдрийн хувьд доктор Я.Батцэцэгийн “Монгол Улсад уул-төмөрлөгийн цогцолбор төлөвшүүлэх чиг баримтлал” нэг сэдэвт бүтээлээс зарим үр дүнг дэлгэрэнгүй харж болно [3].

2.2 Уул уурхайн үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлэх боломж

Олон улсын туршлагаас харахад эдийн засгийн аливаа салбар болон салбар дундын харилцан уялдаа бүхий хэсгүүдийг хөгжүүлэх нэгэн бодлого нь энэхүү эдийн засгийн бөөгнөрөл үүсгэх явдал болсон байна [18]. Үүний тулд тусгайлан газар нутгийн хил хязгаар дэд бүтцийг шийдвэрлэх, ажиллах хүчиний урьдчилсан тооцоо, хүн амын төвлөрөл болон бараа бүтээгдэхүүний эдийн засгийн эргэлтийг цогцоор нь төлөвлөж хийсэн сайн үр дүнгүүд олон гарчээ.

Эцсийн үр дүн нь “нийгэм – эдийн засаг”-ийн үр ашиг боловч тогтвортой хөгжлийн нөхцөлд байгаль орчны асуудлыг орхигдуулахгүй байх зарчмыг хадгална. Иймээс уул уурхайн төслийн үр ашгийг дараах зурагт үзүүлснээр схемчлэн хэрэгжүүлж болно.



Зураг 13 Уул уурхайн төслийн төлөвлөлт, хэрэгжилт

Уул уурхайн нэгэн томоохон төслийг түшиглэн эдийн засгийн бөөгнөрлийг үүсгэх боломжийг дэвшүүлэхдээ нэн тэргүүнд өөрсдийн туршлагадаа тулгуурлан кластерын талаар гаргасан улс орнуудын тодорхойлолтоос авч үзье. Үүнд: "...Кластер нь маш чухал ур чадварыг бий болгодог бөгөөд энэ нь үзэл бодол, арга техник солилцдог хүмүүсийг холбох нь чухал гэсэн уг. Харилцан уялдаатай салбарт ажиллаж байхдаа санал солилцож, ажлын байраа нэгээс нөгөөд шилжүүлэх, эсвэл өөрсдөө бизнес эрхлэх боломжийг нь олгосноор эдийн засгийн бөөгнөрөл үүсгэж, өсч хөгжиж чадна гэсэн уг...." хэмээн үздэг байна.

Энэ агуулгыг хангах кластерийг Зэсийн уурхайг түшилэн байгуулах талаар авч үзэхэд, “кластер дотор пүүс, ханган нийлүүлэгч, үйлчлүүлэгчид хэр зэрэг холбогдсон, кластерийн чиг баримжаа нь гадаадаас худалдан авдаг бүтээгдэхүүн үйлчилгээг орлох, баяжмалыг боловсруулж экспортийн бүтээгдэхүүний нэр төрлийг өсгөх гэсэн үзэл баримтлалд шууд нийцэж байна”.

Үүнийг дагаад “шинжлэх ухаан-үйлдвэрлэл”-ийн уялдааг хангах, тусгайлан хил хязгаарыг тогтоосон бүсэд эдийн засгийн бөөгнөрөл үүсгэх, газарзүйн төвлөрлөөс үүдэлтэй өртөг буурах эдийн засгийн үйл ажиллагааг бий болгох боломж бүрдэхээр байна (2-р зураг). Үйлдвэрлэл технологийн парк хэлбэрээр нэмж хэрэгжүүлэх төслүүдээс шалтгаалан энэхүү загварыг өргөжүүлэх боломжтой юм. Энд зэсийн ордыг түшиглэсэн эдийн засгийн бөөгнөрөлийг үүсгэснээр, бүтээгдэхүүний нөр төрөл өсөх, нэгж бүтээгдэхүүний өөрийн өртөг буурах, үйлдвэрлэлийн үр ашиг нэмэгдүүлэх боломжтой гэдгийг тухайн төслийг гүйцэтгэсэн судалгааны баг тогтоосон болно [17].



Зураг 14“Уул уурхай - металлурги - химийн үйлдвэрийн цогцолбор”
үйлдвэрлэл технологийн паркийг кластерины загвар

Үүний нэгэн адил уул уурхай хөгжсөн бүс нутагт шинээр хөгжүүлэх боломжтой баяжуулах, боловсруулах үйлдвэрийн төслүүдийг түшиглэн бизнесийн таатай орчин бүрдүүлж болохоор байна. Энэ тохиолдолд Монгол Улсын их хурлаар 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдөр баталсан “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай” хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан хөнгөлөлтийг эдлэх боломж бүрдэнэ.

2.3 Баяжуулах, боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх стратеги

Дээрх судалгаануудаас харахад Монгол Улс ашигт малтмал баяжуулах, боловсруулах салбартаа урт хугацааны стратеги төлөвлөгөөг салбар дундын өргөн хүрээнд авч хэрэгжүүлснээр дараах давуу тал үүсэх боломжтой юм. Үүнд:

1. Одын ашиглалтыг сайжруулах,
2. Технологийн хувьд цаг хугацаа хожих,
3. Төслийн хөрөнгө, оруулалтын эрсдэлийг удирдах
4. Хүний нөөцийн эрэлт хэрэгцээг урьдчилан таамаглаж, бэлтгэх,
5. Төслийн орлого бүрдүүлэх үндсэн чиг баримжааг тогтоох
6. Эдийн засгийн үр ашигийг бодитой үнэлэх гэх мэт.

Эдгээр давуу талыг буй болгох дараах стратегийн загваруудыг жишээ болгон боловсрууллаа. Үүний тулд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100

дугаар тушаалаар баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ыг удирдлага болгосон.

Тус аргачлалд “Стратегийн зорилго нь: орчны шинжилгээний үр дүнд тулгуурлан стратегийн зорилгыг тодорхойлно. Стратегийн зорилго нь ирээдүйд хүрэх үр дүн юм. Өөрөөр хэлбэл, салбар болон засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, байгууллагын нөхцөл байдлыг тодорхойлсны дараа ирээдүйд хүрэх үр дүнгээ урьдчилан харж хамгийн оновчтой арга замыг зорилго болгон томъёолно.” гэж заасан.

Иймээс манай баяжуулах боловсруулах салбарын стратегийг урьдчилсан байдлаар тодорхойлж, дараах зурагт үзүүллээ.

A. Зэс - молибдений орд ашиглах стратегийн зураглал.

Энэхүү зураглалыг өндөр хөгжилтэй аливаа улс орнуудын үйлдвэржилтийн бодлого, хэрэгжилтийг эш болгосон бөгөөд дотоодын эрдэмтдийн хийж гүйцэтгэсэн ажлын үр дүнг үндэслэн, Монгол Улсын хууль эрхзүйн орчинг баримтлан судлаачдын зүгээс боловсруулсан болно.

Зураг 15 Зэс –молибдений орд ашиглах стратеги



Урт хугацаанд ашиглагдах зөвхөн нэг ордыг түшиглэн хүнд үйлдвэрлэлийн томоохон цогцолбор хөгжүүлэх боломжтойг 1998 онд академич П.Очирбат “Эрдэс баялагийн цогцолборын тогтвортой хөгжил ба экологи” бүтээлдээ тусгасан нь эдүгээ биеллээ олж байна. Судалгааны ажлын үнэ цэнийг цаг хугацааны хэмжүүрээр илэрхийлсэн бодит байдлыг эндээс харж болно.

Ийнхүү орд газрыг цогцолбоор хөгжүүлэх чиг хандлага нь баяжуулах боловсруулах үйлдвэрийн оролцоог нэн тэргүүнд тодорхойлох үндсэн хүчин зүйл болно.

B. Нүүрсний орд ашиглах стратегийн зураглал


Нүүрсний салбарын хөгжлийн хувьд, технологи дамжуулж, “түлш - эрчим хүч” гэсэн цогцолбороос “нүүрс - химийн цогцолбор” -т шилжин хөгжүүлэх шинэ хандлагыг нэн даруй боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай болжээ. Энэ нь дэлхийн эрчим хүчний эх үүсвэрийн шинэ хандлагаас багагүй шатгаалж байна.

Өөрөөр хэлбэл, манай улсын хөрөнгө оруулагчид, шинээр бий болж байгаа зах зээлийн эрэлд цаг алдалгүй гарч, технологи дамжуулан нутагшуулах, “ордыг иж бүрэн ашиглах” хуулийн заалтыг хангаж ажиллах, улсын хэмжээнд дэвшүүлээд байгаа “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого” зэрэг эрхзүйн баримт бичгүүдийг амьдралд хэрэгжүүлэх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэхэд өрсөлдөх чадвараа дээшлүүлэн ажиллах хэрэгцээ, шаардлага гараад тодорхой хугацаа өнгөрлөө.

Иймд судлаачдын зүгээс өнөөгийн дотоод нөөц бололцоо, суурь нөхцөлдөө тулгуурлан, ойрын таван жилд анхдагч нүүрсийг баяжуулж, боловсруулснаар химийн салбарын түүхий эдийг бэлтгэх замаар олон улсын зах зээлд өрсөлдөх нэгэн боломж гарч ирнэ гэж үзэж байна.

Үүний тулд хэрэглэгчийн стандартыг үндэслэл болгон анхдагч нүүрсийг эдийн засгийн эргэлтэнд оруулах дөрвөн хувилбарыг дэвшүүлж байна. Үүнд:

Зураг 16 Нүүрсийг эдийн засгийн эргэлтэнд оруулах боломжит хувилбарууд (богино



Үүнд:

1. Анхдагч нүүрсийг шууд борлуулах. Тухайн ордын нүүрсний чанар хэрэглэгчийн шаардлагыг бүрэн хангаж байгаа тохиолдолд шууд борлуулалт хийж болох боловч энэ нь төдийлөн олон орд, ордын нийт нөөцөд тохиохгүй байна.
2. Анхдагч нүүрсийг баяжуулах. Ихэнх ордын хувьд нүүрсийг баяжуулж, технологийн үзүүлэлтийг сайжруулах шаардлагатай байдаг. Ялангуяа нүүрсний давхаргуудын дунд хоосон чулуулгийн үе ихээр агуулж байгаа тохиолдолд ордыг үр ашигтай ашиглах гол шийдэл нь баяжуулах юм. Баяжуулах үйлдвэрийг барихын тулд дэд бүтцийг сайтар тооцоолох шаардлагатай.
3. Анхдагч нүүрсийг баяжуулах, боловсруулах. Баяжуулах үйлдвэрээс гарсан нүүрсний баяжмалыг дулааны боловсруулалт хийх замаар экспортын бүтээгдэхүүний нэр төрлийг өсгөх, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж байна. Тухайлбал, хэрэглээнээс нь хамааруулан:
 - металлурги,
 - сайжруулсан ган боловсруулах,
 - металл боловсруулах үе шатны коксыг үйлдвэрлэж болно.

Коксжуулалтын явцад ялгаран гарах дайвар бүтээгдэхүүнүүд (нүүрсний хий, давирхай, хүхэр, бензол гэх мэт) бүгд химийн үйлдвэрийн түүхий эд болохын хувьд зах зээлээ зөв тодорхойлж чадсан нөхцөлд эдийн засгийн үр өгөөжийг бий болгох боломжит хувилбар юм.


4. Хамтран ажиллах. Хөрөнгө оруулагчид, төсөл хэрэгжүүлж буй ордын нүүрсний шинж чанарыг нарийвчлан судалж, шаардлагатай тохиолдолд зохистой харьцаагаар (жишээ нь: илчлэг багатай ч хорт холцын агуулгагүй нүүрсийг стандартаас давсан хорьт холцын агуулгатай, өндөр илчлэгтэй нүүрстэй хольж, техникийн үзүүлэлтийг дундачлах гэх мэт) холих замаар хэрэглэгчид хүрэх нүүрсийг бэлтгэх боломж өндөр байна.

Дээрх шийдлүүдээс харахад “нүүрс-химийн үйлдвэрлэл” хөгжүүлэх үндэс нэгэнт бий болсон гэж дүгнэлээ.

Иймд манай улсын хувьд экспортын бүтээгдэхүүний нэр, төрлийг нэмэгдүүлж, чанарыг сайжруулахын зэрэгцээ импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд үйл ажиллагаагаа төвлөрүүлэх нь илүү үр дүнтэй байж болох юм.

Үүний тулд бидний зүгээс нүүрсний сав газар бүхий бүс нутгуудад баримтлаж болох Нүүрс-химиийн үйлдвэрлэлийг цогцолбороор хөгжүүлэх зураглал”-ыг боловсрууллаа.

Зураг 17 Нүүрс-химиийн үйлдвэрлэлийг цогцолбороор хөгжүүлэх зураглал



Энэхүү зураглал нь нүүрс-химиийн үйлдвэрийг Монголд хөгжүүлэх цорын ганц шийдэл биш бөгөөд практик үйл ажиллагааны үр ашиг болон энэхүү цогцолборт хамааруулж болох төслийн үр өгөөжтэй уялдуулан судалгааны ажлыг үргэлжлүүлж байгаа болно.

2.4 Эрдсийн түүхий эдийг иж бүрэн ашиглах диверсификациийн хэтийн төлөвийн үнэлгээ (“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын жишээн дээр)

2.4.1 Уул уурхай, боловсруулах үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөр (диверсификац)-ийг төлөвлөхдөө инновацид чиглэсэн төрөлжүүлэх алгоритмыг хэрэглэх

Төрөлжүүлэх сэдэл, нөхцөлийг тодорхойлох. Зэсийн зах зээлийн салбарын загварт дүн шинжилгээ хийсний үндсэн дээр “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг төрөлжүүлэх гадны хөшүүргийг тодорхойлсон. Зах зээлийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлдог хүчин зүйлүүдийн нийлбэрээр дэлхийн эдийн засгийн ерөнхий нөхцөл байдал (хөгжлийн хурд буурах, хямрал), түүнчлэн улс орон, бус нутгийн эдийн засгийн хөгжлийн чиг хандлагыг харж болно.

Түүнчлэн өнгөт металлургийн нэгдлийн үйл явц (зах зээлд шинээр томоохон оролцогчид бий болох), шинэлэг технологи нэвтрүүлэх гэх мэт үйл явцыг анхаарч үзэх хэрэгтэй. Сүүлийн хэдэн жилд Rio Tinto групп, BHP групп нэгдэж шинээр уул уурхайн том компани Glencore Xstrata Plc гарч ирсэн бөгөөд энэ нь тухайн салбartaа дэлхийд 4-р байранд орж байна. Үүний зэрэгцээ уул уурхай, боловсруулах томоохон компаниуд (түүний дотор Rio Tinto) хөрөнгөө хэсэгчлэн зарж шинэ төслүүд дээр ажиллаж байгаа бөгөөд босгосон хөрөнгийг бүрэн хүчин чадлаараа ажиллуулж байна. Тухайлбал 750 мянган тн үйлдвэрлэлийн хүчин чадалтай Grasburgийн уурхай (Индонез) 2013 оны 2-р улиралд тоног төхөөрөмжийн эвдрэлийн улмаас түр зогссон.

Энэ түүх Замби дахь Конколагийн зэсийн уурхай (жилд 380 мянган тонн), Перугийн Antarcassay (жилд 160 мянган тонн) уурхайд давтагдсан байдаг. “Туркайз Хилл Ресурс” компани Оюутолгой төслийг (жилд 450 мянган тонн үйлдвэрлэлийн хүчин чадалтай) ашиглалтад оруулснаар Монголын үйлдвэрлэл нэмэгдэнэ. Чили дэх зэсийн үйлдвэрлэлийг жилд 170 мянган тонн хүчин чадалтай Mina Ministro Hales (Codelco), 180 мянган тонн Caserones уурхай (Pan Pacific Copper), 227 мянган тонн Сьерра Горда уурхай (KGHM - Сумитомо консорциум) зэрэг төслүүдээр нэмэгдүүлэх боломжтой.

Дээрх төслүүдээс гадна Замби, Конго, Мексикт цэвэршуулсэн зэс үйлдвэрлэх шинэ байгууламжуудыг ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. Дараах хүснэгтэд өрсөлдөөний орчинд дүн шинжилгээ хийх салбарын загварыг үзүүлэв.

**Хүснэгт 22 Өрсөлдөөнт орчны шинжилгээний үр дүнгийн салбарын загвар
(зэсийн олборлолт, боловсруулах үйлдвэр)**

Параметр, тэдгээрийн шинж чанар	Стратегийн ач холбогдол	
Үйлдвэрийн эдийн засгийн үндсэн шинж чанарууд		
Молибдены тусгай бүтээгдэхүүн	мян.тн	0	0,01	0,03	0,04	0,05	0,05	0,05	0,05	0,05	0,05	0,05	0,43
Аммоны принитрат дахь рени	мян.тн	0	0,44	0,89	1,18	1,33	1,41	1,41	1,41	1,41	1,41	1,41	12,31
Зэсийн гулдмай	мян.тн	0	0	0	50	50	50	50	50	50	50	50	400
Мөнгөний хлорид	мян.унц	0	0	0	645	643	651	655	578	579	581	581	4914
Катодын зэс	мян.тн	0	0	0	0	30	30	30	30	30	30	30	210
Дулааны хангамж	мян.Гкал	0	0	0	19	19	19	19	19	19	19	19	149
1 тн хүдэр олборлох өөрийн өртөг	дол/тн	1,18	1,38	1,32	1,33	1,31	1,26	1,23	1,24	1,21	1,24	1,29	1,27
БҮ-т 1 нт хүдэр боловсруулах өөрийн өртөг	дол/тн	3,42	3,57	3,65	3,45	3,41	3,32	3,28	3,28	3,28	3,28	3,24	3,38
Хөрөнгө оруулалт	мян.дол	55114	88367	240473	94930	13643	9971	3458	6994	11086	6037	4131	534204
Борлуулалтын орлого	мян.дол	380284	360155	350025	427541	480520	407455	402333	401301	400241	399456	399456	4408768
Үйл ажиллагааны нийт зардал	мян.дол	175502	189546	196047	224373	247442	239804	237338	237453	236784	237131	236904	2458323

Цэвэр ашиг Цэвэр мөнгөн урсгал (NCF)	мян.дол мян.дол	143360 94377	121607 50532	110664 -	160445 104600	189336 218600	141059 173815	138780 176633	137524 172034	129748 160152	125444 161095	125603 163673	1523569 1523569
--------------------------------------------	--------------------	-----------------	-----------------	-------------	------------------	------------------	------------------	------------------	------------------	------------------	------------------	------------------	--------------------

Хүснэгт 40 Төрөлжүүлэх хөтөлбөрийн үр ашгийн нэгдсэн үзүүлэлт

Янз бүрийн хүчин зүйлийн өөрчлөлтөөс хамаарч төрөлжүүлэх хөтөлбөрийн төслүүдийн өгөөжийн (өнөөгийн цэвэр үнэ цэнэ ба дотоод өгөөжийн түвшин) үзүүлэлтүүд эрсдлийн шинжилгээтэй хамааралтай болохыг харуулсан. Таваарын бүтээгдэхүүний үнэ, хөрөнгө оруулалт болон ашиглалтын зардал, үйлдвэрлэлийн хэмжээг хүчин зүйлсийг нөлөөлөл болгон авсан.

1. Ил уурхайгаас хүдэр тээвэрлэхдээ мөчлөгт урсгалын технологи ашиглах үед зэсийн агуулга 0.35%, уурхайн гүн +1040 м, хүдэр боловсруулах үйлдвэрийн хүчин чадал жилд 25.2 сая тонн байна.

Төсөл гадны хүчин зүйлсэд мэдрэмтгий байдалд дүн шинжилгээ хийхэд дараахь үзүүлэлтүүдийг харуулав.

- үйлдвэрлэлийн хэмжээ буурах, ашиглалтын зардал нэмэгдэхэд төслийн тогтвортой байдлын түвшин нэлээд өндөр байна. Үйлдвэрлэлийн хэмжээ 35%-иар буурч, ашиглалтын зардал 54%-иар өсөхөд үзүүлэлтүүд эерэг хэвээр байна.
- үнийн түвшинг бууруулснаар хөрөнгө оруулалтын зардлын өгөөжид үзүүлэх нөлөө илүү өндөр байна. Бүтээгдэхүүний үнэ 21% -иас дээш буурахад хөнгөлөлтүүд сөрөг нөлөөтэй байна.

 2. Цаашид уусгалтын аргаар ядуу хүдэр, зэсийн баяжмалыг уусган катодын зэс үйлдвэрлэх үйлдвэр байгуулахад.

Дараах хүчин зүйлсийн аль нэг нь өөрчлөгдөхөд өнөөгийн цэвэр үнэ цэнэ (NPV) эерэг байх ба дотоод өгөөжийн түвшин (IRR) 8%-иас их байна.

- үйлдвэрлэлийн хэмжээ 17% -иар буурсан;
 - катодын зэсийн үнийг 4 хувиар бууруулах;
 - ашиглалтын зардлыг 6% -иар нэмэгдүүлэх;
 - хөрөнгө оруулалтын зардлыг 27 хувиар нэмэгдүүлэх.
3. "Hydrocopper" технологиор зэсийн баяжмал үйлдвэрлэх үйлдвэр байгуулахад
Төслийн гадны хүчин зүйлсийн мэдрэмтгий байдал буурахад дараахь зүйлийг харуулав.
 - үйлдвэрлэлийн хэмжээ буурах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд төслийн тогтвортой байдал нэлээд өндөр байна. Үйлдвэрлэлийн хэмжээ 38%-иар буурахад эсвэл хөрөнгө оруулалт 80%-иар өссөхөд боломжит хөнгөлөлтүүд эерэг хэвээр байна;
 - үнийн бууралт болон ашиглалтын зардал өндөр байгаа нь хөрөнгө оруулалтын зардлын үр ашигт үзүүлэх нөлөөлөл өндөр байна. Бүтээгдэхүүний үнэ 10% -иас дээш буурах эсвэл үйл ажиллагааны зардал 14% -иас дээш өсөхөд хөнгөлөлтүүд сөрөг болно.
 4. Молибдений баяжмал боловсруулах үйлдвэр байгуулахад.
Дараах хүчин зүйлсийн аль нэг нь өөрчлөгдөхөд өнөөгийн цэвэр үнэ цэнэ (NPV) эерэг хэвээр байх ба дотоод өгөөжийн түвшин (IRR) 8%-иас их байна.
 - үйлдвэрлэлийн хэмжээ 58%-иар буурсан.
 - молибдений оксидын үнэ 16 хувиар буурсан.
 - үйл ажиллагааны зардал 23%-иар нэмэгдсэн.
 - хөрөнгө оруулалтын зардал 181%-иар өссөн.
 5. Зэсийн агуулга 0.35%, ил уурхайн гүн +1040 м, хүдэр баяжуулах үйлдвэрийн хүчин чадал жилд 25.2 сая тонн, ил уурхайгаас хүдэр тээвэрлэхдээ мөчлөгт урсгалын

технологи ашиглах, зэс гулдмай, катодын зэсийн үйлдвэр болон молибдений үйлдвэр барихад (сонголт 1.2.M3T nar).

Төсөл гадны хүчин зүйлсийн нөлөөлөлийн мэдрэг байдалд дүн шинжилгээ хийхэд дараахь байдлыг харуулав.

- Төслийн тогтвортой байдлын түвшин нь ашиглалтын зардал болон хөрөнгө оруулалтын зардал нэмэгдэхэд өндөр байна. Түүнээс гадна үйлдвэрлэлийн хэмжээ буурахад нэлээд өндөр байна. Үйл ажиллагааны зардал 69% -иас дээш өссөн эсвэл үйлдвэрлэлийн хэмжээ 38% -иас дээш буурсан тохиолдолд хөнгөлөлт эерэг хэвээр байна;
- үнийн түвшин буурахад хөрөнгө оруулалтын зардлын үр ашигт үзүүлэх нөлөө өндөр байна. Бүтээгдэхүүний үнэ 24% -иас дээш буурахад хөнгөлөлтийн хэмжээ сөрөг байна.

6. Дулааны станцын өнөөгийн байдал

Дараах хүчин зүйлсийн аль нэг нь өөрчлөгдөхөд өнөөгийн цэвэр үнэ цэнэ (NPV) эерэг хэвээр байх ба дотоод өгөөжийн түвшин (IRR) 8%-иас их байна.

- үйлдвэрлэлийн хэмжээ 23% -иар өссөн;
- дулааны эрчим хүчиний үнийг 5 хувиар нэмэгдүүлэх
- ашиглалтын зардлыг 6%-иар бууруулах.

7. Дулааны станцыг өргөтгөх

Төслийн гадны хүчин зүйлсийн нөлөөлөлд мэдрэмтгий эсэхэд дүн шинжилгээ хийхэд дараахь зүйлийг харуулав.

- Төслийн тогтвортой байдлын түвшин нь ашиглалтын зардал, хөрөнгө оруулалт нэмэгдэх, түүнчлэн үйлдвэрлэлийн хэмжээ буурахад нэлээд өндөр байна. Үйл ажиллагааны зардал 33% -иас дээш өссөн, хөрөнгө оруулалт 81% -иар өссөн, үйлдвэрлэлийн хэмжээ 31% -иас дээш буурсан тохиолдолд хөнгөлөлт эерэг хэвээр байна;
 - үнийн түвшин буурах нь хөрөнгө оруулалтын зардлын үр ашигт үзүүлэх нөлөө – өндөр байна. Бүтээгдэхүүний үнэ 16% -иас дээш буурахад хөнгөлөлтийн хэмжээ хасах болно.
8. Зэсийн агуулга 0,35%, ил уурхайн гүн +1040 м, хүдэр баяжуулах үйлдвэрийн хүчин чадал жилд 25,2 сая тонн, ил уурхайгаас хүдэр тээвэрлэхэд мөчлөгт урсгалын технологи ашиглах, зэс гулдмай, катодын зэсийн үйлдвэр барих, зэс молибдений үйлдвэр, түүнчлэн одоо байгаа дулааны цахилгаан станцыг өргөтгөх (хувилбар 1.2.M3T TS).

Дараах хүчин зүйлсийн аль нэг нь өөрчлөгдөхөд төслийн гадаад болон дотоод хүчин зүйлсийн мэдрэмтгий байдалд дүн шинжилгээ хийхэд:

- үйл ажиллагааны зардлыг 75% -иас дээш нэмэгдсэн;
- үйлдвэрлэлийн хэмжээ 39%-иар буурсан.
- Бүтээгдэхүүний үнэ 25-аас дээш хувиар буурсан.

Хөтөлбөрийн удирдлага болон техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлох (3-р шат)

Төслийн аргаар хөтөлбөрийг үндэслэл, үр ашгийг бүрдүүлэхийн тулд энэ үе шатанд дараахь ажлуудыг шийдвэрлэх шаардлагатай.

- хөтөлбөрийг удирдах үйл явц, үйл ажиллагааг тодорхойлох;
- хөтөлбөрийн багийг бүрдүүлэх;

- хөтөлбөрийн техникийн хэрэгслийг тодорхойлох.

Төслийн аргыг хэрэгжүүлэхдээ компани хэд хэдэн үйл явцыг боловсруулах шаардлагатай. Эхлээд төслийн эхний шатнаас дараагийн шат руу шилжүүлэх үйл явцыг боловсруулах нь оновчтой.

Төслийн үе шатнаас дараагийн шатруу шилжих үйл явц

Тодорхой үе шатанд төлөвлөсөн ажлууд дууссаны дараа төслийн үр дүнгийн биелэлтэд шинжилгээ, бие даасан шалгалт хийх шаардлагатай. Үнэлгээ нь ихэвчлэн гурван үндсэн үе шатыг агуулдаг.

1. Төслийн танилцуулга: шинжээч нар аудит эхлэхийн өмнө хэрэгжилтийн төлөвлөгөө, эрсдэлийн бүртгэл, төслийн зохион байгуулалт, зардлын тооцоо болон календарьчилсэн төлөвлөгөө, төслийн үйл явц гэх мэттэй танилцана.
2. Төслийн багтай ажлын уулзалт хийх: Шинжээчдийн бүрэлдэхүүнд багтсан төрөл бүрийн чиг үүргийн төлөөлөгчид төслийн багийнхантай уулзаж, нарийвчилсан хэлэлцүүлэг хийнэ. Багууд шийдвэрлэх шаардлагатай ажлууд, тэдгээрийг эрэмбэлэн ажлуудаа тодорхойлдог.
3. Тайланг бүрдүүлэх: шалгалтын үр дүнд үндэслэн тайлан болон залруулах төлөвлөгөө боловсруулна. Бэлтгэсэн тайлан нь үйл ажиллагааны тодорхой төлөвлөгөөг батлахад хэрэгтэй.

Энэхүү шалгалтын үр дүнд үндэслэн мэдээллийн багцыг бүрдүүлсэн бөгөөд зорилго нь төслийг дараагийн шатанд шилжүүлэх эсвэл дуусган менежментийн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахын тулд бүх чиг үүргийн ажлын үр дүнг нэгтгэх явдал юм.

Үйлдвэрийн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах үйл явцыг төлөвлөх гол орц нь хөрөнгийг тогтоосон шаардлагын дагуу ашиглах тухай нэг буюу хэд хэдэн шийдвэрийн агуулгын тодорхойлолт, бизнесийн стратеги, зорилгын тодорхойлолт, бизнесийн шийдвэр гаргах бодлого юм.

Төлөвлөгөөний баг үйл явцын орц, шалгуур үзүүлэлтүүдийн үнэлгээнд үндэслэн дараагийн үе шатуудад зориулсан ажиллах хүч, үйл ажиллагаа, нөөц, арга хэрэгслийг тодорхойлдог.

Өмнө нь боловсруулсан загварууд нь одоогийн төсөлд тохирсон байдаг бөгөөд тэдгээрийг дахин ашиглах боломжтой. Хэрэв төсөл нь тусдаа загвар боловсруулах шаардлагатай бол ийм загварчлалын нөөц нь ихэнхдээ чухал байдаг.

Шинэ програм хангамж, загваруудыг боловсруулж нэвтрүүлэх нь цаг хугацаа их шаарддаг.

Шинжээчийн баг, бүтцийн нэгжийн удирдлагатай зөвшилцөн үйл явцын дэлгэрэнгүй тодорхойлсон баримт бичиг нь төлөвлөлтийн үе шатны гарц юм. Үүнд:

1. Үйл явц (жишээлбэл: зорилго, шалгуур үзүүлэлт, арга, таамаглал гэх мэт);
2. Оролцогч талуудын ашиг сонирхол, стратеги, нөөц болон шийдвэр гаргах бодлогод тусгагдаагүй бусад асуудал;
3. Шинжилгээний үйл явцын нэг хэсэг болон ороогүй хэсгүүд;
4. Шинжээчдийн хянах боломжтой болон боломжгүй, өөрчлөх хэсгүүд

Компани нь хөрөнгө оруулалтыг төлөвлөх үйл ажиллагаа дотоод журамтай ба стандарт болох бүрэн боломжтой.

Ийм тохиолдолд туршлага дээр тулгуурлан хамгийн зөв шийдвэр гаргах нь ойлгомжтой. Энэ тохиолдолд үйл явц нь шийдвэр гаргах, баримтжуулах, мэдээлэх үе шатуудад хурдан шилжинэ.

Төслийн хөтөлбөрийн менежментийг ихэвчлэн хөтөлбөрийн удирдлагын баг тодорхойлдог. Үйлдвэрийн нэгжийн зохион байгуулалтын бүтэц нь технологийн болон бизнесийн үйл явцын дагуу баригдсан бөгөөд зах зээл дэх үйл ажиллагааны орчин үеийн нөхцөл, аж ахуйн нэгжийн зорилго, зорилт, хамрах хүрээтэй нийцдэг. Шинээр баригдах үйлдвэрүүдийн хяналтыг Хөгжлийн хэлтэс хариуцана.

Бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг хариуцдаг үндсэн бүтцийн нэгжүүд нь:

- Үйлдвэрлэл, техникийн хэлтэс (ерөнхий захирлын үйлдвэрлэл эрхэлсэн орлогчид харьяалагддаг),
- Худалдааны хэлтэс (ерөнхий захирлын Эдийн засаг эрхэлсэн орлогчид харьяалагддаг).

Үйлдвэрлэл, техникийн хэлтсийн үндсэн чиг үүрэг нь зах зээлд нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, шинэ төрлийн тоног төхөөрөмж, технологи, материал, эрчим хүчний нөөцийг нэвтрүүлэх, ашиглах гэх мэт бүтцийн нэгжийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах явдал юм.

Худалдааны хэлтэс нь зах зээлийн нөхцөл байдлыг үнэлэх, түүний хөгжлийн чиг хандлагын талаархи урьдчилсан мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, түншүүдтэй шууд харилцаа тогтоох, тэдэнтэй гэрээний нөхцлийг тохиролцох гэх мэт компанийн бүтээгдэхүүний экспортыг хариуцан ажилладаг.

Иймд төслийн аргыг ашиглах нь төслийн менежментийн багийг бүрдүүлэх, зохих техникийн хэрэгслийг ашиглах үндэслэл, хөтөлбөрийг удирдах үйл явц, журмыг тодорхойлох боломжийг олгодог.

Хөтөлбөр болон үйлдвэрлэлийн үйл ажиллагааг бүхэлд нь удирдах техникийн гол хэрэгсэл бол автоматжуулсан хяналтын систем юм. “Эрдэнэт үйлдвэр” хэдэн жилийн турш автоматжуулсан хяналтын системд хөрөнгө оруулалт хийсээр ирсэн.

Цаашид автомат удирдлагын системийг хөгжүүлэх нь харилцаа холбооны систем, өгөгдөл дамжуулах, харилцаа холбоог хослуулсан үйлдвэрлэлийн корпорацийн сүлжээг бий болгоход оршино.

Мэдээллийн технологи, харилцаа холбооны технологийн хөгжлийн өнөөгийн түвшин нь эдгээр чиглэлүүдийг нэгтгэх боломжийг олгож байгаа нь аж ахуйн нэгжийн зохион байгуулалт, техникийн түвшинг дээшлүүлэх, утас, факс үйлчилгээний өртөгийг бууруулах боломжтой.

Харилцаа холбоог хөгжүүлэхийн тулд шилэн кабелийн технологид суурилсан холбооны систем, өгөгдөл дамжуулах, харилцаа холбооны системийг иж бүрэн шинэчлэх; мэдээллийн сүлжээ, харилцаа холбооны техникийн нэгдмэл байдал; IP-телефоныг нэвтрүүлэх, интернет технологид суурилсан олон улсын телефон холбооны зохион байгуулалт; "Сэлэнгэ" чиглэлд харилцаа холбооны хэрэгслийг шинэчлэх; МТС модультай ERA Financials нягтлан бодох бүртгэлийн системийг нэвтрүүлэх, цаашлаад шинэ хувилбарууд гарах үед системийг шинэчлэх; экспортын үйл ажиллагаанд дэд системийг нэвтрүүлэх; мэдээллийн технологийн нэгдсэн стандартыг боловсруулж хэрэгжүүлэх; тусгай утасны харилцаа холбоог нэвтрүүлэх; ““Эрдэнэт үйлдвэр”"-ийн дотоод сүлжээнд олон улсын харилцаа холбоо бүхий "Интернет-конференц" системийг нэвтрүүлэх; эдийн засаг санхүүгийн үйл ажиллагаанд хянах системийг нэвтрүүлэх ажлуудыг хийхээр төлөвлөж байна.

Уурхайн тээвэрлэлтийн үйл ажиллагааны хяналтын системд диспетчерийн системийг 2-р үе шаттай хэрэгжүүлэх, ирж буй хүдрийн чанарыг хурдан тодорхойлохын тулд Бутлан тээвэрлэх хэсэгт тасралтгүй конвейер анализаторыг нэвтрүүлэх нь чухал. Хүдрийн ил уурхайгаас баяжуулах үйлдвэр хүртэл геологи-маркшайдерийн тооцооны шинэ программ хангамжийг нэвтрүүлэх нь чухал юм.

Уурхайн тээвэрлэлтийн диспетчерийн системийн 2-р үе шатыг нэвтрүүлэхдээ БелАЗ-д ачигдсан хүдрийн чанарын найрлагыг тооцож, экскаваторын утгах үеийн координатыг тодорхойлох боломжтой тоног төхөөрөмжөөр шинэчлэх. Энэхүү 2-р шатыг нэвтрүүлснээр баяжуулах үйлдвэрт нийлүүлж буй хүдрийн чанарыг тогтвортжуулах асуудал шийдэгдэнэ.

Автоматжуулсан процессын хяналтын системийг цаашид хөгжүүлэхийн тулд дараах ажлуудыг хийхээр төлөвлөж байна.

1. Автоматжуулсан системийг хөгжүүлэхдээ уурхайн дижитал газрын загварт мэдээлэл цуглуулах, уулын ажил төлөвлөх, уурхайн олборлолтын үйл ажиллагааг загварчлах
2. Автоматжуулсан процессын хяналтын системийн 2-р шатныг хэрэгжүүлэх
3. Хүдрийн урсацын чанарыг хурдан тодорхойлохын тулд конвейер дээр тасралтгүй РКЦ анализаторуудыг нэвтрүүлэх.
4. Цооногийн ашиглалтын туршилт хийх радиоизотопын анализаторын датчикийг нэвтрүүлэх.

GemCom нь BHP Billiton, Codelco, De Beers зэрэг компаниудад уул уурхайн төслүүдийг удирддаг програм хангамжийг нэвтрүүлэх

Хөтөлбөрийн удирдлага, техникийн нөхцлийг тодорхойлох үе шатанд төслийн аргыг ашиглах нь төслийн багийг бүрдүүлэх, компанийн зураг төсөл, ашиглалтын үйл ажиллагаанд ажилчдын тоо, ямар техникийн хэрэгслийг ашиглах зэргийг тодорхойлох боломжтой.

Бүлгийн дүгнэлт

1. Ашигт малтмал түүхий эдийн цогц хэрэглээг нэмэгдүүлэх замаар холбогдох инновацид чиглэсэн төрөлжилтийг боловсруулан алгоритмын туршилтыг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын жишээн дээр гүйцэтгэсэн.
2. Нөөцийн үзэл баримтлалд тулгуурлан компанийн дотоод нөөц - зэсийн зах зээлийн салбарын загварт дүн шинжилгээ хийсний үндсэн дээр зэсийн зах зээлийн хөгжил, өрсөлдөөн нэмэгдэж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хэрэгцээ, төрөлжүүлэх гадаад хөшүүргийг тодорхойлсон. Давуу тал, сул тал, боломж, аюул заналхийллийн SWOT шинжилгээгээр компанийн хөгжлийн хамгийн ирээдүйтэй нь шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулалтын зах зээлийг өргөжүүлэх явдал болохыг харуулж байна.
3. Төрөлжүүлэх (эдийн засаг, нийгэм, байгаль орчны менежмент) үндсэн зорилтууд нь шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, боловсруулахад шинэ технологи ашиглах замаар ашиг орлого, нэмүү өртгийг шингэсэн бүтээгдэхүүнийг гаргах, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ашиглалтын хугацааг уртасгах, хүдрийн тэнцвэрт байдлыг бий болгох явдал юм.
4. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын үйлдвэрлэлийн дэд бүтэц, технологи, санхүү, хүний нөөц, материал, төсөл, улс төр, байгаль орчин зэрэгт дүн шинжилгээ хийж төрөлжилтийн хязгаарлалтыг тодорхойлсон.

5. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын нөхцөлд одоо байгаа үйлдвэрүүдийг шинэчлэх, өргөтгөл хийх, боловсруулалтын гүнийг нэмэгдүүлэх, ашигт малтмал түүхий эдийн нэгдсэн хэрэглээг харгалзан шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд төрөлжүүлэх загварыг сонгосон. Төрөлжүүлэх стратегийн хэрэгжилт нь үйлдвэрийн дотоод хөгжил, шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд суурилдаг.
6. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын үйлдвэрлэлийг төрөлжүүлэх хөтөлбөр болон нэмэлт үр нөлөөг тодорхойлсон бөгөөд үүнд Дулааны цахилгаан станцын өргөтгөлд 13,936 мянган ам.долларын хөрөнгө оруулалт, сүүлд баригдах 1,370 сая долларын өртөг бүхий хаягдлын овоолгын барилгын ажил, 5,521 сая рублийн нийгэмд үзүүлэх нөлөө багтсан.
7. Төрөлжүүлэх төсөл хөтөлбөр хэрэгжсэнээр балансын нөөцийн үнэлгээ 861 сая ам.доллар буюу 8.6%-иар нэмэгдэнэ.
8. Хөтөлбөрийн дараах үе шатуудад үйлдвэрийг төрөлжүүлэх хөтөлбөрийг үндэслэл болгохын тулд төслийн аргыг ашигласан: хөтөлбөрийг урьдчилан боловсруулах; хөтөлбөр боловсруулах; хөтөлбөрийн удирдлагын тодорхойлолт, техникийн үзүүлэлтүүд.
9. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үр дүн нь компанийн стратегийн зорилттой нийцэж байгаа эсэхийг шалгах, хөтөлбөрийн гол оролцогчдыг тодорхойлох, оролцогч талуудын одоогийн болон хүсч буй байдалд дүн шинжилгээ хийх, төслийн менежментийн арга хэрэгслийг төрөлжүүлэх хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлсэн.
10. Хөтөлбөрийн архитектур, төслийн боломжит байдалд дүн шинжилгээ хийх, эдийн засгийн үндэслэлийг шалгах, одоо байгаа эрсдлийг харгалзан үзэх, баг бүрдүүлэх, техникийн хэрэгсэл, үйл явц, хөтөлбөрийг удирдах журмыг тодорхойлсон.


2.5 Төсвийн янз бүрийн төвшин дэх эрдэсийн түүхий эдээс төсөвт үзүүлэх үр нөлөө (улс, орон нутгийн төсөв)

2.5.1 Эдийн засгийн өсөлт

Бүсийн ДНБ-ээр бүсүүдийн эдийн засгийн хөгжлийн түвшин, эдийн засгийн бүтэц, эдийн засгийн үр ашгийг илэрхийлэх бол бүсийн хүн амын амьжиргааны түвшин, бүсийн тэгш бус байдлыг нэг хүнд ногдох бүсийн ДНБ-ээр тооцож, илэрхийлэх боломжтой. Одоогийн байдлаар бүсийн ДНБ нь зөвхөн оны үнээр тооцогдох боломжтой байна.

Манай улсын оны үнээр тооцсон ДНБ-ний хэмжээ 2000 оноос хойш уул уурхайн салбарын олборлолт, үйлдвэрлэлээс ихээхэн хамаарч эрчимтэй өсөж, 2010 онд хамгийн өндөр буюу 48.0 хувиар өссөн. Гэвч эдийн засгийн өсөлт 2011 оноос эхлэн буурч, 2016 онд 3.4 хувь болж, 2017 оноос дахин сэргэсэн байна.


ДНБ-ий өсөлтийг бүсээр авч үзвэл хамгийн их өсөлттэй байсан 2010 онд төвийн бүс (60.3%), Улаанбаатар (57.2%), зүүн бүс (49.0%) өссөн нь улсын түвшнээс давсан өсөлтийг харуулж байна. Харин 2017 онд хангайн бүс (27.3%) хамгийн их, баруун бүс (7.0%) хамгийн бага өсөлттэй байна.



Зураг 26 ДНБ-ий жилийн өсөлт, бууралт, хувиар, бүсээр, 2001-2017 он

Хэдийгээр бүсүүдийн ДНБ өссөн ч уг өсөлт нь улсын нийт өсөлтийг хэрхэн бүрдүүлж байгааг бүсүүдийн оролцоогоор нь илэрхийлнэ. 2017 оны ДНБ-ий 16.5 хувийн өсөлтийн 9.8 пунктийг Улаанбаатар, 3.4 пунктийг хангайн бүс, 1.9 пунктийг төвийн бүс, 1.0 пунктийг зүүн бүс, 0.4 пунктийг баруун бүс бүрдүүлсэн байна.

ДНБ-д бүсүүдийн оролцооны хувийг авч үзэхэд Улаанбаатарын ДНБ-ний жилийн өсөлтийн талаас илүү хувийг бүрдүүлж байгаа бөгөөд 2001-2009 онд дунджаар нийт өсөлтийн 63.3 хувийг бүрдүүлж байсан бол энэ үзүүлэлт сүүлийн жилүүдэд тогтмол өссөөр 2010-2017 онд дунджаар 71.0 хувь болсон байна.




Зураг 27 ДНБ-ий жилийн өсөлтөд бүсүүдийн оролцоо (%), 2001-2017 он

Бүсүүдийн ДНБ-ий өсөлтийг эдийн засгийн салбаруудаар авч үзвэл, баруун болон хангайн бүсийн салбаруудын өсөлт тогтвортой биш, өсөлтийг бүрдүүлж байгаа салбарууд нь жил бүр өөр өөр байна. Дараах зургаас харахад баруун болон хангайн бүсийн 2012 оноос бусад жилүүдэд үйлдвэрлэлийн салбарын өсөлтийн хувь өндөр байгаа хэдий ч нийт бүсийн өсөлтийн 30-аас доош хувийг бүрдүүлж байна. Эдгээр бүсийн өсөлт нь үндсэндээ хөдөө аж ахуй, үйлчилгээний салбараас бүрдэж байна.


Харин төвийн болон зүүн бүсийн хувьд эдийн засгийн нөхцөл байдал үйлдвэрлэлийн салбараар ихээхэн хамааралтай дүр харагдаж байна. 2015 онд үйлдвэрлэлийн салбар бууралттай гарснаар нийт эдийн засгийн өсөлт бууралттай гарсан байна. Эндээс үзэхэд

бүсийн хөгжил нь төрөлжсөн биш байгаа бөгөөд тухайн жилийн тэргүүлэх чиглэл, хөрөнгө оруулалт, уул уурхайн салбарын үйлдвэрлэл болон гаднын хүчин зүйл болох байгаль, цаг агаарын байдал зэргээс шууд хамааралтай хэвээр байна.



Зураг 28 Бүсүүдийн ДНБ-ий өсөлт, бууралт, эдийн засгийн салбараар, хувиар, 2011-2017 он

Бүс нутгийн эдийн засгийн өсөлт, эдийн засгийн салбаруудын өсөлт харилцан адилгүй байгаа нь харагдаж байна. Тэгвэл бүсүүдийн ДНБ-д уул уурхайн салбарын эзлэх хувийг авч үзье. Уул уурхайн салбар нь аж үйлдвэрийн салбарт багтдаг салбар билээ.



Зураг 29 Бүсийн ДНБ-д уул уурхайн салбарын эзлэх хувь, 2010-2017 он


Хангайн бүсийн ДНБ-д уул уурхайн салбарын үйлдвэрлэл 2010 онд бусад бүсүүдээс хамгийн их буюу бараг тал (49.3) хувийг эзэлж байсан бол 2017 оны байдлаар 36.7 хувийг эзэлж байна. Зүүн бүсийн хувьд нийт ДНБ-д уул уурхайн салбарын хувь өсөж байгаа бол төвийн бүсийн өсөлт буурч эргэн өсөх хандлгатай болжээ.

Эдийн засгийн бүтцээр нь улс орны хөгжлийн түвшинг тодорхойлдог ба Улсын хэмжээнд ДНБ-ний 20 гаруй хувийг уул уурхайгаас бүрдүүлж байгаа нь уул уурхайгаас

хараат улс болон хувирсныг харуулж байгаа бөгөөд эдийн засгийн бүтцэд ихээхэн өөрчлөлт орсон. Бүтцийн энэ гажуудал нь манай улсын тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлж байгаа төдийгүй хөгжлийн түвшин үйлдвэрлэл, дэд бүтцийн бүтээн байгуулалтаар тодорхойлогддог ѿ шатаас ухарч уламжлалт аж ахуй, уул уурхайн олборлолт гэсэн ѿ шат руу шилжин орж байна. Энэ нь уул уурхайн түүхий эд экспортлогч улс болсон гэсэн үг юм.


ДНБ-ий бүтцийг бүсээр авч үзвэл эдийн засгийн харьяатын зарчмын дагуу дийлэнх хувь нь Улаанбаатарт ногдож, үйлдвэрлэл явагдаж байгаа бүс нутгийн эдийн засагт төдийлөн хувь нэмрээ оруулахгүй байгаа нь харагдаж байна.

Нийт ДНБ-ий дийлэнх хувийг Улаанбаатар бүрдүүлж байна. Тухайлбал, 2001-2010 онуудын дунджаар Улаанбаатар 57.9 хувь, хангайн бүс 19.8, төвийн бүс 10.7 хувь, баруун бүс 7.0 хувь, зүүн бүс 4.5 хувийг эзэлж байсан бол 2011-2017 онуудын дунджаар Улаанбаатарын эзлэх хувь 7.0 пунктээр, зүүн бүсийнх 0.6 пунктээр өсөж, бусад бүсийнх буурсан хандлагатай байна.



Зураг 30 ДНБ-д бүсүүдийн эзлэх хувь, 2001-2017 он

Бүсүүдийн ДНБ-ий салбаруудын бүтцийг авч үзвэл, 2005 онд баруун бүсийн ДНБ-ий 70 гаруй хувийг ХАА-н салбар бүрдүүлж байсан бол үйлдвэрлэл, үйлчилгээний салбар өргөжсөнөөр 2017 онд ХАА-н салбарын эзлэх хувь 39.9 болсон байна. Зүүн бүсийн хувьд 2005 онд ХАА-н салбарын эзлэх хувь 62.9 хувь байсан бол 2017 онд үйлдвэрлэлийн салбар 53.0 хувь байна. Хангайн бүсийн хувьд 2005-2017 онд салбаруудын бүтэц төдийлөн өөрчлөгдөөгүй байна. Төвийн бүсийн хувьд үйлдвэрлэлийн салбарын эзлэх хувь өссөн хандлагатай байна.




Зураг 31 ДНБ-д салбаруудын эзлэх хувь, бүсээр, 2005-2017 он

Улсын түвшинд нийт эдийн засагт үйлдвэрлэл, үйлчилгээний салбар дийлэнх хувийг эзэлж байхад бусийн түвшинд хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээний салбаруудын эзлэх хувийн жин харилцан адилгүй байна.


2.5.2. Төсвийн бүтэц

Орон нутгийн төсвийн нийт орлогыг бүсээр авч үзвэл бүсүүдийн эзлэх хувь харьцангуй өөрчлөлт багатай байна. Тухайлбал, 2010-2017 оны дунджаар Улаанбаатар 42.8 хувийг, төвийн бүс 21.1 хувийг, хангайн бүс 18.9 хувийг, баруун бүс 11.0 хувийг, зүүн бүс 6.2 хувийг бүрдүүлж байна.



Зураг 32 Орон нутгийн төсвийн нийт орлого (тэрбум төгрөг), бүсээр, 2011-2017 он


Орон нутгийн төсвийн тэнцэл 2010-2013 онд ашигтай гарч байснаа 2014 оноос алдагдалтай болжээ. Бүх бусийн төсвийн тэнцэл 2014, 2015 онд алдагдалтай, 2016 онд зүүн бүс 1.3 тэрбум төгрөг, төвийн бүс 7.8 тэрбум төгрөгийн ашигтай, 2017 онд төвийн бүс 51.1 тэрбум төгрөгийн ашигтай, бусад бүсэд алдагдалтай гарсан байна.



Зураг 33 Орон нутгийн төсвийн тэнцэл (тэрбум төгрөг), бүсээр, 2011-2017 он

Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын ажлын албаны мэдээллээр 2017 онд уул уурхайгаас төсөвт 106.2 тэрбум төгрөг төвлөрүүлсэн бөгөөд үнээс төвийн бүс 61.6 хувь буюу 65.4 тэрбум төгрөгийг, хангайн бүс 28.3 хувь буюу 30.0

тэрбум төгрөгийг төвлөрүүлж тэргүүлсэн байсан. Энэхүү мэдээлэл нь Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын ажлын албанад мэдээ ирүүлсэн аймгийн мэдээлэлд үндэслэсэн учраас нийт мэдээллийн бүрдэлт улс, бүсийн дүнг бүрэн илэрхийлэхгүй.



Зураг 34 Уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн төсөвт төвлөрүүлсэн орлого, бүсээр, сая төгрөг, 2015-2017 он

Орон нутгийн төсөв бүрдүүлэх загвар нь дараах бүтэцтэй байв. Үүнд:


1. Улсын төсвөөс дахин хуваарилалтаар олгодог төсвийн хөрөнгө (А)
2. Орон нутаг өөрийн үйлдвэрлэл, үйлчилгээ, татвар, хураамж, төлбөрөөс олсон орлого (Б)
3. Уул уурхайгаас орон нутгийн төсөвт төвлөрүүлдэг орлого (В) зэргээс бүрддэг байв.

2020 оноос уул уурхайгаас орон нутгийн төсөвт ордог орлогын улсын төсөвт төвлөрүүлдэг болсноор орон нутагт уул уурхан үйлдвэрлэл хөгжүүлэх сонирхол эрс буурсан байна.

2.5.3 Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, борлуулалт

Аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртөгт уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарын эзлэх хувь 2017 оны байдлаар 66.9, боловсруулах салбарын эзлэх хувь 26.3, цахилгаан, хий, уур, агааржуулалтын эзлэх хувь 5.5, ус хангамж, бохир ус, хог, хаягдлын менежментийн салбарын эзлэх хувь 1.3 хувийг эзэлж байжээ.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийг дэд салбаруудаар авч үзвэл уул уурхайн салбарын үйлдвэрлэл бусад салбаруудаас өндөр байна. Дэд салбаруудын үйлдвэрлэл 2010-2014 онуудад өсөж, 2015 онд буурсан хэдий ч буцаад өсөх хандлагатай болсон байна.




Зураг 35 Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, дэд салбараар, тэрбум төгрөг, 2010-2018 он

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн бүрдэлтийг бүс нутгаар авч үзвэл Улаанбаатар хотын бүсийн эзлэх хувь сүүлийн есөн жилд хамгийн их хувийг эзэлж байна. Хэдийгээр Улаанбаатар хотын бүс аж үйлдвэрлэлийн салбарт хамгийн их хувийг эзэлж байгаа ч энэ үзүүлэлт нь 2010 оноос өсөж 2015 онд хамгийн өндөр түвшиндээ хүрч буцаад буурах хандлагатай болсон байна.


Хангайн бүсийн аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл буурах хандлагатай байгаа бол төвийн бүсийн аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2015 он хүртэл буурч байсан ч буцаад өсөх хандлагатай болсон байна. Харин баруун болон зүүн бүсийн хувьд эзэлж байгаа бөгөөд цаашид хадгалагдах хандлагатай байна.

Сүүлийн есөн жилийн хугацаанд аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлд бага хувийг



Зураг 36 Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлд бүс нутгийн эзлэх хувь, 2010-2018 он

Дээр зурагт аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлд бүс нутгийн эзлэх хувийг авч үзсэн бол дараагийн хэсэгт бүс нутгуудын аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлд уул уурхайн дэд салбарын эзлэх хувийг авч үзье.



Зураг 37 Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлд уул уурхайн салбарын эзлэх хувь, бүсээр, 2010-2018 он

Сүүлийн есөн жилд аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлд уул уурхай, олборлох салбар баруун бүсээс бусад бүсэд 50-аас дээш хувийг эзэлж байна. Хангайн бүсийн аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн 90-ээс дээш хувийг уул уурхай, олборлох салбар бүрдүүлж ирсэн бөгөөд 2018 онд 91.2 хувийг эзэлж байгаа нь 2010 оноос 6.8 пункттээр буурсан байна.

Харин баруун бүсийн аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлд уул уурхай, олборлох салбарын эзлэх хувь 2010 онд 9.1 хувь, 2013 онд 15.3 хувь байсан бол 2014 оноос огцом өсөж 2018 оны байдлаар 74 хувьд хүрсэн байна. Хэдийгээр энэ нь өндөр өсөлтийг илтгэж байгаа боловч улсын нийт аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлд баруун бүсийн үйлдвэрлэлийн эзлэх хувь 2018 онд ердөө 2 хувь байгааг өмнөх зурагт харуулсан.

Аж үйлдвэрлэлийн салбарын нийт борлуулалтад уул уурхайн салбарын эзлэх хувь хэмжээ бусад салбараас даруй 2.0-3.4 дахин их байгаа байна. Уул уурхайн салбарын борлуулалт 2010-2013 онуудад жигд өсөж байсан бол 2014 онд огцом өссөн ба 2015 онд бага зэрэг буурсан хэдий ч сүүлийн жилүүдэд өсөлт өндөр хэвээр байна. Боловсруулах үйлдвэр болон цахилгаан, хий үйлдвэрлэл, ус хангамжийн салбарын борлуулалт сүүлийн жилүүдэд тогтвортой байжээ.




Зураг 38 Аж үйлдвэрийн салбарын борлуулалт, дэд салбараар, тэрбум төгрөг, 2010-2018 он

Улсын хэмжээнд уул уурхайн салбарын борлуулалт өндөр байгаа бол бүс нутгийн хувьд авч үзье.

Төвийн бүсийн аж үйлдвэрийн салбарын нийт борлуулалтад уул уурхай салбарын борлуулалт 2010 онд 92.4 хувийг эзэлж байсан ба тасралтгүй буурч 2015 онд 83.3 хувь, 2016 оноос буцаад өсөх хандлагатай болж 2018 оны байдлаар 94.6 хувьд хүрчээ.

Улаанбаатар болон зүүн бүсийн аж үйлдвэрийн салбарын борлуулалтад уул уурхайн салбарын эзлэх хувь хэмжээ 2010-2013 онуудад буурч, 2014-2016 онуудад өссөн боловч буцаад буурах хандлагатай болсон байна.




Зураг 39 Аж үйлдвэрийн салбарын борлуулалтад уул уурхайн салбарын эзлэх хувь, бүсээр 2010-2018 он

2.5.4 Гадаад худалдаа

Монгол Улс 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр нийт 156 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 12.9 тэрбум ам.доллар, үүнээс экспорт 7.2 тэрбум ам.доллар, импорт 5.9 тэрбум ам.долларт хүрсэн байна. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оноос 2.3 (22.3%) тэрбум америк доллар, үүнээс экспорт 811.2 (13.1%) сая америк доллараар, импорт 1.5 (35.5%) тэрбум америк доллараар тус тус өсжээ.

Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл 2014 оноос эхлэн ашигтай гарч эхэлсэн бөгөөд 2018 онд ашгийн хэмжээ 1.1 тэрбум ам.долларт хүрч 2017 оноос 39.0 хувиар буурсан байна. Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан гол шалтгаан нь эрдэс бүтээгдэхүүн тэр дундаа нүүрсний экспортын хэмжээ өссөнтэй холбоотой юм.



Зураг 40 Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл, сүүлийн 10 жилд, тэрбум ам.доллараар


Манай 2 хөрш улс нь гадаад худалдааны нийт эргэлтэд хамгийн өндөр дүнг эзэлж байгаа бөгөөд БНХАУ-тай 8.5 тэрбум ам.долларын худалдааг хийжээ. Энэ нь нийт бараа эргэлтийн 65.9 хувийг эзэлж байна.

Экспорт 2018 оноос 13.1 хувиар өсөж Монгол Улсын түүхэнд хамгийн өндөр дүнд буюу 7.0 тэрбум ам.долларт хүрэв. Монгол Улсын экспортын гол нэрийн бүтээгдэхүүн нь эрдэс бүтээгдэхүүн бөгөөд нийт экспортын өөрчлөлт нь эдгээр бүтээгдэхүүнээс шууд хамааралтай байдаг.




Зураг 41 Экспорт, барааны бүлгээр, хувиар, 2017 он

Монгол Улс 2018 онд 6.1 тэрбум ам.долларын эрдэс бүтээгдэхүүн экспортолсон нь өмнөх оноос 23.0 хувиар илүү байна. Энэхүү өсөлт нь чулуун нүүрсний өсөлтөөс голлон хамаарч төмрийн хүдэр, зэсийн баяжмал, цайрын баяжмал, жонш, молибдений баяжмал, боловсруулаагүй нефть зэрэг бүтээгдэхүүн нь эрдэс бүтээгдэхүүний экспортын 92.7 хувийг бүрдүүлж, харин нийт экспортын 86.6 хувийг эзэлж байна.



Зураг 42 Эрдэс бүтээгдэхүүний экспорт, сая ам.доллараар



2.5.5. УУЛ УУРХАЙН ТӨСЛҮҮД ХЭРЭГЖСНЭЭР БҮС НУТАГ ТУС БҮРТ ШИНЭЭР ТӨВЛӨРҮҮЛЭХ ТАТВАР, АЖЛЫН БАЙРНЫ ТООЦООЛОЛ

Энэ судалгааг 4 бүсээр хамааруулж бүс бүрийн хүн амын ажил эрхлэлтийн түвшин, хүн амын ивэвхтэй тоо мөн уул уурхайн салбарын ажиллагсдын өнөөгийн тоо мэдээллийг боловсруулсан. Эдгээр судалгааны үр дүнг доорх харгалзах хэсгүүдэд дэлгэрүүлж харууллаа. Эдгээр мэдээллүүд нь цаашид шинээр бий болох уул уурхайн салбарын ажлын байрны эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцоход үндсэн суурь бааз болох юм.

Хүн амын хөдөлмөр эрхлэлт

2017 онд 15, ба түүнээс дээш насны нийт хүн амын 61.0 хувь нь эдийн засгийн идэвхтэй хүн ам, тэдгээрийн 1.2 сая нь ажиллагчид, 119.1 мянга нь ажилгүй иргэд байна. Уул уурхай, олборлолтын салбарын ажиллагчид нь нийт ажиллагчдын 4.1 хувийг эзэлж байна. Бүс нутгийн ажиллагчдын тоог салбараар авч үзвэл 2017 онд уул уурхай, олборлолтын салбарт улсын хэмжээнд нийт 52.0 мянган ажиллагчид байгаагийн 44.4 хувь Улаанбаатарт, 21.9 хувь төвийн бүсэд, 21.8 хувь хангайн бүсэд эзэлсэн байна. Уул уурхай, олборлолтын ажиллагчдын эзлэх хувь 2010 оноос Улаанбаатарт 10.4 пункт, баруун бүсэд 2.3 пунктээр өссөн. Хангайн бүсэд 6.3 пункт, төвийн бүсэд 5.4 пункт, зүүн бүсэд 1.1 пунктээр тус тус буурсан байна.


Хүснэгт 41 5, 15 ба түүнээс дээш насны ажиллагчдын тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, бүсээр, жилээр, мянган хүн

Салбар	Аймаг	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Бүгд	Улсын дүн	1033.7	1037.7	1056.4	1103.6	1110.7	1151.2	1147.8	1238.3
	Баруун бүс	169.0	167.8	177.6	158.4	154.5	166.7	158.8	173.2
	Төвийн бүс	195.4	199.5	182.3	190.2	184.3	189.6	195.4	215.1
	Хангайн бүс	236.4	232.2	251.1	249.4	243.1	248.6	245.6	254.9
	Зүүн бүс	72.0	76.7	80.2	78.9	76.9	86.4	83.0	83.1

	Улаанбаатар	360.9	361.4	365.3	426.7	451.8	460.0	465.1	512.2
Үүл урхай, олборлолт	Улсын дүн	34.1	45.1	46.7	50.3	40.9	42.6	38.2	52.0
	Баруун бүс	1.2	3.0	1.9	2.5	1.6	2.5	1.3	3.0
	Төвийн бүс	9.3	11.4	12.7	10.6	8.7	8.0	7.6	11.4
	Хангайн бүс	9.6	10.7	10.7	10.8	9.2	11.1	10.5	11.3
	Зүүн бүс	2.4	4.7	2.1	2.8	2.8	2.9	2.8	3.1
	Улаанбаатар	11.6	15.3	19.4	23.6	18.7	18.2	16.1	23.1

Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч)-д тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй иргэдийг хамруулна.

Нийт ажилд орсон иргэдээс уул уурхайн салбарт ажилд орсон иргэний эзлэх хувь 2011 онд 9.9 хувь ногдож байсан бол 2018 онд 5.7 хувь болж 4.2 пунктээр буурсан байна. Уул уурхайн салбарт шинээр ажилд орсон иргэдийг бүсээр авч үзвэл 2018 онд 29.6 хувь төвийн бүсэд, 24.7 хувь зүүн бүсэд, 21.6 хангайн бүсэд, 17.1 хувь баруун бүсэд, 6.9 хувь Улаанбаатар хотод тус тус эзэлж байна. 2011 онд 43.3 хувь төвийн бүсэд, 22.9 хувь Улаанбаатар хотод, 18.8 хувь зүүн бүсэд, 7.9 хувь баруун бүсэд, 7.1 хангайн бүсэд эзэлсэн. Үүнээс дүгнэхэд хангайн бүс 14.5 пункт, баруун бүс 9.1 пункт, зүүн бүс 6.0 пунктээр ёссөн байна. Улаанбаатар 16.0 пункт, төвийн бүс 13.7 пунктээр буурсан байна.




Зураг 44 Уул уурхайн салбарт ажлын шинэ байранд ажилд орсон иргэн, бүсээр, хувиар, 2011-2018 он

Эх үүсвэр: ХХҮЕГ-аас гаргадаг захиргааны статистикийн мэдээ

2.5.6. Дундаж цалин

Ажиллагчдын сарын дундаж цалинг эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзвэл 2017 оны байдлаар уул уурхай, олборлолтын салбарт ажиллагчдын сарын дундаж цалин хамгийн их буюу 2119.1 мянган төгрөг байна. Улсын дундаж цалингаас даруй 2.2 дахин их байна. 2010 онд уул уурхай, олборлолтын салбарт ажиллагчдын сарын дундаж цалин 572.2 мянган төгрөг байсан нь улсын дундаж цалингаас

1.6 дахин их байна. 2017 онд ажиллагчдын улсын дундаж цалин 2010 оноос 603.1 мянган төгрөгөөр (2.7 дахин их) өссөн байна. Уул уурхай, олборлолтын ажиллагчдын дундаж цалин 2010 оноос 1546.9 мянган төгрөгөөр (3.7 дахин их) өссөн байна.



Зураг 45 Ажиллагчдын сарын дундаж цалин, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилааар, 2017 он, мянган төгрөг

БҮЛЭГ 3. ЭРДЭС БАЯЛГИЙН ЦОГЦОЛБОРЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЛААРХИ БАРИМТЛАХ ТӨРИЙН БОДЛОГО (ТӨСӨЛ)

“Эрдэс баялгийн цогцолборын тогтвортой хөгжлийн талаархи баримтлах төрийн бодлого” энэхүү төслийн анхны хувилбарыг Үйлдвэр худалдааны яамны Геологи, уул уурхайн бодлого зохицуулалтын газар, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн (ШУТИС) “Экологи- тогтвортой хөгжлийн төв”-ийн хооронд 2005 оны 3-р сарын 1-нд байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэсэн болно.

Уг төслийг Үйлдвэр худалдааны яамны Сайдын Зөвлөлийн 2007 оны 3-р сарын 30-ны өдрийн хуралдаанаар сайшаан хүлээж авсан байна. 2008 оны 1-р сарын 31-ны өдөр Улсын Их Хурлын 12 дугаар тогтоолоор Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого баталжээ.

2014 оны нэгдүгээр сарын 16 өдөр Монгол Улсын Их хурлаас “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого (2014-2025 он) батлах тухай 18 дугаар тогтоол гаргажээ. Төрийн бодлогын энэхүү баримт бичгийн талаар тус салбарын эрдэмтэн, мэргэжилтнүүд санал бодлоо илэрхийлсний дотор академич П.Очирбат төрийн бодлогыг хэрэгжүүлэх арга замыг оновчтой тодорхойлж чадаагүй байгаад шүүмжлэлтэй хандаж “Mongolian mining” мэргэжлийн сэтгүүлд санал бодлоо нийтлүүлж байжээ.

2015 оны 9 дүгээр сарын 25-27-ны өдрүүдэд Нью-Йорк хотноо НҮБ-ын дээд хэмжээний уулзалт болж дэлхийн 150 гаруй улсын Төр, засгийн тэргүүн оролцож “Тогтвортой хөгжлийн -2030” хөтөлбөрийг баталжээ.

2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр Монгол Улсын Их Хурлын 19 дүгээр тогтоолоор “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ыг баталсан байна.

2016 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцийн Парисын хэлэлцээр байгуулагдсаны Монгол Улс 2016 оны 9 дүгээр сарын 01-ны иөдөр Монгол Улсын хуулиар соёрхон баталжээ.

2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр Монгол Улсын Их Хурлын 52 дугаар тогтоолоор “Алсын Хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлагджээ.

Тогтвортой хөгжлийн талаар сүүлийн арав гаруй жилийн дотор Дэлхийн болон Монгол Улсын хэмжээнд гарсан бодлогын залгамж чанар, уламжлал, шинэчлэлийг агуулсан дээрх шийдвэрүүдийг үндэслэн Баягалийн нөөцөд суурилсан эдийн засагтай Монгол Улсын эрдэс баялгийн цогцолборын тогтвортой хөгжлийн талаар баримтлах төрийн бодлогын төслийг Монгол Улсын Шинжлэх ухаан технологийн их сургуулийн судлаачид Оросын Холбооны Улсын Санктпетербургийн Уул уурхайн Их сургуулийн багтай хийж буй хамтарсан судалгааны хүрээнд шинэчлэн найруулж боловсруулсан болно.

I. Нийтлэг үндэслэл

Эрдэс баялгийн цогцолбор гэдэг ойлголтод ашигт малтмалын хайгуул, олборлолт, баяжуулалт, металл үйлдвэрлэлт, хүдрийн бүс эрдэс, металлаас хагас боловсрогдсон бүтээгдэхүүн, металл хийц үйлдвэрлэх үйл явцыг багтаав. Эрдэс түүхий эд ба металлын салбарын талаархи төрийн бодлогын энэхүү баримт бичигт Монгол Улс нь байгалийн нөөцөд суурилсан эдийн засагтай орон учир Уул уурхайн аж үйлдвэрийн тогтвортой хөгжлийн зорилго зорилтыг тодорхойлж түүнийг хэрэгжүүлэхэд төрийн үүргийг тусган тайлбарлаж байна. Цаашид “Төрийн бодлого” гэж товчлон бичнэ. “Төрийн бодлого”-ын үндэс нь:

- ✓ Монгол Улсын Үндсэн хууль,
- ✓ Газрын хэвлийн тухай хууль,
- ✓ Ашигт малтмалын тухай хууль,
- ✓ Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”,
- ✓ Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль,
- ✓ Химиин хорт бодисоос хамгаалах тухай хууль,
- ✓ Монгол Улсын Шинжлэх ухаан технологийн талаар төрийн бодлого,
- ✓ Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого (2014-2025 он) зэрэг хууль эрх зүйн актууд болно.

“Төрийн бодлого” нь Уул уурхайн аж үйлдвэрийн төлөөлөгчид, Байгаль орчныг хамгаалах байгууллага, Эрдэмтэд, Үйлдвэрчний эвлэл, Засгийн газрын зөвшилцлийн үндсэн дээр хэлэлцэж баталсан “үул уурхайн тогтвортой хөгжлийн зарчим”-ыг хэрэгжүүлэхэд чухал алхам болох юм.

Энэхүү баримт бичгийг боловсруулах явцад сонирхогч талуудтай олон удаа зөвлөлдөж хэлэлцэж санал зөвлөлгөөнийг нь авч тусгасан болно. “Төрийн бодлого”-ын үндсэн зарчмын дагуу Засгийн газар нь Уул уурхайн аж үйлдвэрийг дэмжих талаар уян хатан ажиллах болно. “Төрийн бодлого” нь эдийн засгийн бүс, аймаг орон нутгийн удирдлагын үүргийг харгалзан тусгаж гарсан хүндрэл, тодорхой нөхцөл байдал, Засгийн газар, Уул уурхайн салбарын өмнө тулгарсан хүндрэл бэрхшээлийг цаг тухайд нь шийдвэрлэх талаар хариуцлагатай хандах зарчмыг баримталсан болно.

“Төрийн бодлого”-ын хэрэгжилтийг эрдэс баялгийн хөгжлийн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна. Түүнээс гадна энэхүү баримт бичигт нутгийн удирдлагын эрх үүргийн талаар заасан хэмжээнд хариуцлага хүлээнэ.

Тогтвортой хөгжлийн ерөнхий ойлголт нь сав шимиин (биосфериин) болон оюун шимиин (ноосфериин) экологийн тэнцвэрийг хангаж цэвэр ариун орчинд эрдэм боловсролтой, эрүүл саруул, хангалиун амьдрах үйлдвэрлэл хэрэглээний болон соёл иргэншлийн шинэ зарчим юм. Энэ бол эх дэлхий дээр хүн төрөлхтөн оршин амьдрах хугацаагаа хорогдуулахгүй хадгалах үндсэн нөхцөл юм. Иймийн учир хүний бүх үйл ажиллагаа үйлдвэрлэл үйлчилгээ, байгаль орчноо хамгаалахад чиглэгдэх ёстой. Хүн ам ёсч байна, хэрэглээ нэмэгдэж байна. Байгалийн нөөц, даац буурч байна. Дэлхийгээ хайлаж, хамгаалж, хямгадаж амьдарцгаая хүмүүсээ. Ингэвэл тогтвортой хөгжиж чадна.

Байгалийн баялагт суурилсан эдийн засаг бүхий Монгол Улсын эрдэс баялгийн цогцолборын тогтвортой хөгжил нь хэрэглээ, үйлдвэрлэл, байгалийн нөөцийн тэнцвэрийг урт хугацаанд хадгалах экологийн зарчмаар ухаалаг уул уурхайг хөгжүүлэхийг хэлнэ.

Ухаалаг уул уурхай гэдэг ойлголтод оюуны багтаамж ихтэй, нэмүү өртөг шингэсэн дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг цоцгцолборыг багтаадаг.

Газрын хэвллийн баялгийг иж бүрэн бүрэн гүйцэд ашиглах экологи-эдийн засаг-технологийн цогцолбор бүхий гипроэдийн засгийн системд ухаалаг уул уурхайг багтаадаг.

Газрын генд уусган баяжуулах аргаар ашигт малтмалыг олборлох нь ухаалаг уул уурхай юм.

Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас бохирдсон, доройтсон, эвдэрсэн газар, газрын хэвллийг хоргуйжүүлэх, нөхөн сэргээх, хамгаалах ажлын үр дүнг дээшлүүлж, ашиглагчдын хариуцлагыг дээшлүүлнэ.

Тогтвортой уул уурхай

Хүн төрөлхтөний соёл иргэншлийн хөгжлийн материаллаг үндэс болсон эрдсийн баялгийг өнөөгийн болон хойч үеийнхий хэрэгцээг хангахад зориулан олборлож боловсруулах үйлдвэрлэлийн төрлийг тогтвортой уул уурхай гэнэ.

Тогтвортой уул уурхайн гол шинж нь:

1. Байгалийн баялагт суурилсан эдийн засгийг нийгмийн хэрэгцээг хангах зорилгод нийцүүлэн тэнцвэртэй хөгжүүлдэг байх
2. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь хүрээлэн байгаа орчны агаар, ус, хөрс ургамал, ой мод, ан амьтны орших нөхцөлд сөрөг нөлөөгүй байх
3. Ашигт малтмалын нөөцийг алдагдал, хаягдал, бохирдолт багатай ашиглах технологи бүхий байх
4. Ашигт малтмалын нөөцийн өсөлтийг олборлолтоос түрүүлүүлэх

Тогтвортой уул уурхай нь хариуцлагатайбайх ёстой, байгаль орчинд ээлтэй байх ёстой, байгаль орчны хоёрдогч шинэ экосистемийг үүсгэн хөгжүүлэгч геохүчин зүйл байх ёстой юм.

Хариуцлагатай уул уурхайн санаачлага Төрийн бус байгууллагын (ТББ) хүрээг өргөтгөж хариуцлагын тогтолцоог буй болгож дараах зарчмуудыг дагаж мөрдөнө:

- Олон талын оролцоог хангах
- Ил тод нээлттэй байх
- Хуулийг дээдлэн сахих
- Байгаль орчин, хүний аюулгүй байдлын өмнө хариуцлага хүлээх
- Ирээдүйн хөгжилд хөрөнгө оруулах
- Үр өгөөжтэй байх
- Хүмүүнлэг ёс зүйтэй байх
- Дэвшилтэд технологид суурилсан байх гэх мэт.

Монгол Улс олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагад (ОҮИТБС) элсэн орж (2006 он) олборлох салбараас хүлээж авч байгаа орлого, төлбөрийн ил тод байдлыг сайжруулах, олборлох үйлдвэрийг нээлттэй болгоход чиглэсэн үйл ажиллагаа явуулж байна. Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниуд ОҮИТБС-ийн тайлан гаргах, Засгийн газар уул уурхайн компаниудаас хүлээж авсан орлогын тайлангаа жил бүр тайлagnаж байна.

“Төрийн бодлого”-ын зорилго

“Төрийн бодлого” нь тогтвортой хөгжлийн үндсэн дөрвөн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байх ёстой. Үүнд:

1. Эдийн засгийн өсөлтийг хангах,
2. Ард түмний амьдралын чанарыг дээшлүүлэх,
3. Тогтвортой хөгжлийн зорилтыг хангах,
4. Экологийн тэнцвэрт байдлыг хадгалах.

Эдийн засгийн хөгжлийн суурь болсон Уул уурхайн аж үйлдвэр нь Монголын эдийн засгийн өсөлтийг хангахад чухал үүрэгтэй байна. Уул уурхайн аж үйлдвэр нь бүс нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийг тэтгэхэд чухал ач холбогдолтой төдийгүй орон нутгийн хот байгуулалтын гол хүчин зүйл болдог. “Төрийн бодлого”-д Монголын уул уурхайн салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бүх талын таатай нөхцлийг бүрдүүлэх замаар тус салбарыг улсын эдийн засгийн өсөлт, ард түмний сайн сайхан амьдралын түвшинг дээшлүүлэх, байгаль орчноо хамгаалах зорилтыг хангахад чухал түлхэц болно.

Ардчилсан засгийн анхаарлыг Эрдэс баялгийн салбарын хөгжилд төвлөрүүлж ард түмний аж амьдралын чанарыг дээшлүүлэх

“Төрийн бодлого” зөвшлилцлийн зарчим дээр тулгуурласан учир сонгуулийн үр дүнгээс үл шалтгаалан аль ч Засгийн газарт уламжлагдан хэрэгжих ёстой. Газрын хэвлэлийн баялаг нь төрийн нийтийн өмч болохын хувьд уул уурхайн аж үйлдвэрийн бүтээгдэхүүний ашигаас Засгийн газар тухайн нутаг дэвсгэрийн иргэд болон нийт ард түмэнд хувь хүртэх зарчмыг буй болгох нь тэдний амьдралын чанарыг дээшлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж чадна. Тэдгээрийн зэрэгцээгээр хөрөнгө оруулагчид, компани, бусад бүх оролцогчид хувия хүртэх ёстой.

Тогтвортой хөгжлийн зорилтыг хангах

Засгийн газар нь тогтвортой хөгжлийн зорилтыг “Төрийн бодлого” болон “Тогтвортой хөгжлийн хөтөлбөр”-ийн хүрээнд шийдвэрлэх үүрэг хүлээнэ. Энэ зорилгоор улс төрийн энэхүү баримт бичигт тогтвортой хөгжлийн тодорхойлолтыг

Эрдсийн түүхий эд ба металлын салбартай холбон өгч шийдвэр гаргахдаа энэ зарчмыг баримталж байх юм. Энэ баримт бичигт тусгасан бас нэг өвөрмөц зарчим бол Эрдэс түүхий эдийн ба металлын салбарын тогтвортой хөгжилтэй холбогдсон улс төрийн ба шинжлэх ухааны шийдвэр гаргах чиглэлийг тусгайлан зааж өгсөн явдал юм.

Байгалийн нөөцийн баримжаатай Монголын эдийн засгийн тэргүүлэх ач холбогдолтой салбар нь уул уурхай юм.

Байгалийн нөөцийн баримжаатай Монголын эдийн засагт уул уурхайн салбар чухал ач холбогдолтой бөгөөд цаашид ч ийм байх болно. Үүгээр Засгийн газрын үйл ажиллагаа, Улсын хөгжлийн хөтөлбөрүүдэд ч энэ зарчим хадгалагдах юм. Үүнийг дараах 2 шалтгаанаар тайлбарлаж болно. Үүнд:

1. Эрдэс түүхий эд ба металлын эдийн засгийн ач холбогдол.

Монголын уул уурхайн үйлдвэр гэдэг бол:

- Олон янзын ашигт малтмал олборлон боловсруулж түүнийгээ бараг бүхэлд нь экспортлодог. Монголын зах зээлийн шинэ эдийн засагт шинэ технологийн бараа үйлчилгээ оруулагч, шинэ бүтээгдэхүүн нийлүүлэгч, хөрөнгийн болон оюуны багтаамж ихтэй аж үйлдвэрийн салбар юм,
- Гадаад худалдааны тэнцэлд экспортын 90%-ийг эзэлдэг том салбар,
- Монголын дотоодын тээврийн ачаа эргэлтийн 40%-ийг эзэлдэг,
- ЭБЦ нь зөвхөн өөрийн үйл ажиллагааны хүрээнд ажлын байр бүрдүүлээд зогсохгүй хот тосгоны аж ахуй, үйлчилгээний хүрээнд үй олон ажлын байр буй болгодог бөгөөд хот байгуулалтын чухал хүчин зүйл болдог.

2. Уул уурхайн аж үйлдвэрийн ЭБЦ-ын даяаршлал. Эрдэс түүхий эд ба металлын салбарыг төрийн бодлогын чухал хэсэг болгож буй хоёрдахь гол шалтгаан бол харилцан холбоотой дараах 2 нөхцөл:

- Орчин үеийн уул уурхайн аж үйлдвэр улам бүр дэлхий дахины шинжтэй болж буй байдал,
- Экологийн чиглэлийн олон асуудлыг шийдвэрлэхийн тулд дэлхийн орнуудын Засгийн газрууд хамтран ажиллах шаардлага улам өсөж байгаа явдал юм.

Салбарын даяаршил, экологиос эхлээд түүний олон асуудлууд олон улсын шинжтэй байгаа нь төрийн бодлого боловсруулах суурийг өөрчилж байна.

Олон улсын байгууллагууд, төрөл бүрийн институцийн хүрээнд буй болсон механизм нь нийгэм эдийн засгийн болон экологийн асуудлыг шийдвэрлэхэд чухал хэрэгсэл болдог. Ийм учраас Монголын ЭБЦ-ын төрийн бодлого нь олон улсын хэмжээнд 2 ба олон талын харилцаанд идэвхитэй оролцдог түнш байхад чиглэгдэх ёстой байна.

Даяаршил нь зөвхөн хүндрэл учруулдаг биш бас боломж олгодог. Монгол Улс Дэлхийн Худалдааны байгууллагын (ДХБ) гишүүн болсноор эрдсийн түүхий эд ба металлын салбарын бүтээгдэхүүн экспортлох, шинэ технологи тоног төхөөрөмж экспортлоход таатай нөхцөл бүрдүүлж байна.

Ийм нөхцөлд Монголын Засгийн газар, бус нутаг, аймгийн удирдлагууд гадаадын хөрөнгө оруулалтад таатай нөхцөл, аятай уур амьсгал бүрдүүлэхэд хүчээ нэгтгэж Монголын эдийн засагт хөрөнгө оруулах эрмэлзлэлтэй бүхний өмнө нээлттэй байх зарчмыг баримтлах нь зүйтэй.

Төрийн дотоод бодлогын асуудлыг боловсруулах, шийдвэр гаргахдаа дэлхийн хамтын нийгэмлэгийн дотор гарч буй өөрчлөлт санаачлага, шинэ хандлагыг тусгаж байвал зохино. Эл зарчим нь дотоодын эдийн засгийн өрсөлдөх чадварыг хадгалах, олон улсын тавцан дээр үндэснийхээ сонирхолыг хадгалж хамгаалахад чухал ач холбогдолтой юм

Орон нутгийн мэдлийн асуудлууд

Нутгийн өөрөө удирдах байгууллага (Бүсийн Зөвлөл, Аймгийн болон сумын ИТХ, Засаг даргын Тамгын газар) орон нутгийн чанартай ашигт малтмалын олборлолтой холбогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд ашигт малтмалын хайгуул, ордыг ашиглах, уурхай байгуулж ажиллуулах, нөхөн сэргээх, уурхайг хаах үйл ажиллагаанд оролцно. Засгийн газар нь уран, нефть болон гадаадын хөрөнгө оруулалттай томоохон уул уурхайн олборлох боловсруулах том хэмжээний аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбогдсон асуудлыг хариуцна.

Засгийн газрын үндсэн үүрэг

Ашигт малтмалын ба металлын асуудлыг төрийн захиргааны төв байгууллагад үндсэндээ хариуцуулж Засгийн газрын үндсэн үүрэгт дараах асуудлыг үлдээсэн байна. Үүнд:

- Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад харилцаа хамтын ажиллагаа, олон улсын худалдаа,
- Төсөв санхүүгийн асуудал, мөнгө зээлийн бодлого,
- Шинжлэх ухаан техник,
- Бүс нутгийн асуудал,
- Хүрээлэгч орчны хамгаалалт,
- Эрүүлийг хамгаалах (Орон нутагтай хамт),
- Олон улсын тусламж,
- Эрдэс түүхий эд, металлтай холбоотой үндэсний статистик мэдээлэл,
- Цөмийн энерги, ураны олборлолт зэрэг болно.

Хамтын хүчин чармайлт

Эрдэс түүхий эдийн нөөцийн асуудлыг эрхлэн удирдаж буй орон нутгийн байгууллагатай нягт хамтран ажиллах нь Засгийн газрын чухал үүрэг юм. Аж үйлдвэрийнхээ болон төрийн бус байгууллагатай хамтран түншийн холбоотой ажиллах нь эрдсийн түүхий эдийн салбарын асуудлыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой юм.

Эрдэс түүхий эдийн металлын салбарын тогтвортой хөгжил гэж юуг хэлэх вэ?

Хүрээлэгч орчин ба хөгжлийн асуудал эрхэлдэг Дэлхийн комисс (Брундан-дын Комисс гэж нэрлэдэг) Тогтвортой хөгжлийн талаар дараах тодорхойлолт өгсөн байна: “Өнөөгийнхөө бодит хэрэгцээг хангахдаа хойч үеийнхээ хэрэгцээг хангах чадавхид нь аюул учруулахгүй байх хөгжлийг тогтвортой хөгжил гэнэ” гэжээ.

Энэ тодорхойлолтыг Монголын Засгийн газар хүлээн зөвшөөрч төрийн бодлогын зарчмаа болгож байна. ЭБЦ-ын салбарын тогтвортой хөгжил нь Төрийн бодлогын бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд өөртөө дараах элементүүдийг агуулна. Үүнд:

- Эрдсийн түүхий эд, металл болон түүний бүтээгдэхүүний хайгуул, олборлолт, үйлдвэрлэл, нэмүү өртөг, хэрэглээ нөхөн сэргээлт, дахин ашиглалт, дахин

боловсруулалт, зөөж хаях, булшлах зэрэг үйл явдлыг үр ашигтай, өрсөлдөх чадвартай, хүрээлэгч орчныг хамгаалах шаардлагад нийцсэн аж ахуй эрхлэх хамгийн тэргүүний аргыг хэрэглэх,

- Засгийн газар шийдвэр гаргахдаа нөөц ашиглагчдын хэрэглээ, сонирхолыг хүндэтгэж түүнийг харгалzan үздэг байх,
- Өнөөгийн болон хойч үеийнхнийхээ амьдралын чанар, хүрээлэгч орчны байдлаар хадгалах ба дээшлүүлэх,
- Сонирхогч талууд, хүмүүсийн санал бодлыг шийдвэр гаргах үйл явцдаа өргөн тусгадаг байх.

Эрдэс түүхий эд, металлын салбарын тогтвортой хөгжлийг тодорхойлохдоо ашигт малтмалыг олборлох нь зөвхөн өнөө үеийнхэнд эдийн засаг, нийгмийн ашиг өгч буй биш гэдгийг бодож байвал зохино. Хүний нөөцийн хөгжилд зориулан буй бодит хөрөнгө оруулалт нь зөвхөн өнөө үеийнхэнд бус хойч үеийнхэндээ ач тусаа өгөх болно.

Эрдэс түүхий эдийн салбарын бодлогын зорилго

Эдийн засгийн өсөлтийг хангах, ажлын байрыг нэмэгдүүлэх, үр ашиг, хөгжил дэвшлийн төлөө ард түмнийхээ хүсэл эрмэлзлэлд тулгуурлан тогтвортой хөгжлийн зарчмуудыг амьдралд хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Засгийн газар Төрийн бодлогын баримт бичигтээ (Алсын хараа-2050) улс төрийн бодлогын дараах зорилгыг дэвшүүлж байна.

- Алсын хараа-2050, Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн I үе шат 2021-2030, Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, боловсруулалтын түвшин нэмэгдсэн байна. Уул уурхайн аж үйлдвэрт холбогдолтой асуудлаар Засгийн газрын шийдвэр гаргахдаа тогтвортой хөгжлийн зарчмыг хатуу баримтлах,
- Дэлхийн зах зээл дээр Монголын Уул уурхай аж үйлдвэрийн өрсөлдөх чадварыг хангахдаа олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын нээлттэй чөлөөтэй байх зарчимтай нягт уялдуулах,
- Бусад улс оронтой сонирхогч байгууллага, олон улсын институцуудтай хамтран ажиллах замаар эрдэс түүхий эд, металлыг дэлхийн хэмжээнд тогтвортой ашиглах үзэл баримтлалыг дэлгэрүүлэх,
- Эрдэс түүхий эд, металл болон дагалдах бүтээгдэхүүнийг аюулгүй ашиглах талаар тэргүүлэх ач холбогдол өгч байх,
- Эрдсийн түүхий эд, металлын салбарын үйл ажиллагаанд нутгийн иргэдийн оролцоог өргөтгөх,
- Уул уурхайн олборлох, боловсруулах аж үйлдвэрийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хүрээлэгч орчны хамгаалалтыг хангах зорилгоор шинжлэх ухаан техник, технологийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг тодорхойлох.

Эдгээр ерөнхий зорилтууд нь улс төрийн тодорхой санаачлага, хандлагыг агуулж байгаа бөгөөд эрдсийн түүхий эд, металлын салбарыг хөгжүүлэх стратегийн үндэс юм.

П. Эрдэс баялгийн цогцолборын тогтвортой хөгжлийн зарчмыг нэвтрүүлэх төрийн шийдвэр

Алсын хараа-2050 бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.2 дахь зорилтод: “Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж экспортын баримжаатай

эдийн засгийг бий болгоход” эрдэс баялгийн салбар шийдвэрлэх үүрэгтэй оролцох болно. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод Уул уурхайн салбарыг эдийн засгийн тэргүүлэх салбар гэж тодорхойлоод Уул уурхайн салбарыг хөгжүүлэх чиглэлийг эдийн засгийн зорилтын 4.2.11; 4.2.12; 4.2.13; 4.2.14-т тодорхой заасны дотор 4.2.14-т Уул уурхайн ордыг ашиглалтад оруулж, өндөр технологийн хүнд үйлдвэрийн дараах цогцолборуудыг барьж байгуулна. Үүнд:

Уул уурхайн ордууд

- Таван толгойн нүүрсний орд;
- Оюу толгойн далд уурхай;
- Дорноговийн цахиурын орд;
- Цагаан суваргын орд;
- Хармагтайн орд;
- Литийн орд;
- Газрын ховор элементийн хайгуул, судалгааны ажлыг эрчимжүүлнэ.

Хүнд үйлдвэр

- Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр;
- Нефть хими, кокс-хими, металлургийн үйлдвэр;
- Нүүрс баяжуулах үйлдвэр;
- Нүүрс-хими, нүүрс-эрчим хүч, метан ган төмрийн үйлдвэрлэл, технологийн парк;
- Алт цэвэршүүлэх үйлдвэр;
- Жонш баяжуулах үйлдвэр
- Газрын тос боловсруулах үйлдвэр, түүний дэд бүтэцийн сүлжээ нефть-химиийн үйлдвэр барьж байгуулна. (4.2.16)
- Геологийн судалгааны ажлыг эрчимжүүлж, дунд, урт хугацааны эдийн засгийн өсөлтийг хангах эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлнэ. (4.2.24)
- Импортыг орлох барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжинэ. (4.2.19)
- Говийн бүс рүү ус дамжуулах хоолой барьж байгуулна. (4.2.15)
- Стратегийн орд газруудыг хилийн боомттой холбосон дараах чиглэлийн төмөр замуудыг барьж байгуулна. (8.13.):

“Таван толгой-Зүүнбаян”

“Зүүнбаян-Хангимандал”

“Нарийн сухайт-Шивээ хүрэн”

“Таван толгой-Гашуун сухайт”

“Сайншанд-Баруун Урт-Хөөт” зэрэг байгууламжууд тусгагдсан болно.

Үндэсний баялгийн санг хөгжүүлэх

“Алсын хараа-2050” бодлогын хүрээнд Үндэсний баялгийн сангийн эрх зүйн орчныг төгөлдөржүүлж, зохион байгуулалтын шинэчлэлт хийхдээ эрдэс баялгийн орлогын дийлэнх хэсгийг баялагийн санд төвлөрүүлж түүнийхээ зарим хэсгийг олон улсын санхүүгийн зах зээл дээр хөрөнгө оруулалт хийх (4.6.4)

“Алсын харах-2050” Үндэсний баялгийн сангийн 4.6 дахь зорилтыг хэрэгжүүлэхэд зарцуулахаар (4.6.1; 4.6.2; 4.6.3; 4.6.4; 4.6.5; 4.6.6; 4.6.7; 4.6.8; 4.6.9; 4.6.10.) заасныг эрдэс баялгийн салбар гол үүрэгтэй байна.

Тогтвортой хөгжилд үндэслэсэн шийдвэр гаргах зарчим

Эрдэс түүхий эдийн болон металлын холбогдолтой асуудлаар шийдвэр гаргахдаа экологи, эдийн засаг, нийгмийн болон технологийн хүчин зүйлүүдийг бүрэн тусгахын тулд Засгийн газар дараах зарчмуудыг удирдлага болгох болно.

1. Төрийн уян хатан бодлого: Уул уурхайн аж үйлдвэрийн хөгжил нь төрийн урьдчилан товлосон тогтвортой бодлого явуулахыг шаарддаг. Эл бодлого нь-ашигт малтмалыг эрж хайж олохоос эхлээд орд газрыг ашиглалтад оруулах хүртэл урт хугацаа их хөрөнгө шаарддаг, зардал ихтэй, зардлаа нөхөх хугацаа удаан, бүтээгдэхүүний зах зээл нь цаг үеийн шинжтэй зэрэг тус салбарын онцлогийг тусгасан байх шаардлагатай. Түүнээс гадна төрийн бодлого нь ашигт малтмалыг олборлож боловсруулах явцад хүрээлэгч байгаль орчинд учруулж болзошгүй хор хохирлыг урьдчилан тодорхойлж түүнээс урьдчилан сэргийлэх, сөрөг үр дагаварыг хамгийн бага зардлаар хамгийн үр ашигтай буруулах удирдлага зохион байгуулалтын аргыг бодож тусгасан байх ёстой. Шийдвэр гаргах эрхтэй төрийн зүтгэлтний үйл ажиллагаандaa тогтвортой хөгжлийн зарчмыг үндэс болгохын учир нь дээрхи хүчин зүйлүүдээс урган гарч буй хэрэг юм.
2. Зах зээлийн механизмын үүрэг: Зах зээлийн механизм бол хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны сонголт хийх, хүн хүчийг хувиарлах хамгийн үр ашигтай хэрэгсэл мөн. Уул уурхайн аж үйлдвэр зардал ихтэй ч гэсэн дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвартай байх ёстой гэдэг зарчмыг Засгийн газар баримтладаг. Ийм нөхцөлд уул уурхайн аж үйлдвэрийн амьдрах чадварыг ямар нэгэн зохиомол арга хэлбэрээр торгоох, тогтоон барих боломж байхгүй. Засгийн газар уул уурхайн салбарт хөрөнгө оруулах асуудалд хувийн хэвшлийнхэн гол үүрэг гүйцэтгэнэ гэж үздэгийн учир ч үүнтэй холбоотой. Тэд эрсдлийн түвшинг үнэлэх хөрөнгө хaa байршуулах талаар илүү сайн мэдрэмжтэй байдаг.
3. Төрийн зохицуулалтын үүрэг: Нийгмийн хэрэглээг хангахын тулд зарим тохиолдолд төрийн зохицуулалт хийх шаардлага гардаг. Иймэрхүү зохицуулалт нь ялангуяа хүрээлэгч орчныг хамгаалах, иргэдийн эрүүл мэнд, хүний аюулгүй байдлыг хангахад голчлон чиглэгдэх бөгөөд хууль, дүрэм, стандартыг үндэслэн уг үйл ажиллагаагаа явуулна. Аливаа зохицуулалт нь дараах зарчмууд дээр үндэслэсэн байх учиртай. Үүнд:
 - a) Төвийн ба нутгийн удирдлагын нэгдлийг хангах,
 - b) Зааж зааварлах, захирэн тушаах бус үр дүнгээ сайжруулахад чиглэсэн байх,
 - c) Уул уурхайн аж үйлдвэрийг дэлхийн зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулахын тулд үйл ажиллагааг нь ил тод байлгах, элдэв саатал, үргүй зардлыг багасгахад тус болох,
 - d) Зах зээлд үйлчилж буй гол хүчин зүйлүүдийг боломжоор хангах зэрэг зарчмууд чухал юм.
4. Төрийн бус зохицуулалтын үүрэг: Төрийн болон аж үйлдвэрийнхний харилцан ойлголцлыг бэхжүүлэх, шийдвэр гаргахад олон түмний оролцоог нэмэгдүүлэхэд төрийн бус зохицуулалтын ач холбогдол их байдаг. Сайн дурын үүсгэл санаачлага, хөтөлбөр зөвлөмж, санамж, хэв хэмжээ болон хүрээлэгч орчныг хамгаалах талаар авах арга

хэмжээний гэрээ, тохиролцоо зэрэг олон хэлбэрийн хамтын ажиллагаа нь шийдвэр гаргах үйл явцыг ил тод, олон түмний оролцоотой болгоход шилдэг арга юм. Иймэрхүү хэлбэрийн зохицуулалт нь хэлэлцэн тохирсон ажил хэрэгжүүлээгүй, хохирол учирсан тохиолдолд хариуцлага хүлээх, хүлээлгэх тогтолцоог бүрдүүлдэгээрээ ач холбогдол сайтай байна.

5. Шинжлэх ухааны ач холбогдол: Төрийн бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх шийдвэр гаргахдаа шинжлэх ухааны хамгийн бодитой мэдээлэл, тэдний дэвшүүлж буй хамгийн чухал саналыг түшиглэх нь зүйтэй. Ийм хандлагыг зөвхөн үндэсний түвшинд бус мөн олон улсын хэмжээнд ч баримтлах учиртай. Харин эрсдлийг үнэлхэд шинжлэх ухааны үүргийг хэт үнэлэх хэрэггүй байж болно.
6. Бохирдоос зайлсхийх зарчмыг дэмжих: “Бохирдлыг арилгах хөтөлбөр” Засгийнх байх ёстой. Энэ нь аюулгүй орчинд амьдрах хүний эрхийг хангах Үндсэн хуулиар хүлээлгэсэн төрийн үүрэг юм. Бохирдуулагч бодис, хаягдал гаргахгүй байх, хэмжээг хамгийн бага болгох технологи, материал, энерги, бүтээгдэхүүн ашиглаж хэрэглэх замаар хүний эрүүл мэнд, хүрээлэгч орчинд хохирол учруулах эрсдлийг арилгахад бүх үйл ажиллагаа чиглэгдэх ёстой. Бохирдлыг арилгахад бус бохирдол гаргахгүй байхад бодлого төвлөрөх ёстой.
7. Урьдчилан сэргийлэх зарчмын чухлыг хүлээн зөвшөөрөхийн учир: Шинжлэх ухааны бүрэн итгэл үнэмшил бий болоогүй, шалтаг шалтгааны холбоо тогтоогүй нөхцөлд бас хүрээлэгч орчинд учруулах үр дагавар хүнд, бүр сэргээгдэшгүй уршигтай байж болзошгүй нөхцөлд Засгийн газар шийдвэр гаргахад урьдчилан сэргийлэх зарчим чухал үүрэг гүйцэтгэдэг.
8. “Бохирдуулагч хариуцах” зарчмыг хүлээн зөвшөөрөхийн учир: “Бохирдуулагч хариуцах” зарчим нь Рио-Де-Жанейрогийн Тунхагийн 16 дугаар зүйлд тусгагдсан байна.

16 дугаар зарчим:

“Бохирдолтой холбоотой зардлыг зарчмын хувьд бохирдуулагч нөхөх ёстой гэсэн хандлагыг анхааралдаа авч, үндэсний төр засгийн байгууллага олон нийтийн сонирхолыг зохих ёсоор харгалзан үзэж, олон улсын худалдаа хөрөнгө оруулалтад саад учруулахгүйгээр экологийн зардлыг нөхөх, эдийн засгийн хэрэгслийг ашиглахад туслалцаа үзүүлэхийг эрмэлзэх ёстой”.

III. Монгол Улсын Уул уурхайн Аж үйлдвэрийн өрсөлдөх чадварыг яаж хангах вэ?

Экспортыг дэмжих бодлого

Хааяагүй хөрөнгийн зах зээл даяаршиж, хөрөнгө оруулалт чөлөөтэй болж буй нөхцөлд эрдэс баялгийн цогцолборын уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтын хойноос өрсөлдөх шаардлага нэмэгдэж байна.

Байгалийн нөөцийн адил нөхцөлтэй байгаа тохиолдолд ашигт малтмал олборлох салбарт ямар нөхцөл хангасан улс оронд хөрөнгө оруулах вэ? гэвэл:

1. Улс төрийн тогтвортой байдал хангагдсан,
2. Өрсөлдөх чадвартай татварын нөхцөлтэй,
3. Дэд бүтцийн хөгжил сайтай,
4. Мэргэжлийн ажиллах хүчний нөөцтэй,

5. Хууль эрх зүй, дүрэм журам, норматив сайтай, аливааг урьдчилан тодорхой мэдэх боломжтой.

Ийм нөхцөл төв орон нутгийн төрийн байгууллагууд хөрөнгө оруулалтын таатай нөхцөл үйл ажиллагаагаа нэгтгэж дотоод гадаадын хөрөнгө оруулагчдыг аль болох бүрэн тодорхой мэдээлэлээр хангах хэрэгтэй. Үүний тулд төрийн захиргааны байгууллагууд харилцан уялдаатай 2 чиглэлээр ажиллах нь зүйтэй.

1. Бодлого, зохицуулалт, санхүүгийн салбарт өөрчлөлт хийж сайжруулах замаар хөрөнгө оруулалтын таатай нөхцөл бүрдүүлэх,
2. Шинэтгэлийн нааштай үр дүнгээ үр ашигтай өргөн сурталчлах.

Хөрөнгө оруулагчдыг өөрийн орны чадавхи боломжийн талаар мэдээлэлээр хангахын тулд ашигт малтмалын хайгуул, экологийн хамгаалалт, байгалийн нөөцийг үр ашигтай ашиглах талаар өөрийн орны чадавхи, боломжийг хөрөнгө оруулагчдад өргөн мэдээлэхэд Засгийн газар онцгой анхаарна. Засгийн газар уг ажлыг орон нутаг, аж үйлдвэрийнхэн, хувийн хэвшлийнхэн, нутгийн захиргаадтай нягт хамтран “Нэг баг” болж гүйцэтгэнэ.

Санхүүжилт ба татвар

Монгол Улс ашигт малтмалын хайгуул, олборлолт, боловсруулалтын салбарт эрсдлийн хөрөнгө оруулалтын зах зээлд идэвхитэй байр суурь эзлэхийн төлөө тэмцэх хэрэгтэй. Ингэхийн тулд үнэт цаасны зах зээлийг эрчимтэй хөгжүүлэх шаардлагатай. Санхүүгийн чадавхи султай, эрсдэл ихтэй шинэ технологи бүхий үйлдвэрлэлд эрсдлийн капитал илүү ашигтай. Засгийн газрын санхүүгийн систем нь хөрөнгө оруулалтыг татах, өрсөлдөх чадварыг хангах, хөрөнгө оруулалтын таатай орчныг хангахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Монголын эдийн засаг эрдэс баялгийн нөөц дээр сууринсан байдлыг харгалзан Төрөөс тус салбарын санхүүжилтийн талаар тусгай бодлого баримтлах болно. Үүнд:

- Уул уурхайн үйлдвэрийн санхүүгийн горимыг хайгуулын эрсдэл, балансын нөөцийн эрсдэл болон энэ салбарын бусад өвөрмөц онцлогтой холбогдсон эрсдлийг бодолцон тогтоох,
- Уул уурхайн компаниудад гадаад орнуудын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг компаниудын эрсдлийн горимтой төстэй санхүүгийн горим олгох асуудлыг боломжийн хирээр шийдвэрлэх,
- Ашигт малтмалын ашиглалтын лицензийн төлбөр, татварын хэмжээг тогтоохдоо хөрөнгө оруулалтаа аль болох түргэн нөхөх шаардлага боломжкоо бүрэн ашиглаж чадаагүйгээс учрах эрсдэл зэргийг бодолзохын зэрэгцээгээр газрын хэвлэйн баялаг төрийн нийтийн өмч гэдгийг ч харгалзах учиртай болно.
- Уул уурхайн татварын системд ялгаварт түрээсийн систем нэвтрүүлэх боломжийг судлаж хэрэглэх чиглэлээр ажиллах.

Зохицуулалтын үр ашиг

Зохицуулах арга нь төрийн бодлогыг хэрэгжүүлэх Засгийн газрын чухал хэрэгсэл юм. Зохицуулалтын горим нь хөрөнгө оруулалтын орчин уул уурхайн үйлдвэрийн олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд мэдэгдэхүйц нөлөөлөх чадвартай, үр ашигтай байх ёстой. Аливаа дурэм, хэм хэмжээ, эрх зүйн акт нь экологи, эдийн засаг,

нийгмийн талаар төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрч анхааralдаа байлгах ёстай.

Ингэхдээ дээр дурьдсан арга хэрэгслүүдийг хэрэглэхдээ эрдэс баялгийн цогцолборын салбарт үйл ажиллагаа явуулдаг байгууллага хүмүүст чирэгдэл учруулахгүй байхыг нэгэн адил анхааран харьцуулвал зохино.

Төрийн зохицуулалтын системийг төгөлдөржүүлэх үйл явц нь байгаль хамгаалах ажлын үр дүнг дээшлүүлэх зорилттой нягт уялдсан байх ёстай.

Ашигт малтмал олборлох хүрээнд экологийн чиглэлтэй төрийн зохицуулалт хийхдээ хүрээлэгч орчныг хамгийн дээд стандартын түвшинд байлгах бодлогыг Засгийн газар баримтлана. Зохицуулалттай холбогдсон дүрэм, журам, шаардлагыг боловсруулахдаа Засгийн газар дараах зарчмыг баримтлана:

- Боловсруулалтын эхэн үеэс эхлэн сонирхогч талуудыг идэвхитэй оролцуулж шийдвэрлэх асуудал, зохицуулах хэлбэр хандлагыг хамтран тодорхойлох,
- Зохицуулалтын дүрэм журамд дурьдахгүйгээр тохирч болох нийтлэг бус асуудал, арга хэмжээг газар дээр нь тохиролцож хэрэгжүүлж хэвшүүлж болно.
- Агаар, усны чанарын стандартыг тухайн нутаг, бусийн байгалийн орчны өвөрмөц байдлын талаархи судалгаанд тулгуурлан боловсруулж байх,
- Дүрэм журам болон зохицуулалтын чанартай эрх хэмжээг боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулахдаа шинжлэх ухааны аргачлал, шалгуурт тулгуурлах, тухайн дүрэм журмын үр ашигтай эсэх, хүний эрүүл мэнд, байгаль экологид хэрхэн нөлөөлөхийг хянаж байх,
- Төрийн зохицуулалтын шинэтгэлийн үйл явц, үр дүнг хянаж олон түмэнд тайлагнах, тогтвортой хөгжлийн зорилт хэрхэн хэрэгжиж байгааг ард түмэн үнэлэж цэгнэх боломжоор хангах зэрэг зарчмууд юм.

Уул уурхайн үйлдвэрүүд үйл ажиллагаа явуулж байгаа нутаг газрынхаа экологийг хамгаалах талаар хүлээх хариуцлагаа улам өндөржүүлж ашигт малтмал, металлыг амьдралын мөчлөгийн бүх хугацаанд тэдгээрийг оновчтой үр ашигтай ашигласны төлөө Засгийн газар тухайн аж ахуйн нэгжийг дэмжиж урамшуулж байх болно.

Уран мэтийн өвөрмөц шинж чанартай ашигт малтмалыг олборлох боловсруулахад тавих хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа эрүүл мэндийн талаархи зохицуулалтаар Засгийн газар онцгой анхаарна.

Экспортыг дэмжих бодлого

Худалдан авагч уул уурхайн бүтээгдэхүүнийг хаана ямар нөхцлөөр авахаа шийдэхэд худалдааны болон худалдааны бус хүчин зүйлүүд их нөлөөлдөг. Тийм учраас экспортыг нэмэгдүүлэхийн тулд Засгийн газар аж үйлдвэрийнхэнтэй хамтран ажиллаж уламжлалт болон шинэ зах зээлд гарахад нь туслалцаа үзүүлнэ. Ингэхдээ бүтээгдэхүүнээ зах зээлд сурталчлах үүрэг хувийн хэвшлийнхэнд үлдэх юм. Экспортыг дэмжих талаар Засгийн газрын оролцоо дараах хэлбэртэй байна.

- Хувийн хэвшлийн мэдээлэл цуглуулах ажилд туслах, зах зээлийн талаар судалгааны чиглэлтэй мэдээлэлээр хангах,
- Эрдсийн түүхий эд, металлын гаралтай бүтээгдэхүүн, хүрээлэгч орчныг хамгаалах зориулалт бүхий бараа, ажил үйлчилгээний талаар уламжлалт болон шинэ зах зээлд зарлаж сурталчлах,

- Эрдсийн түүхий эд, металлын зах зээл дээр нээлттэй байх, Засгийн газар хоорондын бараа судлалын ажлын хэсгүүд болон түүнтэй төстэй байгууллага, механизмыг ашиглан мэдээлэл солилцох үйл ажиллагааг чухалчлах болно.

IV. Шинжлэх ухаан инновац, технологийн бодлого

Үндэслэл

Шинжлэх ухаан технологийг улс орны тогтвортой хөгжлийн үндсэн хүчин зүйлийн нэг болгон хөгжүүлж, үр ашигтай үндэсний инновацын тогтолцоог бүрдүүлэх. (Алсын харaa-2050. I үе шат 2025-2030).

1. Мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор судалгаа хөгжүүлэлт, инновацын санхүүжилтийн олон эх үүсвэрт тогтолцоо бүхий төр-шинжлэх ухаан-үйлдвэрлэл, бизнесийн түншлэлийн таатай орчин бүрдсэн байна.

II үе шат (2031-2040)

1. Нано, био, мэдээлэлийн технологи, хиймэл оюун ухаан зэрэг шинжлэх ухаан, инновацын тэргүүлэх чиглэлд оруулах хөрөнгө, нөөц болон бусад дэмжлэгийг нэмэгдүүлж, ногоон, цахим эдийн засаг, оюуны үйлдвэрлэлийн бүс нутгийн жишигт хүргэнэ. III үе шат (2041-2050) II үе шатны зорилтыг дэлхийн жишигт хүргэнэ.

Эрдэс баялгийн цогцолборын талаархи Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн бодлого нь тогтвортой хөгжлийг хангах зорилготой нягт уялдан дараах 4 зорилтыг эн тэргүүнд шийдвэрлэхэд чиглэгдэх болно.

1. Ажлын байрыг буй болгох (Шинжлэх ухаан, технологийн үр дунд ажлын байр нэмэгдүүлэх),
2. Эдийн засгийн өсөлтийг хангах (Экологид сууринсан экспортын чиглэлтэй эдийн засгийн бүтээцтэй болох),
3. Амьдралын чанарыг дээшлүүлэх (Хүний нөөцийн хөгжлийг чухалчлах),
4. Мэдлэгийг гүнзгийрүүлэх, өргөжүүлэх (Оюуны багтаамж ихтэй бүтээгдэхүүн ажил үйлчилгээг нэмэгдүүлэх).

Тэргүүлэх чиглэлтэй эдгээр 4 зорилтыг хөгжүүлэхийн зэрэгцээгээр Засгийн газар доорхи 2 зарчмыг баримтлах юм. Үүнд:

1. Эрдэс баялгийн цогцолборын бодлого шинжлэх ухааны бодит гүнзгий мэдлэг дээр тулгуурлан хэрэгжих болно.
2. Шинжлэх ухааны судалгаа нь төрийн бодлогын тэргүүлэх чиглэлийг түшиж явагдах болно.

Тийм учраас Засгийн газар нийтлэг асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байгаа шинжлэх ухааны болон улс төрийн байгууллагын холбоо хамтын ажиллагааг бэхжүүлэхийн төлөө ажиллах болно.

Ажлын ийм арга нь сонирхогч талуудын шаардлагад бүрэн нийцэхийн хамт нийгмийн сонирхолыг бүхэлд нь хангах боломжтой юм.

Эрдэс баялгийн цогцолборын Шинжлэх ухаан технологийн хөтөлбөр

Эрдэс баялгийн цогцолборын шинжлэх ухаан технологийн бодлогыг тодорхойлохдоо Засгийн газар дараах чиглэлийг баримтлана. Үүнд:

- Уул уурхайн олборлох аж үйлдвэрийн бүтээмжийг өсгөхийн тулд Аж үйлдвэрийн хувьсгалын зорилтыг нэвтрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг өргөн нэвтрүүлнэ. (ухаалаг уул уурхай, ухаалаг цооногийн систем)
- Эрдэс баялгийн цогцолборын компаниуд ялангуяа жижиг дунд үйлдвэрүүд гадаадын шинжлэх ухаан технологийн ололтыг ашиглах боломж, нөхцлийг бүрдүүлнэ.
- Гадаадын технологийн боловсруулалтыг түүний үнэт чанар, Монголын Уул уурхайн үйлдвэрлэлд хэрэглэх боломжийн талаас нь үнэлэлт өгөхийн хамт энэхүү технологи нь үндэсний шинжлэх ухаан технологийн ололтыг хэрхэн баяжуулах, юугаараа давуу болохыг тодорхойлно.
- Технологи дамжуулах, нутагшуулах ажлыг хөхүүлэн дэмжиж эрдэм шинжилгээний ажлын үр дүн, шинжлэх ухаан техникийн ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, иймэрхүү хөтөлбөрт хамтран ажиллагч оролцогчдын хооронд туршлага солилцох боломжийг өргөжүүлэн урамшуулна.
- Төрийн бодлогоор дэвшүүлсэн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд геологийн болон геологи-математикийн мэдээлэлээр хангах, ийм мэдээлэл цуглуулахад шаардагдах хэрэгслээр хангана.

Гадаад дотоодын зах зээлийг ашиглахад дөхөмтэй чухал мэдээлэл, туршлага технологийг үйлдвэрлэгчдийн хэрэгцээнд зориулан түгээж байна.

- ✓ Улс орны хэмжээний асуудлыг шийдвэрлэхэд хүчээ нэгтгэх, зохицуулах шаардлагатай үед хамтын ажиллагааг хөгжүүлнэ,
- ✓ Эрдэс баялгийн нөөцийн нөхөн үйлдвэрлэл, ашиглалтын оновчтой горимыг тогтоох талаар гадаад орон, олон улсын хөгжлийн байгууллагатай туршлага солилцохыг чухалчилна,
- ✓ Хүрээлэгч орчныг хамгаалах, бохирдоос урьдчилан сэргийлэх технологи, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, тоног төхөөрөмж бүтээж нэвтрүүлэхэд бүх сонирхогч талуудтай хамтран ажиллана.
- ✓ Өндөр үнэтэй боловсронгуй эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар эрдэс баялгийн нөөцийн ашиглалтаас олох ашгийг нэмэгдүүлэх, ажлын байр буй болгохын тулд аж үйлдвэрийнхэнтэй нягт хамтран ажиллана,
- ✓ Гадаадаас хөрөнгө оруулалт хийх, хамтарсан үйлдвэр байгуулах, лиценз, ноухау, тоног төхөөрөмж худалдан авах зэрэг хэлбэрээр дэвшилт технологи нэвтрүүлэх хэлбэрийг төрөөс хөхүүлэн дэмжинэ.

Шинжлэх ухаан техникийн хөгжлийн стратегийн чиглэл

Эрдэс түүхий эдийн шинжлэх ухаан техникийн хөгжлийн стратегийн чиглэлийн талаар Засгийн газраас сонирхогч талуудтай хамтран дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Өргөн хүрээтэй геологийн мэдээлэлээр хангах

- ✓ Монгол орны геологийн зүй тогтлыг судлан тогтоох, ашигт малтмалын орд, илэрцийг нээж илрүүлэх замаар уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг хангах болно. Геологи хайгуулын ажлын үр дүнг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтыг татахад геологийн судалгааны карт, геологийн мэдээлэл чухал үүрэгтэй байдгийг харгалзан Монгол орны нутаг дэвсгэрт 1:200 000-ны масштабтай геологийн зураглалд бүрэн,

1:50 000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажилд нийт нутаг дэвсгэрээ аль болохоор бүрэн хамруулах ажлыг эрчимжүүлнэ. Энэ ажлын явцыг хурдасгах, эцсийн үр дүнг дээшлүүлэх зорилгоор зайнаас тандах судалгаа, региональ болоод эрлийн геофизикийн аргуудыг өргөн хэрэглэх, судалгааны материалын боловсруулалтад орчин үеийн техник, технологи нэвтрүүлэх болно.

- ✓ Монгол Улсын нутаг дэвсгэрийн геологи, тектоник, ашигт малмал, геоэкологийн болон металлогенийн төрөлжсөн зургууд, геологийн төрөл бүрийн зургийг тоон хэлбэрт шилжүүлэн боловсруулах (Геологи-математикийн мэдээлэл). Үүний тулд “Геологийн зураглалын үндэсний хөтөлбөр” боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай (Национальная программа геологического картирования),
 - Геологийн жинхэнэ бодит судалгааны хүрээнд бүс нутгийг жигд хамруулах зарчмыг баримтлана. Ингэснээр бүс нутгийн сонирхолыг тэнцвэржүүлж тэнд ашигт малтмалын шинэ ордыг илрүүлэн ашиглаж хөгжлийн өсөлтийг хангах боломж бүрдэнэ,
 - Геологи хайгуулын ажлын шинэ аргыг нэвтрүүлж гүн тогтоцтой хүдрийн биеийг нээж уул уурхайн үйлдвэрийг нөөц өсгөх боломжоор хангах болно,
 - Геологийн судалгааны карт, мэдээллийг шуурхай түгээх мэдээллийн шинэ технологийг эзэмших ажлыг түргэвчилнэ.

2. Уул уурхайн олборлох аж үйлдвэрийн тогтвортой хөгжлийг хангах

Уул уурхайн олборлох аж үйлдвэрийн тогтвортой хөгжлийн олон чухал асуудлыг үр дүн сайтай шийдвэрлэхэд шинжлэх ухаан техникийн хөгжлийн түвшин, түүний шинэхэн ололтуудыг үйлдвэрт нэвтрүүлж буй байдал тэдгээрийг шийдвэр гаргахдаа хэрэглэх мэдлэг, дадлагын байдлаас ихээхэн шалтгаална. Үүнийг үндэслэн Засгийн газар ЭБЦ-ын шинжлэх ухаан-техникийн хөтөлбөрүүдэд дараах чиглэлийг тэргүүн зэргийн ач холбогдолтой гэж үзнэ.

2.1. Ашигт малтмалын олборлолтыг тогтвортой байлгах

- Энэ чиглэлийн хүрээнд шийдвэрлэх асуудалд:
 - Гүний ус шүүрүүлэх, ус цэвэршүүлэх ажил,
 - Усны орчны бохирдолтод тавих хяналт,
 - Уурхайн үйл ажиллагааг зогсоох, хаах, горимыг тогтоох,
 - Уурхайн эдэлбэр газрыг нөхөн сэргээх.
- Уурхайн эдэлбэр газрын хүрээнд биологийн төрөл зүйл, газрын физик химийн шинж чанарыг хадгалах, хамгаалах талаар нутгийн захиргаатай тохиролцох,
- Химийн идэвхитэй хаягдлыг булж хадгалах, хамгаалах горимыг тогтоох зорилгоор лабораторын болон талбайн туршилтыг хийж экологийн нормын түвшинд байлгах арга хэмжээг авах,

2.2. Уул уурхайн үйлдвэрлэлд ногоон хөгжлийн бодлогыг нэвтрүүлж байгаль орчны сөрөг нөлөөг багасгах

- Алсын хараа-2050-д Ногоон хөгжлийн талаар дэвшүүлсэн зорилтуудыг удирдлага болгон уул уурхайн үйлдвэрлэлийн байгаль орчинд учруулдаг сөрөг нөлөөг багасгана.

- Хөрс хуулалт багатай давхарга хэлбэрийн ордууд дээр ажиллаж байгаа ил уурхайнуудад жилийн газрын эвдрэлийн 70%-д тэнцэхүүц хэмжээний талбайд нөхөн сэргээлтийн ажлыг хийлгэх,
- Стратегийн үнэт баялаг усны зарцуулалтын судалгаа, нормативыг бий болгон усны бохирдол, зарцуулалт багатай ажилладаг үйлдвэрүүдийг урамшуулах тогтолцоонд орох,
- Хаягдал нөөцийг бүртгэлжүүлэх, ашиглалтын металл авалтын доод түвшинг ордуудын онцлогт тохируулан тогтоох, шаардлагатай тохиолдолд хаягдал ихтэй олборлогч үйлдвэрүүдийг зогсоох, хаягдал багатай технологи нэвтрүүлэлтэд татварын хөнгөлөлт болон бусад урамшуулал олгох журамд шилжих,
- Байгалийн баялгийн нөөц, экосистемийн үйлчилгээний үнэ цэн, даацыг тогтоож, үнэлгээг шинэчилнэ,
- Ашиглагдаж дууссан ордуудын орчим үүссэн газрын эвдрэл, байгаль орчны бохирдлыг хаягдал нөөц болон тухайн районд байгаа бусад ашигт малтмалын нөөцийн үнэлгээнд тулгуурлан нөхөн сэргээх боломжийг тодотгож, холбогдох арга хэмжээ авах,
- Олборлолтын ажлын үед нөхөн сэргээх боломжгүй ордуудын тодорхойлолтыг гарган нөхөн сэргээлтийн ажлын төлбөрийг ашиглалтын үед авч хуримтлал үүсгэн ордуудын нөөц дууссан үед нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгүүлэх хууль эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай. Үүнтэй уялдаатайгаар нөхөн сэргээлтийн ажлын норм, үнэлгээг иж бүрдэл хэлбэрээр боловсруулах шаардлагатай,
- Монгол Улсад хэрэглэгдэж байгаа болон шинээр оруулж байгаа орчин үеийн олборлолтын аргуудын (газрын дээр ба дор уусгах арга гэх мэт) байгаль орчныг хамгаалах стандарт, норм, тэдгээртэй холбогдсон технологийн журам, заавар бий болгох. Энэ асуудалтай уялдан олон талт үйл ажиллагаа бүхий уул уурхайн олборлолт, боловсруулалтын ажлыг цаашид хуульчлах.

2.3. Эрдэс, металлыг хор аюулгүй үр ашигтай боловсруулах экотехнологи

Энэхүү чиглэлийн хүрээнд гол анхаарал дараах зүйлд тавигдана.

- Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг үр ашигтай, экологийн аюулгүй нөхцөлд явуулах,
- Металл бүтээгдэхүүний эдэлгээний хугацааг уртасгах,
- Эрдэс ба металлаар хийсэн бүтээгдэхүүнийг хэрэглэснээс хүрээлэгч орчинд үзүүлэх сөрөг нөлөөг зөөллөхийн тулд энергийн хэрэглээг багасгах болон бусад аргыг эрж хайх,
- Металл хийц, бүтээгдэхүүний үйлдвэрлэлд дахин боловсруулсан материалыг аль болох өргөн хэрэглэх, металлын хаягдлыг дахин боловсруулах технологийг боловсруулах, нэвтрүүлэх,
- Металл ба хүрээлэгч орчны асуудалтай холбогдол бүхий дүрэм, заавар, бодлого боловсруулах шинжлэх ухаан техникийн найдвартай бааз бүрдүүлэх,
- Холимог металлын зарим ордыг түшиглүүлэн кабель, аккумуляторын батарей, цайрдсан нимгэн төмөр үйлдвэрлэх технологийг эзэмших,
- Алтны шороон ордуудыг ашиглаж буй үйлдвэрүүдийн хаягдал, балансын бус нөөцийг эргүүлэн ашиглаж, байгаль орчны бохирдлыг багасгах, жижиг ширхэгтэй тоосонцор алтыг ялган авах технологийн судалгааг эрчимжүүлж дүнг үйлдвэрт нэвтрүүлэх.

2.4. Хүний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн арга хэмжээг төгөлдөржүүлэх

Эрдэс баялгийн цогцолборын шинжлэх ухаан техникийн дэвшил, судалгааны ажил нь хүний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн арга хэмжээг төгөлдөржүүлэхэд чухал үүрэгтэй байна. Тавигдсан зорилгоо хэрэгжүүлэхийн тулд Засгийн газар дараах асуудлуудад тэргүүн ээлжинд анхаарлаа хандуулна:

- Газрын гүний болон ил уурхайн геотехникийн судалгаа,
- Уулын даралтын тогтвортойлжилт, уулын даралтыг удирдахад,
- Газрын доорхи тоног төхөөрөмжийн туршилтад
- Ашигт малтмалын олборлолтын үед уурхайчдын хөдөлмөр хамгаалалыг хангахтай холбогдсон дүрэм, стандартыг боловсруулах техникийн баазыг бэхжүүлэхэд,
- Уул-техникийн хяналтын албатай нягт хамтран ажиллахад,
- Дэд бүтэцийн найдвартай ажиллагааг хангахад.

3. Уул уурхайн олборлох аж үйлдвэрийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх

Шинжлэх ухаан техник бол уул уурхайн олборлох аж үйлдвэрийн өрсөлдөх чадварыг хангахад чухал хөшүүрэг юм. Шинжлэх ухаан техник нь шинэ технологи боловсруулахад тус болохоос гадна түүний үр дүнд зардал багасаж, бүтээмж өсөж, экологийн стандартыг мөрдөх боломж бүрддэг. Уул уурхайн олборлох аж үйлдвэрийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэхийн тулд шинжлэх ухаан техникийн ололтыг ашиглах талаар Засгийн газар дараах асуудлуудад анхаарлаа төвлөрүүлэх болно.

- Ашигт малтмалын орд бүрийн үүсэл тогтолцооны онцлогийн талаар мэдлэгээ өргөжүүлж гүнзгийрүүлэн судлахад,
- Геологи хайгуулын ажлын аргачлалд,
- Ашигт малтмалын олборлох ажлын механикжилт, автоматжилтад,
- Металлургийн боловсруулалтад,
- Үйлдвэрлэлийн энергийн ба материалын багтаамжийг багасгахад,
- Эрдсийн түүхий эдээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг дахин ашиглах, дахин боловсруулахад,
- Уул уурхайн компаниудын бүтээгдэхүүний экспортыг өргөжүүлэхэд туслахад,
- Ашигт малтмалын ордыг хайх, олборлох, хүрээлэгч орчны байдалд хяналт тавих, орчны бохирдолтой хийх тэмцэл, мэдлэг болон технологийг олон улсын зах зээлд борлуулах, солилцоход анхаарна.

4. Эрдсийн түүхий эдээр үнэ өндөртэй бүтээгдэхүүн боловсруулах

Эрдсийн түүхий эдийн анхдагч бүтээгдэхүүний үйлдвэрлэл даяаршиж байгаа нөхцөлд эрдсийн болон металлын төрлийн илүү үнэ цэнэтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь ажлын байрны чухал эх үүсвэр болдог.

Тогтвортой хөгжилд хүрэх зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн хүрээлэгч орчны чанарыг шаардлагын хэмжээнд хүртэл сайжруулж аюулгүй орчныг бүрдүүлсэн, энерги, материалыг үр ашигтай ашиглаж, өндөр үнэ цэнэтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг

компаниудад Засгийн газар Улсын шинжлэх ухаан технологийн хөтөлбөрүүдээр дамжуулан дэмжлэг үзүүлнэ. Үүнтэй холбогдуулан Засгийн газар:

- Компаниудтай хамтран шинэ технологийг боловсруулах, нэвтрүүлэх, өрсөлдөх чадвар, бүтээмж дээшлүүлэх үйл ажиллагаанд оролцно,
- Ижил сонирхолтой судалгааны байгууллагуудыг хамтарсан судалгаанд хүч хөрөнгөө нэгтгэн ажиллах, туслан гүйцэтгэгчээр гэрээ хэлцэл хийх ажлыг зохицуулах төвийн үүрэг гүйцэтгэхэд Засгийн газрын байгууллага идэвхитэй оролцно,
- Нефтийн судалгаанд супер компьютерийн технологийг нэвтрүүлэх,
- Нүүрсийг энерготехнологийн болон химийн түүхий эдийн чиглэлээр ашиглах, гидрогенизац, пиролизийн технологиор боловсруулах пилотын үйлдвэр байгуулах замаар технологийн туршилт, тохируулга, горим боловсруулна.
- Монгол орны өнгөт ба үнэт металл, ураны ордыг гүний болон нуруулдан уусгаж баяжуулах аргаар олборлох судалгааны хамтарсан эрдэм шинжилгээ, туршилт зохион бүтээх ажлыг тусгай хөтөлбөрөөр хэрэгжүүлэх.
- Фосфорит, циолит зэрэг уул-химийн түүхий эдийг боловсруулах. Тухайлбал:
 - Фосфорын болон азот фосфорын холимог бордоо үйлдвэрлэх технологи,
 - Өндөр цэвэршилттэй металл, нэгдлийг биоусгалт, хандлалт, шингээлт зэрэг экологийн цэвэр технологиор гаргаж авах.

V. Эрдсийн түүхий эд ба нийгмийн хөгжил

Эрдсийн түүхий эд ба металлтай холбоотой экологийн асуудал

Эрдсийн түүхий эд ба металл нь хүний нийгмийн хөгжлийг тэтгэгч юугаар ч сольшгүй хэрэглээний зүйлс юм. Хүний бие мах бодид байдаг өчүүхэн төдий эрдсийн зүйл, металл нь амьдралыг тэтгэгч чухал нөхцөл болжог. Тэгсэн атлаа зарим эрдэс, металлыг олборлох, баяжуулах, боловсруулах явцад хүний эрүүл мэнд болон хүрээлэгч орчинд сөрөг нөлөө үзүүлэх явдал байдаг. Эдгээр сөрөг нөлөөг багасгах, арилгахад чиглэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажил Засгийн газрын бодлогод багтах ёстай. Ийм арга хэмжээний хүрээнд хор нөлөө бүхий бодисын шинж чанар, үйлчлэх орчны талаархи шинжлэх ухааны мэдлэгийг өргөжүүлэн гүнзгийрүүлэх, хортой нөлөөллийн эрсдлээс хамгаалах, багасгах үр ашигтай арга замыг боловсруулж өргөн хэрэглэх зэрэг хүний эрүүл мэнд, хүрээлэгч орчныг хамгаалах талаар Засгийн газрын хүлээх үүргийг багтаан хэрэгжүүлвэл зохино. Нэгэнт Монгол Улсын эдийн засагт эрдэс баялгийн салбар тэргүүлэх байр эзэлдгийн хувьд түүнтэй холбогдсон эрүүл мэнд, экологийн асуудлыг шийдвэрлэх нь улс төрийн бодлогын чухал хэсэг байх ёстай юм.

Эрдэс баялгийн амьдралын мөчлөгийн удирдлага

Эрдсийн түүхий эд ба металлтай холбоотой эрүүл мэнд, хүрээлэгч орчныг хамгаалах асуудлыг шийдвэрлэхэд амьдралын мөчлөгийн удирдлагын зарчим чухал үүрэг гүйцэтгэнэ. Энэхүү зарчмыг олборлох, боловсруулах үйл ажиллагааны амьдралын мөчлөгт ч хэрэглэнэ, бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн хүрээнд ч хэрэглэнэ.

- Үйл ажиллагааны амьдралын мөчлөгийн удирдлагыг эрдсийн түүхий эдийг олборлох, металл боловсруулах тодорхой нөхцөлд үүсэх эрсдлийг бууруулах зорилгоор тухайлбал, хайгуул хийх, олборлох, баяжуулах, хайлуулах,

цэвэршүүлэх зэрэг үйл ажиллагаа бүрт тохируулан хэрэглэнэ. Удирдлагын энэхүү хүрээнд хаягдлыг цуглуулах, дахин ашиглах, зайлцуулах, бууллах, үйлдвэрлэлийн дамжлагыг ажиллагаанаас гаргах, ухсан, овоолсон газрыг нөхөн сэргээх ажлууд хамаарна.

- Бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн удирдлагыг төрөл бүрийн элемент, бодис, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, хэрэглэх, дахин ашиглах, дахин боловсруулах, устгах бүх үеүүдэд үнэлгээ өгсний үндсэн дээр тэдгээрийн сөрөг эрсдлийг арилгах зорилгоор хэрэглэнэ.

Эрсдлийн зэргийн үнэлгээ ба эрсдлийн удирдлага

Эрдсийн түүхий эд ба металлын амьдралын мөчлөгийн удирдлагын хүрээний асуудал дотор эрсдлийн зэргийн үнэлгээ ба эрсдлийн удирдлага багтдаг.

- Эрсдлийн зэргийг үнэлсэнээр ямар нэгэн үйл ажиллагаа болон бүтээгдэхүүнээс гаралтай бодисын болзошгүй сөрөг нөлөөний түвшинг тодорхойлдог.
- Эрсдлийн удирдлага гэдэг нь тодорхой эрсдлийн талаар авах арга хэмжээг боловсруулж шийдвэрлэж хэрэгжүүлэх үйл явцыг хэлнэ. Ингэхдээ эрсдлийн зэргийн үнэлгээний дүн, эдийн засаг, нийгэм эрх зүйн хүчин зүйлүүдийг бодож тусгаж байвал зохино.

Эрүүл мэнд ба хүрээлэгч орчин, аюулгүй ашиглах зарчим (ААЗ)

Аюулгүй ашиглах зарчим бол амьдралын мөчлөгийн удирдлагыг үргэлжлүүлэх өвөрмөц хэлбэр. ААЗ 2 хэсгээс бүрддэг. Энэ нь: Эрсдлийн зэргийг үнэлэх зарчим, Эрсдлийн удирдлагын зарчим.

ААЗ-ын тухай ойлголт зарим талаараа хөдөлмөр хамгаалалын ойголтуудтай тохирдог боловч энд гол асуудал ашиглалт дээр төвлөрдөг. Түүнээс гадна ААЗ нь “Эрсдэл”, “Ашиглалт” гэсэн 2 ойлголтыг байнга өөртөө агуулдаг.

Аюултай хог хаягдлын ашиглалт зохицуулалтын бодлого нь хүрээлэгч орчинд нөлөөлж байгаа болон хүрээлэгч орчноор дамжин нөлөөлөх боломжтой аюултай хог хаягдлын ашиглалтыг оновчтой зохицуулах шинжлэх ухааны үндэслэлтэй шийдвэр гаргах журмыг тогтоож өгдөг.

Аюултай хог хаягдлын ашиглалт, зохицуулалтын бодлого, ААЗ нь эрдсийн түүхий эд болон металлтай холбогдсон хоёр зарчмыг хүлээн зөвшөөрч бодлогоо түүнд зохицуулдаг. Тухайлбал:

- Байгальд тохиолдох эрдсийн түүхий эд болон металлууд нь хүрээлэгч орчноос ангид байх (салангид) бололцоогүй байдгийг,
- Зарим тохиолдолд эрдсийн түүхий эд болон металл агуулсан бүтээгдэхүүний ашиглалтанд тодорхой эрсдэл байдгийг харгалзан ашиглалтыг хориглох, үйлдвэрлэлийг нь аажмаар зогсоо буюу эдгээр бүтээгдэхүүнүүдийн хаягдлыг бүрэн устгахаас өөр аргагүй гэдэг 2 зарчим юм.

Аюултай хог хаягдлын ашиглалт, зохицуулалтын бодлогоор баяжигдсан ААЗ-н заалтын дагуу дараах зүйлүүдийг хүлээн зөвшөөрдөг:

- Эрдсийн түүхий эд болон металлыг олборлоод, тэдгээрээр бүтээгдэхүүн үйлдвэрлэн, ашиглаж, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын дагуу хүрээлэн буй орчинд нь буцааж шингээх,

- Эдгээр байгалийн нөөцийг зүй зохистойгоор ашиглавал нийгэмд их хэмжээний үр ашгийг өгдөг,
- Эрдэс болон металл агуулсан зарим бүтээгдэхүүн эрүүл мэнд, экологид хохирол учруулж болох учраас тийм бүтээгдэхүүний ашиглалтыг амьдралынх нь бүхий л мөчлөгийн туршид шорооноос шороо болтол нь зохицуулах ёстой,
- Эрдсийн түүхий эд, металл мэтийн байгальд тохиолдох органик биш бодисуудын шинж чанар нь нийлэг органик химийн бодисуудын шинж чанараас ялгаатай байдаг учир эдгээр бүлэг бодисуудын хувьд эрсдлийн удирдлагын янз бүрийн аргуудыг хэрэглэх ёстой,
- Үйлдвэрлэлийг нь үе шаттайгаар хориглох буюу зогсоох, эсвэл олборлолтыг бүрэн зогсоох асуудал нь эрдсийн түүхий эд болон металлаас шалтгаалдаггүй.

Аль ч Засгийн газар ААЗ-ыг дэмжин түүнийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж, эрдсийн түүхий эд болон металлууд, дайвар бүтээгдэхүүнүүд тэдгээрийн ашиглалттай холбоотой асуудлуудыг олон улсын байгууллагуудаар батлуулах бодлого баримталдаг.

Аюулгүй ашиглах зарчмыг тодорхойлж, амьдралд хэрэгжүүлэх

АЗ-ын гол санаа нь амьдралаар батлагдсан оновчтой аж ахуйг эрхлэхэд үндэслэгддэг хэдий ч эрдсийн түүхий эд болон металлыг ашиглах хандлагыг тодорхойлдог. Практик талаас авч үзвэл дээрхи ААЗ нь эрсдэлийн зэргийн үнэлгээг илэрхийлэх бөгөөд энэ нь эрдсийн түүхий эд болон металл агуулсан бүтээгдэхүүний ашиглалттай холбоотой амьдралын мөчлөгийн янз бүрийн түвшинд хийгддэг. Үнэлгээний үр дүнг эрсдэл бууруулах сайн арга боловсруулахад ашигладаг. Зарим тохиолдолд тодорхой төрлийн бүтээгдэхүүн, түүнчлэн тодорхой зорилгоор ашиглаж байгаа бүтээгдэхүүнтэй холбоотой эрсдлийн хяналтыг удирдлагаар хангах боломжгүй гэж тооцдог. Ийм тохиолдолд Засгийн газар тодорхой төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэхийг эсвэл тодорхой зорилгоор бүтээгдэхүүн ашиглахыг зогсоон хориглодог байна. Засгийн газар ААЗ-ын практик хэрэгжилт, аюултай хог хаягдлын ашиглалт, зохицуулалтын бодлогын заалтыг үндэслэн өөрийн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлно. Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл нь:

- ААЗ-ыг практикт хэрэгжүүлэх стратегийг боловсруулж ашиглах зорилгоор Засгийн газар Уулын баяжуулах үйлдвэрүүдтэй хамтран ажиллах шаардлагатай. Ийм стратегид, тухайлбал амьдралын мөчлөгийн зарчимд тулгуурласан аж ахуйн оновчтой хөтөлбөрийг батлах асуудлыг багтаадаг. Уул уурхайн үйлдвэрүүд нь эрдсийн түүхий эд болон металлтай холбоотой эрүүл мэнд, экологийг хамгаалах асуудлыг шийдэхэд чухал үүрэг гүйцэтгэх ёстой.
- Эрдсийн түүхий эд болон металл тэдгээрээс гарган авах бүтээгдэхүүнд хамаарах эрүүл мэнд, экологи хамгаалах санаачлагын хүрээнд ААЗ-аар дэлхийн орнуудтай хамтран ажиллах.
- Эрдсийн түүхий эд болон металл, тэдгээрт хамаарах бүтээгдэхүүнийг аюулгүй ашиглалтын хүрээнд шинжлэх ухаан техникийн дэвшилийг тооцсон зохих бодлогыг боловсруулах үйл ажиллагаанд орон нутгийн засаг захиргааг татан оруулж, сонирхсон талуудтай хамтран үйл ажиллагаа явуулах үр ашигтай механизмыг буй болгохыг эрмэлзэх.

Эрдсийн түүхий эд болон металлын дахин боловсруулалт

Өнөөдөр дэлхийн хүн ам өсөн нэмэгдэж, олон улсын зах зээл дээр эдийн засаг, нийгмийн хөгжилд нэн чухал түүхий эд болох эрдэс, металлын эрэлт хэрэгцээний түвшин нэмэгдэж байгаа ба цаашид ч өсөх хандлагатай байна. Эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаа нь Засгийн газрыг эрдсийн түүхий эд болон металлын нөөцийн ашиглалттай холбогдсон, ялангуяа нөөцийг хойч үедээ ашиглуулахаар үлдээхтэй холбогдсон асуудал дээр анхаарал хандуулж энэ чиглэлээр стратеги боловсруулахад хүргэж байна.

Эрдсийн түүхий эд болон металлын нөөцөд нөлөөлдөг хэд хэдэн хүчин зүйлүүд байна. Эрэлт хэрэгцээний улам өсөн нэмэгдэж буй өндөр хурдацад эрдсийн түүхий эд болон металл үндсэн эх үүсвэр болж байгаагийн учир нь шинээр олборлож буй ашигт малтмалууд дахин боловсруулалтанд оруулах хоёрдогч нэн чухал түүхий эдийн эх үүсвэр бодлогт оршино.

Эрдсийн түүхий эд болон металл өөрийн үнэ цэн, тогтвортой шинж байдал, бат бэх удаан эдэлгээ, химийн шинж чанар, эрэлт хэрэгцээ, зориулалтынхаа хувьд ямар нэгэн хязгаарлалтгүйгээр ашиглагдах бололцоотой. Тийм учраас дахин боловсруулагдсан материалууд хангамжийн хоёрдогч чухал эх үүсвэр болох бөгөөд дотоод гадаадын зах зээл дээр урт хугацааны гэрээний дагуу тухайн үеийн үнэ ханшаар худалдаалагддаг. Түүнчлэн дахин боловсруулалт нь хүрээлэн буй орчныг хамгаалахад хамгийн тустай байдаг.

Дахин боловсруулалт нь металлын амьдралын мөчлөгийг уртасгахын зэрэгцээ хогийн овоо, хог шатаалтыг багасгаж, металлын үйлдвэрлэлд зайлшгүй шаардагдах энергийн хэрэглээ, анхдагч эх үүсвэрээс металл хайлуулахаас илт хэмнэлттэй. Иймээс дэлхийн Засгийн газрууд байгаа нөөц дээрээ үндэслэн дараах бодит давуу талуудыг тооцон бий болгож ашиглах чиглэлийг баримталж байгааг дэмжих. Үүнд:

- Үр ашгийг дээшлүүлэх, дахин боловсруулалтыг явуулахад саад болж байгаа аливаа шаардлагагүй хаалт хоригуудыг үгүй болгон ашигтай ажиллах зорилгоор бусад сонирхсон талуудтай нутаг дэвсгэр, бүс нутгийн хүрээнд хамтран ажиллах,
- Хаягдал төмрийг цуглуулах, ангилах, ялган авах ажиллагаанд тэргүүний технологийг хэрэглэж, дахин боловсруулах ажлын үр дүнг сайжруулахад хамтран ажиллах, дахин боловсруулалтанд оруулахаар ялгасан бүтээгдэхүүний боловсруулалттай холбогдсон үйл ажиллагааг дэмжих,
- Заавал цэвэрлэн зайлцуулах ёстай хортой, аюултай хог хаягдал дотор дахин боловсруулалтанд орох боломж бүхий металл агуулж буй “хаягдал” байдаг тухай ойлголтыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрч ашиглах чиглэлээр хамтран ажиллах. дэмжүүлэх.

Металлыг дахин боловсруулж түүний үр ашигтай эдэлгээ, хэрэглээний хугацааг уртасгах

Металлын дахин боловсруулалт, түүнээс гарах бүтээгдэхүүний ашиглалт зэрэг нь тухайн орны дотоодын болон олон улсын худалдаа, бизнесийн аргад үндэслэгддэг. Дахин боловсруулалтаас гарган авах үнэт металл, бүтээгдэхүүнүүдэд дэлхийн нийт хэрэглээний 30-60% оногддог учир тэдгээрийг гарган авахад ашигладаг түүхий эдийг хаягдал гэж үзэх учиргүй юм.

Дахин ашиглалтад орох металлуудыг одоогоор “хаягдал” гэж нэрлэдэгээс тэдгээрийг ашиглахад саад учирдаг боловч эдгээр металлуудыг боловсруулах үйлдвэрийн

чухал түүхий эд гэж үздэг. Дахин боловсруулалтад орж болох металл ба металл агуулсан материалуудын эрсдлийн зэргийн үнэлгээний үр дүнг үндэслэн уг асуудлыг шийдвэрлэх ёстой.

Энэ нь аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, түүнийг зайлзулахад тавих хяналтын талаархи Базелийн конвенцид заагдсан хилийн хязгаарлалтын үйлдлээс дахин боловсруулалтанд орох хоёрдогч металл агуулсан материалуудыг хасуулах асуудлыг уг зөвлөлгөөнөөр хэлэлцүүлэхээр оруулна гэсэн уг. Иймээс үнэтэй нөөцийг бүрэн ашиглахын тулд олон улсын хэмжээнд хоёрдогч түүхий эд хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюулгүй болохыг харилцан нотолсон хяналтыг хангах талаар хамтран ажиллах шаардлагатай.

“Хаягдал” гэсэн тодорхойлолтыг авч үзэхдээ олон улсын хүчин төгөлдөр эрх зүйн актууд, түүний дотроос Эдийн засгийн хөгжил, хамтын ажиллагааны байгууллагын (ОЭСР) Зөвлөлийн шийдвэрүүд, мөн аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх тухай асуудлын хяналтын тухай Базелийн конвенцийн зарчмыг иш үндэс болговол зохино.

Өнөөгийн байдлаар дахин боловсруулсан металлын ашиглалтын асуудал нэгдсэн ойлголтод хүрээгүй боловч энэ чиглэлээр баримтлах үндсэн зарчмуудыг дараах байдлаар ангилж болох юм. Үүнд:

- Хор нөлөө, аюул багатай металл болон металл агуулдаг материал, түүнийг дахин ашиглахад тавигдах шаардлага, үзлэг шалгалтыг журамлах,
- Хүний эрүүл мэнд, хүрээлэгч орчинд нөлөө багатай аюултай металл болон металл агуулдаг материал, түүнд тавих шаардлага,
- Аюултай металл болон металл агуулдаг материал, түүнийг дахин ашиглах үед хийгдэх хүрээлэгч орчин болон экологит нөлөөлөх нөлөөг илрүүлэхэд чиглэгдсэн үзлэг шалгалтад хамаарулах гэх мэт.

Уулын ажлын нөхөн сэргээлт

Уулын ажлын нөхөн сэргээлтийн зорилго нь ашигт малтмалыг ашигласны дараа тэр хэсэгт хүн амьдрах таатай орчин үүсгэх, хүрээлэгч орчны экологийн тэнцвэрт байдлыг хадгалан үлдээх шаардлагыг хангасан байх ёстой. Засгийн газар нь уулын ажлын нөхөн сэргээлттэй холбогдсон эдийн засаг, техник, шинжлэх ухааны олон төрлийн шийдвэр гаргахад хуучны адил гол үүргийг гүйцэтгэж байна.

Засгийн газар уулын ажлын нөхөн сэргээлтийг орон нутгийн удирдлага, эрдэс баялгийг эзэмшигч, ашиглагчийн үүднээс хяналт тавих үүрэгтэй гэж үздэг. Засгийн газар нь ашигласан ордуудын нөхөн сэргээлтийн ажилд хяналт тавих үүргээ дараах чиглэлээр гүйцэтгэх. Үүнд:

- Ордуудын нөөц нь дууссаны дараах нөхөн сэргээлтийн ажлыг цаашид эдгээр газруудыг ашиглахад муу нөлөө үзүүлэхгүйгээр хийгдсэн эсэхэд хяналт тавих,
- Ордуудыг ашиглахад гаргасан хөрөнгө оруулалтын зардалтай адил хэмжээний анхаарал татахуйц зардлыг нөхөн сэргээлтийн үед гаргаж байгаа эсэхэд хяналт тавих,
- Үйлдвэр Засгийн газрын хоорондын хамтын ажиллагаа үр дүнтэй байх механизмыг бий болгох, ашигласан газрыг хаахад зохих зардал гаргасан эсэхэд хяналт тавих.

Түүнээс гадна Засгийн газар нь уулын ажлын нөхөн сэргээлттэй холбоотой эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн олон төрлийн шийдвэр гаргахад гол үүргийг гүйцэтгэнэ.

Уулын малталтын нөлөөнд автсан газрыг нөхөн сэргээх ажлыг чанартай гүйцэтгэх чухал нөхцөл бол уг ажлыг харилцан уялдаатай, нарийн дараалалтай хийж тэргүүний туршлага арга барилаар баяжуулж байх явдал юм. Засгийн газар нөхөн сэргээлтийн талаар нийтлэг хатуу журам тогтоон мөрдүүлэх хэрэгтэй.

Уулын малталтаар унаган төрхөө алдсан газрыг нөхөн сэргээх төлөвлөгөөг уурхай байгуулах зураг төслийн салшгүй хэсэг болгон боловсруулж хэрэгжүүлэхийн хамт, уг ажлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг баталгаажуулах, тэхдээ зөвхөн нэг удаагийн нөхөн сэргээлтээр хязгаарлахгүй, шаардлагатай гэж үзвэл тухайн газар нутгийг урт хугацаагаар тордох зардлыг санхүүжүүлэх баталгааг гаргуулах хэрэгтэй.

Засгийн газар өнөөгийн ажиллаж буй болон төлөвлөгдеж буй уулын үйлдвэрийн нөхөн сэргээлтийн асуудлыг шийдвэрлэж журамлахын хамт урьд өмнө ашиглаж байгаад нөхөн сэргээлгүй орхисон уурхайн эдэлбэр газрын асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

Иймэрхүү эзэнгүй хаягдсан, нурж эвдэрсэн уурхайн талбай, газар тухайн нутгийн экологид хохирол учруулахын зэрэгцээ хүний эрүүл мэндэд хортой нелөөлж, нийгмийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байдлаас урьдчилан сэргийлэх.

Засгийн газар өөрийн хүчээр болон олон улсын байгууллагатай хамтран тухайн байдлыг үнэлж, сонирхогч талуудын хүлээж авч болохуйц уг ажлыг санхүүжүүлэх механизмыг олох талаар ажиллах хэрэгтэй.

Удаан хугацаанд хадгалагдаж орчныг бохирдуулах эх үүсвэр байж болзошгүй баяжуулах фабрикийн хаягдлыг хадгалах байгууламж, ураны уурхайн хаягдлын овоолго бүхий газрын нөхөн сэргээлтэд онцгой анхаарч өвөрмөц арга хэмжээ авах асуудлыг Засгийн газар анхааралдаа авч хянавал зохино.

Газар ашиглах эрх эдлэх боломж

Уул уурхайн аж үйлдвэр Монголын эдийн засагт чухал хувь нэмэр оруулсаар байхын тулд ашигт малтмалын шинэ ордыг нээн илрүүлэх шаардлагатай. Монгол Улс өөрийнхөө байгалийн баялгийн чадавхийг бүрэн ашиглахын тулд уул уурхайн салбарт зөвшөөрөгдсөн болон төрөөс тогтоосон хязгаарлалтын хүрээнд эрэл хайгуул, ашиглалт явуулах газар ашиглах эрх эдлэх боломж олгох шаардлага гарна. Ийм эрх олгохын хамт Засгийн газар дараах нөхцлөөр хангавал зохино. Үүнд:

- Ашигт малтмалын орд олж илрүүлсэн тохиолдолд уул уурхайн компани уг ордыг ашиглах эрхийн баталгааг тусгай зөвшөөрлийг хууль тогтоомжид заагдсан бүх шаардлагыг хангаж, холбогдох зөвшөөрлийг авсны дагуу олгох,
- Ашигт малтмал олборлох зорилгоор газрын хэвлийг ашиглах хугацаа, байгаль орчны унаган төрхийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ, газар ашиглах эрхээ алдах болон нөхөн төлбөрийн талаар хөрөнгө оруулагчид ил тод мэдээлж, харилцан тохиролцож байх,
- Тусгай хамгаалалттай газар нутгийн талаар баримтлах Төрийн бодлого, хууль тогтоомжийг нарийн чанд дагаж мөрдөх, биелэлтэд хяналт тавьж хамтарч ажиллах.

Тусгай хамгаалалттай газар нутаг

Газар нутгийг тусгай хамгаалалтад болон орон нутгийн хэрэгцээнд авч түүний үйл ажиллагааг удирдан явуулахдаа улс орныхоо нийгэм эдийн засгийн хөгжилд уул уурхайн аж үйлдвэрийн гүйцэтгэх үүрэг, ач холбогдлыг бодолцох ёстой.

Ингэхдээ эрдэс түүхий эдийн нөөц ихтэй газар нутгийг хууль болон байгаль орчныг хамгаалах сонирхолд харшилаарагүй байвал Дархан Цаазтай газрын хүрээнд оруулахгүйгээр үлдээж ашигт малтмалыг нь ашиглахыг эрмэлздэг. Энэ зарчмаас үүдэн Засгийн газар дараах бодлогыг баримтлавал зохино.

- Газар нутгийг Дархан цаазтай болгох бодлогыг боловсруулж, шийдвэрлэхдээ шинжлэх ухааны хамгийн найдвартай үндэслэлийг ашиглах, байгаль орчны талаархи нутгийн уламжлал, мэдлэг, санал бодлыг түшиглэх, газар зүй, хүн амын өсөлт хөдөлгөөний байдал, тухайн бус нутгийн аль нэг хэсэгт ашигт малтмалын ордыг ашиглах боломжтой зэргийг харгалзан үздэг байх,
- Ашигт малтмалын ордыг ашиглах шаардлага гарвал түүнийг зөвхөн онцгой чухал нөхцөлд, нийгэм эдийн засгийн үр дагаварыг сайтар судалж үзсэний үндсэн дээр шийдвэр гаргаж байх,
- Ийнхүү шийдвэр гаргахдаа сонирхогч талуудтай юуны түрүүн нутгийн засаг захиргаа, иргэдийн төлөөлөгчид, төрийн бус байгууллага, аж үйлдвэрийнхэнтэй харилцан зөвлөлдөж тохиролцох шаардлагатай.

Тусгай хамгаалалттай газар нутгийн хэсгийг “Дэлхийн Парк”-ийн статустай болгох тухай

Монгол орны нутаг дэвсгэр нь Дэлхийн болон бус нутгийн экологийн тэнцлийг хангахад чухал нөлөө бүхий тогтоц байршилтай эх газрын эрс тэс уур амьсгалтай өндөр уулын, ойт хээрийн, тал хээрийн, цөлөрхөг хээрийн, цөлийн бүсүүдийг өөртөө агуулсан Дэлхийн усны хагалбар газар нутаг билээ. Хөвсгөлийн уулс Байгаль нуурын эх болдог. Зүүн хэсэгт Монголын тэгш өндөрлөгийн хагас нь Амур мөрний эх болж уг мөрөн зүүн тийш Хятад руу урсдаг.

Рамсарын конвенцид бүртгэлтэй 6 газар Монголд байдаг. Олон улсын хамтын ажиллагаа хэрэгждэг дээрхи газруудын ихэнх нь Тусгай хамгаалалттай газар нутагт багтдаг Үндэсний паркийн статустай бөгөөд Монгол-Хятад, Монгол-Оросын хилийн дагуу оршдог болно.

Монгол орон олон янзын эндемик ба гоц ашигт ургамлын өлгий нутаг юм. Тухайлбал: 136 төрлийн хөхтөн, 436 зүйлийн шувуу, 22 зүйлийн мөлхөгч, 8 зүйлийн загас, 3000 зүйлийн дээд ургамал, 937 зүйлийн личен байдаг. Дээрхи зүйлийн ихэнх нь ховор буюу ховорт ордог. Монгол Улсын газар нутаг Дэлхийн болон бус нутгийн экологид онцгой байр эзэлдэг учраас тус улсын нутгийн зарим хэсэг Дэлхийн Тусгай хамгаалалттай газар нутгийн жагсаалтад бүртгэгдэн хамгаалагдаж байна. Тухайлбал:

1. Дэлхийн “Хүн ба шим мандлын нөөц газрын сүлжээ (МАВ)”-нд Говийн Их Дархан цаазат газар 1991 онд, Богдхан Уулын Дархан цаазат газар 1996 онд, Увс нуурын ай савын Дархан цаазат газар 1997 онд тус тус хамрагдаад байна.
2. Олон улсын ач холбогдол бүхий ус намгархаг газар ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай Рамсарын Конвенцийн хавсралт жагсаалт (Ramsar site)-д Монголын Дагуурын Дархан цаазат газар 1997 онд, Тэрхийн цагаан нуур, Өгийн нуур, Говийн нууруудын хөндий (Орог нуур, Таацын цагаан нуур, Бөөн цагаан нуур, Адгийн цагаан нуур) 1998 онд, Хар ус нуурын Байгалийн цогцолборт газар, Айраг нуур 1999 онд тус тус бүртгэгджээ.
3. Зүүн Хойд Азийн Тогоруу хамгаалах олон улсын сүлжээнд Сонгол Дагуурын Дархан цаазат газар 1997 онд,

4. Зүүн Хойд Азийн Галуу, нугасны овгийн шувуудыг хамгаалах олон улсын сүлжээнд Тэрхийн цагаан нуур, Өгийн нуур 1999 онд бүртгэгдсэн байна.
5. Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гаас дэлхийн нийтийн хэмжээнд зайлшгүй хамгаалах шаардлагатай гэж үзсэн 200 эко бүс нутгийг тогтоогоод үүнийг хэрэгжүүлж чадвал ХХI зуунд дэлхийн биологийн төрөл зүйлийн 95%-ийг устах аюулаас сэргийлэн хамгаалж чадах боломжтой гэж эрдэмтэд үзэж байгаа ажээ. Энэ 200 эко бүсэд Монгол Улсын Дагуурын хээр тал (Дорнод аймаг), Алтай Соёны уул нурууд багтдаг байна.
6. Хөрш зэргэлдээ улс орнуудтай хамтран олон талын хил дамжсан Дархан газруудыг байгуулж хамтран хамгаалах хэлбэрийг хөгжүүлэх нь чухал ач холбогдолтой. Монгол Улсын “Монгол Дагуур”-ын Дархан цаазат газар, Оросын Холбооны Улсын “Даурский” Дархан цаазат газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын “Далай нуур” Дархан цаазат газрыг хамруулсан нутгийг хамтран хамгаалах 3 улсын яам хоорондын хэлэлцээрийг 1994 онд байгуулжээ.
7. 2000-2004 онд Дэлхийн соёлын болон байгалийн өвд (World Heritage)-ийн жагсаалтад Увс нуурын ай сав газрыг, Хустайн байгалийн цогцолборт газрыг дэлхийн Хүн ба шим мандлын нөөц газрын сүлжээнд хамруулсан бөгөөд цаашид Говь гурван сайхны Дархан цаазат газрын “А” хэсэг, Хөвсгөл нуурыг бөө мөргөлтэй цаатангүүдүн нутгийн хамт, мөн эртний тахилгат Отгон тэнгэр уул, Богдхан уул, Бурхан халдун уул, Алтан овоо зэрэг газруудыг хамруулах бодлого байдаг.
8. НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр, Даян дэлхийн байгаль орчны сан (GEF), Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF), ХБНГУ-ын техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг (GTZ), Нидерланд Улсын Засгийн газар, Олон улсын “Тахь” хамгаалах сан, АНУ-ын дотоод хэргийн департмент, Олон улсын хөгжлийн агентлаг, АНУ-ын Филадельфийн Байгалийн шинжлэх ухааны академи зэрэг байгууллагуудтай ТХГН-ийн чиглэлээр олон арван төсөл хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж байна.

Олон улсын хамтын ажиллагааны эдгээр хэлбэрийг үргэлжлүүлэн хөгжүүлж, Монгол Улсын нутаг дэвсгэрийн 30%-ийг Тусгай хамгаалалттай газар нутаг болгох зорилтыг хэрэгжүүлж түүнийхээ зарим хэсгийг Дэлхийн паркийн статустай болгож үүнийхээ төлөө нөхөн олговорын хэлбэртэй санхүүжилт авч эдийн засгаа хөгжүүлэхийг Төрийн бодлого болгон НҮБ-аар дэмжүүлж өндөр хөгжилтэй орнуудын оролцоотойгоор хэрэгжүүлэх нь зөвхөн Монгол Улсын тогтвортой хөгжлийн үндсэн зорилтын нэг төдийгүй Дэлхийн болон бүс нутгийн тогтвортой хөгжилд чухал ач холбогдолтой болно. Энэ зорилтын эхний алхам болгож ЮНЕСКО-ийн Дэлхийн Геопаркийн сүлжээнд Шар цав дахь үлэг гүрвэлийн мөрт газар, Ханбогдын боржин чулуут газар зэргийг оруулах

VI. Эрдэс баялгийн салбарын эдийн засгийн гадаад харилцаа

v. Төсвийн өсөлтөнд хийсэн үнэлгээ зэрэг төслүүдийн эдийн засгийн үр ашгийн үзүүлэлтүүдэд үнэлгээ хийсэн байdag.

Ийм судалгааны үр дүнд Казакстан Улст цагаан тугалгын хүдэр олборлох болон боловсруулах төслийн явцад гарсан нэмүү өртийн өсөлтийг эдийн засгийн үндэслэлтэй болохыг тогтоосон.

Зохиогчдын үзэж байгаагаар MCP /эрдэс баялагийн нөөц/ үнэлэх үнэлгээний явцад технологийн дамжлага /ЦДС-нэмүү өртийн гинжин холбоо/ эрдсийн түүхий эдийн анхан шатны боловсруулалт болон олборлолтын явцад хязгаарлагддаг. Иймд эрдэс баялагийн түүхий эдийг дахин боловсруулах, олборлох үеийн хөндлөнгийн нөлөөлөл эдгээр боловсруулсан загваруудад үнэлэгдээгүй байдаг. Эрдсийн хөрөнгийн үнэ цэнийг тооцоолсон тооцоо эдгээрт мөн ороогүй байдаг.

Өнөө үед ашигт малтмалын ордуудыг судлах, шинжлэх явцын гадаад /эсвэл экстернал/ хүчин зүйлүүдийн үүсэл, үнэлгээ нилээд маргаан үүсгэсэн сэдэв болоод байгаа. Нэг талаас нэлээд олон ажлуудад байгалийн баялгийг ашигладаг салбаруудад үүсдэг гадаад хүчин зүйлүүдийг судалж, ангилж, тодорхойлж ирсэн байдаг. Нөгөө талаас судлаачдын дунд шинжлэх ухааны үзэл баримтлалд нь нэгдсэн нэг зүйл ажиглагддаггүй.

Ихэнх судалгааны ажилдаа гадаад хүчин зүйлийн судалгаа, амьд байгальд үзүүлэх нөлөөлөл, экосистемийн чанар буурч байгаа зэрэгт түлхүү анхаарсан байдаг. Тогтвортой хөгжлийн нөхцөлд гадаад хүчин зүйлийн нөлөөллийг судлах нь онцгой чухал болох нь маргашгүй зүйл. Үүний зэрэгцээ зохиогчид батлагдсан ашигт малтмалын ордуудын ашиглалтын техникийн төслүүдийг чанартай болжээ гэсэн саналыг дэмждэг. Яагаад гэвэл тэдний судалгааны ажилд эрдэс баялгийн нөөцийн олборлолт, боловсруулалтын үйл ажиллагаанаас хүрээлэн байгаа орчин болон нийгэмд үзүүлэх нөлөөллийг тооцсон байдаг. Иймдээ ч эрдсийн хөрөнгийн үнэлгээ хийхэд ийм гадаад хүчин зүйлсийн нөлөөллийг нэмж тооцох хэрэг гардаггүй. Гаргах зардал болон үр дүнг хөрөнгө оруулалтын төслийн эдийн засгийн үр дүнг тооцоходо аль хэдийнээ тооцоод гаргачихсан байдаг.

Үнэлэх, таньж тодорхойлох талаас нь авч үзвэл уулын ажлын амьд биш орчинд /хөрс, геологийн/ үзүүлэх гадаад хүчин зүйлийг тодорхойлох нь илүү төвөгтэй. Газрын хөрсний нөөцийн ашиглалт, нөөцийн шавхагдал зэргээс үүсэх нийгмийн, эдийн засаг, экологийн үр дагавруудтай холбоотой түр зуурын гадаад хүчин зүйлс илүү их төвөг учруулдаг.

Профессор ИПКОН РАН Е.И.Панфиловын тэмдэглэн хэлснээр: Газрын хөрсөнд үзүүлэх нөлөөллийг хүрээлэн байгаа орчинд үзүүлэх нөлөөтэй адилтгаж эсвэл хольж хутгаж байна гэжээ. Хүрээлэн байгаа орчин гэдэг ойлголтондоо дэд бүтэц, хүнд нөлөөлөх нөлөөг мөн багтааж байна. Ялангуяа дэд бүтэц болон хүмүүст учруулах хохирлыг тодорхойлоходо ийм хандлага гаргаж байна хэмээн тэмдэглэсэн байна. Жинхэнэ хэрэг дээрээ эдгээр үйл явц хэдийгээр хоорондоо харилцан уялдаатай ч мэдэгдэхүйц ялгаатай. Жишээ нь: Берекник дахь калийн ордын гадаргуугийн хөрс доошилж экологийн болон эдийн засгийн нилээд их хэмжээний хохирлыг бүс нутагт болон улс оронд учруулсан нь геологийн орчинд техногенийн учруулсан хохирлын үр дагавар юм. Ийм учраас зохиогчид эдгээр ойлголтуудыг ялгаж үздэг. Эхний ойлголт нь техногенийн геологийн орчинд нөлөөлөх нөлөөлийн үрээр үүссэн үр дагварт хамаарна. Геологийн орчин гэдгийг нөхцөлийн хувьд ямар нэгэн байдлаар “газрын гүн” гэсэн ойлголтой адилтгаж болно. Үүссэн үр дагаврууд өөрсдөө “геологийн хор хохирол” гэсэн нэр томъёогоор

тодорхойлогддог. Өөрөөр хэлбэл хүний үйл ажиллагаа геологийн орчинд үзүүлэх хор хохирол юм. Негөө нэг ойлголтын хувьд техногенийн нөлөөлөлд газрын хөрсний үзүүлэх хариу үйлдлээр тайлбарлаж болох үр дагавруудын цогц нийлэмжүүдийг батгаасан, иймд тэднийг “техногенийн үр дагаврууд” гэж нэрлэж болно. Хэрвээ тэд сөрөг үр дагавартай байх юм бол тэдгээрийг “геотехногенийн хор хохирол” хэмээн хууль ёсны дагуу үзэх болно. Тэдгээрийн бүрэлдэхүүн хэсгүүд нь хүний амьдрал, үйл ажиллагаанд, амьдрах орчинд, түүний дотроос байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлж экологийн, эдийн засгийн, нийгмийн зэрэг өөр үр дагаварууд бий болгодог.

Ийм хандлага байгалийн нөөц баялгийг эзэмших явцад үзүүлэх гаднах сөрөг нөлөөллийг таньж мэдэх, тодорхойлох ажлын үндэс байж болно. ОВОС-ын үндсэн заалтуудыг ашиглан геологийн орчинд нөлөөлж болох нөлөөллүүдийг ангилж болох шинж чанараар нь 4 бүлэг болгон хувааж болно.

1-р бүлэг: Тoo хэмжээг нь цөөрүүлэх зарчмаар газрын гүнээс гаргаж авах

2-р бүлэг: Геологийн орчныг эвдэх эсвэл өөрчлөх

3-р бүлэг: Геологийн орчныг бохирдуулах /Геомеханик, гидрогеологийн, геохимийн, цацрагийн, геотермийн, геобактерлогийн гэх мэт/

4-р бүлэг: Газрын гүнд цогцоор нөлөөлөх нөлөөлөл. Энэ нөлөөлөл дээр дурдсан

З бүлгийн янз бүрийн нэгдэл байдлаар илэрдэг. З бүлгийн янз бүрийн нэгдэл геологийн орчинд нөлөөлөх нөлөөллийг З үндсэн түвшинд авч үздэг.

1-р түвшин: Геологийн орчныг тэр дундаас түүний бүрэлдэхүүн хэсгүүд болох эрдсийн үүслийг судлах. /Ашигт малтмалын орд/

2-р түвшин: Ашигт малтмалын ордыг эзэмших /ашиглах/

3-р түвшин: Ашигт малтмалыг ордыг эзэмшиж ашиглаж дуусах, уулын объектүүдээ хааж битүүмжлэх.

Эрдэс баялгийн хөрөнгийн эдийн засгийн үнэлгээ хийх үед ордыг эзэмших, ашиглах болон ашиглалтын хугацаа дуусах шатанд нөлөөлөх боломжуудыг илрүүлж үнэлдэг.

Орд газрын геологи хайгуулыг хийж дуусч ашиглах шатанд геологийн орчинд нөлөөлөх нөлөөлөлд онцгой байр суурийг хэрэглэж буй арга технологи, өөрөөр хэлбэл геологийн орчноос дээж-эрдэс авч судалдаг арга гол үүрэг гүйцэтгэдэг. Ингэснээр байж болох нөлөөллүүдийг шинж чанараар нь ангилах нь хамгийн гол арга байх болно. Энэхүү шинж чанараар нь уг нөлөөллийг 4 бүлэгт хуваадаг: механик аргачлал, тэслэх аргачлал, гидродинамик аргачлал, өрөмдөх геотехникийн арга. Геологийн орчноос авсан дээжид дээрх аргачлалуудаар шинжилгээ хийж үзэхэд бусад бүх төрлийн нөлөөллүүдийг (хэмжээ, хүчин чадал, эрчмийг) тодорхойлж болох нь харагдсан.

Ашигт малтмалыг боловсруулах төгсгөлийн шатанд, өөрөөр хэлбэл ашигт малтмалын нөөц дуусч, геологийн орчинд нөлөөлөх нөлөөгүй болоход уул уурхайн үйлдвэрүүдийг хаадаг. Гэвч яг энэ үед ашигт малтмалын ордыг ашиглахын өмнөх үр дагавар идэвхтэй, өргөн цар хүрээтэй илэрдэг. Гэхдээ шууд хаах үед биш ч тодорхой хугацааны (цар жилийн) дараа нөлөөлөл нь илэрдэг. ИПКОН РАН-ы эрдэмтдийн судалгаанд геологийн орчинд нөлөөлөх техногенийн нөлөөллийг дүгнэх, тоон чанарын хувьд тодорхойлох нь ярвигтай бөгөөд ихэнх тохиолдолд хүнд хэцүү, заримдаа бүүр шийдвэрлэх боломжгүй болохыг онцолсон байдаг. Өнөөдрийг хүртэл геологийн орчинд нөлөөлдөг техногенийн нөлөөллийг үнэлэх үзүүлэлт, түүнд хандах нэгдсэн хандлага бий

боловгүй гол шалтгаануудын нэг нь оршдог. Бүр онож хэлбэл энэхүү техногенийн нөлөөллийг геологийн орчин хэрхэн өөртөө тусгадаг, хүлээж авдгийг үнэлэх үзүүлэлт байхгүй гэсэн үг. Жишээ нь: хөрснөөс эрдсийн дээж гаргаж авлаа гэж саная. Түүний тоог гаргах бол амархан. Харин авсан дээжийн үр дагаврыг тоон илэрхийлэлд оруулах л хэцүү. Өөрөөр хэлбэл геологийн орчинд, яг тэр үед, яг тэр газар нутагт уг нөлөөлөлд хэрхэн хариу үйлдэл үзүүлэхийг тодорхойлж хэлэх хэцүү. Гэхдээ геологийн орчин урт хугацааны туршид хэрхэн дээрх нөлөөлүүдэд хариу үйлдэл үзүүлэхийг эдгээр аргуудыг ашиглан хийсвэрээр, цар хэмжээний хүрээнд тодорхойлох бараг боломжгүй.

Газрын гүнд болж байгаа байгалийн өөрийх нь унаган төрх эвдэгдэж байгаа үед дээрх зорилт улам ярвигтай болдог. Жишээ нь: уулын ажлын явцад усны судал эсвэл магнаас үүсэн хийн урсгал дайрагдвал асуудал улам ээдрээтэй болно. Тодруулбал, Москвагийн ойролцоо орших нүүрсний уурхайг хааж битүүмжилнээс болж нилээд газар нутагт намаг үүсч усархаг болсон. Мөн мэргэжилтнүүдийн тооцоолсноор уулын ажлын үр нөлөөгөөр Рихтерийн шаталбараар 5-аас дээш баллын хүчтэй газар хөдлөлт болжээ. Сөрөг үр дагавар бүхий геологийн хор хохирол, өөрөөр хэлбэл техногенийн хор хохирлыг урдьчилан харж, тодорхойлж, үнэлж болох асуудал юм. Техногенийг хор хохирлыг дараах байдлаар ангилна.

1. *Байгаль-экологийн*
2. *Эдийн засгийн*
3. *Нийгмийн*

Байгаль-экологийн хор хохирлыг үнэлэх тал дээр техник-экологи-эдийн засгийн чиглэлээр нилээд тооны аргачлал боловсруулагдсан. Жишээ нь: Оросын эрдэмтэн В.И.Пачев, Монголын эрдэмтэн Халтар нарын боловсруулсан байгаль-экологийн хор хохирлыг иж бүрэн үнэлэх арга аргачлалаар геотехногенийн хор хөнөөлийн гол илрэл нь байгаль экологид үзүүлсэн хор хөнөөл гэж тодорхойлдог. Энэхүү арга аргачлал нь байгаль орчны үндсэн бүрэлдэхүүн хэсэгт, тэр тусмаа газрын гүний хөрсөнд ирэх гол ачаалал цаг хугацааны хувьд ямар давтамжтайгаа байж болохыг тооцоолох боломжийг олгодог.

Харин эдийн засгийн сөрөг нөлөөлөл нь олж болох байсан ашиг, эдийн засгийн алдагдал байдлаар илэрдэг. Үүнтэй уялдан дээрх сөрөг үр дагавар, сөрөг нөлөөллийг 2 хэсэгт хувааж үздэг.

Бүлэг-1: Энэ бүлэгт дараах алдагдал хамаардаг:

- 1.1. Нэмэлт зардал. Энэ зардал лицензтэй орд газрын талаарх уулын болон геологийн дутуу эсвэл найдваргүй мэдээлэлтэй байснаас үүсдэг.
- 1.2. Ашигт малтмалын нөөцийн норм хэтэрсэн хаягдал, өөрөөр хэлбэл ашиггүй хэмээн тооцооноос хассан балансын бус нөөц
- 1.3. Уулын ажлын тоног төхөөрөмж эд агуурсын гэмтэл, алдагдал
- 1.4. Тооцоолоогүй зардал. Ийм зардал цаашид уулын ажлаар ухаж гэмтээсэн геологийн орчныг хадгалж үлдээх шаардлагын үүднээс гардаг.
- 1.5. Бүх хэлбэрээр бий болсон экологийн хор хөнөөл, хохирлыг арилгахад зориулж гаргасан нөөц болон хэрэгслийн зардал

Бүлэг-2: Алдагдсан боломж /Гүйцэд олж аваагүй ашиг орлого/ 2 хэлбэрийн хор хохирол байна. Улс болон ашигт малтмал ашиглагчдад учирсан хохирол.

Дутуу олж авсан ашиг буюу түүнийг алдсан алдагдлаас үүссэн нийгэмд учрах хор хөнөөлийн эх үүсвэр янз бүрийн хэлбэрээр үүссэн байдаг. Энэ алдагдал буюу хор хохирол ихэвчлэн улсын, болон хувийн хэмшлийн хамтарсан уул уурхайн компанийд учирдаг. Уг хор хохирол нь дээр дурдсан 4 техногенийн хор хохирлоор тодорхойлогддог. Иймд тусд нь нэг ангиал үүсгэж хүний эрүүл мэнд, оюун санааны хохирлоор тодорхойлох нь оновчтой байдаг. Нийгэмд үзүүлсэн хор хохирол, хор хөнөөлийг бүлэг болон төрөл зүйлд хуваах нь ярвигтай бөгөөд олон хүчин зүйлүүдийг тооцох асуудал болж ирдэг. Түүнийг шийдвэрлэх арга зам нь нийгмийн судалгаа байдаг бөгөөд энэ тохиолдолд уг судалгаа хязгаарлагдмал байдалтай болно. Нийгэмд үзүүлэх хор хөнөөлийг хүмүүс болон бүлэглэлийн бие сэтгэхүйд нөлөөлсөн гол хүчин зүйлсийн үндсэн дээр тодорхойлж болно. Жишээ нь: амьдралын орчинд үзүүлсэн хор хөнөөл, хохирлын чанараар /Кузбасс, КМА, Уралын уул уурхайн бүс нутаг, Налайхын уурхай/, дэд бүтцэд үзүүлсэн хор хохирол нөлөө /Алс хойд хязгаарын муж нутаг, Алс Дорнод зэрэг бага хөгжилтэй бүс нутаг/, нийгэм-ахуйд болон үндэстний соёл, урлаг зэрэгт үзүүлсэн хор хохирол гэх мэт ангилж болно. Тэрчлэн хүн амын хэт төвлөрөлт зэрэг нилээд чухал хүчин зүйлүүдээр бас ангиал хийж болно.

Гүйцэд олж аваагүй ашиг орлогоос үүдэлтэй нийгэмд үзүүлсэн хор хохирол, хор хөнөөлийг таньж мэдэх, тодорхойлохын төвөгтэй тал нь уулын ажил өөрөө уг улс эсвэл газар нутгийн нийгэм эдийн засгийн хөгжилтэй холбоо бүхий үйл ажиллагаануудтай уялдаатай байдгаар тайлбарлагдана. Уул уурхайн үйлдвэрлэлийн уул уурхайн бүс нутагт үзүүлэх нөлөөллийг үнэлсэн хэд хэдэн судалгааны ажлуудыг зохиогчид хийсэн байна. Зохиогчдын нэг болох Невская М.А. –ын олон жилийн турш бий болгосон арга зүйн боловсруулалт нь уул уурхайн үйлдвэрлэлийн байгалийн нөөцийн чадамжид /потенциаль/ үзүүлэх нийгэм-экологи-эдийн засгийн үр нөлөөг дүгнэх, танихад ихээхэн нэмэр хандив болсон. Ингэхдээ уг зохиогч хийсэн тооцооллынхоо үнэлэх тал болон субъектив хандлагыг тодотгож өгсөн.

Орос, Монгол, Вьетнам, Казакстан зэрэг улсуудын янз бүрийн бүс нутгуудад эрдсийн хөрөнгө болон ОВОС-ын боловсруулалтын төслийн техник-эдийн засгийн хэдэн арван үндэслэлд хийсэн судалгаан дээр тулгуурлан зохиогчид төслийг бэлтгэх болон батлах үед зохицуулалтын шаардлагуудыг тооцсон гэж үздэг. Энэ ажилд экспертууд болон төслийг хэрэгжүүлэгчдийг оролцуулжээ. Иймд уулын ажлаас гарах урсгал болон капитал зардалд нөлөөлөх гадна хүчин зүйлсийг тооцсон. Эрдсийн хөрөнгийн эдийн засгийн үнэлгээ хийхэд гаднах нөлөөллийг тусд нь бие даасан элемент гэж авч үзэх нь давтан хийсэн тооцоолол болох болно. Иймээс эрдсийн хөрөнгийн үнэлгээг гаргах эдийн засгийн үнэлэмжид хандах арга зүйн хандлага дотор ашиглалтын явц, ашигт малтмалын ордыг хаах битүүмжлэхэд гарах геотехногенийг хор нөлөөг оруулан тооцох боломжтой гэж зохиогчид үздэг. Эрдэс баялгийн хөрөнгийн үнэ цэнийн үнэлгээ хийх явцад хор хөнөөлийг үнэлэхдээ сайн мэдэх арга техникуүдийг ашиглаж болно.

Гадны эерэг нөлөөллийг үнэлэхдээ зохиогчид гурав дахь этгээдийн тооцоо? Үнэлгээг авч ашиглах нь асуудалтай гэж үздэг. Үр ашгийг гүйцэд хүртэж чадаагүй талын үйл ажиллагаатай уялдан бий болсон эдийн засгийн үнэ цэнийн өсөлт, үр дагаврыг тэд л өөрсдөө амсдаг. Иймд эдгээр үр дагаврууд нь гадны нөлөөлөл биш юм. Гэхдээ цаашид ашиглах зорилготой техногенийн ашигт малтмалын уурхайг бий болгож, зарим ГПО-д дахин боловсруулалт хийвэл бусад субъектүүд уг ажлыг гүйцэтгэж болно. Ийм тохиолдолд тэдгээрийг гаднах хүчин зүйл гэж үзнэ.

Эрдсийн хөрөнгийн нөөцийн үнэлэмж NFV-гийн профилийн утгаас ялгаатай. Ялгах үзүүлэлт нь ордыг эзэмших мөн эрдсийн хөрөнгийн анхан шатны боловсруулалт хоёр юм. Ашигт малтмалын ордыг эзэмших, ашиглах үйл ажиллагааны анхан шатан дээр эрдсийн хөрөнгийн үнэ цэнийг төсөлд оруулсан хөрөнгө оруулалтыг эрдсийн хөрөнгийн дуусах үеийн үнэлгээтэй харыцуулж үнэлдэг. Үнэлэмж NFV-гийн профилийн өгөөжөөс доогуур гарч болно. Энэ нь эрдсийн хөрөнгийн нөөц барагдах, ашигт малтмалын анхан шатны боловсруулалтын явцад түүнийг газрын хэвлэйд орхих зэрэгтэй холбоотой.

Иймд гаргаж ирсэн мөн үнэлсэн хүчин зүйлүүдийн нөлөөллийг тооцсоноор эрдсийн хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнийг илүү зөв тодорхойлж үндсэн загварт засвар оруулж болно.

Эрдсийн хөрөнгийн үнэ цэнийн үнэлгээний загварыг бүрдүүлэх онолын талаар Монгол Улсад хийгдсэн зарим судалгаа байх боловч нэгдсэн шийдвэр гаргах төвшинд хүрсэн онолын үндэс хараахан боловсрогоогүй байна.

Уулын үйлдвэрийн төслийн техник-эдийн засгийн үндэслэл буюу Эрдсийн хөрөнгийн санхүү эдийн засгийн үнэлгээ хийх хуульчлан мөрдөх нэгдсэн аргачлал, загвар боловсрогоогүй байна.

Эрдсийн хөрөнгийн үнэ цэнийг тодорхойлохын тулд эрдэс түүхий эдийн нөөцийг тодорхойлох аргачлал нь олон улсын стандартад нийцсэн байх шаардлага гадаадын хөрөнгө оруулалттай уул уурхайн салбарт чухал ач холбогдолтой байна. Учир иймээс нөөцийн ангилал, тооцоог Австрали улсын JORC журмаас хэсэгчлэн авч ашигласан байна. Түүнчлэн Ази Номхон далайн орнуудад хэрэглэж буй CRIRSCO загварт шилжин элсэж хайгуулын ажлын үр дүн, ашигт малтмалын баялаг, ордын нөөцийг нээлттэй тайлагнах Монгол Улсын журмыг боловсруулсан боловч албан ёсоор хэрэглэх шийдвэр гараагүй байна. Ашигт малтмалын ордын санхүү-эдийн засгийн үнэлгээний талаар нарийн судалгаа хийсэн монгол эрдэмтдийн бүтээлүүд дотор Д.Даваасамбуу, Г.Даваацэрэн, Я.Пүрвээ, Б.Бат-Очир, Б.Цацрал, Ж.Лхамсүрэн, Ж.Дамдинжав нарын бүтээлүүд чухал байр эзэлдэг байна.

Дүгнэлт

Эрдсийн хөрөнгийн үнэлэмжийн загварын онолын үндэслэл нь нийгмийн сайн сайхан, гадны нөлөөллийн талаарх концепци бөгөөд харин арга зүйн үндэс нь –төсөл хэрэгжүүлэх үеийн нийгмийн үр өгөөжид эдийн засгийн шинжилгээ хийх аргачлал байдаг.

Томоохон хэмжээний хөрөнгө оруулалтын төслүүд, хөтөлбөрүүдийн нийгэм эдийн засгийн үр өгөөжид шинжилгээ хийх олон улсын хэмжээнд тэр тусмаа Европын Холбооны хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн үндсэн аргуудыг хооронд нь харьцуулж судалгаагаа хийсэн. Эдгээр арга, аргачлалуудад дараах 4 төслийн анализ багтдаг: “Зарлага-ашиг орлогод” (*Cost-Benefit Analysis, CBA*) хийх шинжилгээ, “Зарлага- Үр дүн” (*Cost-Effectiveness Analysis, CEA*) хийх шинжилгээ, “Хамгийн бага зарлагад” (*Least-Cost Analysis, LCA*) хийх , “Олон шалгуурт” (*Multi-Criteria Analysis, MCA*) хийх шинжилгээний аргууд байна.

Дээр дурдсан аргуудын харьцуулсан шинжилгээ дараах чиглэлээр дүгнэлт хийх боломж олгов: Уул уурхайн төслүүдийг гүйцэтгэх эрдсийн хөрөнгийн үнэлэмжийн загвар гаргахад нийгэм эдийн засгийн хувьд үр өгөөжтэй байхаар бидний шийдвэрлэхээр зорьсон зорилго зорилтод шинжилгээ хийх арга аргачлалыг сонгох, хэрэглэх үүднээс СВА илүү их тохиromжтой байлаа. Энэ юугаар тодорхойлогддог вэ гэвэл: СВА арга аргачлал нь эдийн засгийн зардал, экстерналаар/мөнгөн хэлбэрээр/ тооцоолсон ашиг зэрэгт чигэлсэн байдгаараа онцлог. Энэ аргачлал ашигт малтмал боловсруулах төсөлд шинжилгээ хийхэд үр дүнтэй. Уул уурхайн төслийг хэрэгжүүлэхэд гарах үр дагавар, зардал, ашиг орлого зэргийг мөнгөн хэлбэрээр хэмжинэ. Төслийн явцад боловсруулагдах эрдсийн хөрөнгийн үнэлэмжинд нөлөөлөл гадны нөлөөллийг энэ байдлаар тооцоолно.

Эдийн засгийн үнэ цэнийг олж авах явцад мөн фиксальны засвар хийхэд хэрэгтэй үндсэн өөрчлөлтүүдийг, зах зээлийн үнээс сүүдрийн үнэнд шилжих шилжилт, гадна талын нөлөөллүүдэд үзүүлэх зах зээлийн бус нөлөөлөл, өөрчлөлтүүдийн судалсан. Ингээд эрдсийн хөрөнгийн үнэ цэнийг үнэлэх үеийн гадны нөлөөллийн монетизаци, тооцоо, идентификаци зэргийн зайлшгүй хэрэгцээний талаар үндэслэлтэй дүгнэлтүүд хийгдсэн.

Оросын хөрөнгө оруулалтын шинжилгээн дэх одоо хүчин төгөлдөр хэрэглэгдэж байгаа арга зүйн хандлага, арга аргачилалд харьцуулах шинжилгээ хийсэн нь эрдэс баялгийн үнэлэмжийн активын загварыг гаргахад санал болгож болохуйц арга аргачлал хэмээн ОХУ-ын байгаль орчны яам үзжээ.

Энэхүү аргачилал нь эрдсийн хөрөнгийн үнэ цэнэд хийх эдийн загийн үнэлгээний талаар боловсруулсан арга зүйн хандлагын үндсэн суурь болсон. Үүнээс гадна, зохиогчид гадны нөлөөлөлд ашигт малтмалын орд газрыг ашиглах, хаах, битүүмжлэхэд гарах геотехногений хор хөнөөлийн эдийн засгийн хэлбэрийг тооцож байхыг санал болгосон.

Монгол Улсад хэрэглэж буй ашигт малтмалын ордын санхүү-эдийн засгийн үнэлгээний аргыг анхааралтай судалж эрдсийн хөрөнгийн үнэ цэнийн үнэлгээнд тусгах боломж байна.

БҮЛЭГ 2. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХҮРЭЭНД ЭРДЭС БАЯЛГИЙН ҮНЭ ЦЭНИЙГ ТООЦОЖ ТОГТООХ ДЕТЕРМИН ЗАГВАР БОЛОВСРУУЛАХ НЬ

2.1. Эрдэс баялгийн үнэ цэнийг тооцох детермин загварын сонголт ба хязгаарлалт (детерминированная модель)

Гадаад улс орнууд, Оросын практикт хөрөнгө оруулалтын төслийг үнэлэх аргачлалын нийтлэг өрөнхий байдал, түүнчлэн уул уурхайн төслийн онцлогийг харгалзан, ашигт малтмалын нөөцийг тухайн жилийн бодит болон өртгийн хэмжилт, түүний өөрчлөлтийг тооцох аргачлалыг детермин загвар болгон ашиглахыг санал болгож байна.

Детермин загварыг эрдсийн хөрөнгийн үнэлгээний үнэ цэнийг тооцох үндсэн загвар болгон сонгох нь дараах нөхцөл байдлаас шалтгаалж байгаа юм. Үүнд:

1. Уг загвар нь үндэсний баялгийн нэг хэсэг болох эрдэс баялгийн нөөцийг тооцоолоход зориулагдсан.
2. Тус загвар нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн, өргөн тархсан орлогын хандлагад суурилдаг бөгөөд түүний мөн чанар нь ашигт малтмалын ордыг ашигласнаар ирээдүйд авчрах үр өгөөжийн одоогийн (өнөөгийн) үнэ цэнийг тооцох буюу өөрөөр хэлбэл урьдчилан тооцоолсон орлогыг капиталжуулах/хөрөнгө болгон хувиргах замаар үнэлэхэд оршино.
3. Мөн эрдсийн хөрөнгийн нийгмийн үр өгөөж (үнэ цэнэ)-ийг жишиг болгон авч болох улс ардын аж ахуйн эдийн засгийн үр ашгийн үнэлгээг тусгасан.
4. Загвар нь тухайн жилд орд газрын талбай (талбайн) ашиглах техникийн төслийн дагуу олборлосон ашигт малтмалын нөөцийн эзэлхүүний хөдөлгөөнийг тухайн ордын ашиглалтаас цаашид олох орлогын үнэлгээний хамт бүртгэхийг заадаг.
5. Үлдэгдэл техникийг ашиглах, татварын орлогыг орлогод бүртгэх нь уг загварыг эрдсийн хөрөнгөөс олсон түрээсийн (рентийн) орлогын хувьд үнэ цэнэтэй загвар гэж үзэх боломжийг бидэнд олгодог.

Үндсэн загварын нөөцийн үнэ өртгийн үзүүлэлт нь бүх газрын хэвлий дэх /газрын доорх ашигт малтмалын олборлолт, борлуулалтын үр дүнд олж болох хөнгөлөлттэй цэвэр мөнгөн урсгалын /гүйлгээний (DNCF) хэмжээ юм. (томъёо (5):

$$\text{ДЧДП} = \sum_{lu=1}^n \text{ДЧДП}_{lu} \quad (5)$$

Үүнд: ДЧДП - үнэлэх объектын үнэ өртөг (газрын хэвлийн нийт хэсгээс олох хөнгөлөлттэй (дискаунталсан) цэвэр мөнгөн урсгал /гүйлгээ), сая төг;
ДЧДП_{lu} - газрын хэвлий дэх ашигт малтмалын нөөцийн үнэ өртөг, сая төг;
lu - газрын хэвлийн хэсэг, эсвэл газрын хэвлийн хэд хэдэн хэсэг;
n - газрын хэвлийн хэсгийн тоо.

Газрын хэвлий дэх ашигт малтмалын нөөцийн өртгийг (6) томъёогоор тооцоолно.

$$\text{ДЧДП}_{lu} = \sum_{t=1}^T (\text{ЧДТ}_t / (1 + E)^t) \quad (6)$$

Үүнд: ЧДТ_t - t жилд газрын хэвлийн хэсэг эсвэл хэд хэдэн газрын хэвлийн хэсгийн цэвэр мөнгөн урсгал/гүйлгээ, сая төг;
E - хөнгөлөлтийн хувь хэмжээ; (дискаунт)

t - газрын хэвлүй ашигласан жил ($t = 1, 2, \dots T$);

Т – таамагласан/урьдчилан тооцсон хугацааны жилийн тоо.

Үнэлгээний объектын жилийн цэвэр мөнгөн гүйлгээг (7) томъёоны дагуу балансын аргыг ашиглан тооцоолно.

$$\text{ЧДТ}_t = Bt - Ot - Kt + Ht \quad (7)$$

Үүнд: Bt - олборлосон ашигт малтмалын борлуулалтаас олсон жилийн орлого, сая төг;

Ot - ашигт малтмал олборлох төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны нийт зардал, сая төг;

Kt - ашигт малтмал олборлох төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн зардал, сая төг;

Ht - үйлдвэрлэлийн өртөгт хамаарах татвар, сая төг;

t - газрын хэвлүй ашигласан жил.

Олборлосон ашигт малтмалын борлуулалтаас олсон жилийн орлогыг тодорхойлоходоо (8) томъёог ашиглана.

$$Bt = \sum_{\text{ПИ}=1}^N (\Pi_{\text{ПИ},t} * D_{\text{ПИ},t}) \quad (8)$$

Үүнд: $\Pi_{\text{ПИ},t}$ - t жилд олборлосон ашигт малтмалын борлуулалтын үнэ, төг/борлуулсан нэгж бүтээгдэхүүн (чанарын урьдчилан таамагласан буюу төлөвлөсөн өөрчлөлтөд тохируулсан тайлант жилийн үнэ);

$D_{\text{ПИ},t}$ - t жилийн ашигт малтмалын борлуулалтын хэмжээ (ПИ), борлуулсан бүтээгдэхүүний нэгж;

ПИ - ашигт малтмал;

Н - арилжааны ашигт малтмалын төрлийн тоо (PI1, PI2, ..., PIN).

Эрдсийн түүхий эдийг үнэлэх зорилгоор ашигт малтмалын борлуулалтын үнэ нь тухайн аргачлалаар санал болгож буй салбарын дундаж үнийн дүнгээс ялгаатай нь богино, дунд, урт хугацааны үнийн урьдчилсан утгыг харгалзан үзэх, түүнчлэн тусгай зөвшөөрлийн талбайд олборлосон ашигт малтмалын төрөл тус бүрийг борлуулахтай холбоотой газрын хэвлүйг ашиглагчийн тээвэрлэлт, арилжааны болон бусад зардлын талаарх мэдээллийг харгалзан үзнэ.

Ашигт малтмал олборлох төслийг (Ot) хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардалд: ашиглалтын (үйл ажиллагааны) зардал, үйлдвэрлэлийн өртөгт хамаарах татварын болон татварын бус төлбөр орно. Ашиглалтын (засвар үйлчилгээний) зардалд ашигт малтмалыг олборлох, цуглуулах, бэлтгэх, тээвэрлэх, боловсруулах, баяжуулахтай холбоотой бүх зардлыг харгалзан үзнэ. Үнэ, орлогод багтсан тээврийн бүх зардал, ерөнхий болон захиргааны зардлыг харгалзан үзнэ. Үйл ажиллагааны (ашиглалтын) зардлыг тодорхойлоходоо элэгдлийн суутгалыг тооцохгүй.

Ашигт малтмал олборлох төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн зардалд (Kt) ордын ашиглалтын хугацаанд жил бүр ашигт малтмал олборлоход шаардлагатай үндсэн хөрөнгийг олж авах, барих хөрөнгө оруулалт багтана.

Үйлдвэрлэлийн өртөгт (*Ht*) хамаарах татварын болон татварын бус төлбөрт дараахь зүйлс орно.

- a) ашигт малтмалын олборлолтын татвар;
- b) заавал төлөх төлбөр: газрын хэвлийг ашиглах эрхийн тогтмол төлбөр, агаар мандалд бохирдуулагч бодис ялгаруулсны төлбөр, зөвшөөрөгдсөн ялгаруулалтын хүрээнд хийгдсэн усны биед бохирдуулагч бодис хаясны төлбөр, зөвшөөрөгдөх хаягдлын стандарт, үйлдвэрлэлийн болон хэрэглээний хог хаягдлыг тогтоосон хязгаарт байрлуулах, устгасны төлбөр, тээврийн татвар, газрын албан татвар Газрын хэвлийн хэсгийн өртгийн тооцоог хийсэн геологи-эдийн засгийн (техникийн) үнэлгээний дагуу нөөцийн баталгаажсан мэдээлэлд үндэслэн, жишээлбэл, JORC Code эсвэл CRICOS-ийн дагуу хийдэг.

* ¹ *JORC код - хайгуулын үр дүн, ашигт малтмалын нөөцүү, хүдрийн нөөцийг олон нийтэд тайлагнах бат бөх стандартыг сурталчлах мэргэжлийн үйл ажиллагааны код*

Судалгаагаар эрдсийн хөрөнгийн үнэлгээний үндсэн загварт дараах хязгаарлалтууд илэрсэн.

1. Үндсэн загварын гол хязгаарлалт нь үндэсний баялагийн үзэл баримтлалд Эрдэс баялгийн үнэлгээ нь ашигт малтмалын нөөцийг үйлдвэрлэгдээгүй биет хөрөнгө гэж үзэх, i.e. Эрдсийн нөөцийг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөхийн тулд тухайн баялгийг өмчлөх, эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөлийг хангасан байх ёстой бөгөөд энэ нь үндэсний баялагт олборлосон нөөцийн хэмжээг харгалзан үзэх боломжгүй юм. Эдийн засгийн эргэлтийг хэсэг хугацаанд эсвэл үүрд .

Үндсэн загварын гол хязгаарлалт нь үндэсний баялгийн үзэл баримтлалд ашигт малтмалын нөөцийн үнэлгээнд эрдсийн нөөцийг үйлдвэрлэгдээгүй биет хөрөнгө гэж үзэх, өөрөөр хэлбэл ашигт малтмалын нөөцийг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөхийн тулд ашигт малтмалын нөөцийн үнэлгээ хийх, тухайн баялгийг өмчлөх, эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөлийг хангасан байх гэж заасан бөгөөд эдийн засгийн эргэлтээс хэсэг хугацаанд, эсвэл бүрмөсөн хасагдсан нөөцийн хэмжээг үндэсний баялагт тусгах боломжгүй буюу тооцохыг зөвшөөрдөггүй (газрын хэвлийн нөөцөд шилжүүлсэн, боловсруулагдаагүй нөөц, тусгай зөвшөөрөл авсан, олборлох болон боловсруулах шатны хаягдал дахь нөөц, байгалийн болон бусад шалтгааны улмаас алдагдсан нөөц).

Нэг талаас, энэ арга нь өртөг өндөртэй, учир нь Мөнгөн гүйлгээний бодит тооцоонд үндэслэсэн бол нөгөө талаар эрдсийн түүхий эдийн нэгдсэн ашиглалтын бодит болон урьдчилан тооцоолсон алдагдал, янз бүрийн шалтгааны улмаас үнийн өсөлтийг тооцдоггүй тул ашигт малтмалын үнэ цэнийг бүрэн тусгадаггүй. Тиймээс үнэ цэнийн өөрчлөлттэй холбоотой дотоод нөлөөллийн үнэлгээг харгалзан суурь загварыг өөрчлөх шаардлагатай. Ашигт малтмалын үнэ цэнийн эдгээр өөрчлөлт нь газрын хэвлий дэх ашигт малтмалын алдагдлыг олборлох, ашигт малтмалын хаягдлыг боловсруулах болон эрдсийн түүхий эдийг иж бүрэн ашиглахтай холбоотой юм.

2. Аргачлалын дагуу баталсан хөнгөлөлтийн хувь хэмжээ 10%-тай тэнцэх бол тухайн ордын эрдсийн хөрөнгийн үнэлгээг үндэслэлтэй гэж үзэх боломжгүй. Тиймээс үндсэн загвар нь боломжит хөнгөлөлтийн хувь хэмжээг харгалзан CAPM, WACC, Gordon эсвэл хуримтлагдсан аргын дагуу арилжааны хөнгөлөлтийн хувь хэмжээ, болон нийгмийн хөнгөлөлтийн хувь хэмжээг харгалзан тодорхойлдог.

3. Ашигт малтмалын үнэ цэнийг үнэлэх ордын ашиглалтын хугацааг 20 жилээр хязгаарлахгүйгээр, харин тухайн ордыг ашиглах батлагдсан техникийн төслийн дагуу өөрчлөлт оруулах замаар ашиглах ёстой. Иймд үндсэн загвар нь эдийн засгийн үнэ цэнийг тооцохдоо дотоод болон гадаад нөлөөлөл гарч болзошгүй урьдчилсан болон таамаглалаас хойшхи үеийг харгалzan үзнэ.
4. Загвар нь детермин тул зөвхөн эрдсийн хөрөнгийн үнэлгээний үндэслэл болох бөгөөд тухайн ордыг ашиглах эрсдэлт хүчин зүйлсийг зөв тооцохыг шаарддаг. Иймд үндсэн загварын эрсдэлт хүчин зүйлсийг харгалzan нэмэгдүүлж, тодорхой бус загвар болгон танилцуулах нь зүйтэй.

2.2. Эрдсийн хөрөнгийн үнэ цэнийг үнэлэх детермин загварыг бий болгох урьдчилсан нөхцөл, арга зүйн хандлага

Судалгааны зохиогчид эрдсийн хөрөнгийн үнэ цэнийг тодорхойлохын тулд эдийн засгийн үнэ цэнийг үнэлэх боловсронгуй загварын аргачлалыг гадаадын практикт орчин үеийн хөрөнгө оруулалтын үнэлгээний арга зүй болгон хослуулсан нэгдсэн арга хандлагыг боловсруулсан; ашигт малтмалын нөөцийг үнэлэх ОХУ-ын Байгалийн нөөц, экологийн яамны аргачлалаар батлагдсан үндсэн загвар; түүнчлэн эрдсийн хөрөнгийн хүчин зүйлийн шинжилгээний арга хэрэгсэл.

Эрдсийн хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнийг тооцох боловсруулсан арга зүйн хандлагыг Зураг 46-д үзүүлэв.



Зураг 46 Эрдсийн хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнийг тооцох арга
Эх сурвалж: зохиогчийн боловсруулсан арга

1-р бүлэгт дурдсанчлан эрдсийн хөрөнгийн үнэ цэнийг үнэлэх арга зүйн үндэслэлтэй аргачлал нь ашигласан ордын хөрөнгө оруулалтын төслөөс орж ирэх цэвэр мөнгөн гүйлгээний тохируулга зэргийг харгалзан эдийн засгийн үнэлгээний (ENPV) үнэ цэнийг үнэлэх загварыг бий болгох юм.

Эрдсийн хөрөнгийн үнэ цэнийг үнэлэх эхний бүлэг (төсвийн тохируулга) зохиогчийн боловсруулсан арга зүйн арга барилаар хийгдээгүй. Энэ нь хөрөнгө оруулалтын төслүүдийг үнэлэхдээ Оросын аргачлалд зардлын бүх үзүүлэлтийг шууд бус татвараас “цэвэрлэсэн” аргыг ашигладагтай холбоотой юм. Байгалийн монопол үйлчилгээний тарифыг (төмөр зам, гол хоолойгоор дамжуулан газрын тос тээвэрлэх болон бусад) төрөөс зохицуулдаг боловч зах зээлийн үнэд шилжихийн тулд тусгай аргаар зохицуулалт хийх шаардлагатай болдог. Эрдсийн хөрөнгийн үнэ цэнийг үнэлэхэд зориулсан тэдгээрийг хэрэгжүүлэх цогц, боловсруулсан аргачлал байхгүй тул ийм зохицуулалт хийх нь тохиромжгүй юм.

Хэмжээг шилжүүлэн авч үзэх цогц, боловсруулсан аргачлал байхгүйгээс Оросын нөхцөлд хоёр дахь бүлгийн тохируулгыг (далд үнэд шилжих, зах зээлийн үнийг ашиглах) хэрэглэхэд асуудалтай байна. Далд үнээр орж ирж байгаа бараа бүтээгдэхүүний зах зээлийн үнийг төслийн санхүүгийн зардалд хөрвүүлэх хүчин зүйлийг ашиглах боломжтой. Төслийн үр дүнгийн хувьд хэрэглэгчдийн төлөхөд бэлэн байгаа хамгийн дээд үнэ буюу төлбөрийн бэлэн байдал (Willingness-To-Pay, WTP) гэсэн ойлголтыг ашиглана. Ажиллах хүчийг нөөц болгон ашиглахад хөдөлмөрийн зах зээл хангалтгүй, хөдөлмөрийн өртгийг гажуудуулдаг тул далд цалинд тооцно. Эхөрөнгийн цэнийг тооцох аргачлалын хувьд төрийн дэмжлэгтэй зарим төслийг эс тооцвол, жишээлбэл, газрын ховор металлын үйлдвэрлэл, уул уурхайн бүх төслүүд дэх арилжааны бүтээгдхүүнүүд зах зээлийн үнийг баримталдаг болохыг дурьдах нь зүйтэй. Групп компаниуд - арилжааны байгууллагуудын бүтцэд шилжүүлгийн үнийг ашиглах замаар зах зээлийн үнийн тодорхой гажуудлыг бий болгодог бол үндсэн аргачлалд компани хоорондын хувьцааны ашгийг хуваарилах замаар үнийн хүчин зүйлийг харгалзан үздэг. Иймд зохиогчийн боловсруулсан аргачлалд эрдсийн хөрөнгийн үнэ цэнийг далд үнээр тооцох зохицуулалт хийгдээгүй.

Гурав дахь бүлгийн тохируулга (зах зээлийн бус нөлөөллийн үнэлгээ) -ийг ашигт малтмалын хөрөнгийн үнэ цэнийг үнэлэх зохиогчийн боловсруулсан аргачлалд харгалзан үзэх шаардлагатай. Хэрэв зах зээлийн бус нөлөөллийг өргөн утгаар авч үзвэл хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн гүйлгээний үр дагавар нь дотоод болон гадаад нөлөөллийн хэлбэрээр илэрдэг ч ашигт малтмалын олборлолтой холбоотой уул уурхайн төслүүдийн хувьд зах зээлийн бус зарим нөлөөлөл нь тодорхой нөхцөлд ашигт малтмалын хөрөнгийн үнэ цэнийг өсгөх хүчин зүйлүүдийн нэг болдог.

Эрдсийн хөрөнгийн үнэлгээний загварыг бий болгох үндсэн үе шатуудыг Зураг 47-т үзүүлэв.

Эрдсийн хөрөнгийн үнэ цэнийг үнэлэх боломжит сонголтод суурилсан үндсэн загвар сонгох боловсруулалтын шатанд 4 үндсэн аргад дүн шинжилгээ хийж, нийгмийн томоохон хөрөнгө оруулалтын төслүүдийн үр ашгийг үнэлдэг Европын практикт хүлээн зөвшөөрөгдсөн зардал/үр ашгийн шинжилгээний аргыг сонгох нь үндэслэлтэй гэж үзсэн. Мөн Оросын 3 аргын дүн шинжилгээнд үндэслэн нийгмийн томоохон хөрөнгө оруулалтын төслүүдийг үнэлэхэд ашигласан Байгалийн нөөц, Экологийн яамны аргачлалыг сонгох нь үндэслэлтэй гэж үзсэн. Сонгосон үндсэн загвар нь эдийн засгийн үр

өгөөжийг олж авах хугацаанд төслийн хэрэгжилтээс нэмэлт орлого авах тохируулгад хамаарна.

Эрдсийн хөрөнгийн үнэ цэнийг үнэлэх детермин загварыг боловсруулах шатанд өртөг бүрдүүлэгч хүчин зүйлсийг тодорхойлсны үндсэн дээр эрдсийн хөрөнгийн үнэ цэнийг үнэлэх загварт багтсан хүчин зүйлсийн эдийн засаг, математикийн хүчин зүйлсийн багц загвар бий болсон.

Эрдсийн хөрөнгийн үнэ цэнийг үнэлэх тодорхой бус (детерминчлэгдээгүй) загварыг бий болгох шатанд эрдсийн хөрөнгийг боловсруулах төслийн эрсдэлт хүчин зүйлсийн нөлөөллийг шинжлэн үнэлж, тодорхойлсон болно.



Зураг 47 Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний загварыг бий болгох үе шатууд.
Эх сурвалж: зохиогчийн боловсруулсан арга

Зохиогчдын тодорхойлсон ОХУ-ын Байгалийн нөөц, Экологийн яамны аргачлалын дагуу ашигт малтмалын хөрөнгийн үнэ цэнийг тооцоолох үндсэн загварын хязгаарлалт, хийсэн судалгаанууд нь үндсэн загварыг өөрчлөх дараах арга зүйн урьдчилсан нөхцөлийг нотлох боломжийг олгосон.

Тогтвортой хөгжлийн нөхцөлд ашигт малтмалын хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнийг үнэлэх зохиогчийн боловсруулсан загварт үнэлгээнд дараах хүчин зүйлсийн нөлөөллийг харгалзан үзэхийг санал болгож байна.

1. Эрдсийн хөрөнгө барагдах;
2. Газрын хэвлэй дэх ашигт малтмалын хаягдлыг бууруулах;

3. Ашигт малтмалын нөөцийг цогцоор нь ашиглах (КИМС) болон уулын үйлдвэрийн хаягдлыг боловсруулах;
4. Нийгмийн хөнгөлөлтийн хувь хэмжээ; (дискаунтлах)
5. Ордыг ашиглах, ашиглалтаас эдийн засгийн үр өгөөжийг олж авах хугацаа.

Эрдсийн хөрөнгийн үнэлгээний загварт эрдсийн хөрөнгийн хомсдолыг үнэлэх

Эрдсийн хөрөнгийн хомсдол үүсэх, хомсдолын үнэлгээний чиглэлээр зохиогчдын хийсэн судалгаанууд [37] нь өөрчлөгдсөн үндсэн загварт төрөл бүрийн эрдсийн хөрөнгийн хомсдолыг харгалзан үзэхтэй холбоотой дараах дүгнэлт, зөвлөмжийг гаргах боломжтой болсон.

Үзэл баримтлалын хувьд ашигт малтмалын үнэ цэнийг нийгмийн хэрэгцээний хөгжлийн түвшинтэй холбоотой үндэсний эдийн засгийн хэрэгцээг хангах түвшингээр тодорхойлдог (2-р хэсэг). Үндэсний эдийн засгийн хэрэгцээг хангах, нийгмийн хэрэгцээг хөгжүүлэх эдийн засгийн тал нь эдийн засаг, нийгэмд ашигт малтмалын эрэлт хэрэгцээ байгаа (эсвэл байхгүй) явдал юм. Ашигт малтмалын нөөцийн эрэлт, эрэлтийн хэмжээ, түүний өөрчлөлтөд эдийн засгийн (зах зээлийн), шинжлэх ухаан, техникийн болон байгууллагын хүчин зүйлс нөлөөлдөг. Эдгээр хүчин зүйлсийн нөлөөлөл нь ашигт малтмалын нөөцийн хомсдолд хүргэдэг бөгөөд бодит болон эдийн засгийн гэсэн хоёр хэлбэрээр илэрдэг.

Хомсдол гэдэг нь техникийн зураг төслийн дагуу ашиглалтад оруулсан ордын нөөцийн үнэ цэнэ алдагдах, буурах нь одоогийн байдлаар ашигт малтмалын нөөц багассан, байхгүй болсон байдлыг хомсдол гэнэ.

Бодит хомсдол гэдэг нь уул уурхай, геологийн (байгалийн) хүчин зүйлс, эдийн засгийн үндэслэлгүй үйл ажиллагааны хүчин зүйлс, талбайн ашиглалтын төслүүдийн зураг төслийн алдаа зэргээс үүдэлтэй нийгэмд эрэлт хэрэгцээтэй байгаа ашигт малтмалын нөөцийн алдагдал (үүний үр дүнд тэдгээрийг ашиглах боломжтой орлого) юм. Бодит хомсдолын үр дагавар - тухайн үед алдагдсан нөөцийг нийгэм ашиглах боломжгүй. Боломжит технологийн арга хэмжээ авахгүйгээр ийм нөөц нь бодитоор хүртээмжгүй болдог тул ийм хомсдолыг үнэмлэхүй гэж үзэж болно. Биет хомсдолын улмаас эрдсийн түүхий эд, нөөц алдагдаж байгаагийн нэг жишээ нь газрын хэвлэй дэх ашигт малтмалын нөөцийн хаягдал нь бодит хомсдлын нөлөөгөөр үр ашигтай нөөцийн хэмжээ хэтэрсэн хаягдал байж болзошгүй юм.

Ашигт малтмалын эдийн засгийн хомсдол гэдэг нь ашигт малтмалын нөөц байхгүй, ашиглах боломжгүй, хүртээмжгүй болох эдийн засаг, үйлдвэрлэлийн (технологи, байгаль орчин, үйлдвэрлэлийн аюулгүй байдал болон бусад) болон хүчин зүйлүүдийн үр дүнд ашигт малтмалын ашиглалтаас олох орлого буурах, эсвэл ашигт малтмалын ашиглалтыг түр орхисны улмаас орлого алдагдахыг ойлгоно. Тиймээс, өргөн утгаараа эдийн засгийн хомсдол гэдэг нь ашигт малтмалын нөөц ашиглалтаас олох орлогын бууралт (алдагдал) бөгөөд бөгөөд дараах үр дагавруудаас бий болдог.

- Олборлолт, анхан шатны боловсруулалтын явцад ашигт малтмалын нөөцийг илүү бүрэн дүүрэн ашиглахад хувь нэмэр оруулдаг хүчин зүйл байхгүй, ингэснээр уул уурхайн хаягдлыг боловсруулах (үүсмэл ордуудыг ашиглах), чулзуулаг агуулсан ашигтай бүрэлдэхүүн хэсгүүдийг агуулж болзошгүй үүсмэл ордууд үүсэхэд хүргэдэг бөгөөд энэ хугацаанд ашиглах боломжгүй юм.;

- Эрдсийн түүхий эдийн нэгдсэн ашиглалтанд ашигт малтмалын нөөцийг бүрэн ашиглахад хувь нэмэр оруулах хүчин зүйлс дутмаг;
- ашигласан ашигт малтмалын оронд өөр нөөц ашиглахыг дэмжих хүчин зүйлс байгаа эсэх (хүснэгт 42).

Хүснэгт 42 Ашигт малтмалын хомсдолын хүчин зүйлсийн жишээ

Хүчин зүйлсийн бүлгүүд	ХОМСДОЛ		
	Биет	Эдийн засгийн - үнэ цэнийн бууралт буюу элэгдэл	
	Хөгжлийн зүйлсийн дутагдал	Хөгжлийн хүчин зүйлсийн дутагдал	Альтернатив нөөцийг хөгжүүлэх хүчин зүйлүүд
Эдийн засгийн	Төслийн шийдлийндутаг дал (зарим аллаа)	Шинэ технологи нэвтрүүлэхэд санхүүгийн эх үүсвэр лутмаг	Зах зээл дээр илүү хямд орлуулагч, түүхий эд, эрчим хүчний өөр эх үүсвэр бий болсон
Технологийн	Ашигт малтмалын анхан шатны боловсруулалтын явцад ашигт малтмал, ашигтай бүрэлдэхүүн хэсгүүдийг олборлох явцад бүрэн олборлох		Ашигт малтмалын түүхий эд, түлшийг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологийн
Байгууллагын	-	Хэрэглээний үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр дутмаг, Ашигт малтмал олборлох, боловсруулах шинэ технологи нэвтрүүлэх. Татварын таагүй	Байгаль орчинд ээлгэй бус түүхий эд, эрчим хүч үйлдвэрлэх, ашиглахыг хориглох. "Ногоон" эрчим хүч, эдийн засгийг дэмжих. Нийгмийн хөдөлгөөн гэх мэт.
Байгалийн	Уул уурхай, геологийн хүнд нөхцөл, ашигт малтмалын хэт их алдагдалд хүргэдэг тектоник явц (ashiqt		-

Бодит болон эдийн засгийн хомсдол нь эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн болон байгууллагын гэх мэт өмнө нь тодорхойлсон бүлгийн хүчин зүйлсийн нөлөөн дор үүсдэг боловч эдгээр хүчин зүйлсийн хомсдолын хэлбэрт үзүүлэх нөлөө нь янз бүрийн хэлбэрээр илэрдэг. Бодит хомсдол нь ашигтай (эдийн засгийн хувьд ашигтай) нөөцөөс орлогын шууд алдагдал болох нь төслийн алдаа, түүнчлэн ашиглалтын явцад уул уурхай, геологийн нөхцөл байдлын нөлөөллөөс үүдэлтэй байж болно.

Эдийн засгийн үнэ цэнийн бууралтад нөлөөлөх шалтгаан:


Ашигт малтмалын эрэлт байхгүй (буурсан) тохиолдолд ашигт малтмалын нөөц ашигласны орлого буурах - үнэ цэнийн бууралт буюу элэгдэл гэнэ. /нөхөн сэргээгдэхгүй ашигт малтмалын түүхий эдийг зохих ёсоор орлуулах (эдийн засгийн хүчин зүйл), хямд

эсвэл дахин үйлдвэрлэх боломжтой орлуулагч байгаа эсэх (гадаад байдал); технологийн хүчин зүйл; үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хангах хүчин зүйл; илүүдэл алдагдлын хүчин зүйл; улс төр, байгаль орчин, нийгмийн болон бусад шалтгаанаар ашигт малтмалын нөөцийг ашиглах хязгаарлалт (байгууллагын хүчин зүйл)/.

Эдийн засгийн хомсдолд нөлөөлж буй хүчин зүйлс цаг хугацааны явцад өөрчлөгдеж болох тул эдийн засгийн хомсдолыг нөөцийн түр хугацааны элэгдэл гэж үзэж болно. Энэхүү элэгдэл нь үндэсний эдийн засагт ашигт малтмалын түүхий эдийн нэгдсан ашиглалтын эрэлт буурсантай холбоотой бөгөөд эргээд нийгмийн шаардлагад өөрчлөлт оруулж, байгаль орчинд ээлтэй түүхий эд, түлш ашиглахад чиглэсэн хөгжлийн үр дагавар юм.

Тогтвортой хөгжлийн, тэр дундаа эргэлтийн эдийн засгийн орчин үеийн санаанууд эрдэс баялгийн хомсдолд ихээхэн нөлөөлж байна. Үүний зэрэгцээ эрдсийн түүхий эдийг олборлох, боловсруулах, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх нь эрдсийн хөрөнгийн үнэ цэнэ, (зардлыг бууруулах, орлого, ордыг ашиглах хугацааг нэмэгдүүлэх), эрэлтийг нэмэгдүүлэх эсвэл зардлыг бууруулахад тусалдаг. Жишээлбэл, засгийн газрын хөтөлбөр, төсөл, хууль тогтоомж гэх мэт (байгууллагын хүчин зүйл) эрэлтийг нэмэгдүүлж, зардлыг бууруулах замаар эрдсийн хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлдэг.

Ашигт малтмалын нөөц ашигласны орлого, үнэ цэнийг эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, институци, байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр хомсдолд тооцож бүрдүүлснийг Зураг 48-т үзүүлэв.



Зураг 48 Хомсдолын хүчин зүйлсийг харгалзан эрдсийн хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнийг бүрдүүлэх

Эх сурвалж: зохиогчийн боловсруулсан арга

Энэхүү схемд үндэсний эдийн засгийн хэрэгцээг хангах, нийгмийн хэрэгцээг хөгжүүлэх нь эрдсийн хөрөнгийн хэрэгцээ, ашигт малтмалын ашиглалтын орлогыг тусгасан үнэ цэнийн хоёр тал юм. Үйлдвэрлэл байхгүй (эсвэл дутмаг) (бага агуулгатай түүхий эдийг боловсруулах технологи дутмаг, уул уурхайн хаягдлыг боловсруулах (үүсмэл ордуудыг ашиглах) арга, эрдсийн түүхий эдийн нэгдсэн ашиглалт, хаягдал багатай технологи гэх мэт) болон байгууллагын хүчин зүйлс (дотоодын эрэлтийг дэмжих хөтөлбөр, боловсруулах үйлдвэрүүд дутмаг) гэх мэт) нь ашигт малтмалын эрэлтийг бууруулж, ашигт малтмалын нөөцийг эдийн засгийн хувьд хомдоход хүргэдэг.

Сонгосон бүлгийн хүчин зүйлсийн сөрөг илрэл нь цаг хугацааны явцад өөрчлөгдөж болно. Тухайлбал, технологийн хүртээмж, таатай үнэ, зах зээлийн нөхцөл байдал нь ашигт малтмалын эрэлт хэрэгцээг хангахад хувь нэмэр оруулдаг бол байгууллагын таатай орчин (шинэ технологийг дэмжих хөтөлбөр, татварын горим гэх мэт) нь ашигт малтмалын эрэлт хэрэгцээ өсөх нөхцөлийг бүрдүүлэх, орлого нэмэгдэж, эрдсийн хөрөнгийн үнэ цэнийн өсөлтөд хүргэнэ (хүснэгт 43).

Хүснэгт 43 Ашигт малтмалын үр ашгийг тооцох хүчин зүйлс

Хүчин зүйлийн бүлгүүд	Ашигт малтмалын ҮР АШИГ
Эдийн засгийн	<ul style="list-style-type: none"> - Ашигт малтмалын нөөц багасах - Дэвшилтэт технологи нэвтрүүлэх санхүүгийн эх үүсвэрийн боломж - Нэмүү өртгийн сүлжээ (VAC) болон түүүнтэй холбогдох шинэ ажлын байр бий болгох
Шинжлэх ухаан, техникийн	<ul style="list-style-type: none"> - Ашигт малтмалын олборлолт, боловсруулалтын үр ашигтай технологийг нэвтрүүлэх - Боломжит шилдэг технологийг нэвтрүүлэх - Алдагдал, хаягдлыг бууруулах үүднээс техникийн төслүүдэд тавигдах чанарын шаардлагыг нэмэгдүүлэх.
Байгууллагын	<ul style="list-style-type: none"> - Инновацийг дэмжих үндэсний хөтөлбөрүүд байгаа эсэх - Нэмүү өртгийн сүлжээг бий болгоход нөлөөлөх бизнесийн харилцааны хэлбэрийг хөгжүүлэх - Хаягдал багатай технологи, ашигт малтмалыг цогцоор нь ашиглах технологи нэвтрүүлж буй уул уурхайн компаниудад зориулсан татварын таатай зохицуулалт /нөхцөл. - Ногоон уул уурхайн хөтөлбөрийг хэрэгжүүлэх - Ашигт малтмалын алдагдлыг зохистой бууруулах, уул уурхайн хаягдлыг бууруулахад ногоон уул уурхайн татварын журмыг бий болгох.
Байгалийн	<ul style="list-style-type: none"> - Байгаль, цаг уурын тааламжгүй нөхцлөөс шалтгаалан өөр, сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглахыг хязгаарлах.

МСК - Эрдэс түүхий эдийн цогцолбор Ногоон уул уурхай

Тогтвортой хөгжил, эргэлтийн эдийн засгийн нөхцөлд уул уурхайг ногоон болгох, салбарын эдгээр чиглэлийг дэмжсэн институцийн орчныг бүрдүүлэхэд анхаарч МСК-ийг шинэлэг байдлаар хөгжүүлэх замаар ашигт малтмалын үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой.

Эрдсийн хөрөнгийн хомсдол нь биет болон эдийн засгийн хомсдол хэлбэрээр илэрч болно. Эрдсийн хөрөнгийн үнэлгээний зориулалтаар ашиглах биет хомсдол гэдэг нь ашигт малтмалын арилжааны нөөцийг төслөөр батлагдсан хэмжээнээс давсан биет байдлаар хорогдуулахыг хэлнэ. Тиймээс ашигт малтмалын нөөцийн биет /бодит хомсдолыг үнэлэхийн тулд тухайн үеийн ашигт малтмалын газрын хэвлэй дэх ашигтай нөөцийн нормоос давсан илүүдэл алдагдлаас олох орлогын алдагдлыг тооцож үнэлэх ёстой. Үүний зэрэгцээ орчин үеийн технологийн зарим шийдэл, шинэлэг технологи нь ийм нөөцийг ашиглах боломжийг бүрдүүлдэг учраас эрдсийн хөрөнгийн үр ашгийг үнэлэхдээ, ийм технологийг хэрэгжүүлэхтэй холбоотой хөрөнгийн болон ашиглалтын зардал, нөөцөөс олох орлогыг харгалзан үзэх шаардлагатай.

Үр ашиглагдаагүй байсан ашигт малтмалын олборлох, боловсруулах үйл ажиллагаа явуулах буюу эрдсийн түүхий эдийг цогцоор нь ашиглах (KIMS), үүсмэл ордуудыг ашиглах (TM) эсвэл уул уурхайн хаягдлыг боловсруулах (GPO) зэрэг төслийг хэрэгжүүлэх, үнэлэх замаар эдийн засгийн алдагдал /хомсдолыг үе шаттайгаар нөхөх боломжтой юм.

Ийм төслүүд нь ашигт малтмалын үр ашгийг нэмэгдүүлэх нэмэлт орлого олох боломжийг бүрдүүлдэг бөгөөд энэ нь шинэ технологи ашиглах эсвэл шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсний (Жишээ нь: ГПО - уул уурхайн хог хаягдлыг боловсруулах, КИМС - ашигт малтмалын түүхий эдийг цогцоор нь ашиглах, TM - үүсмэл ордуудыг ашиглах) үр дүнд олж авсан нэмэлт ашигт малтмалыг боловсруулснаас олсон орлого юм.

Нэмэлт хөрөнгийн болон үйл ажиллагааны зардалд элэгдүүлсэн /үнэ буурсан ашигт малтмалыг олборлох, боловсруулахад зориулагдсан хаягдлын байгууламжийг барих, засварлах зардал (ГПО-уул уурхайн хаягдлыг боловсруулах, эсвэл TM-үүсмэл ордуудыг ашиглах); элэгдүүлсэн /үнэ буурсан ашигт малтмалын нөөцийг хамгаалах үнэ өртөг (ГПО-уул уурхайн хаягдлыг боловсруулах, эсвэл TM-үүсмэл ордуудыг ашиглах), түүнчлэн зах зээлд нийлүүлэх нэмэлт бүтээгдэхүүн гаргаж авах, үйлдвэрлэхтэй холбоотой зардлууд (ГПО-уул уурхайн хаягдлыг боловсруулах, эсвэл TM-үүсмэл ордуудыг ашиглах) орно.

Зохиогчдын санал болгож буй ашигт малтмалын нөөцийн үр ашгийн загварчлал дахь хорогдолын нягтлан бодох бүртгэл нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, эргэлтийн эдийн засаг түүнчлэн дотоод болон гадаад нөлөөг тооцож эдийн засгийн үр ашгийг (ENPV) тодорхойлох аргачлалтай нийцэж байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Үүний зэрэгцээ ашигт малтмалын нөөцийн хомсдолын чанарын болон тоон үнэлгээний олон асуудал хангалттай сайн судлагдаагүй, тусгай судалгаа хийх шаардлагатай байгаа нь эрдсийн нөөцийг үнэлэх загвар нь хязгаарлагдмал болохыг харуулж байна.

Эрдсийн хөрөнгийн үр ашгийн хүчин зүйл болох газрын хэвлэй дэх ашигт малтмалын хаягдлыг бууруулах нь

Төслийн шийдлүүдтэй харьцуулахад уг туршилтын загварыг хөгжүүлэхэд хэт их алдагдалтай, бодит зардал өсдөг зэрэг нь орчин үеийн ашиглалтын гүн дэх чулуулгийн даралтыг урьдчилан таамаглахад хэцүү байдагтай холбоотой. Хүдрийн ордын хувьд гүн нь 1800 м хүрдэг ба үүний зэрэгцээ уул-геологи, уул-техникийн эрсдэлүүд нэмэгддэг нь боловсруулах технологийн схемийн зураг төслийг хийхэд хүндрэл учруулж, чулуулгийн даралтыг хянахтай холбоотой техникийн шийдлүүдийн үндэслэл гарцаагүй хэрэгтэй болох нь тодорхой юм .

Ийм эрсдэл гарах нь хүдрийн нөөцийн тодорхой хэсгийг алдах, уурхайн үйл ажиллагаа зогсох, чулуулгийн тэсрэлт үүсэх, үйлдвэрлэлийн тогтвортой байдлын түвшин буурахад хүргэдэг. Энэ нь НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Зорилтуудад (TX3) нийцүүлэн компанийн стратеги болон байгаль орчин, нийгэм, компанийн засаглалын үйл ажиллагааны (ESG) зорилгод хүрэхэд нелөөлдөг.

Урьдчилан таамаглах үндсэн аргуудын нэг нь газрын хэвлийн геодинамик бүсчлэлийн арга бөгөөд энэ нь блок /цул үргэлжилсэн тогтоцын геологийн бүтцийг нарийн тодорхойлох төдийгүй уул уурхайн олборлолтод хамгийн аюултай тектоник даралтын (TH3), геодинамикийн аюултай (ГОЗ) эсвэл эрсдэлтэй бүсүүдийг тодорхойлох боломжийг олгодог. Хүдрийн ордын ашиглалт нь уулын чулуулгийн тогтоц дахь геодинамикийн үйл явц, үзэгдлийн хөгжлийг давхар судална гэсэн үг. Тектоник даралтад өртсөн бүсийг уулын чулуулгийн блок /цул үргэлжилсэн тогтоцын даралтын төлөвийг тооцоолох аналитик аргаар тодорхойлно.

Харилцан уялдаатай блок тогтоцын бүтцийн асуудлын гол онцлог нь тооцоололын аргаар шийддэг энгийн асуудлуудыг бодвол хил хязгаарын тоо (контакт) хамаагүй их байдаг учраас их хэмжээний хил хязгаарыг тооцож үзэхэд хамгийн сайн тохирох хилийн интеграл тэгшитгэлийн арга эсвэл тооцоолох аргууд дээр суурилсан програм хангамжийн системийг ашиглах нь зүйтэй. Уулын тогтоцыг чулуулгийн блокуудад хуваасан тектоник хагарал байгаа нь блок тогтоц дахь даралтын талбайг хувааж, түүнийг тухайн блокийн зэрэглэлийн хувьд тэгш бус илүү эсвэл бага түвшний даралттай нэг буюу хэд хэдэн блокоос бүрдэх хэсгүүдэд хуваагдсаныг харуулж байгаа юм.

Ордын тектоник хагарлын тоон хэмжээг тодорхойлоход хамгийн түгээмэл бөгөөд тодорхойлох хүчин зүйл болох хагарлын хавтгайн ойролцоо даралтын тархалтын шинж чанарт үндэслэсэн VNIMI ангиллыг ашиглахыг зөвлөдөг. Үүний зэрэгцээ ангилал нь даралтын байдлаас гадна тэсрэлтээс болж хагарсан нелөөллийн бүс дэх тогтоцын геологийн бүтцийг харгалзан үздэг бөгөөд үүний дагуу хагарал, даралтын төлөвийн төрлийг нүдэн баримжаагаар тодорхойлно. VNIMI ангиллын дагуу ан цав ихтэй бүсүүдээр тодорхойлогддог тектоник эвдрэлүүд нь 1-р төрөлд хамаарах ба дитъюнктив хагарлын хэсэгт шууд ачааллын бүс байдгаараа ялгаатай.

Ачааллын бүсийн дараа хоёр жигүүрт /захын 2 хэсэгт/ шилжилтийн бүсүүд байрлах бөгөөд тэдгээрийн дотор даралтын түвшин аажмаар нэмэгдэх буюу даралтын хэмжээ ихэссэн бүсүүд дагаж тогтсон байдаг. Ачааллын бүсэд – үйрэх /бутрах бүс хамт орших нь ийм төрлийн хагарлын геологийн гол шинж тэмдэг юм. Шилжилтийн бүсэд ан цав нэмж үүсэх боломжтой бөгөөд даралт ихэссэн бүсэд чулуулаг нь илүү нягт, бат бөх байдаг. Орон зайн геомеханик асуудлыг шийдэхийн тулд компьютерийн бүтээмжтэй технологийг

ашиглан нарийн тоо тооцооллын бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Орон зайн нөхцөл дөх блок-цул чулуулгийн тогтоцын үүсмэл даралт-деформацийн төлөвийг тодорхойлох тоон туршилтыг хийхэд PRESS 3D URAL программ хангамж [38] өргөн хэрэглэгддэг. Сидоров Д.В.-ийн боловсруулсан програмын гол үр дүн нь шинжлэх ухааны үндэслэлтэй тулгуур баганын хэмжэсүүд бөгөөд энэ нь газар доорх хүдрийн алдагдлыг багасгах боломжийг олгодог. Технологийн патентлагдсан шийдлүүдийг ашиглан сайн чанарын нүүрстэй нүүрсний ордуудыг далд аргаар олборлосноор ижил төстэй үр дүнд хүрч болох юм .

Эрдсийн хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх хүчин зүйлс болох ашигт малтмалын нөөцийг цогцоор нь хөгжүүлэх ба уул уурхайн хаягдлыг дахин (ТМ-Үүсмэл ордыг ашиглах) боловсруулах нь

Орчин үеийн нөхцөлд уул уурхайн бүтээгдэхүүний үр ашгийг хянах боломжтой хүчин зүйлүүдийн нэг нь хатуу ашигт малтмалын ордууд, эрдсийн түүхий эд зэргийг цогц байдлаар ашиглах (KIMS) түвшинд хүрэх гэж үзэж болно.

Цогц байдал гэдэг нь байгалийг ашиглах тогтвортой менежментийн нэг хэсэг болох газрын хэвллийг зохистой ашиглах үндсэн чиглэлүүдийг хэлнэ. Ашигт малтмалын олборлолтыг цогцоор нь хөгжүүлэх, ашиглах нь НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн зорилт №12-ын хүрээнд зохистой хэрэглээ, үйлдвэрлэлийн хэв маягт шилжихийг дэмждэг эргэлтийн эдийн засгийн үзэл баримтлалын хүрээнд жинхэнэ утгаа олж, хэрэгжих боломжтой юм.

Цогц байдлаар ашиглах зарчмыг үр дүнтэй хэрэгжүүлсний жишээ бол төрийн бодлогын нэг хэсэг болох эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахын тулд газар доорх баялгийг ашиглах Хятад улсын загвар юм.

БНХАУ-ын Засгийн газар нь чанар муутай ашигт малтмалын нөөцийг эзэмших, ашиглах, уул уурхайн хаягдлыг цогцоор нь ашиглах шинэлэг технологийг нэвтрүүлэхэд татварын хөнгөлөлт үзүүлэх болон бусад урамшуулалт олгох замаар уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн ашигт малтмалын иж бүрэн хайгуул, үнэлгээ хийх, бүтээн байгуулах үйл ажиллагааг дэмжиж, идэвхжүүлэхээр үзэл баримтлалаа томьёолжээ. Олон найрлагат хүдрийг цогц байдлаар ашиглах түвшинг нэмэгдүүлэх, уул уурхайн бүтээгдэхүүнийг нарийн боловсруулах технологийг нэвтрүүлэх, эрчим хүч хэмнэлх, хаягдлыг багасгах, уул уурхайн болзолт түүхий эдийг орлуулах, эдийн засгийн хараат байдлыг бууруулахын тулд Хятад улсын уул уурхайн салбарын тогтвортой хөгжил, газар доорх баялгийг ашиглах, эдийн засгийн эргэлтийн зарчмуудыг хэрэгжүүлэх чиглэлийг авч үзэж, тусгасан болно [42]. Хятад улсын 2021-2024 оны хөгжлийн төлөвлөгөөнд нөөцийн ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх, алдагдлыг бууруулах, нүүрстөрөгчийн ялгаралтыг багасгаж, эдийн засаг, нийгэмд ногоон хөгжлийг авчрахын тулд эдийн засгийн эргэлтэд тулгуурлан хөгжих үзэл баримтлалыг тусгасан байна .

ОХУ-д ашигт малтмалын үр ашгийн буюу газрын хэвллийн баялгын цогц ашиглалтын шинжлэх ухаан, арга зүйн үндэс нь академич В.И. Вернадский ба академич А.Е.Ферсманы эрдэс түүхий эдийг бүрдүүлэгч бүхий л үнэ цэнэтэй хэсгүүдийг цогцоор нь ашиглах хэрэглээний онол дээр тулгуурладаг. Одоогийн байдлаар эрдэс баялгийн цогцолборын технологийн үе шатуудыг ногоон болгох, ордуудыг цогцоор нь ашиглах

конвергент уул уурхайн технологийг бий болгох үзэл санааг дэмжсэн байгальд ээлтэй технологийн онол тулхүү хөгжиж байна.

3.2. Ашигт малтмалыг олборлох боловсруулах үеийн технологийн зохион байгуулалтын, уул-геологийн хүчин зүйлийн нөлөөллөөс үүсэх зардлын өөрчлөлтийг үнэлэх аргачлал ба цогц загварууд

Уул уурхайн үйлдвэрлэлийн өөрийн өртгийн бууралт (өсөлт)-ын хүчин зүйл гэдэг ойлголтод уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны нөхцөлд эрдсийн түүхий эдийн олборлолт, баяжуулалтын бүрэн өөрийн өртгийн хэмжээнд (өсөлт бууралтад) нөлөөлдөг хүчин зүйл (хүдрийн болон нүүрсний гүний уурхай, хүдрийн болон нүүрсний ил уурхай, баяжуулах фабрик) нэгж бүтээгдэхүүнд ногдох зардлын төвшинг илэрхийлэх өөрчлөлтийг багтаана.

Эрдсийн хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлтийн үнэлгээний аргачлалд ашигт малтмалын олборлолтын өөрийн өртгийн өөрчлөлтийн нөлөөллийн дараах хүчин зүйлүүдийг тусгана.

1. Ашигт малтмалын олборлолтын хэмжээний өөрчлөлтөд олборлолтын үеийн хаягдлын өсөлт (бууралт)-ын өөрчлөлтийн нөлөөллийг тусгах;
2. Олборлолтын хэмжээний өөрчлөлтөд бохирдолтын үзүүлэлтийн өөрчлөлтийг тусгах;
3. Уулын бэлтгэл ажлын хэмжээ, олборлолтын үр ашгийн өсөлт;
4. Уул-геологийн өөрчлөлт;
5. Материалын болон хөдөлмөрийн нөөцийн үнийн өөрчлөлтаас үүдсэн бэлтгэл малталтын болон олборлолтын зардлын өөрчлөлт.

Эрдсийн хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлтөд ашигт малтмалын баяжуулалтын өөрийн өртгийн өөрчлөлтийн нөлөөллийн дараах хүчин зүйлүүдийг тусгана:

1. Ашигт малтмалын баяжуулалтын хэмжээний өөрчлөлт бохирдолтын төвшинг бууруулах замаар (өсгөснөөс) эрдсийн агуулгын өсөлтөөс хамаарах эрдсийн агуулгын өсөлтөөс хамаарах;
 2. Металл авалтын коэффициентийн өсөлтөөс баяжуулалтын хэмжээ өсөхөд технологийн хүчин зүйл нөлөөлсөн байна.
 3. Баяжуулалтад материалын болон хөдөлмөрийн нөөцийн зардлын нөлөөлөл байна.
- Ашигт малтмалын олборлолтын жилийн өөрийн өртгийн өөрчлөлтөд нөлөөлөх хамаарлын судалгааг хойно үзүүлэв.

1. Эрдсийн хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлтийг олборлолтын хэмжээний өсөлт, өөрийн өртгийн бууралтыг тогтмол зардлын төвшинг (ΔC_Q) тогтвортой байлгах нөхцлөөр дараах томъёогоор тооцно. (25)

$$\Delta C_Q = \frac{\Delta Q * C_{уд} * Y}{Q_1} \quad (25)$$

ΔC_Q – ашигт малтмалын олборлолтын үйлдвэрлэлийн өөрийн өртөг, олборлолтын хэмжээний өөрчлөлт үр дүнгээр, төг/т

ΔQ – олборлолтын хэмжээний өөрчлөлт

($\Delta Q = Q_1 - Q$), т; Q – олборлолтын суурь хэмжээ, т;

Q_1 – төлөвлөгөөт жилийн олборлолт, т;

$C_{уд}$ – нэг тонн ашигт малтмалын суурь үеийн өөрийн өртөг. (олборлолтын хэмжээ өөрчлөгдөхөөс өмнөх үеийн) төг/т;

Y – суурь үеийн өөрийн өртөгт эзлэх тогтмол зардлын хувийн жин, %

Нүүрсний гүний уурхайн олборлолтын хэмжээг олборлолтын мөргөцгөөс ($Q_{оч}$) бэлтгэл малталтын ($Q_{бэлт}$) олборлосон нүүрсний нийлбэрээр тодорхойлно. (томъёо 26)

$$Q_i = Q_{оч} + Q_{бэлт} \quad (26)$$

Ашиглалтын мөргөцгөөс олборлох ($Q_{оч}$) хэмжээг тодорхойлоходоо технологийн үзүүлэлтүүд-ашиглалтын мөргөцгийн тоо, тэдгээрийн дундаж урт, тоног төхөөрөмжийн ажиллагааны техникийн нөхцөл болох ашиглалтын мөрөгцгийн ахилтын хурд; уул-геологийн нөхцөл давхрагын бүтээмж зэргийг хамтатган дараах томъёогоор (27) бодно.

$$QQ_{oq} = l * n * v * p \quad (27)$$

l – ашиглалтын мөргөцгийн дундаж урт, м.

n – ашиглалтын мөргөцгийн тоо

v – ашиглалтын мөргөцгийн ахилтын жилийн дундаж хурд, м/жил.

p – давхаргын бүтээмж, т/м²

Бэлтгэл малталтаас олборлох ($Q_{бэлт}$) хэмжээг дараах томъёогоор (28) бодно.

$$Q_{бэлт} = \sum_{i=1}^n Q_{mi} * B_i \quad (28)$$


Q_{mi} – уулын малтыг нэвтрэх ажлын хэмжээ, м

B_i – 1м уулын малталтаас гарах уулын цулын хэмжээ, т/м

Олборлолтын хэмжээний өөрчлөлт нь эрдсийн түүхий эдийн зах зээлийн эрэлтээс хамаарна. Олборлолтын хэмжээ өсөхөд тогтмол зардлын хэмнэлтээс үүдэлтэй үр ашгийн хэмжээ өсөх эдийн засгийн үр дүн гарна.

Харгалзах хэд хэдэн нөхцөл бас байгааг бодолцох хэрэгтэй. Тухайлбал, технологийн дамжлагын нэвтрүүлэх чадлын хязгаарлагдмал байдал, зохицуулагчийн нормт хэмжээ, уул уурхайн компанийн үйл ажиллагааны хязгаарлалт, ордыг ашиглах төслийн уулын ажлын төлөвлөгөөний хязгаар зэрэг нөхцлүүд байдаг.

Ашигт малтмалын олборлолтын хэмжээг өсгөх технологийн хүчин зүйл бол лаавын уртыг нэмэгдүүлэх явдал юм. Өсөлтийн үр дүнг нөхцөлдүүлэгч нь ажлын төвлөрлийг хангаж олборлох төхөөрөмжийг угсрах, задлаж зөөхөд зарцуулдаг цаг хугацааны хэмнэлт байдаг. (Зураг 49)



Зураг 49 Лаавын уртыг нэмснээр хоногийн олборлолт өсөх жишээ

Технологийн хүчин зүйлд хамааруулж болох нөхцлийн нэг бол олборлолт, нэвтрэлтэд өндөр хүчин чадалтай тоног төхөөрөмж нэвтрүүлснээр ажлын ахилтын хурдыг нэмэгдүүлэх боломж олдоно.

Өнөдр хүчин чадалтай төхөөрөмж хэрэглэхэд хязгаарлагч хүчин зүйлийн дотор уул-геологийн нөхцөл, уулын ажил хийхэд аюулгүй ажиллагааны шаардлага, тэр дундаа гүүрс, чулуулгийн цөмрөл, хийн тэсрэлт, уулын цохилтын аюулаас урьдчилан сэргийлэх явдал их чухал.

Уул-геологийн тааламжтай нөхцөл нь олборлолтын хэмжээг бууруулж эрдэс түүхий эдийн чанарыг дээшлүүлж, хаягдлыг багасгах замаар бүтээмжийг нэмэгдүүлэх боломж олгож байна.

Олборлолтын хэмжээ, нөөцийн ашиглалт уул-геологийн нөхцлийг оновчтой удирдахын тулд олборлолт, бэлтгэл ажлын механикжуулалтын төвшинг дээшлүүлэх, ашиглалтын системийг төгөлдөржүүлэх бүтээмж өндөртэй машин механизмыг нэвтрүүлэх, орчин үеийн материал (тэсрэх материал, эрчим хүчний эх үүсвэр) хэрэглэх хөдөлмөрийн болон аюулгүй ажиллагааны нөхцлийг сайжруулах шаардлагатай юм.

2. Олборлолтын хөдөлмөр зарцуулалтыг багасгах замаар Эрдсийн хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлтийг дараах томъёогоор (29) тодрхойлж болно.

$$\Delta C_B = \frac{\Delta B_1 - B}{1000} * 3\Pi \quad (29)$$

Энд B_1 , B шинэ ба суурь нөхцөлд хөдөлмөр зарцуулалтын хэмжээ, хүн/1000т

3Π – суурь нөхцөл дэх нэг ажилтны дундаж цалин, төг/хүн

3. Уулын нэвтрэлтийн ажилтны дундаж цалингийн өөрчлөлтөөр Эрдсийн хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлтийг тодорхойлох томъёо (30)

$$\Delta C_{3\Pi} = (3\Pi_1 - 3\Pi) \frac{T_1}{1000} \quad (30)$$

Энд $3\Pi_1$, 3Π – нэг ажилтны дундаж цалин суурь болон шинэ нөхцөлд, төг/хүн

T_1 – шинэ нөхцлийн хөдөлмөр зарцуулалт

4. Материалын зардлын өөрчлөлтөөр (цахилгааны тариф, хангамжийн байгууллагын үйлчилгээ) Эрдсийн хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлтийг тодорхойлох томъёо (31)

$$\Delta C_{\Pi} = \frac{(\Pi_1 - \Pi)*R}{Q_1} \quad (31)$$

Π_1 , Π – шинэ, суурь үеийн нэгж материал (үйлчилгээний) үнэ (тариф), төг/нэгж

R – материал (үйлчилгээний зарцуулалт), нэгж

5. Үйлдвэрлэлийн үндсэн хэрэгслийн бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлт (үндсэн хэрэгслийн жилийн дундаж үнийн өөрчлөлт ба элэгдэл хорогдлын жилийн дундаж нормын өөрчлөлт) Эрдсийн хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлтийг дараах томъёонуудаар (32), (33) тодорхойлно.

$$\Delta C_a^\phi = \frac{(\Phi_1 - \Phi)*N}{Q_1} \quad (32)$$

$$\Delta C_a^N = \frac{(N_1 - N) * \Phi_1}{Q_1} \quad (33)$$

Энд Φ_1 ба Φ – үндсэн хэрэгслийн жилийн дундаж үнэ шинэ ба суурь нөхцөлд, төг.

N_1 ба N – элэгдэл хорогдлын шинэ хуучин нөхцөлд, %.

6. Уулын нэвтрэлтийн ажлын зардлын өөрчлөлт (ΔC_{una}) болон төсвийн зардлын өөрчлөлтийг тусгасан (ΔC_{toscov}) бэлтгэл малталтын ажлын бүтэц, хэмжээ (ΔC_L) уулын бэлтгэл нэвтрэлтийн ажлын үргэлжлэх хугацаа (ΔC_T) зэргээс хамаарч Эрдсийн хөрөнгийн үнэ цэнэ өөрчлөгдхийг дараах томъёогоор (34) тодорхойлно.

$$(\Delta C_{una}) = \Delta C_{toscov} + \Delta C_L + \Delta C_T \quad (34)$$

- Төсвийн зардлын өөрчлөлт (ΔC_{toscov}) Эрдсийн хөрөнгийн үнэ цэнийг дараах томъёогоор (35) тодорхойлно.

$$\Delta C_{toscov} = \sum_{i=1}^n Y_i * \Delta P_{edi} \left(1 + \frac{\Delta III}{100}\right) + \Delta H_{nak} + \Delta \Pi_{toscov} \quad (35)$$

Энд Y_i - ажлын хэмжээ, эсвэл хийцийн элемент

i-ийн төрөл;

ΔIII – уурхайн нийт зардлын нормативын өөрчлөлт, %;

ΔH_{nak} – нэмэгдэл зардлын өөрчлөлт, төг;

$\Delta \Pi_{toscov}$ – төсвийн орлогын өөрчлөлт, төг;

- Уулын бэлтгэл ажлын бүтэц, бүрэлдэхүүний (ΔC_L) өөрчлөлтөөс хамаарах Эрдсийн хөрөнгийн өөрчлөлтийг дараах томъёогоор (36) тодорхойлно.

$$\Delta C_L = \frac{L_1}{Q_1} - \frac{L}{Q} \quad (36)$$

Энд L_1 , L – бэлтгэл ажлын шинэ хуучин үеийн хэмжээ, төг;

- Уулын бэлтгэл ажлын хугацааны богиносгосноос (ΔC_T) Эрдсийн хөрөнгийн үнэ цэнэд өөрчлөгдхөх хэмжээг дараах томъёогоор (37) тодорхойлно.

$$\Delta C_T = P_{t.3} \left(1 - \frac{T_1}{T}\right)$$

Энд $P_{t.3}$ – уулын нэвтрэлтийн ажлын техникийн төслийн суурь хувилбарт төсвийн тогтмол зардлын хэмжээ;

Т ба T_1 – уулын нэвтрэлтийн ажлын үргэлжлэх хугацаа (төслийн) техникийн шийдлийн хуучин шинэ хувилбараар.

- Тогтмол зардлын хэмжээг ($P_{t.3}$) 38-р томъёогоор тодорхойлно.

$$P_{t.3} = \text{ФОТ} * \frac{H_{nak}}{100} + \text{ФОТ} * \frac{\Pi}{100} \quad (38)$$

Энд ФОТ – үндсэн ажилчид механикжуулагчдын цалингийн сан, мян.төг;

H_{nak} – нэмэгдэл зардлын норм, %;

Π – төсвийн ашгийн норм, %

7. Уулын бэлтгэл ажлын суутгалын коэффициентийн өөрчлөлттэй холбоотой Эрдсийн хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлтийг ($\Delta C_{\text{суут.коэф}}$) 39-р томъёогоор тодорхойлно.

$$\Delta C_{\text{суут.коэф}} = C_{y.\text{б.а}} * Q_1 * (K_{y.\text{б.а}1} - K_{y.\text{б.а}}) \quad (39)$$

Энд $C_{\text{суут.коэф}}$ – уулын бэлтгэл ажлын суутгалын коэффициентийн өөрчлөлтөөс хамаарсан зардлын өөрчлөлт, мян.төг;

$C_{y.\text{б.а}}$ – 1 куб.м уулын бэлтгэл ажлын суурь үнийн үе, төг;

Q_1 – төлөвлөгөөт хугацааны ашигт малтмалын олборлолтын хэмжээ, мян.т;

$K_{y.\text{б.а}1}$ ба $K_{y.\text{б.а}}$ – төлөвлөгөө ба суурь оны суутгалын коэф, куб.м/т.

Төлөвлөгөөт хугацаанд уулын бэлтгэл ажлын хэмжээ буурсны үр дүнд суутгалын коэффициент өөрчлөгдөхөд 1 куб.м-ийн өөрийн өртгийг зөвхөн хувьсах зардлын хэсэгт тусгадаг.

Эрдсийн хөрөнгийн үнэ цэнийн нийлбэр өөрчлөлтийг олборлолтын ($\Delta C_{\text{ол}}$) үеийн зардлын өөрчлөлтийн нөлөөгөөр жилийн зардлын өөрчлөлтөөр 40-р томъёогоор тодорхойлно.

$$\Delta C_{\text{ол}} = \Delta C_Q + \Delta C_B + \Delta C_{\text{ЗП}} + \Delta C_{\text{Ц}} + \Delta C_a^{\phi} + \Delta C_a^N + \Delta C_{y.\text{б.а}} + \Delta C_{\text{суут.коэф}} \quad (40)$$

Бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өөрийн өртөг болон Эрдсийн хөрөнгийн өөрчлөлт нь хүдэр дэх металлын агуулгын өөрчлөлт, металл авалтын өөрчлөлтийн хамаарлаар доорх томъёогоор тодорхойлогдоно.

Эрдсийн хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлт хүдэр дэх металлын агуулгын өөрчлөлтөөс хамаарлыг тодорхойлоходоо баяжмал дахь металлын гаралтын нийлбэр (өсөлт, бууралт) нэгж металлын хувьсах зардлаар (суурь оны) ($\Delta C_{\text{агуулга}}$) дараах томъёогоор (41) тодорхойлогдоно.

$$\Delta C_{\text{агуулга}} = Q_1 * \frac{(Кагуул1 - Кагуул)}{100} * \frac{К_{\text{мет.авалт}}}{100} * C_{\text{ме}} \quad (41)$$

Энд $\Delta C_{\text{агуулга}}$ – хүдэр дэх металлын агуулгын өөрчлөлтөөс хамаарч өөрчлөгдөх зардал, мян.төг;

Q_1 – төлөвлөгөөт олборлолт, боловсруулалтын хэмжээ, мян.төг;

$K_{\text{агуул1}}$ ба $K_{\text{агуул}}$ – хүдэр дэх металлын агуулга, төлөвлөгөөт ба суурь үеийн, %;

$K_{\text{мет.авалт}}$ – металл авалт суурь үеийн, %;

$C_{\text{ме}}$ – суурь үеийн хувьсах зардлаар тодорхойлогдсон баяжмал дахь 1 тн металлын өөрийн өртөг, төг/т.

Хүдэр дэх металлын агуулгын өөрчлөлтийн тооцоог металл бүрээр хийнэ.

Баяжуулалтын үеийн баяжмалын металл авалтын коэффициентийн өөрчлөлттэй холбоотой Эрдсийн хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлтийг дараах томъёогоор (42) тодорхойлно.

$$\Delta C_{\text{мет.ав ОФ}} = Q_1 * \frac{(Кагуул)}{100} * \frac{(К_{\text{мет.авалт1}} - К_{\text{мет.авалт}})}{100} * C_{\text{ме}} \quad (42)$$

Энд $\Delta C_{\text{мет.ав}} \text{ОФ}$ - металл авалтын өөрчлөлтөөс хэмнэлт, мян.төг;

Q_1 - олборлолт, боловсруулалтын төлөвлөгөөт хэмжээ, мян.т;

Кагуул - суурь үеийн хүдэр дэх металлын агуулга, %;

$K_{\text{мет.авалт1}}$ ба $K_{\text{мет.авалт}}$ – баяжмал дахь металл авалт шинэ ба суурь үеийн хувилбар, %;

$C_{\text{ме}}$ – суурь үнийн үеийн хувьсах зардлаар тодорхойлогдсон баяжмал дахь1 тн металлын өөрийн өртөг, төг/т.

Бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн болон Эрдсийн хөрөнгийн зардлын өөрчлөлтийн нийлбэр эрдэс түүхий эдийн баяжуулалтын зардал бүрдүүлэх хүчин зүйлийн өөрчлөлтийн нөлөөллөөс хамаарч өөрчлөгдөх хэмжээг 43-р томъёогоор тодорхойлно.

$$\Delta \bar{C}_{\text{баяж}} = \Delta C_{\text{баяж}} = \Delta C_{\text{агуул}} + \Delta C_{\text{мет.ав.ОФ}} \quad (43)$$

(дээрх томъёоны тэмдэглэгээг түрүүчийн томъёонуудад бичсэн)

Ийм замаар Эрдсийн хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнийн үнэлгээний загвар нь жилийн цэвэр мөнгөний урсгалын хэмжээгээр илэрхийлэгдэхдээ эрдсийн түүхий эдийн олборлолт, боловсруулалтын зардал бүрдүүлэх хүчин зүйлүүдийн нөлөөлийг тусгасан томъёо (44) дараах хэлбэртэй байна.

$$C_{\text{ДП}_t} = C_{\text{Д}} - \Delta P_{\text{П}} + \Delta D_{\text{Д}} + \Delta D_{\text{ГП}} + \Delta D_{\text{К}} + H_t + \Delta \bar{C}_{\text{Д}} + \Delta \bar{C}_{\text{от}} \quad (44)$$

Дискантчлагдсан ЦЭМА2 загвар нь дараах хэлбэртэй болно. Томъёо (45)

$$C_{\text{ЭМА2}} = C_{\text{ЭМА1}} + \sum_{t=1}^R \Delta \bar{C}_{\text{Д}} * \beta t + \sum_{t=1}^S \Delta \bar{C} * \beta t \quad (45)$$

Энд: R – Эрдсийн хөрөнгийн олборлолтын зардлын хэтийн төлвийн өөрчлөлт;

S – Олборлосон түүхий эдийг боловсруулах зардлын өөрчлөлтийн хэтийн төлөв.

3-р бүлгийн дүгнэлт

Эрдсийн хөрөнгийн үнэ цэнэд нөлөөлөх хүчин зүйлүүдийг тодорхойлж ангилсан. Уул уурхайн үйлдвэрлэлийн болон эрдсийн түүхий эдийн анхан шатны боловсруулалтын зардлын үнэлгээний онцлогийг тодорхойлдог үндсэн хүчин зүйлүүдэд дараах үзүүлэлтүүдийг хамааруулав:

- Уулын үйлдвэрийн үйлдвэрлэлийн хэмжээ (хүчин чадал),
- Үйлдвэрлэлийн төрөлжилтийн төвшин, нэг болон олон төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг байдал,
- Олборлолт, боловсруулалтын ажлын механикжуулалт, автоматжуулалтын төвшин,
- Технологийн дамжлагын тоо,
- Олборлолт, боловсруулалтын үеийн ашигт малтмалын болон ашигт бодисын хаягдал,
- Металл авалтын дээд хязгаар, дагавар элементийн ашиглалтын хэмжээ гэх мэт.

Эрдсийн хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлт нь орлогын болон зарлагын хүчин зүйлүүд, үйлдвэрлэлийн хэмжээ, эрх зүйн нөхцөл (төрийн дэмжлэг, төрийн гэрээний үнэ тарифын өөрчлөлт, татварын системийн өөрчлөлт, хөдөлмөрийн хөлсөнд тавигдах шаардлага,

экологийн чиглэлтэй шаардлагууд) зэрэг хүчин зүйлүүдээс шалтгаалдгийг нотолсон байна.

Орлогын хүчин зүйлийн хүрээнд дараах зүйлийг багтаан ойлгож байна. Үүнд: Эрдсийн түүхий эдийн зах зээлийн үнэ, эрэлт хэрэгцээ, тоо, чанарт тавигдах шаардлагын өөрчлөлт, Эрдсийн түүхий эдийн хэрэглээний шинэ аргын нэвтрэлт, олборлолт, боловсруулалтад дайвар, дагавар ашиг эрдсийг ашиглах шинэ арга технологийг нэвтрүүлэх, ашигт малтмалын газрын хэвллийн хаягдлыг бууруулах, уул уурхайн үйлдвэрлэлийн хаягдлыг ашиглах зэрэг болно.

Зарлагын хүчин зүйлийн хүрээнд дараах зүйлийг багтаан ойлгож байна. Үүнд: уулын үйлдвэрлэлийн болон анхан шатны боловсруулалтад нөлөөлдөг гадаад, дотоод хүчин зүйлүүд, түүний хамаарлтай уул-геологийн өвөрмөц нөхцлөөс хамаарч уулын рентийн I – ийг бүрдүүлдэг бөгөөд инновацийн хөгжлөөр бүрдүүлдэг уул-технологийн, геомеханикийн нөхцөл, уулын рентийн II байдлаас шалтгаалдаг байна.

Эрдсийн түүхий эдийн олборлолт, анхан шатны боловсруулалтын зардал бүрдүүлэлтийн хүчин зүйл болон уулын үйлдвэрлэл баяжуулалтын зардлын хэмжээ хоёрын харилцан хамаарлын шинжилгээ ба загварыг боловсруулав.

Зардал ба үнэ цэнийг үнэлэх эдийн засаг-математикийн хүчин зүйлийн үндсэн 10 загварыг томъёолов.

Эрдсийн хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлтийг үнэлэх аргачлал нь ашигт малтмалын олборлолтын өөрийн өртгийн өөрчлөлтийн хамаарлыг тусгасан 5 бүлэг үндсэн хүчин зүйл, тэдгээрийн үндсэн дээр 8 загварт тусгасан болно.

Эрдсийн хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлтийг үнэлэх аргачлалд ашигт малтмалын баяжуулалтын өөрийн өртгийн өөрчлөлтийн 3 бүлэг үндсэн хүчин зүйл 2 үндсэн загварыг тусгасан болно.

Бидний боловсруулсан хүчин зүйлийн цогц загвар нь эрдсийн хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнийн үнэлгээний детермин (магадлалын) загварт тусгагдсан болно.

**БҮЛЭГ 4. АШИГТ МАЛТМАЛЫН ОРД АШИГЛАСНЫ ҮР АШГИЙГ ҮНЭЛЭХЭД
АШИГЛАХ ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛИЙГ ТООЦСОН АШИГТ МАЛТМАЛЫН
ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭНИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДЕТЕРМИН БУС
(НЕДЕТЕРМИНИРОВАННАЯ МОДЕЛЬ) ЗАГВАР БОЛОВСРУУЛАХ**

4.1 Төслийн эрсдэлийг үнэлэх арга зүй

Эрдсийн хөрөнгийн үнэ цэнийг тодорхойлох явцад эрсдэлийн хүчин зүйлийг тооцохдоо эрсдэлийн удирдлагын сонгодог зарчмуудад суурилна. Тодорхой бус байдал нь ирээдүйн төсөл хэрэгжүүлэх орчны талаарх төсөөлөл, төсөлтэй холбоотой зардал, үр дүнгийн тоон болон чанарын үзүүлэлтүүд бүрэн бус, тодорхойгүй байх явдал юм.

“Эрсдэл” гэдэг ухагдахуун нь янз бүрийн эх үүсвэр, нөхцөл байдлаас хамаарч олон янзаар тодорхойлогдоно. Үүнд:

1. Тодорхой үйлдвэрлэл, санхүүгийн үйл ажиллагааны үр дүнд нэмэлт зардал шаардагдах, орлого нөөцөө алдах магадлал, аюулын заналхийлэл;
2. Төслийг хэрэгжүүлэхэд төлөвлөсөн болон бодит үр дүнгийн зөрүү, хэлбэлзэлд хүргэдэг, төслийн үр дүнд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлс;
3. Сонгогдсон нөхцөлөөр амжилтгүй болж, өөр бусад сонгогдоогүй боломжийн үр дүнтэй харьцуулахад нөхцөл байдлыг муутгах тохиолдлын үр дүн (тухайн нөхцөлд үйлдлийг гүйцэтгээгүй тохиолдолтой харьцуулах);
4. Зайлшгүй сонгогдох нөхцөлд тодорхой бус байдлыг даван туулахад хүлээгдэх, хүссэн үр дүнд хүрэх тоон болон чанарын үнэлгээг хийхдээ зорилго хэрэгжихгүй байх, амжилтгүй болох магадлалыг тогтоохтой холбоотой ажиллагаа
5. Нэг болон хэд хэдэн зорилтод эерэг болон сөрөг нөлөөлөх тодорхой бус нөхцөл байдал, эсвэл үйл ажиллагаа
6. Төслийн үр дүнд эерэг, сөрөг нөлөө үзүүлэх үйл явцын болох магадлал.


Эрсдэл хэмээх ойлголт нь өөртөө дараах элементүүдийг агуулдаг. Үүнд:

- Сонгогдсон хувилбарын тавигдсан зорилгоос хэлбэлзэх боломж;
- Сонгосон хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой тодорхой бус байдалд материалын болон бусад байдлаар алдагдал хүлээх боломж
- Хүссэн үр дүнд хүрэх магадлал

Эрсдэлийг удирдах - Энэ нь үйлдвэрийн газрын болон тодорхой төслийн үйл ажиллагааны үнэлгээ, технологи, процесс, хүний нөөц, стратегийн талаар удирдлагын нэгдсэн шийдвэр гаргах үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөлөлийг системтэйгээр таньж илрүүлэх процесс юм.

Тасралтгүй, мөчлөгийн шинжтэй явагддаг уул уурхайн төслүүдийг хэрэгжүүлэх явцад эрсдэлийг удирдах процесс дараах зурагт үзүүлсэн үйлдлийн багцуудыг агуулна (50-р зураг). Үүнд:

1. Төслийн зорилго тодорхойлох
2. Эрсдэлүүдийг илрүүлж таних, тэдгээрийн чанарын үнэлгээг хийх
3. Эрсдэлийг удирдах арга хэмжээг тодорхойлж, Эрсдэлийн тоон шинжилгээ хийж, эрсдэлийг удирдах стратеги боловсруулах
4. Эрсдэлийн удирдлагын үр дүнгийн тайлагнал, мониторинг



Зураг 50 Төслийн эрсдэлийг удирдах процесс

1-р үе шат. Төслийн зорилго тодорхойлох хамгийн эхний алхам болох төдийгүй эрсдэлийг удирдах төлөвлөгөө гаргахад, төслийн үндсэн өгөгдлүүдийг бүрдүүлэхэд тун чухал. Төслийн зорилго нь урьдчилан хараагүй, үүсч болох нөхцөл байдлыг тогтоох явдал (зорилго хэрэгжүүлэхэд саад болох). Зураг4.2.

Үүнд: Төслийг хугацаанд нь хэрэгжүүлэх, төслийн эдийн засгийн үзүүлэлтүүд, батлагдсан төсвийг мөрдөх, объектуудын үйлдвэрлэлийн болон чанарын шинж чанар тохирч байх



Зураг 51 Төслийн зорилгод амжилттай хүрэх шалгуур

2-р үе шат. Эрсдэлийг таньж илрүүлэх үндсэн аргууд нь:

- Мэдээллийн эх үүсвэрийг шинжлэх
- Бүрэн болон хэсэгчилсэн бүтэц, нэгжтэй ярилцах
- Оюуны довтолгооны арга
- Эрсдэл-сессийг явуулах
- Хяналтын хуудас

- Системийн доголдлын үр дагавар, ажлын чадавхи, аюулын хүчин зүйлийн шинжилгээ (НАЗОР)
- Дэд бүтцийн, цаг агаарын, геотехникийн мэдээллийн шинжилгээ (НАЗИД)
- ХБО, Нийгэмд үзүүлэх нөлөөллийн шинжилгээ (ENVID)
- Төслийн үйлдвэрлэл, экологийн аюулгүй байдал, хөдөлмөр хамгаалал, иргэний хамгааллын шаардлагаас гарах эрсдэлүүдийг тодорхойлох, шинжлэх (PHSER)

3-р үе шат. Эрсдэлийг удирдах талаар арга хэмжээ боловсруулах, үлдэгдэл магадлал үнэлэх, төслийн эрсдэлийн нөлөөлөл тогтоох арга хэмжээ нь:

- Эрсдэл тус бүрийг бууруулах арга хэмжээг хэн хэрэгжүүлж байгаа, хичнээн цаг хугацаа шаардаж байгааг тодорхойлох
- Эрсдэлийг бууруулах арга хэмжээг боловсруулах, төслийн эрсдэлийн бүртгэлийг нэгтгэх
- Төслийн эрсдэлийн нөлөөлөл, үлдэгдэл магадлалыг үнэлэх
- Төслийн эрсдэлийг бүртгэж, хүлээн зөвшөөрөх

4-р үе шат. Эрсдэлийн удирдлагын үр дүнгийн тайлан, хяналт нь төслийн эрсдэлийн бүртгэлийн үндсэн дээр хэрэгжинэ.

Энэ үе шатны зорилго нь эрсдэлийн ноцтой байдал, статусын өөрчлөгдөх боломжийг шалгаж, эрсдэлийг удирдах, тодорхойлох арга хэмжээг хянах явдал юм.

Эрсдэл болон эрсдэлийн удирдлагын арга хэмжээний мониторинг нь цаг хугацаандаа эрсдэлийг дахин үнэлэх, хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг шинжлэх, хэрэгжсэн эрсдэлийн талаарх мэдээллийн сан бүрдүүлэх, эрсдэлийг үнэлэх, удирдах арга сонгоход шаардлагатай мэдлэг, туршлага хуримтлуулахад чиглэнэ.

Эрсдэлийн мониторингийн зорилго нь дараах баталгааг гаргах, хангах явдал юм. Үүнд:


- Бүх эрсдэлүүд хяналтанд байх
- Төсөлд шинээр үүсэх эрсдэлийг цаг хугацаанд нь илрүүлж, бүртгэж байх
- Эрсдэлүүд нь эрсдэлийн удирдлагын арга хэмжээнд зохистой байдлаар тусгагдан хэрэгжиж, нөхөн хаагдаж, эрсдэлээс хамгаалагдаж байх
- Эрсдэлийн удирдлагын арга хэмжээнүүд цаг хугацаандаа хэрэгжиж байх
- Эрсдэлийн удирдлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах нөөцөөр хангагдаж, тэр нь үр өгөөжтэй байх
- Эрсдэлийн үнэлгээнд болж өнгөрсөн бодит хүчин зүйлсийн өөрчлөлтийг тооцох

Хяналт мониторингийн системийн зохион байгуулалт нь дараах зарчмуудыг баримтлана.
Үүнд:

- Хамгийн гол түлхүүр эрсдэлүүдэд хамгийн их анхаарал хандуулах
- Эрсдэлийн удирдлагын тайлан нь хамгийн гол чухал мэдээллийг агуулна.

Эрсдэлийн ангилал - ямар нэгэн шинж төрхөөр, шалгуураар, нэгдсэн ойлголтоор эрсдэлийг бүлэглэн ангилж системчилнэ.

Ашигт малтмалын орд ашиглах төслүүдийн эрсдэлийг ангилах ерөнхий схемийг 52-р зургаар харуулж байна.



Зураг 52 Төслийн эрсдэлийн ангилал
(ARIS Business Architect 7.2-ыг хэрэглэж зохиосон схем)

Эрсдэлийн чанарын шинжилгээ – Энэ нь эрсдэлүүд үүсэх магадлал, тэдгээрийн нөлөөллийг харьцуулах, үнэлэх замаар цаашдын шинжилгээнд эрсдэлийг эрэмблэх, тайлбарлах явдал юм.

Эрсдэлийн шинж чанарыг тайлбарлах, илрүүлэхэд анхдагч мэдээлэл, өгөгдлийг янз бүрийн эх үүсвэрүүдээс авдаг. Үүнд:

- байгууллагын мэдлэгийн сан (өмнөх төслүүдийн мэдээлэл),
- тухайн салбарын нээлттэй эх үүсвэрүүдийн янз бүрийн мэдээллүүд, шинжлэх ухааны судалгаа,
- маркетингийн дүн шинжилгээ болон бусад судалгааны ажлууд хяналтын хуудас,
- баримт материалын шинжилгээ зэрэг.

Чанарын шинжилгээний аргуудад: оюуны довтолгоо, эрсдэлийн карт, шалтгаан-үр дагаврын шинжилгээ (Исикавын диаграмм), “Зангиа ба эрвээхэй” шинжилгээ, Эрсдэлийн сарнай, “Хэрэв, юу” арга, “Дельфи”арга, 635-ын арга, “Нэрлэсэн бүлэг” арга, “Кроуфордын карт” бүтэн болон хэсэгчилсэн ярилцлагын арга зэргийг ашигладаг байна. Чанарын шинжилгээний аргуудыг хэрэглэснээр эрдсийн хөрөнгийн үнэ цэнэд нөлөөлөх тоон үзүүлэлт гаргах албагүй.

Эрсдэлийн тоон шинжилгээ -Төслийн эрсдэлийн тоон шинжилгээ нь магадлалын онол, математик статистик, үйлдлийн шинжилгээний онолд тулгуурлана. Төслийн эрсдэлийн тоон шинжилгээг хийхэд хоёр нөхцөлийг зайлшгүй авч үзэх хэрэгтэй. Үүнд:

Төслийн суурь тооцооны мэдээллүүд ба чанарын шинжилгээг явуулсан байх.

Эрсдэлийн тоон шинжилгээний бодлого нь төслийн үр ашгийн шалгуур үзүүлэлтүүдэд нөлөөлөх хүчин зүйлийн өөрчлөлтийг тоон хэмжигдэхүүнээр илэрхийлэх явдал юм. Практикт хамгийн өргөн хэрэглэдэг төслийн эрсдэлийн тоон шинжилгээний дараах аргууд байна. Үүнд:

- Шийдвэрийн модны арга
- Үр ашгийн үзүүлэлтүүдийн мэдрэмжийн шинжилгээ (NPV, IRR, R г.м)
- Цаг хугацааны хүчин зүйлийн итгэлцүүрийн (дискаунтын норм) тодорхойлох
- Эрсдэлгүй эквивалент мөнгөн урсгал байгуулах арга
- Цаг хугацааны хүчин зүйлийн итгэлцүүрийн (дискаунтын норм) эрсдэлийг тохируулах арга
- Боломжит хувилбарууд
- “Торнадогийн диаграмм” арга
- Симуляцийн загварчлал - “Монте-Карло”-гийн арга

Шийдвэрийн мод - ашиг болон алдагдалд хүргэхүйц орчны нөхцөл байдлын байж болох боломж, магадлал нь тодорхой байх эрсдэлийн нөхцөлд шийдвэр гаргах системийг графикаар харуулсан байна.

Мэдрэмжийн шинжилгээ нь үр ашгийн шалгуур үзүүлэлтүүдийн утга нь нөлөөлөх хүчин зүйлсээс хамаарч хэрхэн хувьсахыг судлахад чиглэнэ. Үүнийг хоёр аргаар хийнэ. Үүнд:

- параметрүүдийг өөрчилж, үр дүнг гаргах
- тогтвортой шалгах (критик цэгийг тооцох)

Цаг хугацааны хүчин зүйлийн итгэлцүүрийг тодорхойлох нь хамгийн энгийн, практикт хамгийн өргөн хэрэглэгддэг арга юм. Үндсэн санаа нь эрсдэлгүй буюу хүлээн зөвшөөрөх боломжтой дискаунтын суурь нормыг авдаг гэсэн үг. Засварлах нь эрсдэлийн хувь хэмжээг дээр нь нэмж өгөх явдал.

Төслийн эрсдэлгүй эквивалент мөнгөн урсгалыг байгуулахдаа таамаглаж байгаа мөнгөн урсгалын элементүүдийг бууруулахад (эрсдэлгүй эквивалентыг байгуулах) үндэслэнэ. Үүний тулд:

- жил бүрийн мөнгөн урсгалын өгөгдсөн утгын хэрэгжих магадлалыг үнэлнэ.
- Үүний дараа мөнгөн урсгалыг бууруулах коэффициентээр засварласны үндсэн дээр шинэ төсөлд орлуулан тавьж, NPV-ийн шинэ утгыг тооцож гаргана.

Цаг хугацааны хүчин зүйлийн итгэлцүүрийн (дискаунтын норм) эрсдэлийг тохируулах арга нь дискаунтын нормыг эрсдэлийг тооцож өсгөхөд суурилна.

- хөрөнгө оруулалтанд шаардагдах капиталын анхны өртгийг (WACC) тогтооно;
- тухайн төсөлтэй холбоотой эрсдэлийн урамшуулал тодорхойлогдоно;
- шинэ дискаунтын нормоор NPV-ыг тооцно.

Боломжит хувилбарын арга нь үр дүнгийн үзүүлэлтүүдийн мэдрэмжийг судлахдаа түүний хэлбэлзэх магадлалын тооцоололд дүн шинжилгээ хийх боломжийг олгодог. Энэ аргын тусламжтайгаар үйл явцын янз бүрийн хувилбаруудын дүр төрхийг харах

боловжтой. Энэ арга нь хэд хэдэн хүчин зүйлсийн нөлөөллийн өөрчлөлтийг нэгэн зэрэг хийх мэдрэмжийн шинжилгээг агуулна.

Төслийн шинжилгээний арга нь:

- гутранги,
- хамгийн их магадлалтай,
- өөдрөг гэсэн гурван боломжит хувилбарыг байгуулдаг.

Хувилбар бүрийн хувьд харгалзах өнөөгийн цэвэр үнэ цэнэ (NPV_T , NPV_M , NPV_o) тогтоогдоно, төслийн хувьд NPV -ийн хэлбэлзлийн хүрээ тооцогдоно.

Монте Карлогийн арга – шинжилж байгаа параметрүүдийн тохиолдлын утгуудыг ашиглаж байгаа үед компьютерийн программын тусламжтайгаар адилтгасан мэдрэмжийн шинжилгээ, үнэлгээг хийх арга юм.

Энэ арга нь үнэлгээний үзүүлэлтүүдэд харгалзах тохиолдлын утгуудыг компьютерийн программын тусламжтай хуваарилахад суурилна. Монгте-Карлогийн аргыг Microsoft Excel -ийн орчинд хэрэглэх боломжтой.

Эрсдэлийн чанарын болон тоон шинжилгээний олон янзын аргуудаас төслийн мэдээллээс хамаарч тодорхой нэг аргыг сонгоход хүргэнэ.

4.2 Хатуу ашигт малтмал ашиглах төслийн онцлог

Эрэл хайгуулын ажлаас эхлээд уурхайлалт явагдах, уурхайг хаах хүртэлх уулын үйлдвэрлэлийн бүхий л үе шатанд тодорхойгүй байдал маш ихээр үүсдэг онцлогтой. Энэхүү тодорхойгүй байдлын төрлүүдэд:

1. эдийн засгийн,
2. үнийн,
3. мэдээллийн,
4. улс төрийн,
5. эрх зүйн орчны,
6. байгаль цаг уурын
7. зөрчилтэй бусад нөхцөлүүд,
8. уул геологийн нөхцөл,
9. газрын хэвлийн тодорхойгүй байдал элбэг байна.

Эдийн засгийн тодорхой бус байдал нь:

- эдийн засгийн субъектууд,
- төрийн эдийн засгийн орчинд үүсэх өөрчлөлтийн нөлөө юм.

Жишээ нь: эрэлтийн хэмжээ, валютын ханшны өөрчлөлт, шинэ өрсөлдөгч бий болох, тэдний зах зээл дэх нөлөөлөл Г.М болно.

Уул уурхайн салбарт урт хугацааны төслийг үнэлэхэд үнийн тодорхойгүй байдал нь байнга анхаарал татсаар ирсэн. Нэг талаас ихэнх түүхий эдийн зах зээл хэвийн нөхцөлд зах зээлийн хүчин зүйлсийн нөлөөнд төрийн зохицуулалт шууд бус байдлаар нөлөөлөх, эсвэл огт хэрэгждэггүй. Иймээс хэвийн нөхцөлд ихэнх тохиолдолд түүхий эдийн үнэ төрийн хяналтгүй, глобаль шинжтэй маш олон хүчин зүйлээс хамаардаг нь тогтвортгүй байдалд хүрдэг.

Нөгөө талаас, урт хугацааны үнийн хандлага тодорхойлдог олон аргуудыг хэрэглэдэг нь үнийн таамаглалын зөвшилцэлд хүрэхийг (зөвшилцсөн таамаглал) шаарддаг. Гэхдээ түүхий эдийн үнийн хандлагыг (юуны өмнө нефть) зөвшилцэж, хүлээн авах нь хамгийн нэр нөлөөтэй таамаглал ч эрдэсийн хөрөнгийн үнэлгээ хийх хөрөнгө

оруулалтын төслийн найдвартай үнийн мэдээлэл, өртгийн үзүүлэлт, үр ашгийн шалгуур болж чаддаггүй.

Судлаачийн байр суурь, олон улсын экспертуудийн урт хугацааны үнийн таамаглал нь дунд хугацааны таамаг үнэ, бодит үнийн зөрүү ТЭЗҮ, өнөөгийн цэвэр үнэ цэнийн тооцоонд тулгуурлах нь хугацаа уртсах тусам тохиромжгүй гэж үздэгээр баталгаажна. Ийм байдлаар орд ашиглах төслийн үнэ цэнийг үнэлэхэд бодитой нөлөө үзүүлэхгүй цаг хугацааны үзэгдэл, тогтвортгүй байдал гэдгийг хүлээн зөвшөөрдөг. ОХУ -ын Байгаль орчны яам, .. аргууд үнийн хүчин зүйлийн нөлөөлөлд эрдэсийн хөрөнгийн үнэ цэнийг богино хугацаагаар тодорхойлоход тэргүүн зэргийн ач холбогдол өгдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Газрын ховор металлын (ГХМ) зах зээлийн нөхцөлийн өөрчлөлтийн тод жишээ байдаг. ГХМ-ын хэрэглээ 1980-аад онд 26 мянган тонн исэл байсан бол өндөр технологийн секторын үсрэнгүй хөгжлийн үе гэгдэх 2010aad он гэхэд 100-120 мянган тоннд хүрсэн нь үүнийг нотолно. Эрэлтийн хэмжээний өсөлт нь зах зээл, үнийн өөрчлөлтөд хүргэсэн. Хятад улс төрөөс хэрэгжүүлсэн хөтөлбөрийнхөө үр дунд 1980-90 онуудад зах зээлд монополь байдлаа хадгалж, бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр тэргүүлэгч байсан бол 2000 оноос нөхцөл байдал өөрчлөгдөж, экспортын хэмжээгээ бууруулж эхлэсэн. Энэ нь өөр томоохон нийлүүлэгч байгаагүйгээс урьдчилан таамаглаагүй үнийн өсөлтийг дагуулжээ. 2009 он гэхэд ГХМ-ын исэл 10 долл/кг -ын түвшинд байсан бол 2011 оны дунд үед 190 долл/кг болж өссөн нь үнийн хүчин зүйлийг таамаглах дээр өгүүлсэн эрсдэлдэй байдлыг баталж байгаа юм.

Үнийн тодорхойгүй байдлын өөр нэг жишээ нь, харьцангуй бага хугацаанд тухайн үеийн нөхцөл байдлын нөлөөгөөр үнэ огцом өөрчлөгдөх юм. Короновирусын тархалтын нөлөөгөөр 2020 оны эхний хагаст зэсийн үнэ 20%, никельийнх 13% цайрынх 14% унасан. Адил төстэй үнийн нөхцөл үнэт металл дээр ажиглагдаж, алтны үнэ 6%, мөнгөнийх 30%, платинах 35%, палладийн үнэ 38% унаж байв.

Мэдээллийн тодорхойгүй байдал нь компанийн аж ахуйн үйл ажиллагааг найдвартгүй байдалд хүргэнэ. Мэдээллийг цахимжуулах нөхцөлд уулын үйлдвэрийн хөрөнгийн үнэ цэнэ нь өгөгдлийг цуглуулах, боловсруулах, тайлбарлах явдал боловсронгуй болж, уулын үйлдвэрийн ажлын үйлдвэрлэл-эдийн засгийн үзүүлэлтүүд, гаргаж байгаа удирдлагын шийдвэрт эерэгээр нөлөөлж байна. Жишээ болгож, “Щербинский” нүүрсний ил уурхайн жишээг үзье. Уурхайг ашиглалтанд оруулсны дараа уулын ажил зогссон, энэ үед уурхайд 60 сая рублийн хөрөнгө оруулалт хийгдсэн байсан.

Мэдээллийн тодорхойгүй байдал уулын үйлдвэрт, тэр дундаа ажил явагдаж байгаа объектын процессын талын мэдээлэл байхгүй байх. Тухайлбал, уулын чулуулгийн хөдөлгөөний чиглэл, хурд зэрэг мэдэгдэхгүй байх нь худал ташаа таамаглал гарах шалтгаан болж, осол болох нөхцөл үүсдэг. Жишээ нь, 2005 онд Новокузнецкийн “Есаульская” уурхайд метаны дэлбэрэлт болсноор 25 хүн амь наасаа алдсан. Далд уурхайд ажилчид, уулын аврагч нарыг байхад, гал унтраах үед дэлбэрэлт болсон. Осолын шалтгааныг судлаад уулын аврагчдын ажил хийх аюулгүй зайн тооцоо нь баталгаагүй өгөгдөл суурилж хийгдсэнд байжээ.

Улс төрийн тодорхой бус байдал, улс оронд тогтвортгүй байдлыг үүсгэдэг. Тоног төхөөрөмж нийлүүлэгч орон, үйлчлүүлэгчид ч чухал үүрэгтэй, бараа материал, үйлчилгээний нийлүүлэлт, бүтээгдэхүүний эрэлт, тавигдах чанарын болон дагалдах үйлчилгээний шаардлагуудыг түншүүд тодорхойлдог.

Эрх зүйн орчны тодорхойгүй байдал нь хууль дүрэм төгс бус, олон янзын үзэл бодол, эсрэг тэсрэг байдал, хуулийн цоорхойг үүсгэдэг. Өмнө нь газрын нөөцийн удирдлага, эсвэл газрын эзэнтэй урьдчилан зөвшилцсөний үндсэн дээр газрын хэвлэйн тухай хуулиар тодорхой хэсгийг ашиглах тусгай зөвшөөрөл олгогдож байсан бол энэ норм хэмжээ цаашдаа хүчгүйдэж, үр дүнд нь газрын хэвлэй ашиглагчдын үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөх болсон.

Байгаль цаг уурын тодорхой бус байдал нь компанийн аж ахуйн үйл ажиллагаанд шууд нөлөөлдөг. Антициклон өндөр үед гүнзгий ил уурхайнуудад манан үүсэх магадлал өндөр болдог, ингэснээр уурхайн агаар солилцоог хязгаарлаж, угаарын хийн концентрац нэмэгдэхэд хүргэнэ.

Зөрчилтэй нөхцөл байдал ч харилцагчийн зан байдалд нөлөөлөх ба зах зээл дэх монопол компанийн бодлогыг өөрчлөхөд хүргэнэ.

Уулын үйлдвэрт газрын хэвлэйн шинж чанарын тодорхойгүй байдал онцгой анхаарах зүйл болдог. Үүнд эрдэсийн түүхий эдийн шинж чанарын өөрчлөмтгий байдал, хажуугийн чулуулаг, тэдгээрийн динамик г.м орно. Газрын хэвлэйг судлах маш олон арга байвч өнөөг хүртэл аюулгүй ажиллахад шаардлагатай бүхий л өгөгдлийг баталгаатай өгөх нэг ч арга байхгүй. Олборлолтын гүний ихсэлт, уул техникийн нөхцөлийн хүндрэл зэргийг тооцож, цаг хугацааг даган газрын хэвлэйн тодорхойгүй байдал улам л ихэснэ. Уулын үйлдвэрийн хувьд эрсдэлийг тодорхойлоход уулын ажлыг явуулах, удирдлагын шийдвэр гаргах цаг хугацаанаас сөрөг үр дагавар болох боломжит хугацаа хоцрогдож байдгийг тооцох хэрэгтэй.

Судлаачийн санал болгосноор уул уурхайн салбарын онцлогийг тусгаж, эрсдэлийг тодорхойлохдоо дараах байдлыг авч үзэх хэрэгтэй. Үүнд: уулын үйлдвэрийн үйл ажиллагааны нөлөөгөөр, газрын хэвлэйн тодорхойгүй байдлын улмаас уулын ажил явуулах ямар ч үе шатны процесст, уурхай, үйлдвэр ямар нэгэн нөөц боломжоо алдах эсвэл бусад оролцогч талуудын алдагдал хүлээх магадлал үүсэх явдал гэж үзэж байна.

Уул уурхайн компанийн (хүдрийн уурхайн) хувьд тэдгээрийн үйл ажиллагааны онцлогийг тусгасан эрсдэлийн хүчин зүйлийг хэд хэдэн хэсэгт хувааж болно.

Нэгдүгээрт, уулын ажил явуулах нөхцөл хүндрэх. Эрдэс, түүхий эдийн шавхагдах байдлаас хамаарч тодорхой төрлийн түүхий эдийн эрэлтийн өсөлт нь өмнө нь ашиглах боломжгүй гэж байсан хэсгийг ч олборлож ашиглахад хүргэдэг. Жишээ нь, ӨАБНУ-д “Tay-Tона”-гийн уурхай, дэлхийн хэмжээнд алтны уурхайнуудаас хамгийн гүнд тооцогддог ба уулын ажлын нийлбэр урт 800 км, олборлолтын гүн 5 км болсон байна. Гүний горизонтуудад температур 60°C болсон нь агааржуулалт, логистикийн гэх мэт олон хүндрэлтэй асуудлыг үүсгэж байв. Үйлдвэрлэлийн ажлын шаардлагаар ийм гүнд алтны дээд агуулга 9 гр/тн байлаа. Ийм жишээ ганц бус. 1975 оноос дэлхийд хүдрийн уурхайн хамгийн их гүн 3 дахин өссөн нь ганц нэг тохиолдлын тухай биш, илүү гүний давхаргуудыг ашиглах хандлага руу шилжиж байгааг харуулж байна.

Уулын олборлох үйлдвэрийн бас нэг эрсдэлийн хүчин зүйл нь бүтээн байгуулах хугацаа урт байх, барьж байгуулж эхлэхээс бүтээгдэхүүний борлуулалт хийгдэж, анхны мөнгөний орох урсгал хүртэлх хугацаа урт байх явдал. Статистикаар дундаж хугацаа 5-8 жил, гэхдээ тааламжгүй нөхцөл, гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр илүү уртасдаг байна. Ихэнх уулын үйлдвэрийн ашиглалтын үе нилээд урт, орд ашиглах дундаж хугацаа 20 жилийг давдаг.

Хүдрийн уурхайнууд ихэвчлэн ашигт малтмалын шинж чанарын өндөр өөрчлөмтгий, ашигт хольцын агууламж доогуур, хүдрийн үнэ цэнэ өндөртэй давхрага бүхий ордуудад янз бүрийн ашиглалтын систем, технологи хэрэглэдэг байна. Эдгээр онцлогууд нь эрсдэлийг аюул заналхийллийн хүчин зүйл гэж үзэж шинжилгээ хийх зайлшгүй шаардлагатайг илтгэнэ.

Эрдэсийн түүхий эдийн бааз, уулын ажил явуулах орчин өөрөө эрсдэлийн объект болохын зэрэгцээ нэгэн зэрэг эрсдэлийн хүчин зүйл болно. Иймээс уулын үйлдвэрийн эрсдэлийг үнэлж, шинжлэх, таньж мэдэхгүйгээр түүхий эдийн олборлолт явуулах боломжгүй юм. Хатуу ашигт малтмалыг олборлох, боловсруулах үеийн эрсдэлийг шинжлэх ухааны зохиол бүтээлд хязгаарлагдмал, дутагдалтай тусгадаг нь эрдэсийн хөрөнгийн үнэ цэнийг бодитой тодорхойлж үнэлэх, бүртгэхэд хүндрэл учруулдаг.

А.Д.Мурзин, Т.М. Роговой нар уулын олборлох үйлдвэрийн эрсдэлийг хэмжигдэх (параметрийн) ба хэмжигдэхгүй (параметрийн бус) гэсэн 2 бүлэгт хувааж үзсэн. Хэмжигдэхгүй эрсдэлд гадаад эрсдэлүүд (эрх зүйн), гадаад дотоод эрсдэлүүд (экологийн, мэдээллийн) хамаарна. Хэмжигдэх эрсдэлүүд нь үнэндээ бас гадаад эрсдэл (үнийн, татварын), дотоод эрсдэлүүдийг (геологийн, технологийн, уул техникийн) агуулдаг. Ийм маягаар хатуу ашигт малтмалыг олборлоход уулын ажил явуулах нөхцөлтэй холбоотой уул техникийн эрсдэлүүд онцгой үүрэгтэй. Энэ ажилд эрсдэлийн шинжилгээ, эрсдэл таньж илрүүлэхэд нэг их анхаараагүй, харин экологи-эдийн засгийн эрсдэлийг нилээд дэлгэрэнгүй авч үзэж байна.

Судалгааны ажилд ашигт малтмалыг ашиглах, бэлтгэх, эрэл хайгуул хийхэд хамгийн их нөлөөлөх тодорхой эрсдэлүүдийг чухалчлан ач холбогдол өгч байна. Судлаач дараах төрлийн эрсдэлүүдийг ялгаж үзэв:

- геологийн (эрдэсийн түүхий эдийн нөөцийн тоо, чанарт хамаарах),
- технологийн (олборлох ажлын технологи),
- санхүү-эдийн засгийн (үнийн тогтвортгүй байдал, эрэлт,
- нийлүүлэлтийн хэлбэлзэл, инфляци),
- улс төрийн (хууль эрхзүйн өөрчлөлт, хувьчлах боломж),
- аюулгүй байдалтай холбоотой эрсдэлүүд (осол аваар үүсэх, мэргэжлийн өвчлөл).

Эрсдэлийн ийм бүлэглэлт нь логиктой, гэхдээ өмнөх тохиолдолд олборлох технологи, осол гарах, технологийн шинжээр нөхцөлдөж үүсэх зэргээр ангилах зарчмын асуудлууд гарах шалтгаан болно.

О.А Леоновагийн ажилд уулын үйлдвэрийн эдийн засгийн эрсдэлүүдийн байгаа ангилалд тулгуурлан макро ба микро эдийн засгийн эрсдэл гэж ангилсан. Судлаач макро эдийн засгийн ангилалд:

- байгалийн бодит;
- салбарын;
- зах зээлийн;
- төсвийн;
- улс төрийн;
- шинжлэх ухаан техникийн эрсдэлийг хамааруулсан 6

Мөн микро эдийн засгийн эрсдэлд:

- хөрөнгө оруулалтын эрсдэл,
- уурхайн үйлдвэрлэл-техникийн эрсдэл,
- аж ахуйн эрсдэл,

- экологийн хохирлын эрсдэлийг багтаасан байна.

Эхлээд харахад энэ ангилал нь логиктой, гэхдээ бүлгүүдэд хамааруулсан эрсдэлүүд асуудал үүсгэдэг. Судлаач нь макро эдийн засгийн эрсдэлд байгалийн бодит эрсдэл, тухайлбал, уул-геологийн эвдрэлийг оруулна гэж баталж байна. Мөн дээр дурдсан геодинамикийн эрсдэлийг ч микро эдийн засгийн үйлдвэрлэл - аж ахуйн эрсдэлд хамааруулж байна.

В.М.Заернюка болон бусад судлаачид уулын үйлдвэрийн эрсдэлийн ангиллыг цогцоор нь авч үзсэн байна. Судлаачид уулын үйлдвэрийн эрсдэлийг мөн л системийн буюу үйлдвэрийн газрын санхүүгийн үр дүнгийн эрсдэлүүд ба системийн бус буюу техникийн шинжтэй эрсдэлүүд гэж 2 бүлэгт хуваасан байна.

Системийн эрсдэлд:

- улс төрийн,
- зах зээлийн,
- макро эдийн засгийн эрсдэлүүдийг хамааруулж,

Системийн бус эрсдэлд:

- геотехникийн (хүдрийн гарал үүсэл, литологтой холбоотой),
- эдийн засгийн (түүхий эдийн олборлолтын хэмжээ, түүний чанарын бүтэц, хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны зардалтай холбоотой),
- экологийн эрсдэлүүд (байгаль орчныг бохирдуулах, чимээ шуугианы нөлөө),
- эрдэсийн гарал үүслийн (хүдэржилтийн бүс, хүдэржилтийн бүс дэх эрдэсийн илэрц)
- аюулгүй байдлын (хийн хяналт, агааржуулалт, механикжилтийн зэрэг г.м) эрсдэл хамаарна.

Уул уурхайн эрсдэлд газрын хэвлэлийн ашиглалттай холбоотойгоор “ИПКОН РАН”-ын олон судлаачид онцгой анхаардаг. В.Н.Захаровагийн судалгааны ажилд:

- нөөцийн үнэлгээний нарийвчлалийг тусгасан геологийн эрсдэл,
- тусгай зөвшөөрөлтэй холбоотой эрх зүйн эрсдэл,
- төлөвлөсөн хэмжээгээр олборлолт хийхэд зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалтын эрсдэл,
- шаардлагатай эдийн засгийн үзүүлэлтүүдийг хангахуйц үйл ажиллагааны эрсдэл зэрэг судлагдсан болно.

Үйлдвэрийн аюулгүй ажиллагааны түвшинд нөлөөлөх гол хүчин зүйлст тоноог төхөөрөмжийн ашиглалттай холбоотой техникийн эрсдэлүүд байна. Зохион байгуулалтын эрсдэлд ослын нөхцөл байдалд хүргэж болох хүний үйл ажиллагаатай холбоотой эрсдэлүүд хамаарна. Ийм эрсдэлүүдийг уулын эрсдэлд хамааруулахгүй, гэхдээ ажлын аюулгүй байдлын үнэлгээнд зайлшгүй тооцох шаардлагатай.

Уул уурхайн онцлогоос хамааруулж, уулын эрсдэлүүдийг цогц байдлаар сонгох нь логикийн хувьд зөв ба энд салбарын онцлог байх ёстой.

Ном зохиолд дурдсанчлан, уулын эрсдэлийн онцлогийг таньж ойлгоход судлаач үүсэх нөхцөл байдлыг авч үзсэн байна. Үүнд:

- олборлолтын ажил явуулах сонгосон схем,
- байгалийн бодит нөхцөл байдал.

Байгалийн бодит нөхцөл байдал нь ордын уул геологийн шинж чанарыг тусгадаг. Байгаль орчны хүчин зүйлүүдийн нөлөөлөлөөр үүсэх уулын эрсдэлийг судлаач авч

Үзэхдээ уул геологийн гэж нэгтгээд, нөлөөлөх хүчин зүйлээс нь хамааруулан 5 бүлэгт хуваасан байна. Үүнд:

1. Хийн ялгаруулалт
 2. Тоосжилт
 3. Уулын даралт
 4. Уулын ажлын нөлөөгөөр уулын чулуулгийн шилжилт
 5. Усны шүүрэлт
1. *Хийн ялгаруулалт.* Нүүрсний давхарга метан агуулдаг учраас нүүрсний уурхайд илүү хамаатай. Нүүрсний бүтэц нэгэн жигд биш, хагарал, нүх сүйтэй, нүүрсэн дэх чөлөөт хий агуулагддагаас хагаралтай байдаг. Иймээс метан хуримтлагдаж, давхрагын хэмжээгээр жигд бус тархалттай байна. Ийм төрлийн эрсдэл хийн ялгаруулалтанд магадлал багатай ч хийн динамиктай гэж хэлж болно.
 2. *Тоосжилт.* Уулын малталтуудын тоос нь маш олон асуудлыг үүсгэнэ. Ийм байдлаар уурхай дах агаар анхаарал татаж, уурхайн эрсдэлийн бүтцэд агаарын найрлагаас хамаарч аэрологийн эрсдэл хэмээн ордог.
 3. *Уулын даралт.* Гэнэтийн бат бус хэврэг уулын чулуулаг нурж, газрын доорхи уурхайн малталтын бэхэлгээг нураах, машин механизм, тоног төхөөрөмжийн хөдөлгөөн, технологийн процессыг алдагдуулах чулуулгийн цохилт үүсэх аюул байдаг. Өөрөөр хэлбэл, чулуулгийн цохилт нь худрийн цул, чулуулаг нурах, ажил явагдсан хоосон орон зайд цохилтын долгион үүсэх, уулын массад гэнэтийн кинетик энергийн хуримтлал үүсэж, газар хөдлөлтийн адил нөлөө үзүүлдэг. *Уулын ажлын нөлөөгөөр, эсвэл байгалийн бусад шалтгаанаар уулын чулуулаг, нурах, шилжилт хөдөлгөөн болдог.* Судалгааны ажлуудад чулуулгийн геологийн бүтэц, байгалийн тектоник даралтын хүч нь чулуулгийн цохилт, нуралтын үндсэн шалтгаан болдог. Чулуулгийн цахилтын үүсэх механизмын төрөл, хэлбэр нь янз бүр. Агуулгаараа зөвхөн чулуулгийн байгалийн даралт бус, уул техникийн нөхцөл, чулуулгийн шинж чанараас хамааралтай. Нүүрсний ордын чулуулгийн цохилтыг тодорхойлсон механизмыг хүдрийн ордод хэрэглэх боломжгүй. Орос улсад гэхэд өнөөгийн байдлаар 50 орчим хүдрийн орд уулын чулуулгийн нуралтад өртөх магадлал өндөртэй. Ийм ордуудад хойд Уралын бокситын орд, Уулын Шоорий орд, Норильск, Кольскийн хагас арал г.м хамаарна. Саяхныг хүртэл нуралтын шалтгааныг уулын ажлын гүнээс хамааралтай гэж үздэг байсан бол энэ нь одоо шалтгаануудын зөвхөн нэг л болж байна. Учир нь 300 м-ээс ихгүй гүнд ихэнх нуралт явагддаг. Уулын чулуулгийн нуралт үүсэх байгалийн шалтгаан нь тектоник хүчиний үйлчлэлээр үүсэх талбар, ойрх газруудад үүссэн эвдрэлүүд, гэнэтийн нуралтад өртөх магадлалтай уулын чулуулаг зэрэг болдог. Жишээ нь, 2011 онд Кемеровагийн Таштаголийн хүдрийн уурхайд уулын чулуулгийн нуралт болсон шалтгаан нь 280 метрийн гүнд болсон 3.8 баллын хүчтэй газар хөдлөлтийн хүч байсан. Таштаголийн төмрийн хүдрийн орд нь 1941 онд ашиглалтанд орсон Баруун сибирийн металлургийн “ЕВРАЗ” группдэд харьяалагддаг. 600 м гүнээс илүү гүн уурхайг уулын нуралтын аюултай гэж үзнэ. Энэ уурхайн ашиглалтын хугацаанд 38 мянган геодинамикийн үзэгдэл болсны 21 нь уулын нуралт, 78 микро нуралт болж байв. Уулын нуралт болох магадлалтай холбоотой эрсдэлийг геомеханизийн, эсвэл геодинамикийн эрсдэл гэж болно.

4. Уулын ажлын болон байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр уулын чулуулгийн шилжилт хөдөлгөөн. Чулуулгийн гулсалт, шилжилт хөдөлгөөний үндсэн шалтгаануудад: тектоникийн процесс, уусгалт хийх, усны түвшин бууруулах, усгүйжүүлэх, эсвэл усжуулах зэргээс үүдэлтэй чулуулгийн механик шинж чанар өөрлөгдсөнтэй холбоотой.
5. *Усны нэвчилт.* Уулын малталтаар цэвэр, эсвэл бага минералжсан ус орж ирэх зэргээр уусамтгай хүдрийн ордын гол онцлог байх ба юуны түрүүн давсны уурхай орно. Энэ асуудал янз бүрийн улс орнуудын хүдрийн уурхайд тулгамдсан асуудлын нэг байдаг, жишээ нь, ашиглалтанд орсон бүх калийн уурхайнуудын үерийн уснаас болж алдагдсан нь одоо байгаагаасаа олон болсон гэдгийг зарим экспертуудийн баталдаг. Чулуулгийн уусалт нь уурхай руу урсан орж, газрын гадаргыг суулт үүсгэж, бүтэлгүйтэлд хүрдэг.

Хамгийн тод жишээний нэг нь Оросын калийн салбарын Пермийн хязгаар дах “Уралкалии” нэгдлийн Березниковын калийн үйлдвэр юм. Анхны бүтэлгүйтэл нь 20-р зууны 80 аад онд болсон. Сүйрлийн нөхцөл байдлын хүрээ нь 21-р зуунд ч үргэлжилж байна. 2006 онд уурхай руу орох ус цагт $300\text{m}^3 - 400\text{m}^3$ байснаа удалгүй $1200 \text{ m}^3/\text{цагт}$ хүрсэн. Уурхай руу орох ус удирдагдахгүй болсон ба уулын ажлууд зогссон. Цаашдаа ч ашиглах боломжгүй болов. 2008 онд хамгийн том нуралт $385 \times 270 \text{ м}$ болсон ба 2010 онд төмөр замын ойр нуралт болж, заводын удирдлагын дэргэд конусан хэлбэрийн цөмрөлт үүсснээс хүний амь эрсэдсэн. Тухайн уурхайд өөрийн талбайгаас хальж, гулсалт үүссэн ба 2014 онд иргэдийн ногооны талбай руу нуралт болж, хэд хэдэн орон сууцны байшин өртсөн юм.


Энэ асуудал харьцангуй цөөн тохиолдох ч бусад түүхий эдийг олборлоход гарах боломжтой. Жишээ нь, Казахсан дах Соколовскийн магнетитийн орд нь усархаг элс шаврын хурдастай, усны агууламж ихтэй тул усанд автаж өндөр аюултайд тооцогдоно. Иймэрхүү байдал “СУБР” ХК-ийн бокситын ордод үүсч, уулын малталтын ажлыг тектоникийн эвдрэлтэй нөхцөлд усны урсацын хагаралтай бүсэд явуулснаас үүдэлтэй аюул байгаа юм. гүний усны нөлөө, уусгалтын нөлөөний эрсдэлийг гидрогеологийн эрсдэл гэж тодорхойлно.

Эрсдэл үүсэх хоёрдагч орчин нь уулын ажил явуулах схемтэй холбоотой, ялангуяа ашиглалтын систем.

Ашиглалтын системийн параметрүүд мөргөцөг дэх, ордын бусад хэсгүүд дэх, бүүр газрын гадарга дээрх ажлын байруудад ажилтнуудын аюулгүй байдалд нөлөөлнө. Жишээ нь, хүдрийн уурхайнуудад өргөн тархсан баганат камерын ашиглалтын системд үүссэн орон зайд (ашигласан камер) массив дах даралт дахин хуваарилагдаж, чулуулгийн нуралтад хүргэж болзошгүй. Үүний зэрэгцээ тусгаарласан хана, тулгуур, барьериин целикүүдэд эрсдэлийн нөхцөл үүсгэх хүчин зүйлд: олборлолтын болон бэлтгэл малталтын бэхэлгээний арга, ажлын талбайн хэмжээ, блок, төвлөрсөн горизонтуудын тоо давхар, дэд давхрын хэмжээ, өрөмдлөг тэсэлгээний ажлын параметрүүд, ачаа тээврийн урсгалын схем гэх мэт орно.

Уулын үйлдвэрт нөхцөл байдлын шинжилгээ нь тухайн хүчин зүйлсийн нөлөөлөл тодорхой цаг хугацааны мөчлөгтэй богино хугацаанд учирч болохыг харуулсан. Жишээ нь, дээд Заменскийн калийн ордод олборлолт явуулахад 20-30 жилд тодорхой хэсгүүдэд мэдэгдэхүйц сүйрэл ажиглагдсан. Целикэд үлдэх чулуулаг 2 м давж, таазанд завсрын үе

тогтсон байдаг нь чулуулгийн шилжилтийг хурдасгадаг. Үр дүнд нь суултын хурд 500 мм/жил болж, гадаргын хэв гажилтын утга 4 м хүрсэн байна. Хүдрийн ордыг ашиглах системээс хамаарч үүсэх эрсдэлийг уул-техникийн эрсдэл гэж болно. Далд уурхайн үеийн уулын эрсдэлийн бүтцийг дараах байдлаар схемчилж болно.



Зураг 53 Уулын үйлдвэрийн үндсэн эрсдэлүүдийн ангилал

Эрсдэлийн нэг хүчин зүйл нөгөө хүчин зүйлийг бий болгох нөхцөл үүсгэдэг. Эрсдэлүүд өөр хоорондоо харилцан хамааралтай, нийтэд нь урьдчилан хэлэх боломжгүй үр дагаварт хүргэх боломжтой юм. Жишээ нь, “Воркутауголь” компанийн “Северная” уурхайд дэлбэрэлт болсон шалтгаан нь уулын чулуулгийн нуралтаас үүдэлтэй метаны ялгаралт гарсан явдал байв. Нүүрсний уурхайнуудад чулуулгийн нуралт их хэмжээний эвдрэл үүсгэх ба үүнийг дагаж, хий, тоос их хэмжээгээр цацагдаж, дэлбэрэх аюул бий болгодог нь илэрхий зүйл.

Хүдрийн уурхайд техникийн, зохион байгуулалтын эрсдэл түлхүү байна. Нүүрсний уурхайг бодвол, агаарт хий, тоос ялгаруулах эрсдэл өндөр биш. Уул-геологийн эрсдэлүүд, ялангуяа геомеханикийн, тектоникийн, гидрогеологийн эрсдэл голлоно. Уул техникийн эрсдэлүүд үйлдвэрийн осолын гол шалтгаан болж, төрөл бүрийн хохиролд хүргэдэг.

4.3 Эрдсийн хөрөнгийн үнэ цэнийг үнэлэх тодорхойгүй загвар (недетерминированных моделей) дахь эрсдэлийн үнэлгээ

Ашигт малтмалын олборлолт нь эрэл хайгуулын ажлын үед тогтоогдсон баримжаалсан, ойролцоо мэдээлэлд үндэслэн газрын хэвлийн орон зайд тасралтгүй уулын малталтын хөдөлгөөнт процесс явагддагтай уулын эрсдэлүүд холбоотой. Бүх төрлийн уулын ажлын төлөвлөлтийн үндэс нь газрын хэвлийн бодит бус өгөгдөл, судалж байгаа шинж чанаруудын үр дүнгээр тогтоогдсон геологийн загварт суурилдаг. Ордын геологийн загвар бол газрын хэвлийн орон зайн тогтвортой биш, хэд хэдэн цэгийн мэдээлэлд тулгуурлан их бага хэмжээний алдааны түвшинтэй байна. Зарим тохиолдолд эдгээр алдаа гамшигт үр дагаварт хүргэх утгуудыг ч агуулна. Жишээ нь, нүүрсний уурхайд уламжлалт байдлаар бага эрсдэлтэй гэдэг ч хүлээн зөвшөөрөх боломжгүй батлагдаагүй нөөц ашигласан “Анжерская – Южная” уурхай, 2 тэрбум рублийн алдагдал хүлээсний дараа бүтээн байгуулалтын ажлаа зогсоож байв. “Фикзультурник”, “Сибирское” уурхайнуудын удирдлага талбайн үлдэгдэл нөөцийн үнэлгээг албан ёсоор хийхдээ бодит байдлаас 10 дахин өсгөснөөс орд ашиглалтын хугацаа эрс багассан. Ийм байдлаар геологийн өгөгдлүүдийн үнэмшилтэй байдлын эрсдэл ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээнд их хэмжээгээр нөлөөлнө.

Эрдсийн хөрөнгийн үнэ цэнийг үнэлэх, тооцоход хэрэглэгддэг олон янзын аргууд нь шууд нөлөөлдөг. Төслийн үндэслэл, туршлага, мэргэжлийн ном зохиолуудаас судлахад уулын үндсэн эрсдэлүүдийг дараах байдлаар ангилсан байна. Үүнд:

1. Эрдсийн хөрөнгийн үнэ цэнийг үнэлэхэд үнэлэх боломжит арга зүйтэй тул нүүрсний ордод батлагдаагүй нөөц байх эрсдэлийг тооцож болно.
2. Алтны хүдрийн ордын батлагдаагүй нөөцийн эрсдэлийг үнэлэх нэгдсэн арга зүй оросын практикт байхгүй тул ийм эрсдэлийг ашигт малтмалын хөрөнгийн үнэ цэнийг тодорхойлоход оруулаагүй болно.
3. Гүний уурхайн аргаар нүүрс олборлоход салангид эвдрэлүүд үүсэх эрсдэл тооцох үнэлгээний арга зүй байгаа тул эрдсийн хөрөнгийн үнэ цэнийг тодорхойлоход энэхүү эрсдэлийг тооцож боломжтой.
4. Хүдрийн гүний уурхайн их гүнд техноген шинжтэй уулын даралт, нуралтын эрсдэл тооцох үнэлгээний арга, хэрэгсэл байгаа тул хөрөнгийн үнэ цэнийн үнэлгээнд ийм эрсдэлийг тооцож боломжтой.

Өнөө цагт шинжээчдийн тодорхойлсон газрын хэвлийн геологийн судалгааны үнэмшилийн зэрэглэлийн үзүүлэлтуүдийг нөөцийн ангиллын 4 категорийн (A, B, C₁, C₂) хил хүрээгээр ашигт малтмалын улсын нөөцийн бүртгэлд албан ёсоор бүртгэх явдал хүчин төгөлдөр үйлчилж байна. Тухайн категорийн нөөцийн үнэмшилийн түвшинг нэмэгдүүлэхийн тулд геологийн өгөгдлийн үнэмшилтэй байдлын үнэлгээний тоон шалгуурыг хэрэглэх ёстой.

Нийт үйлдвэрлэлийн нөөцийн балансын нөөцөд эзлэх хувь хэмжээ (ДР), хөдөлмөрийн бүтээмж (Пр)-ийн хоорондын харилцан хамаарлын үндсэн дээр эхний хүчин зүйлийн тоон үнэлгээ (46) хийгдэнэ.

$$\text{Пр} = 0.82 * \text{ДР} \quad (46)$$

Энд:

$$\text{Гүний уурхайн хувьд: } \text{ДР} = 100(\text{ПЗ}/\text{БЗ}), \% \quad (47)$$

$$\text{Ил уурхайн хувьд: } \text{ДР} = 100 * [\text{ПЗ}(2.9 - 0.16\text{К})/\text{БЗ}] \quad (48)$$

ПЗ- үйлдвэрлэлийн нөөц

БЗ- Балансын нөөц

К – хөрс хуулалтын коэффициент, м³/тн

Ийм байдлаар төсөлд тооцогдоогүй олбололтод тохиромжгүй нөөцийн хэмжээ нь олборлох хэсгийн үйлдвэрлэлийн нөөцийн хэмжээний өөрчлөлтийг бий болгож, хөдөлмөрийн бүтээмжийн харьцангуй бууралтанд хүргэнэ (49).

$$K_{neq} = (DR - DR_{neq}) / DR \quad (49)$$

Энд:

DR_{neq} – төслөөр олборлохоор тусгагдаагүй, тохиромжгүй нөөцийн (НЗ) нийт үйлдвэрлэлийн нөөцөд эзлэх шилжүүлсэн хувь хэмжээ .

Эндээс далд болон ил уурхайн хувьд:

$$Pr_{oj} = Pr_{pr} * [(P3 - HZ) / P3] = Pr_{pr} * K1 \quad (50)$$

Энд:

Pr_{oj} – үйлдвэрийн газрын уулын эрсдэлийг тооцсон хүлээгдэж байгаа хөдөлмөрийн бүтээмж

Pr_{pr} – үйлдвэрийн газрын төслийн хөдөлмөрийн бүтээмж

ВНИМИ-ийн судалгаагаар механикжсан комплекс бүхий гүний уурхайн тектоникийн хагаралын эрсдэлийн өсөлт хөдөлмөрийн бүтээмжийн харьцангуй бууралтанд хүргэх ба энэ нь (51), (52) томьёогоор тодорхойлогдоно.

$$Kd \leq 100 \text{ үед, } Kpr(Kd) = 1 - 0,0023Kd \quad (51)$$

$$Kd \geq 100 \text{ үед, } Kpr(Kd) = 0,91 - 0,0014 Kd \text{ байна.} \quad (52)$$

Энд:

$Kd = \sum L/S$ - А.С. Забродинагийн эвдрэлийн коэффициент

$\sum L$ - эвдрэлийн нийлбэр урт, м

S – судалж байгаа талбайн хэмжээ, га

Бага мөргөцгийн тоног төхөөрөмжтэй, бусад механикжсан, ашиглалтын хаягдал өндөртэй гүний уурхайд нүүрс олборлоход тектоник эвдрэлийг 30% орчим бага байхаар төсөөлж болно. Тектоникийн эвдрэлийн хүчин зүйлээр нүүрсний гүний уурхайн хувьд (53) томьёогоор авч болно.

$$Pr_{oj} = Pr_{pr} * [Kpr(N * Kd)] / [Kpr(Kd)] = Pr_{pr} * K2 \quad (53)$$

Энд:

N - эвдрэлийн хагаралын явагдах бодит эрчмийг геологи хайгуулын ажлын тогтоосон дүнд (Kd) харьцуулсан харьцаа

Ийм байдлаар геологийн шинжтэй Форс-Мажорын үйлчлэлийн дүнд уулын үйлдвэрийн ажлын төслийн техник эдийн засгийн үзүүлэлтүүд батлагдахгүй байх магадлалын түвшнийг уулын эрсдэлийн үзүүлэлтүүдээр K_1 , K_2 коэффициентүүдийн утгыг ашиглаж болно.

Үүнийг С.В. Шаклеинагийн судалгаанд Кузбассын нүүрсний ордуудад болон “ИПКОН РАН”-ы судалгаанд ч санал болгосон байдал. Эрдсийн хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнийг норматив болон нормативаас давсан хаягдлыг тооцож үнэлэх, нөөцийн тоог засварлахад батлагдаагүй нөөц, эвдрэл, хагарлын уулын эрсдэлийг таамаглах ажил чиглэгдэнэ.

Мэргэжлийн болон шинжлэх ухааны зохиол бүтээлд өмнө нь хийгдсэн ГХА-ын мэдээллийн дутагдалтай байдал нь уулын эрсдэлийн үнэмшлийн түвшинтэй холбоотой багасгаж, бууруулах асуудал, орд газрыг удаан хугацаанд ашиглах төслийн эдийн засгийн үнэлгээний үр дүнг тооцоход нөлөөлсөөр байсныг тэмдэглэх нь зүйтэй.

Нэн ялангуяа өндөр үнэ цэнэтэй хүдрийн ордод геологийн зүгээс батлагдаагүй нөөцийн эрсдэлийн үнэлгээ боловсруулагдаж байна. Алтны хүдрийн нөөцийн хэмжээг дахин үнэлэх судалгаа “Полиметалл” компанид идэвхитэй хийгдэж байгаа. Энэ нь хүдрийн ордын уул геологийн шинж чанарын өөрчлөмтгийн байдалтай нягт холбоотой.

Энэ нь хүдрийн ордын уул геологийн нөхцөлийн өөрчлөлт ихтэй байснаас дахин үнэлгээний эерэг үр дүн гарч ашигт малтмалын хөрөнгийн нөөцийн үнэ цэнийн нилээд их өсөлт бий болж болно. Энэ үед компанийн үйл ажиллагааны практикт эерэг үр дүнг үл харгалзан бүрэн итгэлгүйн улмаас ашиглалтын үед ордод нэмэлт хайгуулын ажлаар гарсан онолын үр дүнгийн магадлалын тоон үнэлгээ ч хангалттай найдвартай биш байдаг.

Нүүрсний болон хүдрийн ордод өнөө цагт уулын ажлын хэтийн төлөвлөлтөнд аюулгүй техникийн шийдэл гаргах шаардлагатай тектоник эвдрэлийн нөлөөллийн бүсэд олборлолтын параметрүүд, уурхайн талбайн хэсэг дэх тектоник эвдрэлийг тооцсон эрүүл ахуйн арга хэмжээнүүд, олборлолтын янз бүрийн шатанд блок дахь ачаалал, даралтын хүчиний байдал, гулсалтын нөхцөл, блокийн шилжилтийн хүчиний энерги зэрэг параметрүүдийн үнэлгээ хийх аргууд хангалттай үндэслэлтэй. Ордуудын уул-динамикийн нөхцөл байдал, ялангуяа тодорхой уурхай бүрт цаг хугацааны явцад өөрчлөгдж байдаг. Олборлолтын шинэ блок руу шилжих, уулын ажил гүнзгийрэх зэрэгт ашиглагдсан орон зайн хэмжээ өссөөр байна.

Ордын нөөцийг бие биенээсээ хамааралгүй хэд хэдэн уурхайгаар олборлох боломжтой. Энэ нь бүс нутгийн хэмжээгээр уулын цулын геомеханикийн нөхцөлийг удирдах, таамаглах үүрэг нэмэгдэнэ. Газрын хэвлэлийн геодинамикийн аюулгүй байдлыг нийтэд нь хангах үр дүнтэй арга нь ашиглаж байгаа уурхай бүрийн уулын ажлын харилцан хамаарлыг хангаж, бүх ордын хэмжээгээр байгаль техногений системийн тогтвортой байдалтай нийцүүлэх хэрэгтэй. Энэ шаардлагын үүднээс төслүүдийн уулын ажлын төлөвлөлтийн схемүүдэд ордын геодинамикийн аюулгүй байдал, эдийн засгийн зохицтой байдлын шаардлагын үүднээс уурхайн талбайн нээлтүүд, тэдгээрийн хил хүрээ тогтоох, нөөцийг олборлох дараалал зэргийг тогтооход бүс нутгийн түвшний шийдвэр, нэгдсэн үзэл баримтлал гол үүрэгтэй.

Геодинамикийн загварчлалын үндсэн дээр нөөц олборлох ажлын фронт тогтоох, төлөвлөх, цаашдын ахилт зэргийг харгалзан ордыг нээх ажлыг хэрэгжүүлнэ. Тектоникийн эвдрэл бүхий орд ашиглахад уурхайн талбайн болон түүний хэсгийн геодинамикийн загварчлалыг хийхдээ зайлшгүй ордын хэмжээний геодинамикийн загварыг боловсруулах шаардлагатай. Ордын геодинамикийн загварыг гаргахад ордын блокын цулуудад динамик явц үүсэх хэмжээсүүдэд гол анхаарлыг хандуулна.

Хэдийгээр хил хязгаарын хэсгүүдэд уулын чулуулаг дах массивын ан цавшил, гажилтуудын нэгэн төрлийн өөрчлөлт тэмдэглэгдсэн байх нь уул-геодинамикийн загвар боловсруулахад ан цавшил, хэв гажилтуудын мэдээлэл зайлшгүй шаардагдах ба үүнийг орчин үеийн компьютерийн системийн тусламжтай уулын чулуулгийн блокийн хагаралын байдлыг тооцдог тоон задлан шинжлэлийн аргаар тодорхойлоход үндэслэнэ. Суналын дагуу, уналын дагуу ан цавшилт, тэдгээрийн тархалтын элементүүдийг агуулсан хагаралын хэмжээсүүдийг тооцоход бүрдүүлэгч чулуулгийн морфологийн өгөгдөл, хагаралын бүтэц, судалж байгаа хэсгийн анхдагч блокийн геологийн бүтцийн загвар шаардлагатай. Анхдагч өгөдөл геологийн картууд, тектоникийн схем, хайгуулын шугамын зүсэлтүүд, геофизикийн хэмжилтийн өгөгдөл, мөн итгэлтэйгээр тектоник блокуудад хуваах, хэд хэдэн ордод хийсэн судалгаагаар геодинамикийн үзэгдлийн

хамгийн аюултай гэж тогтоогдсон жижиг, дунд тектоник хагаралыг засварлах замаар илүү нарийн загварчлал гаргах уулын малтaluудын ажиглалт, хэмжилтүүдийн хэрэгсэл хамаарна.

Уул-геодинамикийн загвар гаргахад уулын чулуулгийн блокын цул дах геодинамикийн аюултай бус үүсэх явцад гол анхаарал тавих ёстой. Энэ нь талбай дах техноген болон байгалийн нийлмэл нөлөөгөөр тодорхойлогдоно.

Уулын ажлын төсөл хийхэд хүдрийн биетийн олборлооор төлөвлөж байгаа хэсгийн уул технологийн олон янзын хүчин зүйлийг тооцно. Тодорхой хэсэгт техноген нэмэлт ачааллын нийт утгыг геодинамикийн аюултай бусийн үзүүлэлтүүд, тэдгээрийн аюулын зэрэг тодорхойлдог. Уул-геодинамикийн загваруудын хувьд уурхайн талбайг нээх болон олборлолтын системийн янз бүрийн хувилбаруудыг харьцуулж, хамгийн аюулгүй хувилбарыг сонгоно.

СУБР-ын ордыг ашиглахад тектоникийн эвдрэлийн бусийн нуралтын аюулыг судалж, хийсэн шинжилгээний үр дүн нь уулын малтaluудыг нураах уулын динамик даралт үүсэх дараах үндсэн шалтгаан байгааг илрүүлжээ:

- төрөл бүрийн зориулалттай уулын малтарт явагдах үед үүссэн тектоникийн хагарлын дагуу давхаргад хүдрийн биет тулгуур (13,5%) байгаа эсэх
- тэдгээрийн ойролцоо хамгийн их хагарлын бусүүд байгаа тохиолдолд тектоник эвдрэлийг буулгахгүй байх (11,3%)
- тектоникийн хагарлын нөлөөлөл идэвхтэй бусэд хүдрийн уулын даралтын концентраци өндөр үед байх нөхцөлөөр босоо малтарт (9,2%) бэлтгэж ашиглаж ажиллаж байна.
- Тектоникийн хагаралтай бэлтгэл малтaluудыг хурц өнцгөөр огтлолцуулан (7,8%) явуулж байна.
- Уулын даралтын төвлөрөл өндөр, тектоникийн хагаралтай хэсэгт олборлолт явуулахдаа олборлолтын камерын систем (5,0%) ашигладаг.

Өнөө цагт массив дах уулын чулуулгийн тогтвортой байдалд тектоник бүтцийн нөлөөллийн үнэлгээ хийхэд хэрэглэдэг аргууд нь (тектоник бүтцийн харилцан нөлөөллийн шинжилгээ, блок дах уулын цулын даралт, деформацийн лабораторийн загварчлал, ажиглалт ба туршилтууд) цогц үнэлгээ хийх боломжгүй, тектоник хагарлын нөлөөллийг тооцсон уулын массивын өөрчлөлтийн шинж чанарыг илтгэсэн янз бүрийн тархмал өгөгдөл ашиглаж байна. Дээр дурдсан аргуудын гаргасан үр дүнгүүд хүчин зүйлийн өргөн хүрээний нөлөөллийн цогц тоон үнэлгээг өгдөггүй, үндсэндээ чанарын шинжтэй байдаг.

Өргөн хүрээний судалгааны арга хэрэгслүүд, болон биет загварууд нь хөдөлмөр зарцуулалт ихтэй, үнэ өндөртэй байдаг. Иймээс өнөө цагт массив дах уулын чулуулгийн байдлыг үнэлэхэд янз бүрийн тооцооны аргыг ашигласан компьютерийн загварчлалыг илүүд үзэж байна. Геомеханикийн тооцооны аргуудыг үр дүнтэй хэрэглэх үндсэн асуудал нь хүдрийн биетийн геологийн бүтцийн загварын анхдагч мэдээллийг босгох төвөгтэй байдагт байгаа юм. Голчлон геомэдээллийн өгөгдлийн загварт ялгаатай тооцох шаардлагатай холбоотой: хүдрийн биетийн хэлбэр, орон зайн байрлалаас тооцооны элементүүдийн шинж чанар өргөн хүрээтэй: геометрийн өгөгдлүүд (өргөн, урт, өндөр г.м), хүдрийн (чулуулгийн) физик-механикийн шинж чанар, тектоник хагаралын үзүүлэлтүүд, хамгаалах арга хэмжээнүүд.

Объектын анхдагч өгөгдлийн сан дараах цогц хэмжээсүүдийг агуулна. Үүнд:

- Ашиглагдсан орон зайд хамаарах объектын хэмжээсүүд (олборлолтын камерууд, янз бүрийн зориулалттай уулын малталтууд г.м)
- Геометрийн хэмжээсүүд (өргөн, урт, өндөр г.м) ба 3D орчинд байрлал, таазны чулуулгийн физик механикийн шинж
- Даацын тулгуур бүтцийн объектуудын хэмжээсүүд (хүдрийн байрлал, камер хоорондын целикийн, үйлдвэрлэлийн бус хүдэржилтийн хэсгийн, чулуулгийн массив), геометрийн хэмжээсүүд (өргөн, урт, өндөр г.м) ба 3D орчин дах байрлал, уулын чулуулгийн физик механикийн шинж
- Тектоник хагарлын хэмжээсүүд (төрөл, хэлбэр, байрлалын элементүүд, дотоод үрэлтийн өнцөг, хагаралын хэсэгт чулуулгийн нийлсэн төрх)
- Том голчтой цооногийн өрөмдлөгөөс уулын даралтын аюултай концентраци үүсэх нөхцөлд хүдэр-чулуулгийн буулгалт хийхэд авах сэргийлэх арга хэмжээний үзүүлэлтүүд
- Олборлолтын мөргөцгөөс авах улны ачааллын хязгаарын заагийн нөхцөл. Олборлох мөргөцгийн уланд ирэх ачааллын утга нь хүдрийн биетийн тааз болон улны харилцан үйлчлэлээс шууд хамаарна. Энэ харилцан хамаарлыг судлах нь шилжилтийн үзүүлэлтүүдийн талаарх мэдээллийг өгнө.

Цаашлаад орон зайн геомеханикийн асуудлыг шийдэх нь хүчин чадал өндөртэй компьютерийн техникийг ашиглан нийлмэл, төвөгтэй математик тооцоолол хийхийг шаардаг. Орон зайн орчинд блокийн массив дах уулын чулуулгийн анхдагч даралтын хүчийг тодорхойлох тоон туршилтуудыг хийхдээ PRESS 3D URAL программ хангамжийг өргөн хэрэглэдэг.

PRESS 3D URAL программ хангамж нь ПАО “Норильский никель” уул металлургын комбинат, “Севуралбокситруда” ХК, “СУЭК-Кузбасс”ХК, “Апатит” ХК, “Дальполиметалл” ХК, “Воркутауголь” ХК г.м оросын томоохон уул уурхай компаниудад ордын нөхцөлийг геодинамикийн бүсчлэлээр явуулж өргөн хүрээнд туршиж боловсруулагдсан юм. Программ хангамж нь геологийн бүтэц, геомеханикийн анхны загвар боловсруулахад өндөр түвшний автматчлагдсан программ болно.

Бүлгийн дүгнэлт

Уул уурхай төслүүдийг хэрэгжүүлэхэд эрсдлүүдийг харгалзаж үзэхэд эрдэсийн түүхий эдийн баазын нөхцөл байдал дордож, нөөцийн чанар муудах, үр ашигтай нөөцийн хэмжээ багасах, геополитикийн нөхцөл байдал өөрчлөгдөх, зах зээл тогтвортгүй болох, макро эдийн засгийн нөхцөл байдал хямрах зэрэг нөлөөл байх тул эрдсийн хөрөнгийн үнэ цэнийг үнэлэх ажлын салшгүй хэсэг болдог.

Эрсдэлийн тоон шинжилгээний аргууд дотроо: Шийдвэрийн модны арга, Үр ашгийн үзүүлэлтүүдийн мэдрэмжийн шинжилгээ, эрсдэлгүй эквивалент мөнгөн урсгал байгуулах арга, цаг хугацааны хүчин зүйлийн итгэлцүүрийн (дискоунтын норм) эрсдэлийг тохируулах арга, боломжит хувилбаруудын арга, “Торнадогийн диаграмм” арга, “Монте-Карло”-гийн аргуудыг агуулдаг. Эдгээр аргуудын хэрэглээ нь эрдсийн хөрөнгийн үнэ цэнийг өөрчлөлтөд хүргэх олон янзын үр дүнг өгдөг.

Уулын эрсдэл ашигт малтмал олборлох явцад газрын хэвлэлийн орон зайд тасралтгүй явагдах уулын ажлуудын мэдээлэл нь геологийн судалгааны явцад тогтоогдсон өгөгдлүүдтэй зөвхөн ойролцоо л байдаг.

Судлагдсан шинж чанаруудын шууд тодорхойлох үр дүнд үндэслэн боловсруулагдсан газрын хэвлийн геологийн загварууд нь тухайн талбайн янз бүрийн хэсэгт тогтмол байдаггүй нэг буюу өөр түвшний алдаатай байдаг.

Ул уурхайн эрсдэлүүд дотроос эрдсийн хөрөнгийн үнэ цэнийг үнэлэхдээ судлаачид дараах зүйлийг харгалzan үзэх боломжтой. Үүнд:

Нүүрсний ордын батлагдаагүй нүүрсний нөөцийн эрсдэл, байгалийн техноген (үүсмэл) эрсдэл их гүнд олборлолт явуулснаас үүдэх уулын нуралтын эрсдэл болно. Эдгээр эрсдэлийг үнэлж, эрдсийн хөрөнгийн үнэ цэнийн үнэлгээ гаргахад хэрэглэх ба үүнд санал болгох эрсдэлийн үнэлгээний арга хэрэгслүүдийн бэлэн байдлаас шалтгаалдаг.

Нүүрсний ордын эрсдэлийг үнэлэх аргачлалыг ИПКОН РАН, НИЦ ВНИМИ -ийн судалгааны төвийн эрдэмтэд олон жилийн туршилт судалгааны ажлын үр дүнд боловсруулжээ. Геологи хайгуулын ажлын үр дүнгийн найдвартай байдал, хэсэгчилсэн хагарлыг тодорхойлсон коэффициентүүдийн утгыг уул уурхайн эрсдэлийн үзүүлэлт болгож ашиглах ба геологи хайгуулын ажлын үр дүнгийн алдааны магадлал, салангид хагарлууд зэрэг нь үйлдвэрийн төслийн техник эдийн засгийн нотлогдоогүй байхыг тооцсон геологийн шинжтэй форс-мажор үйлдлийн дүн юм. Геологийн шинжтэй давагдашгүй хүчний нөхцөл байдлын үр дүнд уурхайн үйл ажиллагаа эрдсийн хөрөнгийн үнэ цэнэ буурах үед эдгээр коэффициентүүдийг тооцож болно гэж судлаач үзэж байгаа юм.

Их гүнтэй хүдрийн ордод чулуулгийн нуралт үүсэх, тодорхой уурхайн талбайн олборлолт явуулах ордын уул-геодинамикийн цаг хугацааны явцад гарах өөрчлөлтийн таамаглал, эрсдэлийн хүчин зүйлийг илрүүлэх аргуудыг энэхүү бүтээлийн авторуудын нэгний судалгаагаар хийсэн болно. шинэ мөргөцөг, блок ашиглалтанд орж, уулын ажил гүнзгийрч, олборлосон талбайн орон зайд нэмэгдэхийн хэрээр уулын ажил явуулах массив дах уулын чулуулгийн геодинамикийн нөхцөлийг тогтмол хянаж, таамаглаж байх шаардлага үүсэх ба тоон загварын тусгай программ хангамжийн бүтээгдэхүүн хэрэглэх шаардлагатай болж байна.

Ул уурхай үйл ажиллагааны явцад чулуулгийн цулын геодинамикийн төлөвийг байнга урьдчилан таамаглахын тулд программ хангамжийн бүтээгдэхүүн, цахим загвар ашиглах болсноор шууд тооцоолол хийх, эрдсийн хөрөнгийн үнэ цэнийн үнэлгээг боловсронгуй болгох боломж нэмэгдэнэ.

БҮЛЭГ 5. ЭРДСИЙН ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭНИЙГ ҮНЭЛЭХ АРГАЧИЛСАН ЗАГВАРЧЛАЛ БА БАТАЛГАА

5.1 Эрдсийн хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнийн үнэлгээ, хаягдлын бууралтыг тооцсон эрдсийн хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнийн үнэлгээ ба загварчлал (Налайхын нүүрсний ордын жишээн дээр)

Монгол Улсын нүүрсний салбарын үйл ажиллагаа, нүүрсний ордын үнэт байдлыг бүрдүүлэх нөхцөлийн шинжилгээ

Нүүрс нь дэлхийн олон улс оронд эдийн засгийн хөгжил болоод хүний аж амьдралд хамгийн өргөн ашиглагддаг түүхий эдийн нэг хэвээр байна. Монгол улсын өрсөлдөх чадвартай ашигт малтмалуудын нэг нь нүүрс бөгөөд одоог хүртэл түлш, эрчим хүчний үндсэн эх үүсвэрээр ашиглагдаж байна. Нүүрсийг Монголын орчин үеийн эдийн засагт илүү үнэ цэнэтэй өндөр технологийн бүтээгдэхүүн болгож боловсруулдаггүй. Нүүрсний нөөц ихтэй учраас Монгол Улсын эдийн засаг нүүрсний салбарын төлөв байдал, хөгжлөөс ихээхэн хамааралтай байдаг.

Монгол Улсад ч хөгжиж буй бусад олон орны нэгэн адилаар Ази, Номхон Далайн Бүс Нутаг(АНДБН)-ын зах зээлийн хөгжлийн шинэ хандлагатай нийцүүлэн нүүрсний ордуудын нөөцийн ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх, мөн энэхүү үйл явцад төрийн зүгээс гүйцэтгэх үүрэг зэрэг олон асуудал шийдвэгдээгүй хэвээр байна. Олборлосон нүүрс нь бараг баяжуулагдаагүй, технологийн илүү дэвшилтэт бүтээгдэхүүн болгон боловсруулаагүй, нүүрсийг түүхий эд болгон ашиглан илүү өндөр өртөгтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг боловсруулах үйлдвэрүүдийг бий болгох хөрөнгө оруулагчдад бодит хөшүүрэг байдаггүй.

Монгол Улсад нүүрс олборлож буй компаниудын одоо байгаа үйлдвэрлэлийн хүчин чадал нь нүүрсний дотоодын хэрэгцээнээс хол давсан бөгөөд, тухайлбал, нүүрсний хувьд: үйлдвэрлэлийн хүчин чадлын ашиглалт одоогоор 50 орчим хувьтай байна. Нөгөөтэйгүүр, нүүрс бол Монгол Улсын экспортын хоёр дахь гол бүтээгдэхүүн. Улсын эдийн засаг нүүрсээс хараат байх байдал нь 2011 оноос хойш тогтвортой өсч байгаа бөгөөд нүүрс худалдаалах гол зах зээл нь АНДБН-ын зах зээл болоод байна. Одоогоор Монголын нүүрсний экспортын 99 хувийг Хятад улсад нийлүүлж байна. Гадаад зах зээлийн эрэлт хэрэгцээг хангах, нүүрсийг дотооддоо боловсруулахад технологийн шинэчлэлийг нэвтрүүлэх зэрэг нь Монгол Улсын нүүрсний ордуудын нөөцийг илүү үр ашигтай ашиглахад хувь нэмэр оруулна.

1. Улс төрийн хүчин зүйл

Монгол Улсын эрчим хүчний бодлогод тусгагдсан зорилго, мөн 2030 он хүртэлх “Нүүрс” хөтөлбөрт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэхийн тулд нүүрс олборлох үйлдвэрүүдийн одоо байгаа болон шинээр илрүүлж буй түүхий эдийн баазыг дахин үнэлэх шаардлагатай байна. Ойрын жилүүдэд нүүрсний нөөцийн чанарын тодорхойлолтыг нарийвчлахад чиглэсэн, тэр дундаа Монголд шаардлагатай байгаа баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийг бий болгоход чиглэсэн судалгаануудыг хийх нэн чухал байна. Дээр дурдсан бүхнийг харгалзан нүүрсний ордуудын нөөцийн үнэ цэнийг нэмэгдүүлэх боломжийг тодорхойлох, мөн тэдгээрийг Улс орны болон дэлхийн нүүрсний салбарын хөгжилд орчин үеийн чиг хандлага, Ази Номхон далайн бүс нутгийн нөөцийн зах зээлд үзүүлэх нөлөөллийг тооцсон илүү үр ашигтай ашиглах арга, хэрэгслийг


тодорхойлох онолын үндэслэл, арга зүйн хандлагыг боловсруулах шаардлага нэмэгдэж байна.

Монгол Улсын нүүрсний салбарын эдийн засаг нь, нэг талаас, дэлхийн нүүрсний олборлолт, ашиглалтын орчин үеийн зүй тогтол, нөгөө талаас - үндэсний эдийн засгийн хөгжлийн онцлогийг харгалзан үзэх ёстой.

Нэгдүгээрт, улсын эдийн засаг нь олон зүйлд байгалийн нөөц, тэр дундаа нүүрсний олборлолтоос ихээхэн хамааралтай. Нүүрсний нөөцөөрөө Монгол Улс дэлхийд 15 дугаарт жагсдаг: геологийн нөөц нь 173.5 тэрбум тонн, харин батлагдсан нөөц нь 37.4 тэрбум тонн байдаг.⁶

Хоёрдугаарт, нүүрс бол бараг цорын ганц түлш нь болж явдаг бөгөөд Монголд хий, нефть, атомын цахилгаан станц байдаггүй учраас улс орон маань ойрын болон дунд хугацаанд нүүрсээр ажилладаг дулааны цахилгаан станцаас татгалзах боломжгүй. Нүүрсийг Монголын эдийн засгийн олон салбарт төдийгүй хилийн чанадад ч өргөнөөр ашиглаж байна. Тиймээс нүүрсний олборлолтын хэмжээ нэмэгдэж байна. Энэхүү өсөлт нь улс орны түлш, эрчим хүчний үйлдвэрлэлийн тогтвортой хөгжилд, мөн Монгол Улс болон бусад оронд нүүрсний ашиглалтын хэмжээнд бүтцийн өөрчлөлт хийхэд нэн чухал юм.

Гуравдугаарт, Монголын эдийн засагт дэлхийн нүүрсний зах зээл, ялангуяа Ази Номхон далайн зах зээлийн өөрчлөлт ихээхэн нөлөө үзүүлж байна. Үүнтэй холбогдуулан, чулуун нүүрсний экспортын хэмжээ маш өндөр байна: тэдгээр нь нийт борлуулалтын 75.7%-ийг эзэлж, байнга өсч байна (Зураг 54). Нүүрс олборлолтын хэмжээг нэмэгдүүлэх шаардлага нь, нэг талаас, тус улсын түлш-эрчим хүчний балансад нүүрс ихээхэн үүрэг гүйцэтгэж байгаа, нөгөө талаас нүүрсний экспорт эрс нэмэгдсэнтэй холбоотой. Мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар эдгээр чиг хандлага нь урт хугацаанд үргэлжлэх болно.⁷



Зураг 54 Монгол Улсын нүүрсний олборлолт, борлуулалт, экспорт, сая тонн
(2014-2021 он)

Эх сурвалж: Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал, газрын тосны газар. www.mrpatm.gov.mn. Эрдэс баялгийн статистик мэдээ. 2014-2021 он.

⁶ Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ашигт малтмал, газрын тосны газрын албан ёсны цахим хуудас. <https://www.mrpatm.gov.mn/>

⁷ Эдийн засгийн судалгааны хүрээлэнгийн албан ёсны цахим хуудас. <http://www.eri.mn/>

Монгол улсын нүүрсний салбарын хөгжлийн мөн чанар нь тодорхой онцлогтой байдаг. Нүүрсний ордын үнэ цэнийг дотооддоо богино болон дунд хугацаанд өсөн нэмэгдүүлснээр дотоодод болон гадаадад нөөцийн ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх, мөн нүүрсний ашиглалтын хэмжээн дэх бүтцийг өөрчлөх замаар нэмэгдүүлэх боломжтой. Монголд "түүхий" нүүрсний цогц боловсруулалт бараг байхгүй. Одоогийн байдлаар, эдийн засгийн бодит секторын хэрэглэгчид болох хүн ам, аж ахуйн нэгжүүдийн эзлэх хувь нэмэгдсэнтэй холбоотойгоор дулааны цахилгаан станцуудын нүүрсний хэрэглээний эзлэх хувь буурч байна.

Манай улсын дотоодын нүүрсний хэрэглээний хэмжээ харьцангуй бага байдаг. Нүүрсний дотоодын хэрэгцээ, экспортод гаргах нүүрсний боломж нь гадаадын хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хангах чиг хандлагатай Монгол Улсын нүүрсний салбарын хөгжлийн чиглэлийг тодорхойлдог. Энэ нь орлогын болон зах зээлийн (харьцуулсан) хандлагыг ашиглан нүүрсний ордын нөөц бололцооны дахин үнэлгээг бодитой болгож байна.

Монгол Улсын нутаг дэвсгэр дээр нүүрсний 49 орд байдгаас 29 нь чулуун нүүрсний, 20 нь хүрэн нүүрсний орд юм. Үүнээс: 8 ордыг төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой таван үйлдвэр боловсруулдаг; 33 ордыг үндэсний болон хамтарсан хорин найман үйлдвэр боловсруулдаг бол 8 ордыг гадаадын 9 компани ашиглаж байна.

Хайгуул хийсэн бүх ордууд нь Монгол орны янз бүрийн хэсэгт байрладаг бөгөөд тээвэр, ложистикийн ургалаас нэлээд алслагдсан байдаг. Өнөөг хүртэл Монгол Улсын олонхи нутаг дэвсгэр дээр тээвэр, ложистикийн дэд бүтэц сүл хөгжсөн нь нүүрсний аж үйлдвэрийн хөгжил, ялангуяа баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийн бүтээн байгуулалт, нүүрс олборлох үйлдвэрүүдийн экспортын үйл ажиллагааны цар хүрээний өсөлтөд саад болж байна. Эдгээр ажиллагаанд төр идэвхтэй оролцож байж л энэ асуудлыг шийдэж чадна гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Нөгөөтэйгүүр, олон ордод чанарын хувьд Хятадын стандартад нийцсэн чулуун нүүрсний их нөөц бий. Энэ нүүрсийг Хятад руу экспортлох нь маш их ирээдүйтэй бөгөөд нүүрсний үнэ цэнийг ихээхэн нэмэгдүүлдэг: экспортын нүүрсний үнэ дотоодын зах зээлд хэрэглэж буй нүүрсний үнээс ихээхэн давсан; Хятадын нүүрсний эрэлт тогтвортой, өндөр байна.⁸

Монгол Улсаас БНХАУ руу нүүрс нийлүүлэх боломжид нөлөөлж болзошгүй нэг хүчин зүйлийг онцлон тэмдэглэх нь зүйтэй - энэ нь Хятадын дэд бүтцийн хөгжлийн онцлог юм: тээврийн асуудлаас болж алслагдсан аймгуудын нүүрсний үнэ нь өндөр байдаг. Энэ хүчин зүйлийг Монгол улс олборлюсон нүүрсээ БНХАУ-ын Монгол Улстай хил залгаа мужуудад нийлүүлэх ажлыг төлөвлөхдөө ашиглаж болно.

Монгол Улсын бас нэгэн маш чухал асуудал бол байгаль орчны асуудал. Сүүлийн жилүүдэд зөвхөн нийслэл Улаанбаатар хот төдийгүй улсын төвийн бүс нутагт агаарын бохирдол нэмэгдэж байна. Үүнтэй холбоотойгоор Монгол Улсад нүүрсний ашиглалтын байгаль орчны үр ашгийг дээшлүүлэх асуудал байнга нэмэгдэж байна.

Нүүрсний ордуудын бие даасан хэсгүүдийн эдийн засгийн үр ашиг нь өөр өөр байх бөгөөд гадаад хүчин зүйл, ялангуяа тухайн нөөцийн зах зээл дээрх үнийн түвшингээс

⁸ Ч.Удвалноров. Эффективность использования запасов угольных месторождений Монголии на основе концепции ценности. Диссертацийн ажил. 2021 он. Санкт-Петербург хот.

ихээхэн хамаардаг. Иймд улсын хэмжээнд төрийн дэмжлэгтэйгээр авто замын өргөн сүлжээг хөгжүүлэх нь нүүрсний ордуудын холбогдох хэсгүүдийн нөөцийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулах болно.

Монгол Улсын нүүрсний геологийн нөөц одоогийн байдлаар 173.5 тэрбум тонн, жилийн олборлолт нь 48 сая тонн (2017 онд) учраас ирээдүйд олборлолт нэмэгдсэн ч гэсэн олон жилийн туршид хангалттай хэмжээгээр байх болно.

Монгол Улсын нүүрсний салбарын нөөцийн чадавхи, нүүрсний ордуудын үнэ цэнийн хүчин зүйлсийн шинжилгээний үр дүн нь улсын хэмжээнд нүүрс олборлолтын өнөөгийн байдалд бий болсон түлш-эрчим хүчний балансын нөхцөл байдал нь 2030 он хүртэлх эрчим хүчний стратегийн дагуу ойрын арван жилд төдийлөн өөрчлөгдөхгүй болохыг харуулж байна. Дотоодын нүүрсний уян бус эрэлт хэрэгцээ, Ази Номхон далайн бүсийн орнуудын нөөцийн зах зээлийн хөгжлийн шинж чанар нь нүүрсний бодит үнэ цэнийг бүрдүүлэхэд нөлөөлж, харин технологийн шинэчлэлийн үр дүн дэх цогц хэрэглээ нь энэхүү үнэ цэнийн өсөлтөд нөлөөлдөг. Нүүрсний ордыг үр ашигтай ашиглахын тулд төр, бизнесийн эрх ашгийг уялдуулах шаардлагатай. Засгийн газар нь нүүрсний олборлолт, ашиглалтын хөгжлийн дэлхийн чиг хандлага, үндэсний эдийн засгийн онцлогийг аль алиныг нь тооцож үзэх ёстай.

Монгол орны нүүрсний ордын байрлал бүс нутгуудад харилцан адилгүй тархжээ. Уг байршилаас хараад төвийн бүсэд ихээхэн төвлөрч байна.

Улс орнуудын нийгэм-эдийн засгийн хөгжилд нүүрсний экспорт чухал үүрэгтэй. Монгол улсын тогтвортой хөгжлийн системийг бүтээж буй нөхцлүүдийн нэг нь нүүрсний салбарын үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх юм. Урт хугацаанд түүний үнэ цэнэ зөвхөн хадгалагдаад зогсохгүй өсөх болно.

Ордын нөөц ашиглалтын үнэ цэнэ нь бизнесийн болоод нийгмийн сайн сайхан байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн эдийн засгийн зорилгыг тусгах бодит боломжийг бий болгодог. Монгол орны хувьд нүүрсний ордын энэхүү үнэ цэнийг тодорхойлохгүйгээр түүний үр ашгийг хүртэх боломжгүй юм. Энэ үүднээс улс дахь нүүрсний ордын нөөцийг ашиглах, үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд төр, бизнес, нийгмийн ашиг сонирхлыг зохицуулах гол түлхүүрүүдийн нэг нь газрын хэвлийг зохистой ашиглах асуудлыг шийдвэрлэх системийг бий болгох явдал юм. Эдийн засгийн асуудлуудыг шийдвэрлэхэд хэрэглэгддэг, «гар удирдлага» хэмээн нэрлэгддэг загвар болох давамгайллын, зах зээлийн эдийн засгийн боловсронгуй загвар байхгүйгээс үүдэн улс орны байгалийн баялгийн эдийн засгийн тогтолцоонд «тер-бизнес» - ийн зөвшилцлийг эрэлхийлэх хэрэгцээ улам бүр нэмэгдэж байна. Олборлосон, хэрэглэгчдэд хүргэсэн нүүрсний үнэ цэнэ нь, нэн ялангуяа ашиглалт нь нийгмийн болон байгаль орчны шаардлагад нийцсэн бол, газрын хэвлийд байгаа үнээсээ өндөр байх нь ойлгомжтой юм.

Нүүрсний орнуудын нөөцийн үнэ цэнийг өөрчлөх хүчин зүйлүүдийг тодорхойлоход нүүрсний нөөцийн чанарын үзүүлэлтүүд, улс орнуудын болон бүс нутгуудын тээвэр-логистикийн дэд бүтцийн хөгжлийн түвшин, Ази номхон далайн орнуудын нөөцийн зах зээлийн хөгжлийн орчин үеийн чиг хандлага болон нүүрсний салбарын технологийн инновацийг нэвтрүүлэх болно.⁹

⁹ М.М. Хайкин, Чимэддорж Удвалноров. Монголын нүүрсний зах зээлийн хөгжлийн асуудлууд. Экономика и предпринимательство. (2017). №9. - С. 1167-1173.

Монголын нүүрс олборлогч компаниудын үйлдвэрлэлийн хүчин чадал нь дунд хугацаанд нүүрсний олборлолтын хэмжээг мэдэгдэхүйц нэмэгдүүлэх, дотоодын нүүрсний хэрэглээ, экспортын бүтцийг өөрчлөх боломж олгоно. Нүүрсний ордуудын нөөцийн үнэ цэнийг нэмэгдүүлэхийн тулд нүүрсний дотоодын хэрэглээний бүтэц болон түүний экспортын хэмжээг зохицуулах шаардлагатай. Энэ тохиолдолд онцгой ач холбогдолтой: нүүрсний ордуудын нөөцийн чанарын үзүүлэлтүүдийн олон улсын стандартад нийцэх түвшинд хүргэх, шинэ авто замын барилгын төслийг хэрэгжүүлэхэд төрөөс үзүүлэх урамшуулалт, эрчим хүч болон нүүрсний үнэ, тарифын зохицуулалт, гадаад эдийн засгийн үйл ажиллагааны зохицуулалт чухал.


Нүүрсний ордуудын нөөцийн хэмжээ нь тогтвортой экспортыг хангах боломжтой бөгөөд улсад тээвэр-логистикийн дэд бүтцийг хөгжүүлэхэд түлхэц болохуйц бөгөөд тэдгээртэй холбоотойгоор Монголын эдийн засгийг тогтвортой хөгжүүлэхэд эко-нийгэм, эдийн засгийн хамгийн чухал зорилтууд экспортын орлогод чиглэгдэнэ.

Нүүрсний ордуудын үнэ цэнийг тодорхойлох аргачлал нь дараах хүчин зүйлүүдийн нөлөөллийг харгалzan олборлогдож буй нүүрсний экспортын хэтийн төлвөөр тэдгээрийг эрэмбэлэх хэрэгтэй байна:

- ордын тодорхойлолт (нөөцийн хэмжээ, нүүрсний төрлүүд, нүүрсний хангамж, орд боловсруулах лицензтэй талбайн тоо хэмжээ),
- нүүрсний чанарын тодорхойлолтууд (шаталтын дулаан, чийгшил, үнслэг, хүхэрлэг),
- тээвэр-логистикийн дэд бүтцийн хөгжлийн түвшин (замын хэв шинж, хэрэглэгчид хүртэлх зайд).

Монголын нүүрсний салбарт үйлдвэрлэл болон инновацийг нэвтрүүлэх нь түүний тогтвортой хөгжилд хэрэгтэй юм.

Гэхдээ богино болон дунд хугацааны хэтийн төлөvt улсын нөөцийн боломж нь энэ зорилгыг шийдэх боломж олгодоггүй, үүнтэй холбоотойгоор одоо байгаа нүүрсний ордын нөөцийн үнэлгээ нэмэгдэж нүүрс олборлодог компаниудын зах зээл бүрдүүлэх үйл ажиллагааны үүрэг нэмэгддэг.



Зураг 55 Монгол улсын нүүрсний орд газруудын байршил

Эх сурвалжс: Ч.Удвалноров (2021)

Монгол Улсын нүүрсний нөөцийн ашигт олборлолтын үнэ цэнийн өсөлтийг дотоодын хэрэгцээ болон импортлогч улсад борлуулах борлуулалтын хэмжээг нэмэгдүүлэх замаар тодорхойлно.

"Нүүрсний үнэ цэнэ" гэсэн ойлголтыг зохиогчийн зүгээс гаргасан тайлбараар энэ нь нүүрсний субъектив ашиг ба солилцооны харилцааны үр дүнд олж авсан түүний үнийн нэгдэл юм. Нүүрсний ордуудын дахин үнэлгээ нь нүүрсний дотоод болон гадаад хэрэглээг харгалзан үнэ цэнийн өөрчлөлтийн өнөөгийн чиг хандлагыг тодорхойлох боломжтой болгож байна.¹⁰

Нүүрсний боломжит үнэ цэнэ гэдэг нь нүүрс олборлогч компанийн ашигладаг тоног төхөөрөмж, технологийн хөгжлийн өнөөгийн түвшинд хамгийн сайн чанарын нүүрс олборлож болох боломжит дээд хэмжээ, холбогдох дээд үнийг үндэслэн тодорхойлсон олборлогдоогүй нөөц дэх нүүрсний үнэ цэнэ юм. Ашигт олборлолтын үнэ цэнэ гэдэг нь түүний тодорхойлогдох үнэ цэнэ, өөрөөр хэлбэл, одоо бодитоор хэрэглэж буй технологи, борлуулалтын бүтээгдэхүүн чанарын хамгийн сайн үзүүлэлттэй, хамгийн дээд үнээр илэрхийлэгдэж буй олборлосон нүүрсний хэмжээ. Нүүрсний арилжааны үнэ гэдэг нь газрын хэвлийг ашиглагч аж ахуйн нэгжийн арилжааны үйл ажиллагааны үр дүнд борлуулсан нүүрсний үнэ бөгөөд энэ нь олборлолт, хадгалалт, тээвэрлэлтийн өртөг, түүнчлэн худалдагчийн үнийн бодлогоос хамаарна.

Боломжит болон ашигт олборлох үнэ цэнэ нь байгалийн хүчин зүйл, нүүрсний үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хүчин зүйлийн нөлөөн дор үүсдэг. Арилжааны үнэ цэнэ нь хамгийн динамик шинж чанар юм. Монголын эдийн засаг дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнийн хэлбэлзэлд маш мэдрэмтгийг байдаг. Нүүрсний арилжааны үнэ цэнэ нь байгалийн болон үйлдвэрлэлийн төдийгүй зах зээлийн хүчин зүйлийн нөлөөлөлд бий болдог. Зах зээлийн хүчин зүйлсийн энэ үйлдэл нь эцсийн дүндээ нүүрсний арилжааны үнэ цэнэ ба түүнээс гарах ашигт олборлолтын үнэ цэнийн тоон зөрүүг/ялгааг/тодорхойлдог. (Хүснэгт 1)-т авч үзсэн үнэ цэнийн төрлүүдийн хоорондын ялгааг тусгасан болно.

Нүүрсний арилжааны үнэ цэнэ нь түүнийг тээвэрлэх нөхцөл, аргаас ихээхэн хамаардаг. Монгол шиг далайд шууд гарцгүй орнуудын хувьд нүүрс тээвэрлэх хамгийн түгээмэл арга бол авто болон төмөр зам юм. Ийм тохиолдолд нүүрсийг авто замаар тээвэрлэх зардал нь төмөр замаас үлэмж өндөр байдаг. Хэрэглэгчдэд нүүрсний үнэ цэнийг нэмэгдүүлэх зайлшгүй нөхцөл бол тээвэр, ложистикийн дэд бүтцийг хөгжүүлэх асуудал онцгой ач холбогдолтой юм.

¹⁰ Ч.Удвалноров. Эффективность использования запасов угольных месторождений Монголии на основе концепции ценности. Диссертацийн ажил. 2021 он. Санкт-Петербург хот.

Нүүрсний үнэ цэнийн төрлүүд¹¹

Хүснэгт 46 Нүүрсний үнэ цэнийн төрлүүд

Үнэ цэнийн төрлүүд	Тодорхойлогдох объект	Өсөлтийн нөхцөл	Бусад төрлийн үнэт зүйлстэй харилцах харилцаа
Боломжит үнэ цэнэ	Нүүрсний нөөцийн тоон болон чанарыг харгалзан хайгуул хийсэн ордуудын нөөцийн өртөг	Нүүрсний ордын хайгуулын чиглэл дэх төрийн идэвхтэй үүрэг	Ашигт олборлтын үнэ цэнийг бий болгох зайлшгүй нөхцөл
Ашигт олборлолтын үнэ цэнэ	Үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүний өртөг ба түүний хэрэглээний өртөг (ашигт байдал)	Технологийн шинэчлэлд тулгуурлан үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах экстенсив /нөөцийн тоо хэмжээний өсөлт/, интенсив /нөөцийн бүтээмжийн өсөлт/ аргуудыг ашиглах	Боломжит үнэ цэнийн үндсэн дээр үүсдэг. Арилжааны үнэ цэнийг бий болгох нөхцөл
Арилжааны үнэ цэнэ	Эцсийн хэрэглэгчийн нүүрсний үнэ	Ази Номхон далайн бүс нутгийн нөөцийн зах зээлийн таатай нөхцөл	Ашигт олборлтыг үндэслэн бий болдог

Дотоодын хэрэглээний хүрэн нүүрсний (Цдэб) ашигт олборлолтын үнэ цэнийг эцсийн бүтээгдэхүүн болох эрчим хүчний үнэ цэнээр тодорхойлж, 1-р томьёоны дагуу тооцохыг санал болгож байна.

$$\Pi_{\text{дэб}} = \sum_{i=1}^{n'} Y_{\vartheta i} \Pi_{\vartheta i}, \quad (1)$$

$\Pi_{\vartheta i}$ – i эрчим хүчний нэгжийн тариф, \$/кВт-цаг;

n' - нүүрс шатаах замаар олж авсан эрчим хүчний төрлийн (дулааны, цахилгааны) тоо;

$Y_{\vartheta i}$ – 1 тн олборлосон буюу баяжуулсан нүүрсийг шатаахад гаргаж авсан i эрчим хүчний хэмжээ, кВт.ц/т.

Хамгийн сайн чанарын нүүрсний ашигт олборлолтын үнэ цэнийг дараах байдлаар тодорхойлно: (\$/т):

$$\Pi_{\text{дэ}} = 1000 \frac{Q \cdot \Pi_{\vartheta}}{Q_{\text{ут}} \cdot \delta_{\text{ут}}}, \quad (2)$$

Q – олборлосон нүүрсний дулаан ялгаруулах чадвар, ккал/кг;

$Q_{\text{ут}}$ – 1 тонн жишиг түлшний дулаан ялгаруулах чадвар ($Q_{\text{ут}} = 7000$ ккал/кг);

$\delta_{\text{ут}}$ – 1 кВт-ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхэд зориулсан жишиг түлшний тодорхой зарцуулалт ($\delta_{\text{ут}} = 0,32$ кг/кВт-ц);

¹¹ Ч.Удвалноров. Эффективность использования запасов угольных месторождений Монголии на основе концепции ценности. Диссертацийн ажил. 2021 он. Санкт-Петербург хот.

Цэ – цахилгаан станцын борлуулсан цахилгааны тариф, \$/кВт·ц; 1000 – кг·с тонн руу хөрвүүлэх коэффициент

Гадаад зах зээл дэх нүүрсний үнэ цэнэ нь зах зээлийн үнэ болон БНХАУ-ын стандартаас хамаарч, зах зээлийн хүчин зүйлээр тодорхойлогддог. Монгол Улсын нүүрсний нөөцийн ашигт олборлолтын үнэ цэнийн өсөлтийг дотоодын хэрэгцээ болон импортлогч улсад борлуулах борлуулалтын хэмжээг иэмэгдүүлэх замаар тодорхойлно. Нүүрсний ордуудын нөөцийн үнэ цэнийн өөрчлөлтөд нөлөөлөх бүлэг хүчин зүйлсийг боловсруулсан болно. (Хүснэгт 47).

Хүснэгт 47 Монголын нүүрсний ордуудын нөөцийн үнэ цэнд нөлөөлөх хүчин зүйлс

Хүчин зүйлүүд		Тайлбар
Уул уурхай, геологийн	Нүүрсний нөөц ордуудын	Дэлхийн нүүрсний нөөцийн хэмжээнд Монгол Улсын эзлэх хувь 0.2 хувь байна. Манай улсын нүүрсний урьдчилсан нөөцийг 173.5 тэрбум тонн гэж тооцсон. 2016 оны байдлаар А, В, С1 ангилалд хамаарах нүүрсний нөөц 31.7 тэрбум тонн байна.
	Нүүрсний төрөл	Монгол Улсын нийт нүүрсний 41 орчим хувийг хүрэн нүүрс, 59 орчим хувийг чулуун нүүрс, коксжих нүүрс эзэлдэг.
	Нүүрсний чанар	Монгол орны нүүрсний ордуудын чанарын үзүүлэлтүүд өөр өөр байдаг. Нүүрсний чанарын хувьд хамгийн үнэ цэнэтэй ордууд манай улсын баруун хэсэгт байдаг ба баруун хэсгээс зүүн тийш чиглэлтэй нүүрний чанар нь мууддаг.
	Ашиглалтын талбайн гүн ба өргөн	Тогтоц нь гүехэн ба ил уурхайн олборлолт явуулдаг.
Үйлдвэрлэл, техникийн	Үйлдвэрлэлийн хүчин чадал	Боломжит үйлдвэрлэлийн хүчин чадал нь бодит үйлдвэрлэлийн хэмжээнээс давсан байна.
	Нүүрсний олборлолтын технологи	Хуучирсан техник, технологи ашиглаж байна.
Эдийн засгийн	Монгол улсад олборлож байгаа нүүрсний дотоод болон хилийн чанад дахь эрэлтийн хэмжээ	Нүүрсний нийлүүлэлтийн хэмжээ нь дотоодын эрэлтийн хэмжээнээс давсан бөгөөд, дотоодод өөр өрсөлдөхүйц нүүрс байхгүй. Гадаад эрэлтийн мэдэгдэхүйц өсөлт.
	Дэлхийн нүүрсний эрэлтийн хэмжээ	Дэлхийн эдийн засагт нүүрс чухал үүрэг гүйцэтгэсэн хэвээр байна. Мөн түлш, эрчим хүчний нөөцийн хэрэглээний бүтцэд нүүрс нь 29 хувийг эзлэж байна.
	Дэлхийн зах зээлийн үнэ	Ази Номхон далайн бүс нутгуудын зах зээлд нүүрсний эрэлт нэмэгдэж байна.
Логистикий	Ордууд болон эцсийн хэрэглэгчийн	Монгол Улсын хувьд ихэнх нүүрсний уурхайнуудын 40 орчим хувь нь хамгийн том хэрэглэгчээсээ 100 км

	хоорондох зайд	хүртэл, 35 хувь нь 100-200 км, үлдсэн 25 орчим хувь нь 200 км зайд байрладаг.
	Зам, ачаа тээврийн нөхцөл	Нүүрсийг төмөр зам, хатуу хучилттай(асфальтан) болон орон нутгийн(шороон) замаар тээвэрлэдэг. Үүний зэрэгцээ нүүрсний компаниудын 15 хувь нь төмөр зам ашигладаг бол 65 хувь нь сайжруулсан замаар хэрэглэгчдэд нүүрс тээвэрлэн хүргэж байна. Харин 20 орчим хувь нь асфальтан зам ашиглаж байгаа нь төр болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон.
	Агуулахын логистикийн зохион байгуулалт	Нүүрсийг ил задгай талбайд урт хугацаагаар хадгалах нь түүний жин, коксжих чадвар, илчлэгийн чанарыг бууруулдаг.
	Логистикийн худалдан авалтын зохион байгуулалт (Эцсийн хэрэглэгчдэд хүргэх борлуулалт)	Бүтээгдэхүүнийг тээвэрлэлтийг янз бүрийн тээврийн хэрэгслээр хийж болно. Монголоос нүүрсийг хямд үнээр экспортлох боломж нь эцсийн хэрэглэгчдэд хүргэх тээвэрлэлтийн зардлаас ихээхэн хамаардаг.
Экологи, газар зүйн	Усны нөөцийн бохирдол	Ул уурхайн компаниуд усны нөөцийг ашигласнаар усны горим өөрчлөгдөж, усны түвшин буурч мөн малчдын хувьд цэвэр усны эх үүсвэр хязгаарлагдмал болж байдаг.
	Агаарын бохирдол	Ул уурхайн үйлдвэрлэлийн явцад ялгардаг тоос шороо, бохирдуулагч бодисын нөлөөгөөр агаарын чанар муудаж байна. Ул уурхайн аливаа үйл ажиллагааны явцад талбайн хэмжээнээс үл хамааран, түүнчлэн тээврийн хэрэгсэл, машин механизмын техникийн хөдөлгөөн гэх мэтээс тоосжилт үүсдэг.
	Ул уурхайн үйл ажиллагаанд өртсөн газрын талбайн хэмжээ	Ул уурхайн үйл ажиллагааны тухайн газар нутагт үзүүлэх нөлөө нь бэлчээрийн талбай алдагдах, газар, хөрсний чанар муудах, газрын ашиглалтын зориулалтыг өөрчлөх, үржил шим буурахад хүргэдэг. Хөрсний бохирдоос болж биологийн төрөл зүйл буурч байна.
	Нүүрсний олборлолт болон ашиглалтын экологийн үйл явцыг удирдах систем	Өнөөгийн байдлаар Монгол Улс өндөр хөгжилтэй орнуудын шилдэг туршлага, тэр дундаа экологийн салбарын технологийн шинэчлэлийг нэвтрүүлэхэд анхаарч ажиллаж байгаа ч уүнд их хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай байна.
	Ордуудын байршил	Монгол орны бүх л газар нутгаар тархан байршсан бөгөөд нүүрсний нөөцөөр тэргүүлэгч нь эдийн застгийн бүсчлэлийн төвийн бүс юм.

Эх сурвалж: Ч.Удвалноров. Эффективность использования запасов угольных месторождений Монголии на основе концепции ценности. Диссертаций ажил. 2021 он. Санкт-Петербург хот.

Налайхын нүүрсний орд¹². Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн энэ орд одоо уул техникийн нөхцөл хүндэрсэн гэсэн тодотголтой явж байна. Богд хаант Монгол улсын үед хятадууд гар аргаар чулуун нүүрс олборлож, Их хүрээ рүү зөөверлөдөг байснаа 1920 онд томоохон уурхай байгуулсан түүхтэй. 1922 онд Ардын засгийн газрын тогтоолоор Автономитын үед гадаадынханд олгосон уул уурхайн бүх зөвшөөрлийг хүчингүй болгож, Монголын нутаг дэвсгэр дээрх газрын баялаг эзэмшигчдээс татвар хураах дүрмийг баталж байжээ. 1922 оны 12 дугаар сарын 25-нд Налайхын уурхайг Монголын анхны улсын үйлдвэр хэмээн бүртгэн авснаар нийслэл хотыг нүүрсээр хангах зориулалттай бэсрэгхэн үйлдвэр байгуулагдсан юм. 1954-1958 онд технологийн шинэчлэл хийж, Налайхын их уурхайг барьж байгуулсан байна. Тэр үед 1200-гаад ажилтантай, 200 гаруй инженертэй том уурхай байжээ. 1995 оны нэгдүгээр сарын 15-нд ТЭХГҮҮЯ-ны Сайдын 111 дүгээр тогтоолоор Налайхын их уурхайг хааж, үйл ажиллагааг нь зогсоосон түүхтэй. Өнгөрсөн хугацаанд уурхайчид уурхайгаа тонож дуусган, үлдсэн нурангид нь уурхай нээж, нүүрс гаргасаар байна. Налайхын уурхай гэж нэрлэгддэг энэ газарт одоо 300 орчим аманд 2000 гаруй хүн амь насаараа дэнчин тавин эрсдэлтэй нөхцөл ажиллаж байна. Ихэнх нь зөвшөөрөлгүйгээр гар аргаар нүүрс олборлодог. Налайхын уурхайн нөөцийг тухайн үедээ Монгол, Оросын геологчид маш нарийн судалж, 75 сая тонн бөгөөд ашиглалтын нөөцийн хэмжээ нь 15 сая гэж тогтоожээ. 1978 онд Оросуудын төслөөр судалгаа хийж, дээр дурьдснаас ч илүү нөөц байх магадлалтай гэсэн дүгнэлт гаргасан байна. Монголын хамгийн дэлгэрэнгүй, бараг 6 үе шаттайгаар хайгуул хийж, нөөцийг нь нарийн тогтоосон газар бол Налайхын уурхай. 1955 онд Налайхын их уурхай ашиглалтад орсноос хаах хүртэлх 50 жилийн хугацаанд нийт нөөцийн гуравны нэг хувь буюу 25 сая тонныг ашигласан тооцоо байдаг. Үүгээр тооцож үзвэл 50 гаруй сая тонн геологийн нөөц бий. Налайхын уурхайн нүүрсний талбайг үндсэндээ гурав хуваадаг байна. Төв хэсгийг нь олборлоочихсон. Харин хоёр жигүүрийн нүүрсэнд огт хүрээгүй байна. Нүүрсний 60 гаруй хувь нь баруун талдаа байдаг. Зүүн жигүүрийн нүүрс нь голд ойрхон учраас ашиглаж болохгүй, гадаргаас нь олборлох ёстой гэж үздэг байна. Тус орд нь орон нутгийн чанартай бөгөөд нийслэлийн жижиг, дунд үйлдвэрүүд болон ойролцоо орон нутгийн иргэдийн түлшний хэрэгцээг хангадаг байна.

5.2 Хүчин зүйлийн загварыг ашиглан эрдсийн хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнийг загварчлах (хүдрийн ордын жишээн дээр)

Хүдрийн орд дахь эрдсийн хөрөнгийн үнэ цэнийг хүдрийн найрлага, хүдэр дэх үндсэн болон дагалдагч ашигтай бүрэлдэхүүн хэсгүүдийн агууламж, зах зээлийн үнэ, ашигтай бүрэлдэхүүн хэсгүүдийн олборлолт зэргээс ихээхэн хамаардаг (хүснэгт 48).

¹² Д.Даваасүрэн, Монгол Улсын ашигт малтмалыг олборлох уул уурхайн үйлдвэрлэлийн байршил. (2021), Чингис хот.

Хүснэгт 48 РМК ба “Норникель” группын ордын хүдрийн зах зээлийн үнэ[138, 139]

Чулуулагийн төрөл		Порфир	Порфир	Зэсийн колчедан	Зэсийн колчедан	Зэсийн колчедан	Порфир	Cu-Ni сульфид
Макро үзүүлэлтүүд								
Зэсийн үнэ	USD/t	9 092	9 092	9 092	9 092	9 092	9 092	9 092
Цайрын үнэ	USD/t	2 832	2 832	2 832	2 832	2 832	2 832	2 832
Никелийн үнэ	USD/t	17 466	17 466	17 466	17 466	17 466	17 466	17 466
Алтны үнэ	USD/o z	1 805	1 805	1 805	1 805	1 805	1 805	1 805
Мөнгөний үнэ	USD/o z	26.42	26.42	26.42	26.42	26.42	26.42	26.42
Цагаан алт	USD/o z	1 174	1 174	1 174	1 174	1 174	1 174	1 174
Палладий	USD/o z	2 599	2 599	2 599	2 599	2 599	2 599	2 599
Хүдэр дэх зэсийн агууламж								
Хүдэр дэх зэс	%	0.32%	0.42	2.11	2.64	1.70	0.32	1.27
Хүдэр дэх цайр	%	-	-	1.27	2.39	2.27	-	-
Хүдэр дэх никель	%	-	-	-	-	-	-	0.75
Хүдэр дэх алт	г/т	0.09	0.08	0.23	1.12	1.59	0.13	0.19
Хүдэр дэх мөнгө	г/т	1.00	0.49	12.08	41.43	35.77	0.00	-
Цагаан алт	г/т	-	-	-	-	-	-	0.87
Палладий	г/т	-	-	-	-	-	-	3.18
Хүдрийн арилжааны үнэ цэнэ								
Хүдэр дэх зэс	USD/t	29	38	191	240	155	29	117
Хүдэр дэх цайр	USD/t	0	0	36	68	64	0	0
Хүдэр дэх никель	USD/t	0	0	0	0	0	0	132
Хүдэр дэх алт	USD/t	5	4	14	65	92	8	11
Хүдэр дэх мөнгө	USD/t	1	0	10	35	30	0	0
Цагаан алт	USD/t	0	0	0	0	0	0	33
Палладий	USD/t	0	0	0	0	0	0	266
Жилийн хүдрийн олборлолт	сая т.	32,0	45,0	0,6	0,2	0,8	90,0	42,0
Хүдэр дэх металлын нийт үнэ	USD/t	36	43	251	408	342	37	558

Сүүлийн 10-15 жилийн хугацаанд ашигт малтмалын нөөц олборлогч орнуудад эрдэст-түүхий эдийн баазын байдал муудаж, тэр дундаа эрдэст-түүхий эдийн нөөцийн нилээд хэсгийн чанар муудаж, ашигтай нөөц хомсдсон байна. Уламжлал ёсоор ашигт малтмалын хүчирхэг баазтай байсан Орос улс ч мөн адил марганц, хром, боксит, зарим ховор металл, хүдрийн бус түүхий эдийн хомсдол, олон ордын газарзүйн тааламжгүй байршил, уул уурхай, геологийн хүнд нөхцөл зэргээрээ онцлог юм. Тухайлбал, 2009-2015 онуудад өнгөт металлын хувьд хүдэр олборлолтын үеийн ашигтай бүрэлдэхүүн хэсгүүдийн дундаж агууламж буурсан: зэсийн хувьд 0.86-1.74(г/т) -аас 0.31-1.67(г/т) хүртэл; никель 0.56-0.85г/т-аас 0.35-0.78г/т хүртэл; хар тугалгын хувьд 0.6-7.68 г/т-аас 0.6-6.55 г/т хүртэл байна.

Хүдрийн чанар, үнэ цэнийн бууралтын динамик нь дэлхийн олон компаниудын хувьд ердийн зүйл бөгөөд, жишээлбэл, CRU зөвлөх группын судалгаагаар ирээдүйд зэсийн өндөр агууламжтай ордуудыг илрүүлж, ашиглахыг хүлээлтгүй болохыг тэмдэглэсэн байдаг. ОХУ-ын шинэ ордуудын зэсийн агуулга нь хүдэр дэх зэсийн агуулга тогтвортой буурах хандлагатай байгаа тул үнэ цэнэ нь өснө гэх баталгаа байхгүй (зураг 56).



Зураг 56 Дэлхийн болон РМК-ийн шинэ ордуудын хүдрийн чанар, үнэ цэнэ буурах хандлага.

CRU International Limited-ийн мэдээллүүд мөн л бүх төслийн хүрээнд зэсийн агуулга буурах хандлагатай байгааг нотлон харуулж байна (хүснэгт 49).

Хүснэгт 49 Дэлхийд зэсийн хүдэр олборлох томоохон хөрөнгө оруулалтын төслүүд

Төсөл	Компани	Улс	Хүдэр дэх зэсийн агуулга, Cu, %
Aitik	Boliden	Швед	0,33
Andacolla	Aur	Чили	0,34
Carerones	Pan Pacific	Чили	0,34

Morrison	Pacific Booker	Канад	0,33
Casino	Western Copper	Канад	0,24
Varvarinskoe	European Min	Казахстан	0,32
Benkala	Frontier Mining	Казахстан	0,3
Bozshakol	Kazakhmys	Казахстан	0,36
Actogay	Kazakhmys	Казахстан	0,38
Tominskoye	RCC	Орос Улс	0,38
Miheevskoye	RCC	Орос Улс	0,4

Уурхайн гүн нэмэгдэж, уул-геологийн нөхцөл муудсаны үр дагавар нь олборлолт, боловсруулалтын өртгийн нэмэгдэл, ашиг болон үйлдвэрлэлийн ашиг буурах явдал. Тухайлбал, 10 жилийн өмнөх зарим үнэлгээгээр хүдэр олборлох явцад олборлолтын ажлын гүн нэмэгдсэнээр олборлолтын өртөг жил бүр 5-7%-иар өссөн байна. Олборлосон хүдрийн чанар буурах нь баяжуулалтын техник-эдийн засгийн үзүүлэлтүүд ихээхэн хэмжээгээр доройтоход хүргэдэг. Ашигтай бүрэлдэхүүн хэсгүүдийн агууламжийн бууралт хүдэр баяжуулалтын өртөгт үзүүлэх нөлөөний аналитик хамаарлыг 3-р бүлэгт үзүүлсэн.

Хүдрийн чанар бодитойгоор буурч байгаа үед олборлолтын хэмжээг дэмжихийн тулд илүү их хэмжээний уулын цулыг олборлох шаардлагатай бөгөөд үүний үр дүнд жилийн хэмжээ нь 5 тэрбум тонн орчим хаягдал үүсдэг. Энэ хэмжээний бараг тал хувийг нь (ашиглаж эсвэл дахин боловсруулж) ашиглаж, харин үлдсэнийг нь хүрээлэн буй орчинд байршуулдаг. Сүүлийн 2-3 жилийн хугацаанд уул уурхайн хаягдлыг ашиглах хувь хэмжээ нэмэгдэж байгаа хэдий ч, хурийтлагдсан хаягдлын хэмжээ хэдийнэ 100 тэрбум тонныг даваад байна.

Технологи, зохион байгуулалт, уул-геологийн хүчин зүйлийн нөлөөгөөр эрдсийн хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлтийг үнэлэхээр боловсруулсан аргачлал нь одоо байгаа ордуудын эрдэс түүхий эдийн нөөцийн үнэ цэнийг удирдахад гарч болзошгүй үр дагаврыг үнэлэх боломжийг олгодог. Эдгээр чиглэлүүд нь ордыг ашиглах төслийн ажлын үзүүлэлтүүд, өөрчлөлттэй холбоотой юм.

Жишээлбэл, судалгааны ажилд нүүрс олборлох аж ахуйн нэгжүүдийн зураг төслийн арга зүй нь залгаа салбарууд дахь обьектуудын зураг төслийн аргаас ихээхэн хоцрогдолтой байгааг тэмдэглэжээ. Одоогийн байдлаар зураг төслийн байгууллагууд төслийн баримт бичгийг боловсруулах даалгаврын дагуу янз бүрийн альтернатив арга, нүүрс олборлох геотехнологийн нарийн системийн бүтцэд ажиллаж байгаа болон баригдаж байгаа уурхайн үйл ажиллагааны загварчлалыг гадаад орчны нөлөөлөлтэй нь харгалзуулан тооцох аргыг бараг ашигладаггүй. Загварын оролтын үзүүлэлтүүдийн хувьд загварчиллын хугацаа, ангилал тус бүрийн нөөцийн хэмжээ, эрдсийн нөөцийн цогцолборт хүрч болох хамгийн их ачаалал, түүнчлэн нүүрсний зах зээлийн хэтийн хөгжлийн талаарх мэдээллийг ашиглахыг зөвлөж байна. Загварчлалын гаралтын үр дүн нь зөвхөн олборлолтын хэмжээ төдийгүй, нөөцийг нээх зардал, илрүүлсэн нөөц болон эрдэст нөөцийн цогцолборын олборлолтонд таатай нөөцийн харьцаагаар тодорхойлогддог техник, эдийн засгийн үзүүлэлтүүд, түүнчлэн газрын хэвлэлийг ашигласны төлбөр, түрээсийн (рентийн) төлбөр байна.

Баригдаж буй уурхайнуудын идэвхгүй нөөцийг нөөцлөх, идэвхтэй нөөцийг баяжуулах зарчимд тулгуурлан эрэлтийн онцлогийг харгалzan нүүрсний зах зээлд эрэлт хэрэгцээтэй байгаа нүүрсний ордуудыг үе шаттайгаар сонгон олборлох аргыг нэвтрүүлэх

нь нүүрсний ордуудын ашиглалтын ашигт байдалд тулгуурладаг.


Судалгааны ажилд зураг төслийн чанарыг сайжруулах замаар эрдсийн хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэх үнэмшилтэй үр дүнгийн жишээг үзүүлэв. Төслийн өмнөх судалгааны үр дүн нь "Ерунаковский-VIII" болон "Ерунаковский Восточный" 2 уурхайн газрыг хамтран олборлож болох боломжийг харуулсан боловч уг хөрөнгө нь эзэмшигчдээ ашиг авчирч чадаагүй. Эрсдэлийг бууруулах зорилгоор 2013 онд 48-3 олборлолтын талбайг зааглаж, ашиглалтад оруулсны дараа Ерунаковская-VIII уурхайн нөөцийн ашиглалтын хурдыг нэмэгдүүлэх шийдвэр гаргасан. Давхаргын ашиглалтын уул-геологийн, уул-техникийн нөхцөл зэргийг (уналтын өнцөг, зузаан, эвдрэлийн зэрэг, хийн агууламж, боловсруулалтын гүн гэх мэт) үндэслэн "Барилгын төслөөр ..." суналын дагуу урт баганаар таазны чулуулгийг бүрэн нурааж боловсруулах системийг бий болгохоор тусгасан.


Энэхүү төлөвлөлтийн давуу талууд: энгийн байдал - хамгаалалтын тулгуурыг нэмэлт нээлтийн ажил хийх шаардлагагүйгээр уурхайн үндсэн малталаас шууд бэлтгэдэг; оновчтой байдал - талбайн байрлал нь хуулалтын тулгуур дахь нүүрс олборлолтын оновчтой хувь хэмжээг хангахаас гадна бялхмаг хоорондын орхиц дээр байрлах чулуулгийн зузааныг бага хэлбэлзүүлэх бөгөөд энэ нь жижиг хэмжээтэй орхицуудыг өрж, нүүрсний нөөцийг олборлох коэффициентийг нэмэгдүүлэх боломжийг өгдөг; үр ашигтай байдал - энэхүү төлөвлөлтийн сонголт нь урт суналттай хуулалтын тулгуурыг байрлуулах боломжийг олгодог; технологийн чадвар - хийгдэж буй штрекүүдийн харьцангуй хэвтээ байрлал нь хонгилын ажлын механикжуулалтыг дээд хэмжээгээр ашиглах, нэвтрэлтийн хурдыг нэмэгдүүлэх боломжийг олгодог; зохистой байдал - төлөвлөлт нь бялхмаг руу орохтой холбоотой асуудлыг шийдвэрлэхэд нөлөөлдөг, учир нь бялхмагийн мөргөцгийн шугам нь уналт руу чиглэдсэн байdag.

Хамгаалалтын багана (целик) үлдээц дэх нүүрсний алдагдлыг багасгах зорилгоор ордын нарийвчилсан нэмэлт хайгуулын геологийн шинэчилсэн мэдээлэлд тулгуурлан 3D компьютерийн программ ашиглан уурхайн талбайн зураг төслийг хийсэн гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Нээлтийн болон бэлтгэлийн малталаыг нүүрсний үлдээц хамгаална. Нүүрсний үлдээцийн өргөнийг цэвэрлэх үйл ажиллагааны тулгуур даралтын хүчтэй нөлөөллийн бүсийн хэмжээнээс багагүй хэмжээгээр авна.

Уулын цохилтын аюулаас доогуур гүнд бялхмаг хооронд байрлах нүүрсний үлдээцийн хэмжээг "ВНИМИ" НХК-ийн дүгнэлтээр тодорхойлсон.

Ордын ашиглалтын явцад гарсан үзүүлэлтүүдийн өөрчлөлтийг 3-р бүлэгт үзүүлсэн томьёогоор алтны ордын жишээн дээр үзүүлэв. Алтны ордыг олборлох жишээн дээр (зураг 57) карьер дахь олборлолтын үйл ажиллагаа буурах тусам металлын агууламж буурч, мөн үүнтэй зэрэгцэн уурхайн цулыг боловсруулах үйлдвэр болон овоолго руу тээвэрлэх зардал нэмэгдэж байгааг харж болно.





Зураг 57 Алтны ордын олборлолтын уул уурхай- геологийн нөхцөл муудаж буй байдал.

Хүдэр дэх ашигтай бүрэлдэхүүн хэсгийн дундаж агууламжийн үнэлгээнд үзүүлэлтийн хаягдлын өөрчлөлт, бохирдолтын үзүүлэх нөлөө ба баяжуулалтын зардал

Баяжуулалтын өртөг болон эрдсийн хөрөнгийн үнэ цэнэ нь уурхайн төлөвлөлт, хөрс хуулалтын коэффициент ба тээвэрлэлтийн зардлын үндсэн зарчим болох хаягдал, бохирдолтын удирдлагаас хамаарна.

Хаягдал, бохирдолтын үзүүлэлтүүдийн янз бүрийн хувилбаруутай байх үеийн хүдэр баяжуулалтын зардлын тооцооны жишээн дээр (хүснэгт 5.8) боловсруулсан хүдрийн хэмжээг харуулсан бөгөөд энэ нь баяжуулах процессын өргтийн өөрчлөлтийг хангаж өгдөг. Үндсэн болон төслийн хувилбаруудад хүдэр дэх алтны босго агууламж 1.50 г/т байна.

Төслийн хувилбарт алдагдал, бохирдолтын үзүүлэлтүүдийг бууруулах зохион байгуулалт, технологийн шийдлүүдийг үндсэн хувилбартай харьцуулан тусгасан болно.

Хүснэгт 50 Алт олборлох үйлдвэрүүдийн техник-эдийн засгийн үзүүлэлтүүдийг хувилбараар⁵ [нөхцөлт жишээгээр]

Үзүүлэлтийн нэр	Хэмжих нэгж	Суурь хувилбар	Төслийн хувилбар
Төлөвлөсөн олборлолт	тонн	1000	1000
Хаягдал	%	3,1	2,10
Чанарын алдагдал	%	17	13
Алт боловсруулах үйлдвэрт орж буй хүдрийн хэмжээ (Qруда)	тонн	1139	1109
Үйлдвэр дэх хүдрийн чанарыг нэмэгдүүлэх үеийн хүдэр боловсруулалтын хэмжээний хорогдол , (ΔQруда)	тонн	-	-30
1 тонн хүдрийг баяжуулах зардал	долл	6,0	6,0
1 тонн хүдэр баяжуулахад гарах зардлын хэмнэлт,	долл	-	180,0

(ΔЭОФ)			
Алт олборлох үйлдвэрт нэг жилд боловсруулах хүдрийн хэмжээ	т	6 000 000	6 000 000
Жилийн зардал хэмнэлт	долл	-	1080 000,0

Хүснэгт 50-д хийсэн судалгаагаар 1000 тонн боловсруулсан хүдэр тутамд үндсэн хувилбараар 3.1% хаягдал, 17% бохирдолтын үзүүлэлттэй байх үед, төслийн хувилбараар 2,1 %-ийн алдагдал, 13.0% бохирдолтын үзүүлэлттэй байх үед, хүдэр дэх ашигтай бүрэлдэхүүн хэсгүүдийн агууламж адил байх нөхцөлд боловсруулсан хүдрийн хэмжээ 30 тонноор багассаныг харуулсан. Боловсруулах үйлдвэрт илгээсэн хүдрийн хэмжээг (Qруда, мянган тонн) балансын нөөц болон хаягдал, бохирдолтыг харгалзан балансын нөөцийн зөрүүгээр тодорхойлно (томъёо (55)):

$$Q_{руды} = B - (B \cdot L/100 + B \cdot R/100) \quad (55)$$

Энд: B – хүдрийн балансын нөөц, мян.т.;

L – олборлолтын үеийн хүдрийн алдагдал, мян.т.;

R – олборлолтын үеийн хүдрийн бохирдол, мян.т.;

Эрдэст нөөцийн үнэ цэнийн өсөлтийг хүдэр боловсруулах нөхцөлт-хувьсах зардлын хувьд урсгал зардлын хэмнэлтийг үндэслэн тодорхойлно (ΔЭОФ). Жилийн хэмнэлтийг боловсруулсан хүдрийн хэмжээний өөрчлөлтөд үндэслэн тодорхойлно (томъёо (56))

$$\Delta\text{ЭОФ} = \Delta Q_{руды} * C_{уд} \quad (56)$$

Энд: $\Delta Q_{руды}$ – хаягдал болон бохирдолтын коэффициентийн бууралтын үр дүнд буурсан алт олборлох үйлдвэрт боловсруулсан хүдрийн хэмжээ, тонн/мян.

Cуд – 1 тонн хүдэр боловсруулах өртөг (хувийн зардал), руб/т.

Тээврийн зардлын бууралт эрдэст түүхий эдийн үнэ цэнийн өөрчлөлтөд үзүүлэх нөлөөлөл нь хөрс хуулалтын чулуулгийг овоолго руу, олборлосон хүдрээ боловсруулах үйлдвэр рүү тээвэрлэхтэй холбоотой. Овоолгыг эсвэл боловсруулах үйлдвэрлэлийг (үйлдвэр) байршуулах логистик нь ашигласан тоног төхөөрөмж болон уулын цулын ширхэгийн найрлагаас шалтгаалан уулын цулын "тээвэрлэлтийн зам" болон технологийн холбоосын бүтээмжийг оновчтой болгоход чиглэгддэг. Үнэлгээний арга нь үр дүнгийн үзүүлэлтийн эцсийн утгад янз бүрийн хүчин зүйлийн нөлөөллийг загварчлахад зориулагдсан мэдрэмжийн шинжилгээ байж болно. Мэдрэмжийн шинжилгээг үйлдвэрлэлийн үйл ажиллагааг төлөвлөхөд онцгой анхаарал хандуулах шаардлагатай, эрсдэлт хүчин зүйл болох хамгийн чухал загварын үзүүлэлтүүдийг тодорхойлоход; эрдсийн хөрөнгийн үнэ цэнэд ихээхэн нөлөөлдөг үзүүлэлтийн өөрчлөлтийн нөхцөлд хүлээгдэж буй зардлын үнэлгээг гаргах зорилгоор ашиглаж болно.

Алтны ил уурхайн зардлын менежментийн чиглэлээр хийсэн судалгаануудаар хөрс хуулалт болон олборлолтын дийлэнх зардал нь уурхайн цулын тээвэрлэлт (64-75%), тэсэлгээний хэрэгслийг (25-30%) тооцсон тэсэлгээ, өрөмдлөгийн ажил ба малталт (11-15%) эзэлж байгааг баталсан байна. Иймд, хамгийн чухал хүчин зүйл болох "уулын цулын тээвэрлэлт"-ийг олборлолтын өртөг болон эрдсийн хөрөнгийн үнэ цэнэд үзүүлэх

нөлөөллийн үнэлгээг хийхдээ чулуулгийг овоолго руу тээвэрлэх, хүдрийг ил уурхайн гүний хэмжээгээр боловсруулах үйлдвэрт хүргэх хүчин зүйлд мэдрэмжийн шинжилгээ хийх шаардлагатай байна.

Хөрс хуулалтын чулуулгийг зөөвөрлөх явцад тээвэрлэлтийн зардлыг эрдсийн хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлтөөр үнэлэх жишээ нь тэсэлсэн уулын цулын (ТУЦ) ширхэгийн найрлагын хэд хэдэн хувилбарын хувийн зардлын өөрчлөлтийн (Х3) тодорхойлолтонд үндэслэсэн болно. Тэсэлсэн уулын цулын ширхэгийн найрлага нь тоног төхөөрөмжийн гүйцэтгэлд нөлөөлдөг бөгөөд энэ нь өрөмдлөг, тэсэлгээ, малталт, тээвэрлэлтийн процессуудын хувийн зардлыг өөрчлөхөд хүргэдэг.

Хөрс хуулалтын ажлын хувийн зардалд “уулын цул тээвэрлэх” хүчин зүйлийн үзүүлэх нөлөөллийг дараах дарааллаар үнэлнэ:

1. Уулын цулын ширхэгийн найрлагатай уялдуулан хөрс хуулалтын ажлын явц тус бүрийн хувийн зардал хоорондын хамаарлыг тогтоодог өрөмдлөг тэсэлгээний ажлын нөхцөлд тохирсон хувийн зардлын загвар.
2. Загварын үр дүнгийн үзүүлэлт болох хөрс хуулалтын ажлын нийт хувийн зардал.
3. Тэсэлсэн уулын цул болон тээвэрлэлтийн замын өөрчлөлтийн тодорхой нөхцлөөс хамааран өөрчлөгддөг загварын үзүүлэлт болох уулын цулыг тээвэрлэх зайд.
4. Тэсэлсэн уулын цул болон тээвэрлэлтийн замыг өөрчлөх үеийн хувийн зардлын хуваарилалт.

Хувийн зардлын загвар нь кондицийн хэмжээнээс хамааран хүдэр олборлолтын ертгийн хураангуй тооцооны үндсэн дээр бүрддэг бөгөөд хувийн зардлын нийт утгууд нь загварын үр дүнгийн үзүүлэлт болно (хүснэгт 51).

Хүснэгт 51 Тэсэлсэн уулын цулын хувийн зардлыг хэмжээний хувилбаруудаар нь тооцсон хураангуй тооцоо (Тэсэлсэн уулын цул /ТУЦ) [нөхцөлт жишээгээр]

Тэсэлсэн уулын цулын жижиг хэсгийн хэмжээ, мм	300	400	500	600	700	800	900
Өрөмдлөг, руб/м3	53,55	52,18	50,41	48,54	46,61	44,41	41,73
Малтлага, руб/м3	26,54	30,97	30,97	35,39	39,81	44,24	53,08
Тээвэрлэлт, руб/м3	249,01	248,00	246,98	247,90	249,85	249,17	249,17
Хөрс хуулалтын ажлын хувийн зардал, руб/м3 (PV-351, WK-35, САТ-220)	329,10	331,14	328,35	331,83	336,27	337,81	343,98

Хүснэгт 52-т кондицийн хэмжээнээс нь хамааруулсан зардлын бүтцийг процесс бүрээр харуулав.

Хүснэгт 52 Хөрс хуулалтын зардлын бүтцийг хувийн зардлын процессоор харуулах нь

Тэсэлсэн уулын цулын жижиг хэсгийн хэмжээ, мм	300	400	500	600	700	800	900
Өрөмдлөг, %	16,3	15,8	15,4	14,6	13,9	13,1	12,1

Малтлага, %	8,1	9,4	9,4	10,7	11,8	13,1	15,4
Тээвэрлэлт, %	75,7	74,9	75,2	74,7	74,3	73,8	72,4
Хөрс хуулалтын ажлын хувийн зардал, % (PV-351, WK-35, CAT-220)	100,0	100,0	100,0	100,0	100,0	100,0	100,0

“Тээвэрлэлтийн зам” хүчин зүйлийн мэдрэмжийн үнэлгээ нь өрөмдлөг, малталтын тогтмол зардлын тогтмол утга болон нөхцөлт хувьсах зардлын хувьд өөрчлөгддөг тээвэрлэлтийн зардлыг харгалзан дүн шинжилгээ хийх явдал юм.

“Тээвэрлэлтийн зам” үр дүнгийн үзүүлэлтэд нөлөөлөх үзүүлэлтийг үнэлэх арга нь өрөмдлөг, малталтын процессын хувийн зардлын тогтмол утгатай үед, мөн “мөр”-ийн өсөлтөөр тээвэрлэлтийн зардал өөрчлөгдөх үед нийт хувийн зардлыг тодорхойлох явдал юм. Тээвэрлэлтийн уртын өөрчлөлтөөс хамаарах нөхцөлт хувьсах зардлын эзлэх хувь нь 76.3% байна (утгыг компанийн мэдээлэлд үндэслэн тооцсон).

“Тээвэрлэлтийн урт” хүчин зүйл хөрс хуулалтын ажлын өртөгт үзүүлэх нөлөөг (ΔC_{LL}) томъёогоор (57) үнэлж болно:

$$\Delta C_L = C_{iL} - C_{jL} \quad (57)$$

Энд: C_{iL} – Тээвэрлэлтийн L урттай тэсэлсэн уурхайн цулын i-р хэмжээтэй нөхцөлд хөрс хуулалтын ажлын өртөг (буюу хувийн зардал), руб/т (m^3).

$$C_{iL} = УДР_{бур. i} + УДР_{тр.ip} + 0,76 * УДР_{тр.ib} + УДР_{тр.ib \text{ пост.}} \quad (58)$$

Энд: УДР_{бур. i} - уулын цулын төлөвлөсөн хэмжээний өрөмдлөгийн хувийн зардал (X3), руб./т (m^3);

УДР_{тр.ip} – тэсэлсэн уулын цулын i-р хэмжээтэй хөрс хуулалтыг р-р ачигчид ачих хувийн зардал (X3_{тр.ip} руб. / т (m^3));

УДР_{тр.ib} – i-р хэмжээтэй тэсэлсэн уулын цул тээвэрлэлтийн тонн-км тутмын хувийн зардал (X3_{тр.ib} руб./ m^3 -км(т-км)));

L_i – тээвэрлэлтийн урт, 1-ээс 25 км хүртэл;

0,76 – уулын цулыг тээвэрлэх нөхцөлт-хувьсах зардлын дундаж эзлэх хувь, нэгж хувь.

УДР_{тр.ib пост.} – тээвэрлэлтийн хувьсах-тогтмол зардал, руб.

Тэсэлсэн уулын цулын өртгийг (C_{jL}) үүний нэгэн адилаар тооцоолно.

Тэсэлсэн уулын цулаар [0,3] гаргасан хувийн зардлын хазайлтын утга нь хоёр хүчин зүйлийн нөлөөллийн үр дүнд харьцангуй [0,4] үүссэн:

1. тэсэлсэн уулын цулыг [0,3] тээвэрлэх нөхцөлт-хувьсах зардлын хазайлт нь харьцангуй [0,4] байна, учир нь тэсэлсэн уулын цулын хувийн зардал [0,3] нь 249.01 руб. m^3 байгаа нь тэсэлсэн уулын цулын тээврийн хувийн зардлаас [0,4] 1,01 руб. m^3 -ээр их байна (248.0 руб. m^3). Эдгээр зардал нь тээвэрлэлтийн замын өсөлтөөр нэмэгдэж, зардлын бүтцэд ихээхэн хувь эзэлдэг тул хувийн зардлын нийт утгыг ихээхэн өөрчилдөг.
2. “Өрөмдлөг” ба “Малтальт” нийтлэлийн дагуух тэсэлсэн уулын цулын [0,3] зардлын хазайлт нь харьцангуй [0,4] бөгөөд энэ нь [0,3] – 80,1 хувийн зардал ба [0,4] 83,1 хувийн зардлын ялгавар маягаар тодорхойлогдох бөгөөд 3,0 руб. m^3 байна.

Гарсан үр дүнгийн шинжилгээ нь тэсэлсэн уулын цулын хувийн зардал [0,3] хувилбаруудтай харьцуулах нөхцлийн хувьд “тээврийн зам” гэсэн хүчин зүйлийн зардлын мэдрэмж нь харьцангуй [0,4] бага бөгөөд зөвхөн мөр 25 км хүртэл нэмэгдсэний дараа л илэрч эхэлдэг болохыг харуулж байна. Энэ нь 25 км-ын дараа тэсэлсэн уулын цулын [0,4] тээвэрлэлтийн зардлын хэмнэлт нь [0,3]-аас их, мөн өрөмдлөг, малталтын зардлын зөрүүгээс их байгаатай холбоотой юм.

Тэгэхээр, хувийн зардлын тооцооны үр дүн нь туршилтын нөхцөлд (тэсэлсэн уулын цулын хувийн зардал [0,3]-ыг [0,4]-тай харьцуулахад) тэсэлсэн уулын цулын [0,3] хувилбарыг сонгох нь эдийн засгийн хувьд илүү тохиромжтой болохыг харуулж байгаа бөгөөд энэ нь хөрс хуулалтын ажлын бага хувийн зардалтай тохирч байна - тэсэлсэн уурхайн цул [0,3] - 329.10 руб. м3 ба тэсэлсэн уулын цул [0,4]-ын харьцаа 331.14 руб. м3. Гэхдээ тээврийн зам 25 км хүртэл нэмэгдсэн тохиолдолд тэсэлсэн уулын цул [0,3]-ын зардал нь тэсэлсэн уулын цул [0,4]-тай харьцуулахад харьцангуй нэмэгдэх бөгөөд энэ нь тэсэлсэн уулын цул [0,4] хэмжээсийн сонголтын нөхцөлд шилжих нь зүйтэй болохыг харуулж байна.

Хүснэгт 53 Тэсэлсэн уулын цулын тээвэрлэлтийн зардлын тооцоо ба “уулын цулыг өөрөө буулгагчаар тээвэрлэх зам
(тээврийн зайд)” хүчин зүйлийн дагуух мэдрэмжийн шинжилгээ


Тэсэлсэн уулын цулын тээвэрлэлтийн зайд, км L_t , км	7	9	11	13	15	17	19	21	37	39	41
1. Өрөмдлөг, руб./м ³	53,55	53,55	53,55	53,55	53,55	53,55	53,55	53,55		53,55	53,55	53,55
2. Малталт, руб./м ³	26,54	26,54	26,54	26,54	26,54	26,54	26,54	26,54	...	26,54	26,54	26,54
3. Тээвэрлэлт, руб./м ³	249,01	249,01	249,01	249,01	249,01	249,01	249,01	249,01	...	249,01	249,01	249,01
4. Тээвэрлэлт, руб./км·м ³	36,33	36,33	36,33	36,33	36,33	36,33	36,33	36,33	...	36,33	36,33	36,33
5. Өрөмдлөг ба Малталт нийт	80,1	80,1	80,1	80,1	80,1	80,1	80,1	80,1	...	80,1	80,1	80,1
6. Тээвэрлэлтийн нөхцөлт тогтмол хэсэг, руб./м ³	60	60	60	60	60	60	60	60		80,1	80,1	80,1
7. Замыг өөрчилсөн нөхцөл дэх тээврийн зардал (нөхцөлт хувьсах хэсэг 0,76%)	189,2	244,4	299,6	354,8	410,1	465,3	520,5	575,8	...	1017,6	1072,8	1128,0
8. НИЙТ Х3* ТУМ** 300	329	384	439	495	550	605	660	716		1 157	1 213	1 268
9. Өрөмдлөг, руб./м ³	52,18	52,18	52,18	52,18	52,18	52,18	52,18	52,18	...	52,18	52,18	52,18
10. Малталт, руб./м ³	30,97	30,97	30,97	30,97	30,97	30,97	30,97	30,97	...	30,97	30,97	30,97
11. Тээвэрлэлт, руб./м ³	248,00	248,00	248,00	248,00	248,00	248,00	248,00	248,00		248,00	248,00	248,00
12. Тээвэрлэлт, руб./км·м ³	36,19	36,19	36,19	36,19	36,19	36,19	36,19	36,19	...	36,19	36,19	36,19
13. Өрөмдлөг ба Малталт нийт	83,1	83,1	83,1	83,1	83,1	83,1	83,1	83,1	...	83,1	83,1	83,1
14. Тээвэрлэлтийн нөхцөлт- хувьсах хэсэг, руб./м ³	60	60	60	60	60	60	60	60	...	60	60	60
15. Замыг өөрчилсөн нөхцөл дэх тээврийн зардал (нөхцөлт хувьсах хэсэг 0,76%)	188,4	243,4	298,4	353,4	408,4	463,4	518,4	573,4	...	1013,4	1068,4	1123,4
16. НИЙТ Х3* ТУС** 400	331	386	441	496	551	606	661	716	...	1 156	1 211	1 266
Тээвэрлэлтийн замаар тээвэрлэх нөхцөлт-хувьсах зардлын өөрчлөлт (Х3 [0,3] харьцангуй [0,4]) (15 - 7	-0,8	-1,0	-1,2	-1,4	-1,7	-1,9	-2,1	-2,3	...	-4,1	-4,4	-4,6

заалт)												
[ΔС]ТҮМ-ын ХЗ [0,3] харьцангуй [0,4], руб/м ³ [ХЗ 0,4 - ХЗ 0,3] (16-8 заалт)	2,0	1,8	1,6	1,4	1,1	0,9	0,7	0,5	...	-6,17	-6,40	-6,62

* УДР – хувийн зардал – ХЗ

** ВГМ – тэсэлсэн уулын цүл – ТҮЦ

Тээврийн замын мэдрэмтгийн байдлын шинжилгээний үр дүнг янз бүрийн төрлийн тоног төхөөрөмжөөр тэсэлсэн уулын цулын хувийн зардлын утга тус бүрийн хувьд явуулах ёстой, учир нь туршилтын үр дүнд гарсан өгөгдлүүдийн дагуу шинжилгээний үр дүн нь “Өрөмдлөг” ба “Малталт”-ын хазайлтын утгаас хамаарах болно. “Тээврийн мөр” хүчин зүйлийн үнэлгээний үр дүн хувийн зардлын үр дүнгийн үзүүлэлтэд үзүүлэх нөлөөллийг Зураг 58-д харуулав.



Зураг 58 Тээврийн зам" хүчин зүйлийн мэдрэмжийн шинжилгээ, тэсэлсэн уулын цулын хувийн зардлын [0,3] харьцангуй [0,4] өөрчлөлтийн динамик, руб/м³

Шинжилгээний үр дүн уурхайн үйл ажиллагааны бууралт, ил уурхайн янз бүрийн хажуугийн овоолгын логистикийг харгалзсан олборлолтын өртөгт уулын цулыг тээвэрлэх зардал ихээхэн нөлөөлж байгааг харуулж байна.

Хүснэгтээс хувийн зардлын утгын шинжилгээнээс хараад, [0,4] харьцуулахад тэсэлсэн уулын цулын хэсэг [0,3] бүхий өрөмдлөгийн схемийг сонгох нь эдийн засгийн хувьд оновчтой байна, учир нь [0,4]-ийн хувийн зардал нь [0,3]-ын хувийн зардлаас бага байна. Гэсэн хэдий ч олборлолтын хүрээ багасах тусам уулын цулын тээвэрлэлтийн зардал нэмэгдэж, [0,3] хувийн зардал ба [0,4] хувийн зардал хоорондын ([0,3]-ын тээвэрлэлтийн хувийн зардал - 249 рубль/м³ ба [0,4] - ийн тээвэрлэлтийн хувийн зардал 248 рубль/м³) үнэмлэхүй утга дахь хувийн зардлын бага ялгаатай үеийн зардлын бүтцэд эзлэх ихээхэн хувийг (дунджаар 75%) харгалзан 9-р хүснэгт дэх тооцооны дагуу тээвэрлэлтийн замыг 27 км-ээс илүү нэмэгдүүлсний дараа тэсэлсэн уулын цулын [0,4] хувилбарт шилжих хэрэгтэй. Технологийн шийдвэр, уурхайн үйлдвэрлэлийн схемд өөрчлөлт нь олборлолтын жилийн зардал болон эрдсийн хөрөнгийн үнэ цэнэд нөлөөлдөг.

Хүдэр боловсруулах байгууламж руу тээвэрлэх зардал, тэдгээрийн баяжуулалтын зардалд үзүүлэх нөлөөллийн үнэлгээний хувилбарын жишээг В.Н. Несис, О.Ю. Лебедева [151] нарын ажилд судалсан байdag бөгөөд түүндээ ордуудыг одоогийн боловсруулах хүчин чадалтай “холбох” боломжийн техник, эдийн засгийн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн боловсруулах төвүүдийг бий болгох арга зүйн хандлагыг санал болгосон байна. Хүдэр боловсруулах хувилбарыг сонгох урьдчилсан шийдвэр

гаргах алгоритм нь хүдэр дэх үнэт металлын агууламжаар дамжуулан үр ашигтай аннуитет болон түүний эдийн засгийн эквивалентыг тооцоолоход суурилдаг. Аргачлал нь хүдэр тээвэрлэх боломжтой замын хамгийн дээд уртыг тооцоолох боломжийг олгодог бөгөөд энэ нь зангилааны хүчин чадлаар боловсруулахад эдийн засгийн хувьд үр ашигтай ([151]). Ийм үнэлгээ нь эрдсийн хөрөнгийн үнэ цэнийг өсгөх (буурах) боломжийг тодорхойлсоны үр дүнд эрдсийн хөрөнгийн үнэ цэнийг удирдах боломжтой болгодог.

Хүдэр дэх металлын агууламжаар аннуитетийн ($\mathcal{E}_{\text{ЭКВ}}$) эдийн засгийн эквивалентыг тодорхойлоход (59) [151] томъёог ашигладаг:

$$\mathcal{E}_{\text{ЭКВ}} = \frac{A_{\text{ЭФФ}} / K_{\text{ИЗВ}}}{Ц_{\Delta u} / N} \quad (59)$$

Энд: Аэфф – үр ашигтай аннуитет, мөн.нэгж.;

Кизв – ялган авалтын коэффициент, хувь нэгж.;

Ц Δu – алтны үнэ, долл/унци;

N – унци дахь граммын хэмжээ, гр

Боловсруулсан нэг тонн хүдэрт ногдох үр ашигтай аннуитетийг тооцож гаргахдаа түүний нийт хэмжээг үйлдвэрийн үйлдвэрлэлийн хүчин чадалд хуваах замаар тодорхойлно.


$$\mathcal{E} = A_{\text{ЭФФ}} = \frac{r \cdot PV}{(1 - \frac{1}{(1+r)^t})} \quad (60)$$

: PV - объектыг ашиглалтад оруулах (үйлдвэрлэлийн эхэн үед) тэр үед үйлдвэрийн барилгажилтанд оруулсан хөрөнгийн урсгал үнэ, мөнгө. нэгж;

r – хөнгөлөлтийн хувь хэмжээ, хувь нэгж;


t – үйлдвэрийн ашиглалтын хугацаа, жил

Хүдрийг алт олборлох үйлдвэрүүд (АОҮ) руу тээвэрлэх зардал ба эрдийн хөрөнгийн үнэ цэнийн хамаарлыг Сопка Кварцевая ордыг Омolonскийн баяжуулах төвтэй "холбох", Дегтярское ордыг Воронцовскийн баяжуулах төвтэй "холбох" эдийн



засгийн оновчтой байдлыг хоёр жишээгээр нотлосон байдаг.

Зураг 59 Сопка Кварцевая ордыг Омolonскийн баяжуулах төвтэй "холбох" эдийн засгийн оновчтой байдлын тооцооны үр




Зураг 60 Дегтярское ордыг Воронцовскийн баяжуулах төвтэй "холбох" эдийн засгийн оновчтой байдлын тооцооны үр дүн

Тооцооллын үр дүн нь хүдэр дэх металлын агууламжаас хамааран тээвэрлэлтийн

бүрэлдэхүүн хэсгийн зардлыг харьцуулах боломжийг олгодог. Судалгаагаар тээвэрлэлтийн уртыг нэмэгдүүлэх нь ордуудын олборлолтыг буурахад хүргэнэ хэмээн баталсан бөгөөд хүдэр дэх алтны агууламж өндөр байх нь төслийн өндөр үр ашиг, мөн эдийн засгийн үнэ цэнийн өсөлтийн баталгаа биш юм.

5.3 Эрдсийн хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнийг үнэлэх загварчлал, эрсдэлийн үнэлгээ (Улуг-Хэмийн нүүрсний сав газрын Элэгестийн ордыг ашиглах төслийн жишээн дээр)

Эрдсийн хөрөнгийн үнэ цэнийг үнэлэх объект болгон "Красная Горка" 1-р уурхайг барихаар төлөвлөж буй Бүгд Найрамдах Тува улсын Элэгестийн ордын олборлолтын талбайн Төслийг авч үзсэн. Тусгай зөвшөөрөлтэй талбайд хийсэн хайгуулын ажлын үр дүнд коксжих нүүрсний Ж зэрэглэлийн нөөцийг А+В+C1+C2 ангиллын нүүрсний зургаан давхаргад 855,089 мянган тонн, үүнээс далд уурхайн нөөц А+В+C1+C2 ангиллаар 837,327 мянган тонн, ил уурхайн боловсруулалт 15100 мянган тонн байгааг тооцож гаргасан байна. 2013 оноос Улуг-Хемскийн нүүрсний сав газрын Элэгестийн ордыг ашиглах тусгай зөвшөөрлийг "Тувагийн Эрчим Хүчний Аж Үйлдвэрийн Корпораци (ТЭПК ХК) ХК эзэмшиж байна.





Зураг 61 Улуг-Хэмскийн нүүрсний сав газрын Элэгестийн орд дахь “ТЭПК” ХК-ийн тусгай зөвшөөрөлтэй талбайн байршлын төлөвлөгөө.

Энэ төсөл нь Элэгест-Кызыл-Курагино төмөр замын бүтээн байгуулалттай нягт холбоотой. 2018 онд төмөр замыг 30 жилийн хугацаатай концессийн гэрээний хүрээнд бүтээн байгуулж, ашиглалтад оруулахаар шийдвэрлэсэн байдаг. «ТЭПК “Кызыл-Курагино”» ХК байгуулагдсан бөгөөд хувьцаа эзэмшигч нь “ТЭПК” ХК юм. 2019 оны дөрөвдүгээр сарын эхээр «ТЭПК “Кызыл-Курагино”» ХК болон “Оросын төмөр зам” НХК (нээлттэй хувьцаат компани)-ийн хооронд “Элэгест-Кызыл-Курагино” төмөр замын зураг төслийг боловсруулах, барих гэрээнд гарын үсэг зурсан. Шинжээчдийн үзэж байгаагаар Тува улсын Элэгестийн ордын олборлолтын талбайн төсөл нь Дорнод Сибирийн бүс нутгийн байдлыг ихээхэн сайжруулж, олон тооны шинэ ажлын байр бий болгож чадах хамгийн том хөрөнгө оруулалтын төсөл юм. Төмөр замын шугам барихаас гадна Элэгестийн ордыг цогцоор нь боловсруулах төсөлд Хабаровскийн хязгаарт нүүрсний боомтын терминалыг барих ажлыг багтаасан .

Төсөл төлөвлөлтийн хувьд хөрөнгө оруулалтыг хуваарилах, хөнгөлөлтийн хувь хэмжээ, нүүрсний борлуулалтын үнийг сонгохдоо дараах нөхцлүүдийг авч үзсэн. Хөрөнгө

оруулалт (56,660,340 мянган рубль):

- 1) өөрийн хөрөнгө нь нийт хөрөнгө оруулалтын 35%;
- 2) зээлийн санхүүжилт - нийт хөрөнгө оруулалтын 65%




Зураг 62 ”Красная Горка” төслийн хөрөнгө оруулалтын бүтэц, динамик 10.5%-ийн хөнгөлөлтийн хувь хэмжээг (61) томъёог ашиглан капиталын жигнэсэн дундаж өртгөөр (WACC) тооцно:

$$WACC = Re * We + Rd * Wd * (1 - T) \quad (61)$$

Энд: Re – 15.2% тэнцэх хэмжээний оруулах ёстой өөрийн хөрөнгө, We – өөрийн хөрөнгийн хэмжээ – 35%, Rd – зээлжих хөрөнгийн хэмжээ, тухайн зээлийн хувьд 10% байна, Wd – зээлжих хөрөнгийн хэмжээ – 65%, $(1-T)$ –татварын хамгаалалт, T нь орлогын албан татварын хувь хэмжээ (20%).

Бүтээгдэхүүний үнэ нь хатуу агуулгатай коксжих нүүрсний (TSI HCC) болон дээд зэрэглэлийн (TSI PHCC) дэлхийн дундаж үнэтэй тохирч байна, зураг 5.12 [159].



Зураг 63 2020 оны 1-р сараас 2022 оны 2-р сар хүртэлх дэлхийн нүүрсний дундаж үнэ, ам.доллар/тн

“Красная Горка” төслийн эдийн засгийн үр ашгийг үнэлэхийн тулд Альт-Инвест Сумм 6.1. програм хангамжийн бүтээгдэхүүнийг ашигласан болно.

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хөрөнгө оруулалт, НӨАТ ороод	56	660	мян.руб.
	340		
Ашиг, НӨАТ-гүй	1	457	мян.руб.
	984000		
Цэвэр ашиг (алдагдал)	285	170	мян.руб.
	646		
Мөнгөн хөрөнгө	320	748	мян.руб.
	978		

**ТАТАН ОРУУЛСАН Мян.руб. Хувь
САНХҮҮЖИЛТ хэмжээ**


Өөрийн хөрөнгө	20	043	35%
	825		
Зээлийн хөрөнгө	36	616	65%
	515		
Нийт	56	660	
	340		

ТӨСЛИЙН ҮР АШИГ

Өнөөгийн цэвэр өртөг, NPV	30	714	мян.руб.
	053		
Дотоод өгөөжийн хэмжээ, IRR	15,2%	%	
Хөнгөлөлтийг харгалзан 15,0 жил хөрөнгө оруулалт хийснээс хойш бүрэн эргэн төлөгдөх хүртэлх хугацаа, PBR			

**ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ҮР
АШИГ**


Өнөөгийн цэвэр өртөг, NPV	7 566 375	мян.руб.
Дотоод өгөөжийн хэмжээ, IRR	18,9%	%
Хөнгөлөлтийг харгалзан 17,1 жил хөрөнгө оруулалт хийснээс хойш бүрэн эргэн төлөгдөх хүртэлх хугацаа, PBR		




Зураг 64 “Красная Горка” төслийн эдийн засгийн үр ашгийн үзүүлэлтүүд

Хөрөнгө оруулалт, нүүрсний үнэ, хөнгөлөлтийн хувь зэрэг төслийн шалгуур үзүүлэлтүүдийн мэдрэмжийн шинжилгээ нь төслийн цэвэр орлого үнийн хүчин зүйлээс ихээхэн хамааралтай болохыг харуулж байгаа бөгөөд энэ нь төслийн хамгийн чухал эрсдэл юм.


Төсвийн үр ашгийг үнэлэхдээ 10%-ийн хөнгөлөлтийн хувь хэмжээг ашигласан. Холбооны төсвийн NPV нь 18,239.9 сая рубль, нутаг дэвсгэрийн төсөөт 12,355.2 сая рубль байна. Ийнхүү төсвийн нийт үр ашиг 30,575.1 сая рубль байна. Арилжааны болон төсвийн үр ашгийг тооцохдоо нийгмийн хөнгөлөлтийн хувь хэмжээг хэрэгжүүлсэн бол үр дүн нь хамаагүй дээр байх байсан. Хөнгөлөлтийн хувь хэмжээг 15 нэгжээр бууруулснаар хөнгөлөлтөөс орох цэвэр орлого 6%-р нэмэгдэх байсан (Зураг65).




Зураг 65 Бүтээгдэхүүний үнээр “Красная Горка” төслийн NPV мэдрэмжийн шинжилгээ, мян. руб.



Зураг 66 Хөрөнгө оруулалтын хэмжээгээр “Красная Горка” төслийн NPV мэдрэмжийн шинжилгээ, мян. руб.



Зураг 67 Тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтаар “Красная Горка” төслийн NPV мэдрэмжийн шинжилгээ, мян” руб.



Зураг 68 Хөнгөлөлтийн хувь хэмжээний өөрчлөлтөөр "Красная Горка" төслийн NPV-ийн мэдрэмтгийн байдлын шинжилгээ, мян. руб.

Үр ашгийн үзүүлэлтүүдийн дүн шинжилгээ нь төслийн үр ашиг хангалтгүй, эргэн төлөгдөх хугацаа урт байгааг харуулж байгаа боловч тус төсөл нь Бүгд Найрамдах Тыва Улсад нийгмийн өндөр ач холбогдолтой бөгөөд энэ нь бүс нутгийн дэд бүтцийн байдлыг сайжруулж, олон тооны шинэ ажлын байр бий болгох боломжтой юм. Тиймээс энэ төсөлд төр, хувийн хэвшилийн түншлэлийн механизмаар хэрэгжих боломжтой төрийн дэмжлэг хэрэгтэй байна.

Элегестийн ордын төслийн эрсдлийн үнэлгээг PERT (Program Evaluation Review Technique) арга буюу төслийн өртгийн шинжилгээг гурван цэгээр гаргасан болно:


1) пессимист буюу гутранги үнэлгээ (cP) - энэ нь таагүй нөхцөл байдлын үеийн төслийн бүхэлд нь эсвэл төслийн салангид элементийн аль нэгний өртгийн хамгийн их боломжит утга;

2) оптимист буюу өөдрөг үнэлгээ (cO) - энэ нь илүү тааламжтай нөхцөл байдлын үеийн төслийн бүхэлд нь эсвэл төслийн тусдаа элементийн өртгийн хамгийн бага боломжит үнэ;

3) Хамгийн их магадлалтай эсвэл бодитой, эсвэл шинжээчийн үнэлгээ (cM) - энэ нь урьдчилан төлөвлөсөн бүх зардлын бодит тооцоог тооцоолох замаар олж авдаг төслийн бүхэлд нь буюу бие даасан элементийн өртөг.

Төслийн хүлээгдэж буй өртгийг тодорхойлохын тулд гурван хувилбарыг боловсруулж, магадлалын хуваарилалтын томъёог ашигладаг.

Зураг 69-д өргөн хэрэглэгддэг тасралтгүй хуваарилалт болох гурвалжин ба бета-хуваарилалт гэсэн хоёр жишээг үзүүлэв.



Зураг 69 *Магадлалын хуваарилалт*

Жигд хуваарилалтыг төслийн эхний үе шатанд хамааралтай, дээд ба доод хязгаарын хооронд байрлалтай бусдаас илүү магадлалтай, тодорхой утга байхгүй тохиолдолд ашиглаж болно. Гурвалжин хуваарилалт/тархалтыг хангалттай өгөгдөл байхгүй эсвэл субъектив өгөгдөл ашигласан тохиолдолд ашигладаг. Гурвалжин хуваарилалтаар төслийн өөдрөг эсвэл гутранги өртгийн магадлал нь 0, харин бодит үнэлгээний магадлал 100% байдаг. Гутранги үнэлгээ нь шинжээчийнхээс бага байх магадлалтай ба төслийн хэрэгжилт дуусах хугацаа ойртох тусам гутранги үнэлгээний магадлалын утга багасна. Гурван цэгээр үнэлгээ гаргах аргыг хэрэгжүүлэх явцад олж авсан утга нь ихэвчлэн шинжээчийн үнэлгээнээс арай өндөр байдаг.

Эрдсийн хөрөнгийн үнэ цэнийн технологийн шинэлэг хүчин зүйлийн нөлөөллийг загварчлах ажлын хүрээнд эрсдэлийг харгалzan Элегестийн ордын ашиглалтын үр ашгийн үнэлгээг (нөөцийн хэсгийг гүний уурхайн аргаар олборлох жишээн дээр) хийсэн. Эрсдлийн гол хүчин зүйлийн хувьд тоног төхөөрөмжийг солих шаардлага мөн макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн тогтвортгүй байдал өндөр байгаагаас бий болсон инфляцийн хүчин зүйлээс шалтгаалан технологийн хүчин зүйлийг сонгосон.

Төслийн мэдрэмжийн шинжилгээ нь одоогийн хориг арга хэмжээний нөхцөлд тоног төхөөрөмжид оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээний хүчин зүйлийн дагуу NPV хазайлт бага түвшинд байгааг харуулж байгаа бөгөөд тоног төхөөрөмжийн импортын өндөр эрсдлийг тооцох хэрэгтэй. ОХУ-д уул уурхайн тоног төхөөрөмж нийлүүлдэг гол улсууд бол Герман, Польш, АНУ, Украин, Чех улсууд юм. Одоогийн байдлаар EX, АНУ болон бусад улс орнуудаас тусгай тоног төхөөрөмж, эд ангиудын экспорт хязгаарлагдмал байгаа. Хориг арга хэмжээ авахаас өмнө нүүрс олборлолтод ашиглаж байсан импортын тоног төхөөрөмжийн эзлэх хувь тухайн тоног төхөөрөмжийн төрлөөс хамаарч 50-90 хувь байсан.

Олж илрүүлсэнээр:

- Польш, Герман, АНУ-аас импортолсон уул уурхайн тоног төхөөрөмж нь дотоодынхоос илүү найдвартай, тоног төхөөрөмжийн ажиллагаа, олборлолтын үйл

явцыг хянах автомат системээр хангагдсан;

2) дотоодын цэвэрлэгч комбайны тонн тутамд ногдох ашиглалтын хувийн зардал нь ижил төстэй технологийн тодорхойлолттай АНУ, Германы комбайнуудын зардлаас бараг нэг хагас дахин бага;


3) DBT тулгуурын нэг тонн олборлолтонд ногдох ашиглалтын хувийн зардал нь ижил төстэй техникийн тодорхойлолт бүхий дотоодынхтой төстэй байна;

4) Оросын мөргөцөгний дамжуургын ашиглалтын хувийн зардал нь ижил төстэй гадаадынхаас 1.6 дахин их байна.

“Красная Горка” уурхай дээр ордыг далд аргаар боловсруулах үндсэн хувилбарын дараах тоног төхөөрөмжийг ашиглахыг санал болгосон: SL-300 цэвэрлэгч комбайн - Eickhoff (Герман); Eickhoff компаний үйлдвэрлэсэн PF4/1032 мөргөцөгийн дамжуурга; Caterpillar (АНУ) компаний DBT механикжуулсан тулгуур.

Төслийн хувилбар (импортын тоног төхөөрөмжийг дотоодын төхөөрөмжөөр бүрэн солих хүчин зүйлийг харгалзан) нь дотоодын тоног төхөөрөмжийг ашиглахаар тооцоолсон (технологийн тодорхойлолтоороо үндсэн хувилбартай хамгийн төстэй байхаар): K700A комбайн, OMT174 механикжуулсан тулгуур ("Объединенные Машиностроительные Технологии "Нээлттэй хувьцаат компани (Киселевск хот, Кемерово муж)); КСЮ381 «Юрга850» хусагч дамжуурга(Юргинский машины үйлдвэр, Кемерово).

Зөвхөн технологийн хүчин зүйлийн нөлөөгөөр NPV-ийн төслийн хувилбарын үр нөлөөг 32,360 сая рубль гэж тооцсон нь суурь хувилбараас 1,659 сая рублиэр илүү байна. Илүү нарийн үнэлгээг хувилбарын шинжилгээгээр (өөдрөг, бодит, гутранги) гаргаж болно, зураг 70.



Зураг 70 "Красная Горка" төслийн нөхцөл дэх тоног төхөөрөмжийн зардлын хувилбарууд

Өөдрөг хувилбар: 2022 оны 5 дугаар сарын 26-ны өдрөөс Төв банкны үндсэн ханс 11%, инфляцийн тооцоолсон түвшин 9.16%, нүүрсний үнэ буурахгүй, импортыг орлох тоног төхөөрөмжийн өртөг 5%-иар буурсан байна (Хүснэгт54).

Хүснэгт 54” Красная Горка” төслийн хөрөнгийн зардлын өөдрөг хувилбар, сая. рубль

Нэр	Тоног төхөөрөмжийн өртөг				Нийт капитал зардал	
	Ашиглалтанд орох 1-р цогцолбор	Ашиглалтанд орох 2-р цогцолбор	Нийт (НӨАТ-гүй)	Нийт (НӨАТ-тэй)	Нийт (НӨАТ-гүй)	Нийт (НӨАТ-тэй)
Бодит хувилбар	8947,2	4434,9	13382,1	16058,5	46944,2	56333,0
Өөдрөг хувилбар	8812,8	4300,5	13113,3	15736,0	46675,4	56010,5
Хэмнэлт	134,4	134,4	268,8	322,6	268,8	322,6

Төслийн эдийн засгийн үр ашгийн үзүүлэлтүүдийг (өөдрөг хувилбар) зураг 71-д үзүүлэв.

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хөрөнгө оруулалт, НӨАТ-тай	56 337 780	мян.руб.
Орлого, НӨАТ-гүй	1 457 984	мян.руб.
	000	
Цэвэр ашиг (алдагдал)	285 375	мян.руб.
	976	
Мөнгөн хөрөнгө	320 631	мян.руб.
	591	
ТАТАН ОРОЛЦУУЛЖ БҮЙ САНХҮҮЖИЛТ		Мян.руб. Хувь
Өөрийн хөрөнгө	19 718 223	35%
Зээлийн хөрөнгө	36 619 557	65%
Нийт:	56 337 780	

ТӨСЛИЙН ҮР АШИГ (FCFF)

Өнөөгийн цэвэр үнэ	45	499	мян.руб.
цэнэ, NPV		609	
Дотоод өгөөжийн түвшин, IRR	15,3%	%	
Эргэн төлөгдөх хугацаа, PBP	13,7		жил
Ашгийн индекс, PI		1,92	
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ҮР АШИГ (FCFF)			
Өнөөгийн цэвэр үнэ	23	685	мян.руб.
цэнэ, NPV		033	
Дотоод өгөөжийн түвшин, IRR	19,0%	%	
Эргэн төлөгдөх хугацаа, PBP	13,4		жил

Зураг 71 “Красная Горка” төслийн эдийн засгийн үр ашгийн үзүүлэлтүүд (өөдрөг хувилбар)

Өөдрөг хувилбар: үндсэн хувь хэмжээ 11%, 2022 оны 5-р сарын эцсийн байдлаар ОХУ-д жилийн инфляци 16.5%, нүүрсний үнэ буурахгүй, импортыг орлох тоног төхөөрөмжийн үнэ түүхий эдийн үнэ өссөнтэй холбоотойгоор 25%-иар өссөн байна (хүснэгт 55).

Хүснэгт 55 Капитал (урт хугацаат санхүүжилтийн эх үүсвэр зардлын гутранги хувилбар, сая руб.

Нэр	Тоног төхөөрөмжийн өртөг				Нийт капитал зардал	
	Ашиглалтанд орох 1-р цогцолбор	Ашиглалтанд орох 2-р цогцолбор	Нийт (НӨАТ-гүй)	Нийт (НӨАТ-тай)	Нийт (НӨАТ-гүй)	Нийт (НӨАТ-тай)
Бодит хувилбар	8947,2	4434,9	13382,1	16058,5	46944,2	56333,0

Гутранги хувилбар	8827,2	4314,9	13142,1	15770,5	46704,2	56045,0
Хэмнэлт	120,0	120,0	240,0	288,0	240,0	288,0

Гутранги хувилбарын дагуу төслийн эдийн засгийн үр ашгийн үзүүлэлтүүдийг зураг 72-д үзүүлэв.

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хөрөнгө оруулалт,	56 372 340	мян.руб.
НӨАТ-тай		
Орлого, НӨАТ-гүй	1 457 984	мян.руб.
	000	
Цэвэр ашиг (алдагдал)	285 281	мян.руб.
	231	
Мөнгөн хөрөнгө	320 570	мян.руб.
	247	
ТАТАН		Хувь
ОРОЛЦУУЛЖ		
БҮЙ САНХҮҮЖИЛТ		
Өөрийн хөрөнгө	19 730 319	35%
Зээлийн хөрөнгө	36 642 021	65%
Нийт:	56 372 340	

ТӨСЛИЙН ҮР АШИГ (FCFF)


Өнөөгийн цэвэр үнэ	28 088	мян.руб.
цэнэ, NPV	587	
Дотоод өгөөжийн	15,3%	%
түвшин, IRR		
Эргэн төлөгдөх хугацаа,	15,3	жид
PBP		
Ашгийн индекс, PI	1,57	
ХУВЬЦАА		
ЭЗЭМШИГЧДИЙН ҮР		
АШИГ (FCFF)		
Өнөөгийн цэвэр үнэ	5 424	мян.руб.
цэнэ, NPV	213	
Дотоод өгөөжийн	19,0 %	%
түвшин, IRR		
Эргэн төлөгдөх хугацаа,	18,3	жил
PBP		

Зураг 72 “Красная Горка” төслийн эдийн засгийн үр ашгийн үзүүлэлтүүд (гутранги хувилбар)

Хувилбаруудын дагуух үр ашгийн дундаж утга нь хамгийн их хүлээгдэж буй NPV утга юм (хүснэгт 56, зураг 72.).

Хүснэгт 56 Хүлээгдэж буй NPV-ийн тооцоо, мян. руб.

Хувилбарууд	NPV
Өөдрөг, сО	45499609
Бодит, сМ	32360314
Гутранги, сР	28107850
Магадлалын хуваарилалт/тархалт	Хүлээгдэж буй NPV, сЕ
Гурвалжин тархалт	35316170
Бета-тархалт	33838242
Дундаж утга	34577206



NPV-ийн хүлээгдэж буй дундаж утга
34 577 сая рубль

$$cE_0 = \frac{cE_1 + cE_2}{2}$$

NPV утгын интервал
25 871 сая руб.-ээс
43 282 сая руб. хүртэл

$$SD = \frac{cO - cP}{6}$$

$$\begin{aligned} \text{Range start} &= cE - SD * n \\ \text{Range finish} &= cE + SD * n \end{aligned}$$

Зураг 73 “Красная Горка” төслийн хувилбараар NPV утгын магадлалын тархалтын үр дүнгийн график төсөөлөл.

Хүлээгдэж буй дундаж цэвэр өнөөгийн үнэ цэнэ нь 34,577,206 мянган рубль бөгөөд энэ нь бодит NPV хувилбарын анхны үнийн дүнтэй харьцуулахад 6,85% (2,216,892 мянган рубль)-иар өндөр байна.

NPV-ийн хүлээгдэж буй утгыг олсны дараа төслийн NPV утгын хүрээг тодорхойлно:

- 1) хамгийн бага хил хязгаарыг (range start) олохын тулд стандарт хазайлтын утгыг (SD) хүлээгдэж буй зардлын утгаас хасна;
- 2) хамгийн дээд хязгаарыг (range finish) олохын тулд төслийн хүлээгдэж буй зардал дээр стандарт хазайлтын утгыг (SD) нэмнэ.

Стандарт хазайлтыг өөдрөг ба гутранги үнэлгээний зөрүүг үндэслэн тодорхойлно (томуёо (62)):

$$SD = \frac{cO - cP}{6} \quad (62)$$

Стандарт хазайлтын утга нь төслийн эрсдэлийн түвшинг харуулж байгаа бөгөөд 2,901,837 мянган рубльтэй тэнцэнэ.

Төслийн зардлын хүрээний нарийвчлалыг нэмэгдүүлэхийн тулд сайжруулсан томьёо (63) ба (64)-г ашигладаг.

$$\text{Range start} = cE - SD * n, \quad (63)$$

$$\text{Range finish} = cE + SD * n. \quad (64)$$

Энд: n – нарийвчлалын коэффициент.

Нарийвчлалын өөр өөр стандарт түвшний төслийн хил хязгаарыг нарийвчлалын коэффициентийн утгыг харгалзан хүснэгт 57-д үзүүлэв.

Хүснэгт 57 Төслийн NPV утгын хил хязгаарын тодорхойлолт, мян. руб.


Нарийвчлал	n	Доод хязгаар	Дээд хязгаар
68%	1	31675369	37479043
90%	1,645	29803684	39350728
95%	2	28773532	40380880
99,7%	3	25871695	43282717

Үзүүлэлтийн утгыг үнэлэх хүрээний нарийвчлал өндөр байх нь NPV үзүүлэлтийн утгын хүрээг нэмэгдүүлж, үүний дагуу эрдэст нөөцийн утгыг ч бас нэмэгдүүлдэг.

5.4 Эрдсийн хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнийг үнэлэх үед уул уурхайн үйлдвэрүүдэд гарсан ослын эдийн засгийн хохирлын үнэлгээ

Уул уурхайн салбартай холбоотой тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд хийсэн дүн шинжилгээ нь орчин үеийн уул уурхайн үйлдвэр нь ажилчид, албан хаагчид, өмчлөгчид, төрийн байгууллагууд, орон нутгийн хүн ам гэх мэт бүх сонирхогч талуудад нөлөөлдөг болохыг харуулсан. Тэдгээрийн гүйцэтгэж буй үүрэг, зорилго, хариуцлагаас нь хамааран тэдний сонирхол өөр өөр байна [34].


Уул уурхайн салбар нь янз бүрийн сонирхогч талуудад ихээхэн хэмжээний сөрөг нөлөө үзүүлдэг эдийн засгийн салбаруудын нэг юм (Зураг 5.23, уул уурхайн нөлөөлөлд зориулан гаргасан 50 эрдэм шинжилгээний эх сурвалжийн түүвэрт үндэслэсэн).



Эдийн засаг, Ажил эрхлэлт ба боловсрол Газар ашиглалт Хүн ам зүй Экологи, Эрүүл мэнд, Хүний



Зураг 74 Шинжлэх ухааны зохиолд холбогдох сэдвийг дурьдах харьцангуй давтамж Дурдсан сөрөг үр дагавар нь эерэг үр дагавараас 2.5 дахин их байна. Энэ нь уул уурхайн салбар байгаль орчин, нийгэмд ихээхэн сөрөг нөлөө үзүүлдэг, мөн осол аваар их гардаг гэдгийг харуулж байна. Байгаль орчин, технологи, цөмийн хяналтын Холбооны албанаас гаргасан мэдээлийн дагуух 2001-2016 онуудад гарсан осол, хүний амь нас хохирсон гэмтлийн динамик нь үүнийг баталж байна (Зураг 75).



Зураг 75 Ашигт малттмалын гүний олборлолтын болон шороон ордын ил уурхайн боловсруулалтын объект дахь ослын болон үхлийн тохиолдлуудын динамик

Статистик мэдээнд зөвхөн ослын тоог тооцсон бөгөөд золгүй тохиолдлын тоог оруулаагүй болно. Сүүлийн таван жилийн тухайд гэвэл 2016 оноос хойш “олборлол-осол” харьцаа буурч эхэлсэн бол одоо дахин өсөж эхэлсэн байна .

Ослын өндөр түвшин нь хохирлын өндөр түвшинг тодорхойлдог.

Уул уурхайн салбарт онцгой байдлын улмаас учирсан хохирлын тооцоог ОХУ-ын Госгортехнадзорын 2002 оны 10-р сарын 29-ний өдрийн 63 тоот тогтоолоор батлагдсан Үйлдвэрлэлийн аюултай объект дээр гарсан ослын хохирлыг үнэлэх арга зүйн зөвлөмжийн дагуу гүйцэтгэдэг. Тэдгээрийн дагуу ослын нийт хохирол нь тодорхой хохирлын нийлбэр байх бөгөөд (65) томъёогоор тодорхойлогддог.

$$Y = \Pi_p + Z_l + Y_k + \Pi_c + Y_e + \Pi_{tp}, \text{ руб.}, \quad (65)$$

Энд: Π_p – компанийн шууд алдагдал, руб.;

Z_l – ослыг арилгах, мөрдөн шалгах зардал, руб.;

Y_k – шууд бус хохирол, руб.;

Π_c – нийгэм-эдийн засгийн хохирол, руб.;

Y_e – экологийн хохирол, руб.;

Π_{tp} – хөдөлмөрийн нөөц алдагдсанаас үүдсэн алдагдал, руб.

Компанийн шууд алдагдалд үндсэн хөрөнгийн сан, бараа материалын үнэ цэнэ болон гуравдагч этгээдийн өмчид учирсан хохирол орно. Үүний дагуу, осол гарсан тохиолдолд олборлолтын ажлын хязгаарлагдмал орон зайнаас шалтгаалан тоног төхөөрөмжийг засварлахын тулд гадаргуу дээр гаргахад хүндрэлтэй, өндөр өртөгтэй тул тоног төхөөрөмж ихээхэн эвдэрдэг бөгөөд, мөргөцөгт үлдээнээс ашиглах боломжгүй болдог. Уул уурхайн үйлдвэрлэлийн бусад салбараас ялгарах гол ялгаа нь уурхайн олборлолт гэх мэт онцгой хөрөнгө юм. Эдгээр хөрөнгө нь үл хөдлөх хөрөнгө бөгөөд бүрэн хохирол нь уул уурхайн үйлдвэрийн хувьд ихээхэн хэмжээний зардал учруулдаг. Мөн 30 гаруй төрлийн ажлыг багтаасан малталтын ажлын их засварын зардал ихээхэн байж болно.

Уул уурхайн салбарт гарсан ослыг арилгах, мөрдөн шалгах зардал ч ихээхэн хэмжээтэй байдаг. Ослын шалтгааныг судлах ажлыг Экологи, технологи, цөмийн хяналтын холбооны албаны комисс гүйцэтгэдэг. Ослыг арилгах арга хэмжээний бүрэлдхүүнд ослын төрөл, уурхайн малталтын байдал гэх мэт янз бүрийн арга хэмжээ багтаж болно. Тухайлбал, 2016 онд “Северная” уурхайд дэлбэрэлт болсны дараа Техникийн зөвлөлөөс “Уурхайн аманд, метан шатаж байгаа газарт хаалт тавьж, агаарыг азотоор шахаж, галыг унтраах” [163] санал гаргаж байсан. Гэвч, энэ нь уурхай руу хүмүүсийг буулгах шаардлагатай байсан боловч хэд хэдэн удаа дэлбэрэлт болсон тул үүнийг хийх боломжгүй болсон байна. “Северная” уурхайн сэргээн босголтын тухайд шинжээчид уг ажлын өртөгийг 120-150 сая ам.доллар гэж тооцсон байдаг. Эдгээр зардалд нийт 10 км урттай малталтын талбайн погон метр тутамд 100,000 орчим рублийн өртөгтэй малталтын ажлыг дахин хийх зардал, дэлбэрэлтээс болж геологийн үзүүлэлтүүд өөрчлөгдсөний улмаас талбайн ашиглалтын төслийг шинэчлэх зардал, уурхайг усгүйжүүлэх зардал, цахилгааны зардал багтсан. Харьцуулан хэлэхэд, 2010 онд дэлбэрэлт болсон “Распадская” уурхайг сэргээхэд 196 сая ам.доллар зарцуулсан байна.

Шууд бус хохирол нь албадан сул зогсолт, үүнтэй холбоотой зардал, түүнчлэн торгууль, алдангийг тооцдог. Өөр зардал ч гарч болох магадлалтай. Жишээлбэл, “Северная” уурхайд үерийн улмаас нүүрсний чийгшил нэмэгдэж, энэ нь нүүрсийг хатаах зардал гарсан. Сул зогсолтын хэмжээ нь ослын цар хүрээнээс хамаардаг.


Тэгэхээр, “Северная” шиг их хэмжээний хохирол учирсан тохиолдолд нөхөн сэргээх хугацаа дор хаяж нэг жил байна. “Распадская” нь таван жилийн дараа л олборлолтын хэмжээгээ сэргээж, ослын өмнөх түвшинд хүргэж чадсан.

Нийгэм-эдийн застгийн хохирол нь ажилтнууд нас барсан, гэмтсэн тохиолдолд нөхөн олговор олгох зардлыг илэрхийлдэг. 2012 онд “Аюултай объект дээр ослын улмаас хохирол учруулсан объектын эзэмшигчийн иргэний хариуцлагын албан журмын даатгалын тухай” Холбооны хууль хүчин төгөлдөр болсон. Уул уурхайн үйлдвэрүүд нь аюултай үйлдвэрлэлийн объектын ангилалд багтдаг тул хуульд заасан нөхөн олговрын төлбөр тэдгээрт ч адил хамаарна. Нэг хүн нас барсны улмаас үйлдвэрлэлээс гарсан хөдөлмөрийн нөөцийн алдагдлыг нэг ажилчин нас барсны улмаас ажил хийгээгүй ажлын өдрийн тоог ажилчны гүйцээж авч чадаагүй ашгийн хувь хэмжээний үржвэрээр тодорхойлно.

Уул уурхайд уул-геологи, уул-техникийн эрсдэлийн бууралтыг хангадаг тоон геомеханикийн ихрийг нэвтрүүлсний үр дүнд эрдсийн хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлтийн эдийн застгийн үнэлгээг компанийн алдсан ашиг хэмээн ойлгож болох алдагдсан ашгийн хэмжээгээр хийж болно. Хүснэгт 5.16-д бокситын ордын олборлолтын явцад болзошгүй

аюултай бүс (БАБ) дэх хүдрийн хэмжээ, талбай, хүдрийн цулыг үе давхраасаар нь харуулав.

Компьютерийн загварчлалын үр дүнд тулгуурлан БАБ-ийн тоог тодорхойлж, дараа нь хүдрийн оршдосын зузаан 3 м, хүдрийн хувийн жин 3 т/м³ байх үед БАБ дэх хүдрийн талбай, массыг тодорхойлсон (Зураг 76, Хүснэгт 58)



Зураг 76 Бокситын ордын олборлолтын үеийн уурхайн ажлын хүрээн дэх болзошгүй аюултай бүсийн (БАБ) тоон хуваарилалт

Хүснэгт 58 Бокситын ордын олборлолтын үеийн болзошгүй аюултай бүс дэх хүдрийн алдагдал

Давхаргын үе	Болзошгүй аюултай бүсийн тоо	Болзошгүй аюултай бүсийн талбай, м ²	Болзошгүй аюултай бүс дэх хүдрийн жин, тонн
-323 м	94	2350	21 150
-348 м	101	2 525	22 725
-360 м	144	3 600	32 400
-375 м	123	3 075	27 675
-380 м	178	4 450	40 050
-390 м	300	7 500	67 500
-406 м	358	8 950	80 550
-420 м	122	3 050	27 450
НИЙТ	1 420	35 500	319 500

БАБ дэх 1 м² цооногийн урсацын тооцоолсон өртөг нь 5000 рубль., (геотехникийн туршилтгүйгээр) бүх БАБ-ийн өрөмдлөгийн нийт зардал нь 177,500 мян.руб. болно. Осол гарч, мөрдөн шалгах ажиллагааны явцад хүдэр олборлох үед үйлдвэрлэлийн зогсолтоос үүссэн хохирлыг уг ослыг арилгахад гарсан бодит зардал, газрын гүн дэх эрдсийн түүхий эдийн алдагдал, компанийн алдагдсан ашгийн нийлбэрээр үнэлж болно. Газрын хэвлий дэх нөөц бүрэн алдагдсан тохиолдолд тооцоо гаргахдаа алдагдлын хэмжээг харгалзан олборлогдсон үнэ цэнэ болон хүдэр олборлох өртгийг тооцно.

Жишээлбэл, давхаргын хувьд: Газрын хэвлий дэх 323 м хүдрийн нөөцийн алдагдал нь 21,150 мян.тонн байж болно.

Олборлогдож буй эрдэст түүхий эдийн үнэ цэнийн тооцоог зах зээлийн үнэ, зохицуулалттай үнэ эсвэл дотоод үнэд (нэгдсэн нэг компанийн өөр өөр салбарууд эсвэл компаний нэгдсэн нэг группын гишүүдийн хооронд тогтоосон үнэ) үндэслэн хийж болно. Газрын хэвлий дэх нөөцийн алдагдлаас үүсэх хохирлын эдийн засгийн үнэлгээний хувьд зах зээлийн үнийг ашиглах нь илүү үндэслэлтэй ч компанийн бодит алдагдсан ашгийг дотоод үнээр тодорхойлдог. Газрын хэвлий дэх хүдрийн нөөц алдагдсанаас нийгэмд учирч буй алдагдалд төсвийн нийт орлого, татвар, ДНБ-ний алдагдал, түүнчлэн бусад салбар дахь мультиплекатив нөлөөлөл зэрэг болно. Асуудал нь "сүүдрийн үнэ", өөрөөр хэлбэл төрийн зохицуулалтын нөлөөллөөс ангид зах зээлийн үнийг сонгох ёстой нийгмийн алдагдлыг тооцоолох үнийн тооцоо юм. ОХУ-д ийм үнийг тооцоолох аргачлал хараахан боловсруулагдаагүй байна.

Лондонгийн металлын биржид 2022 оны 4-5 дугаар сард хөнгөн цагааны үнэ 2700 ам.доллар байсан ба сүүлийн 10 жилийн дундаж үнэ нэг тонн нь 2200 ам.доллар байв. Goldman Sachs-ийн таамаглалаар хөнгөн цагааны дундаж үнэ 2022 онд тонн тутамдаа 3450 ам.доллар (Зураг 5.26), 2023 онд 3850 ам.доллар, 2025 онд 5000 ам.долларт хүрч магадгүй байна.

Зураг 77 Хөнгөн цагааны үнэ



Дотоодын зах зээл дэх хөнгөн цагааны үнийг Холбооны монополийн эсрэг албаны журмын дагуу зохицуулж, тогтоодог.

ОХУ-ын нутаг дэвсгэрт дээр хөнгөн цагааныг худалдах анхдагч үнэ нь (66) томъёоны дагуу EXW эсвэл FCA (үйлдвэрээс) үндэслэн тооцсон үнээ (P1) хэтрэхгүй байх ёстой:

$$\Pi_1 = LME1 + \Pi_{A7}, \quad (66)$$

Энд: LME1 - Лондонгийн металлын бирж (LME / LME) дээрх тухайн үеийн тодорхой маркийн хөнгөн цагааны үнийн дундаж утга.

$$\Pi_{A7} = \Pi_{\text{прег}} - \Lambda_\phi - \Lambda_n, \quad (67)$$

Энд: $\Pi_{\text{прег}}$ – холбогдох бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үндсэн сегмент дэх тодорхой

маркийн хөнгөн цагааны бүс нутгийн дээд зэргийн үзүүлэлтийн дундаж утга, "Русал" компани нь дэлхийн зах зээлийн бусад сегментүүдтэй харьцуулахад хамгийн их бараа бүтээгдэхүүн экспортлодог.;

Л_ф – ОХУ-ын нутаг дэвсгэр дэх боомтоос "Русал" компанийн ачаа тээвэрлэлтийн логистикийн бодит зардлын жигнэсэн дундаж;

Л_п – Ачилт хийгдэх сараас өмнөх 3 дахь сарын ачааг хөлөг онгоц руу шилжүүлэн ачих боомтын зардлыг тооцсон Оросын Холбооны Улсын гол боомт руу хөнгөн цагааныг үйлдвэрүүдээс хургэх Русал компанийн логистикийн бодит зардлын жигнэсэн дундаж.

Дотоодын зах зээлийн үнэ нь LME биржийн үнэд суурилдаг тул алдагдсан ашгийг тооцоходоо биржийн үнийг ашигладаг. Ирээдүйн алдагдлыг үнэлэхдээ өсөх хандлагатай байгаа урьдчилсан үнийг ашиглах ёстой. Тооцооллыг хоёр давхрагад, хамгийн бага ба хамгийн их тооны БАБ-д хийсэн. Боксит түүхий эдийн хувьд зах зээлийн үнэ нь янз бүрийн үнэлгээгээр 80-200 ам.доллар/тн байгааг нэг тонныг нь 10,000 рублиэр, хүдэр олборлох зардлыг 3000 рубль/тн байхаар тооцсон. Тэгэхээр, компанийн хувьд давхраас дахь нөөцийн алдагдал нь цэвэр ашгийн хувьд - 323 м байх болно: (10000-3000) x 21.150 x (1-0.2) = 118440 мян. руб. байна.

Давхраас - 323 м дахь БАБ-ийн өрөмдлөгийн зардал нь 2350x5000 = 11750 мян. руб. байна

Тэгэхээр, жилд 2 сая тонн үйлдвэрлэх хүчин чадалтай төлөвлөгөө нэг бол 15%-иар биелэхгүй, эсвэл 15-20%-ийн нөөцтэй байх шаардлагатай болж байгаа нь төслийн хөрөнгө оруулалтын зардлын 10%-иас давсан байна. POD-ийг тэнгэрийн хаяанд өрөмдөх зардал - 323 м 8950 x5000 = 44750 мянган рубль байна. Давхраас-323 м дахь БАБ-ийн өрөмдлөгийн зардал нь 8950 x5000 = 44750 мян. руб. байна.

Энэ тохиолдолд, дижитал геомеханикийн аналогийг ашиглан – 323 м-ийн давхраасын жишээн дээр тодорхойлсон БАБ-ийн өрөмдлөгийн зардал нь олборлосон хүдрийн цулын үнэ цэнээр тооцсон цэвэр ашгийн 10 орчим хувийг эзэлж байна. Давхраас -323 м нь хамгийн бага тооны боломжит аюултай бүстэй. БАБ 358 нэгжийн тоотой давхраас - 406 м-ын ижил төстэй тооцоог хийхэд БАБ-ийн өрөмдлөгийн зардал нь олборлосон хүдрийн цулын үнэ цэнээс тооцсон цэвэр ашгийн 10 орчим хувийг эзэлж байна. Гэсэн хэдий ч, үнэмлэхүй утгаараа цэвэр ашгийн алдагдал ихээхэн нэмэгдэж, дараах хэмжээтэй байна: (10,000-3,000)x80,550 x (1-0.2) = 451,080 мян. руб.

Бүлгийн дүгнэлт

Нүүрсний ордын жишээ болгон Куан Нинь ордын гүн дэх нүүрс олборлолтын алдагдлыг харгалзан ашигласан нүүрсний нийт нөөцийн үнэ цэнийг 2020 онд 3557.1 сая доллар байсныг тодорхойлсон. Нүүрсний нөөцийн үнэ цэнийг одоо байгаа технологи, нөөцийн ашиглалтын нөхцөлд 2040 он хүртэлх нөөцийн нийт үнэ цэнээр тодорхойлсон. 2020-2040 он хүртэл энэ нь 3283.4 сая доллар байсан. Дараагийн хугацаанд нэмэлт олборлолтын алдагдал 273.7 сая доллар байсныг тооцож гаргасан. Энэ нь 2020 он гэхэд эрдсийн хөрөнгийн тохируулсан үнэ 8.4%-иар өссөн гэсэн үг юм.

Уул уурхайн олборлолт, бэлтгэл ажлын механикжуулалт, автоматжуулалтын түвшинг дээшлүүлэх арга хэмжээ, боловсруулах системийг боловсронгуй болгох; илүү бүтээмжтэй машин механизм ашиглах; үйлдвэрлэлийн байжуулалтыг нэмэгдүүлэх; цогц төлөвлөгөөг хэрэгжүүлэх; орчин үеийн материалыг ашиглах (эрчим хүч, тэсрэх бодис гэх мэт); хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй байдлыг сайжруулах нь эрдсийн хөрөнгийн үнэ

цэнийг өөрчлөхөд хувь нэмэр оруулдаг болохыг харуулж байна.

Судалгааны ажлын практик ач холбогдол нь түүхий эдийн олборлолт болон боловсруулалтын шинэлэг шийдлийг нэвтрүүлэх үед эрдсийн хөрөнгийн нэмэлт үнэ цэнийг үнэлэх зорилгоор түүнийг ашиглах боломжийг нотолсон тодорхой судалгааны аргачлалыг судлахад оршино. Алтны хүдрийн ордуудыг боловруулах явц дахь эрдэст нөөцийн үнэ цэнийн өөрчлөлтийг харуулав.

Бүгд Найрамдах Тува улсын Элегестийн нүүрсний ордын олборлолтын талбайн төслийн эрсдлийн үнэлгээний жишээн дээр ийм төслүүдийн гол эрсдэлүүдэд: дэлхийн нүүрсний үнийн хэлбэлзэл; CO₂ ялгаруулалтын шаардлагын чангатгал; Тува улсын тээврийн системийн нэвтрэх чадварын хязгаарлалт; EX болон Ази Номхон далайн орнууд дахь Оросын нүүрсний хэрэглээний бууралт; OХУ-ын нүүрс худалдан авахад EX болон АНУ-аас тавьсан хориг; Барууны орнуудын зүгээс Оросын эсрэг идэвхтэй хориг арга хэмжээ авч байгаа бодлого орж байгааг баталсан. Тус төсөл нь Бүгд Найрамдах Тува Улс, Красноярскийн хязгаар нутагт Элегест-Кызыл-Курагино чиглэлийн төмөр зам баригдсантай холбоотойгоор бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд нэмэлт нөлөө үзүүлж байгаа; Бүгд Найрамдах Тува Улсаар дамжин Орос, Монгол, Хятадыг холбосон олон улсын агаарын тээвэр, авто тээвэр, төмөр замын коридор бий болгох; Монголоор дамжуулан Ази Номхон далайн орнуудад их хэмжээний нүүрс борлуулах боломжтой байгаагаараа ялгаатай болохыг илрүүлсэн.

Аюултай үйлдвэрлэлийн объектод ослоос учирсан хохирлыг үнэлэх арга зүйн хандлагын дүн шинжилгээ нь уул уурхайн үйлдвэрийн газрууд, тэр дундаа далд уурхайн олборлолтод бүрэн ашиглаж болохыг харуулж байна. Нэмэлт судалгаа шинжилгээ, техникийн арга хэмжээ аваагүй тохиолдолд эрдэст түүхий эдийн нөөц алдагдсанаас үүсэх эдийн засгийн хохирлын тооцоог хийж гүйцэтгэсэн. Дижитал загвар нэвтрүүлэх нь хүдэр олборлолтыг нэмэгдүүлэх, эрдэст нөөцийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд нөлөөлж байгааг харуулж байна.

ЕРӨНХИЙ ДУГНЭЛТ

“Баялгийн баримжаатай эдийн засагтай орны эрдэс түүхий эдийн цогцолборын үнэлгээний аргачлалыг тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан боловсруулах онолын судалгаа” сэдэвт эрдэм шинжилгээний ажлыг гүйцэтгэх явцад дараах онол-практикийн үр дүнд хүрсэн байна. Үүнд:

1. Төслийн нийгмийн үр ашгийн үнэлгээний аргачлалыг гадаадын болон өөрийн орны хүрээнд хийсэн судалгааны үндсэн дээр дараах зүйлийг тогтоов.
 - Үндэсний санхүү эдийн засгийн болон зах зээлийн систем, эрдсийн түүхий эдийн эрх зүйн салбарын онцлогийг харгалзах зайлшгүй шаардлагыг үндэслэж үзвээс хөгжилтэй орнуудад хэрэглэх эдийн засгийн судалгааны Европын аргачлалын дагуу уул уурхайн төслийн үнэ, мөнгөний урсгалыг өөрчлөх боломж хязгаарлагдмал (зарим тохиолдолд хориотой) байна.
 - Орос улсын амьдралд төслийн эдийн засгийн чиглэлтэй судалгааг нийгэм-экологийн хүчин зүйлийг нийгэм-эдийн засгийн хүчин зүйлтэй хамтатгах онцлогтой бөгөөд энэ нь төслийн оролцогчдын (стейкхолдеруудын) тэр дундаа улсыг оролцуулсан орлогыг нэмэгдүүлэхэд чиглэгддэг байна. (үүгээрээ гадаадын практикаас ялгаатай байна).
Батлагдсан аргачлалын зөвлөмжид төслийн нийгмийн үр ашгийг улсын санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөл гэж үзэж буй болно.
2. Эрдсийн хөрөнгийн үнэ цэнийн үнэлгээнд төрөл бүрийн төвшний болон зорилго бүхий аргачлалыг тогтвортой хөгжлийн нөхцөлд цогцоор хэрэглэх үндсэн дээр боловсрогдсон аргачлалын хандлагын агуулгыг нээж харуулсан тодорхойлолтыг өгөхдөө дараах зүйлийг тусгасан:
 - Ашигт малтмалын ордыг ашиглах, анхан шатны боловсруулалтыг болзошгүй эрсдлийг тусгасан уул геологийн технологийн болон зохион байгуулалтын хүчин зүйлүүдийн эдийн засгийн үнэлгээ
 - Эрдсийн түүхий эдийн ордын, эрдсийн түүхий эдийн онцлог чанар болон олборлох, боловсруулах арга ба эрсдлийг бодолцсон эдийн засгийн үнэлгээ
 - Эрдсийн хөрөнгийн нийгэм-экологийн ба нийгмийн үнэ цэнийн үнэлгээ
3. Эрдсийн хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнийг тодорхойлох шинжлэх ухааны үндэслэлтэй горимын алгоритмыг боловсруулав. Үүндээ үнэлгээний суурь загварын сонголт ба үндэслэлийг тусгасан. Суурь загварт өөрчлөлт оруулах, урьдчилсан загвар боловсруулахдаа орлогын хүчин зүйлийн нөлөөллийг тусгах, зардал бүрдүүлэх хүчин зүйлийн цогц загвар боловсруулах, эрдсийн хөрөнгийн үнэлгээнд уулын эрсдлийг тусгах саналыг боловсруулав.
4. Эрдсийн хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнийн үнэлгээний урьдчилсан загварыг (детерминированная модель) тогтвортой хөгжлийн болон эргэлтийн эдийн засгийн нөхцөлд ашигт малтмалын ордыг ашиглах төслийн эдийн засгийн үр ашгийг хангах нөхцөлтэйгөөр боловсруулсан болно. Ингэхдээ эрдсийн хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлтийн хүчин зүйлийн дараах нөлөөлийг тооцоолов:
 - 1) Ашигт малтмалын нөөцийн газрын хэвлэйд үлдэх хаягдал (уул-геологийн ашиглалтын технологийн нөхцлөөс шалтгаалсан тогтоосон (норматив) хэмжээнээс давсан хаягдал)
 - 2) Эрдсийн түүхий эдийн хаягдал нөөцийг ашиглах (шинэ технологи нэвтрүүлэх замаар)

- 3) Уулын үйлдвэрийн боломжит хаягдлыг эргүүлэн ашиглах
- 4) Эрдсийн түүхий эдийг иж бүрэн ашиглах боломж
5. Нийгмийн эрэлтийн хөнгөлөлтийн үнэдслэл ба ордын ашиглалтаас авах орлогын үечлэлийн хандлагын үнэдслэлийг тогтоохдоо ашигт малтмалын газрын хэвлэй дэх хаягдал, уулын үйлдвэрийн хаягдлыг ашиглах, эрдсийн түүхий эдийг иж бүрэн ашиглах үзэл баримтлалыг тусгасан болно.
6. Эрдсийн хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнийг тодорхойлохдоо хөндлөнгийн үр ашгийг орхих, загварт технологийн процессийн бүрэлдэхүүнийг зөвхөн олборлолт, боловсруулалтаар хязгаарласан зэргийг нотлов.
7. Эрдсийн хөрөнгийн ордыг ашиглахдаа гадаад үр ашгийн өсөлтийг баялаг ашиглагчдаас нэмэгдэл үнэлгээ хийхийг шаарддаггүй юм байна. тийм учраас эрдсийн хөрөнгийн эдийн засгийн үнэлгээний шинэчилсэн загварт уулын үйлдвэрийн хаягдлыг боловсруулах, ашигт малтмалын нөөцийн алс хэтийн бодит эх үүсвэр болно гэж үзэж гадаад үр ашгийн тооцоонд тусгаж байхыг санал болгов. Иймэрхүү үр дүн нь тогтвортой хөгжлийн зорилго, зарчимд эргэлтийн эдийн засагт нийцнэ гэж үзсэн болно.
8. Эрдсийн хөрөнгийн үнэ цэнийн өөрчлөлтөд нөлөөлөх үндсэн хүчин зүйлүүдийг тодорхойлж тэдгээрийн ангиллыг тогтоосон байна. Эрдсийн түүхий эдийн олборлолт, анхан шатны боловсруулалтын зардал, үүсгэх хүчин зүйлүүд, уулын үйлдвэрийн зардлын хэмжээний харилцан хамаарлын загварыг боловсруулсан. Эрдсийн хөрөнгийн үнэ цэнийн үнэлгээний урьдчилсан загварт олборлолт, боловсруулалтын зардлыг тусгасан. Эдийн засаг-математикийн үндсэн 10 хүчин зүйлийн цогцолбороог томъёолсон болно.
9. Эрдсийн хөрөнгийн өөрчлөлтийн үнэлгээний боловсруулсан аргачлалд ашигт малтмалын олборлолтын өөрийн өртгийн өөрчлөлттэй холбоотой 5 бүлэг хүчин зүйл, тэдгээрийн үндсэн дээр 8 загвар тусгагдсан байна.
Баяжуулалтын өөрийн өртгийн өөрчлөлтийг тусгасан 3 бүлэг хүчин зүйл, тэдгээрийн үндсэн дээр 2 үндсэн загвар тусгагдсан болно.
10. Судлаачдын боловсруулсан хүчин зүйлийн загваруудад эрдсийн хөрөнгийн үнэ цэнийн үнэлгээний урьдчилсан загвар багтсан байна. Энэ нь ордын ашиглалтын техник эдийн засгийн үр ашгийн эрдсийн хөрөнгийн үнэ цэнийн үнэлгээний үзүүлэлтэд нөлөөллийг тусгах боломжтой бөгөөд тогтвортой хөгжлийн болон эргэлтийн эдийн засгийн зорилго шаардлагад нийцэж байгаа юм.
11. Уул уурхайн төслийн үндсэн эрсдлүүдийн ангиллыг гүйцэтгэж нүүрсний болон хүдрийн ордыг ашиглах төслийн үзүүлэлтэд ашигт малтмалын нөөц нотлогдохгүй байх болон бусад зөрчлийн нөхцөлд уулын үйлдвэрийн эрсдлийг үнэлэх зөвлөмжийг санал болгосон байна.
12. Эрдсийн хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнийг үнэлэх детерминированный болон недетерминированный загварууд хүчин зүйлийн цогц загварыг Орос, Монгол, Вьетнамын уул уурхайн төслүүд дээр туршилт хийсэн байна. Туршилт хийсэн объектуудад нүүрс, алт, зэсийн, хөнгөнцагааны ордууд хамрагдсан бөгөөд тэдний жишигээн дээр тооцоонууд хийгдсэн байна.
 - Газрын хэвлэйд орхигдож байгаа нүүрсийг ашиглах замаар нүүрсний ордын үнэ цэнийг өсгөх

- Технологийн болон инновацийг нэвтрүүлэх замаар хүдрийн нөөцийг ашиглах эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, алтны ордын үнэ цэнийг өсгөх
- Зэсийн болон хөнгөнцагааны ордод тоон, геомеханикийн хослолыг хэрэглэх замаар үнэ цэнийг нь өсгөх тооцоог хийжээ. Эрдсийн хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнийг үнэлэх эдийн засаг-математикийн загварт эрсдлийг болон ордын ашигт малтмалын ашиглалтын үр ашгийг үнэлэх арга хэрэгслийг сонгож тэдгээрийн тусlamжтайгаар Тува улсын нүүрсний ордыг ашиглах төслийн гол эрсдлүүдийн үнэлгээг хийж, түүний эрдсийн эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тодорхойлсон байна.

13. Энэхүү судлагаагаар:

Баялгийн баримжаатай эдийн засагтай улс орны эрдсийн түүхий эдийн үнэ цэнэ бүрэлдэх үзэл баримтлал нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай нягт уялдаж “Эрдсийн хөрөнгийн эдийн засгийн үнэ цэнийн үнэлгээний загвар болох онолын үндэслэлтэй” болохыг тогтоосноор судалгааны ажлын зорилго хангагдсан байна.

Ном зүй

1. Пономаренко Татьяна Владимировна д.э.н профессор, Невская Марина Анатольевна к.э.н, Очирбат Пунсалмаа, д.э.н
Эрдэс түүхий эдийн шавхагдлыг тогтвортой хөгжилтэй уялдуулан үнэлэх аргууд.
УДК 338.5.622
Методы оценки истощения минерально-сырьевых ресурсов в контексте устойчивого развития.
2. Очирбат П, Пономаренко Т.В, Дамбаева И.Ж.
Уулын олборлох үйлдвэрийн нийгмийн лиценз нь хариуцлагатай бизнесийн бодлогын чухал бүрэлдэхүүн хэсэг мөн. Уул уурхайн сэтгүүл. 2020 оны №1;2. (26-30-р тал)
3. Пономаренко Татьяна Владимировна, Курякова Кристина Николаевна, Очирбат Пунсалмаа
Баялгийн баримжаатай эдийн засагтай орны тогтвортой хөгжилд эрдсийн түүхий эдийн салбарын нөлөөллийн үнэлгээ (Монголын жишээн дээр)
Оценка влияния минерально-сырьевого сектора на устойчивое развитие стран с ресурсно-ориентированной экономикой (на примере Монголии)
4. Очирбат П, Чанцалмаа Б, Пономаренко Т.В
Монголын уул уурхайн аж үйлдвэрийн төрөлжүүлэлтийн (диверсификаций) стратегийн үнэлгээ
“Оценка стратегии диверсификации горнопромышленного производства Монголии”. Уул уурхайн сэтгүүл. 2021. №1;2 (стр 18-24)
5. Очирбат Пунсалмаагийн
Некоторые особенности правовой институциональной системы природопользования Монголии. Горная промышленность. №3-2021 (стр 68-71)
6. Очирбат Пунсалмаагийн

Угольная промышленность Монголии: состояние и перспективы развития. Записки горного института 2017. Т 226 (стр 420-427 Горное дело)

7. Уугантуяа Г.
Ашигт малтмалын ордыг ашиглахад уул уурхай, геологийн хүчин зүйлс, уул уурхайн нөхцлийг үнэлэх (Эрдэнэт, Оюу толгойн жишээн дээр)
8. Очирбат Пунсалмаа, Чинзориг Бавуу
“Тогтвортой хөгжил-2030” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд уул уурхайн чиглэлийн их сургуулиудын хамтын ажиллагааг өргөжүүлэх асуудалд
9. Чинзориг Бавуу
Текущая и будущая роли горной отрасли в экономике (Участие в национальном и региональном развитии) VI МЕЖДУНАРОДНЫЙ ЭКОНОМИЧЕСКИЙ СИМПОЗИУМ – 2022. St Petersburg State University.
10. Очирбат Пунсалмаагийн. Монгол Улсын Үндсэн хууль. Хэрэгжилт, хяналт, судалгаа. 2017 он. (Үндсэн хуулийн зургадугаар зүйл 35-54-р тал)
Конституция Монголии: Реализация, контроль, анализ. 2017г. (Глава шестая конституции. Страница 35-54)
11. Эрдэс баялгийн эрх зүйн тойм. 2012 он. Ерөнхий редактор Б.Гүнбилэг, И.Идэш.
Хууль зүйн үндэсний хүрээлэн. Правовой обзор минерального сырья. 2012г. Под главной редакцией Б.Гүнбилэга и И.Идэша.
12. Очирбат Пунсалмаагийн. Стратегия и развития минерально-сырьевого комплекса Монголии. М.2007г.
13. Очирбат Пунсалмаагийн. Нүүрсний аж үйлдвэрийн тогтвортой хөгжлийн шинэ чиглэл. Боть-1. 2021 он.
Новое направление устойчивого развития угольной промышленности. Том 1. 2021г.
14. Очирбат Пунсалмаагийн. Нүүрс-химийн аж үйлдвэрийн хөгжлийн стратеги. Боть-2. 2021 он.
Стратегия развития уголь-химической промышленности. Том-2. 2021г.
15. Очирбат Пунсалмаагийн. Дэлхийн алтан хэвлэй. Улаанбаатар. 2021 он.
Золотой недр земли. Улаанбаатар. 2021г.
16. Очирбат Пунсалмаагийн. Оюу толгой: Эрт, эдүгээ, ирээдүй. Улаанбаатар. 2010 он.
Оюу толгой: Прошлое, настоящее, будущее. Улаанбаатар. 2010 он.
17. Уул уурхайн эдийн засаг. Редактор П.Очирбат. Улаанбаатар. 2019 он.
Экономика, бизнес, менежмент горной промышленности. Том-IV. (Под редакцией Очирбат). Улаанбаатар. 2019г.
18. Очирбат Пунсалмаагийн. Когда закончится угольное царство? (стр 205-209)
Россия и Монголия: результаты и перспективы научного сотрудничества. Труды международной научной конференции. Иркутск. 2022г. стр 205-209.
19. Стандарт внешнего государственного аудита (контроля) СТА 304 «Аудит государственных и международных инвестиционных проектов» (утв.постановлением Коллегии Счетной палаты Российской Федерации, от «23» декабря 2016г. №8ПК).
20. Романова А.Т., Попова М.В. О методах оценки общественной эффективности крупных инвестиционных проектов. //Актуальные проблемы науки и практики современного общества. -№1-2016. DOI 10621681/2311-5351-2016-1-9-14

21. Агеева А.Ф. Критерии эффективности общественной значимых инвестиционных проектов и их расчетные формулы, принятые в российской практике. //Экономика и управление: проблемы, решения. -2020. –Т.2. –№8. –С. 58-64. DOI:10.34684/ek.up.p.r.2020.08.02.007
22. Орлова Е.Р., Сафин Р.Н. Оценка общественной эффективности инвестиционных проектов в современной России. //Труды Института системного анализа РАН-2011- Т.61-№3. –С. 53-64.
23. Агафонцев Е.А. Роль государства при оценке экономической эффективности эксплуатации месторождений полезных ископаемых. //Интернет-журнал «Наукаведение» -Т.7 -№6 -2015.
24. Фрадин И.М. Систематизация отечественных и зарубежных методик оценки общественной эффективности инвестиционных проектов. //Цифровая и отраслевая экономика. – ВГТУ - 2020. - С.134-138.
25. 21. Михеева Н.Н., Новикова Т.С., Суслов В.И. Оценка инвестиционных проектов на основе комплекса межотраслевых межрегиональных моделей //Проблемы прогнозирования. – 2011. – №4. – С. 78–90.
26. Приказ Минприроды России от 04.09.2018 N 413 (ред. от 14.10.2020) "Об утверждении официальной статистической Методологии оценки запасов полезных ископаемых в натуральном и стоимостном измерениях и их изменений за год". <https://files.stroyinf.ru/Index2/1/4293723/4293723313.htm>
27. Пономаренко Т.В. Методический подход к оценке ценности проекта освоения месторождения и создания цепочки добавленной стоимости / Т.В. Пономаренко, Ф.Д.Ларичкин, К.В. Щетинина //Экономические и социальные перемены: факты, тенденции, прогноз. – 2017. – Т. 10. – № 4. – С. 128-143. DOI: 10.15838/esc/2017.4.52.7
28. Юрак В. В. Против устойчивого развития: сценарии будущего / В. В. Юрак, А. В. Душин, Л. А. Мочалова // Записки Горного института. – 2020. – Т. 242. – С. 242-247.
29. Юрак В.В. Теоретико-методический подход к оценке общественной ценности природных ресурсов. Автореферат ... к.э.н. Екатеринбург, 2017.
30. Сидоров Д.В. Геомеханическое обеспечение камерно-столбовой системы разработки удароопасных месторождений Североуральского бокситового бассейна на больших глубинах: дис. ... докт. тех. наук: 25.00.20; [Место защиты: Нац. минерально-сырьевой ун-т «Горный»] – Санкт-Петербург, 2015.
31. Пономаренко Т.В., Дамбаева И.Ж., Пунсалмаагийн Очирбат Инструменты совершенствования организации производства горнорудной компании в условиях устойчивого развития //Горный информационно-аналитический бюллетень (научно-технический журнал). 2022, в печати.
32. Рациональное использование вторичных минеральных ресурсов в условиях экологизации и внедрения наилучших доступных технологий : монография / коллектив авторов; под науч. ред. д. э. н., проф. Ф. Д. Ларичкина, д. э. н., проф. В. А. Кныша. - Апатиты : Издательство ФИЦ КНЦ РАН, 2019. — 252 с.
33. Ponomarenko T., Nevskaia M., Jonek-Kowalska I. Mineral resource depletion assessment: Alternatives, problems, results //Sustainability (Switzerland), 2021, 13(2), 1–15.

34. Que C.T. Coal Mines in Vietnam: Geological Conditions and Their Influence on Production Sustainability Indicators / C.T. Que, M. Nevskaya, O. Marinina // Sustainability. – 2021. – T. 13. – No. 21. – С. 11800.
35. Политика Китая относительно полезных ископаемых (Белая книга) 2004/09/01. <https://www.fmprc.gov.cn/ce/ceka/rus/zggk/t156989.htm>
36. Закон РФ от 21.02.1992 N 2395-1 (ред. от 28.06.2022) "О недрах".
37. Ларичкин Ф. Д. Научные основы оценки экономической эффективности комплексного использования минерального сырья. - Апатиты: КНЦ РАН - 2004. - 252 с.
38. Ларичкин Ф. Д., Азим Иброхим, Глущенко Ю. Г., Переин В. Н., Хамзин Б. С. О методологии обоснования параметров кондиций на месторождениях многокомпонентных руд // Горный журнал – 2011 - № 7 - С. 36–39.
39. Виноградов В. Н. Экономическая оценка комплексного минерального сырья. М.: Недра - 1978. - 223 с.
40. Сечевица А. М. Геолого-промышленная оценка попутных полезных ископаемых в комплексных рудных месторождениях. - М.: Недра -1987.126 с.
41. Методические рекомендации по технико-экономическому обоснованию кондиций для подсчета запасов месторождений твердых полезных ископаемых (кроме углей и горючих сланцев): утв. распоряжением МПР России от 05.06.2007 г. № 37-р. М.:НП НАЭН, 2007. 60 с.
42. Коссова Т.В., Шелунцова М.А. Социальная ставка дисконтирования в России: методология, оценка, межрегиональные различия. //ЭНСР - № 3 (58) - 2012. -С.16-27.
43. Архипов В.М., Емельянов А.М. Оценка социальной ставки дисконтирования. // Финансы и кредит - №17. (221) – 2006.
https://fdp.hse.ru/data/2010/05/15/1234801085/public_001.pdf
44. Самошков А.К. Основные подходы к определению социальной ставки дисконта при оценке капитaloобразующих инвестиций. //Труды ИСА РАН – Том 63 – 1-2013. http://www.isa.ru/proceedings/images/documents/2013-63-1/t-1-13_62-71.pdf
45. Марин Е.А., Пономаренко Т.В., Василенко Н.В., Галевский С.Г. Экономическая оценка проектов разработки месторождений углеводородного сырья в условиях северных районов добычи с применением бинарного и реверсированного дисконтирования. // Север и рынок – 2022 - № 3. В печати.
46. Ivanova D.A., Ponomarenko T.V. Application of complementary assets in mining industry: definition, nature, and features. //St. Petersburg State Polytechnical University Journal. Economics - 14 (2) – 2021- с. 92–104. DOI: 10.18721/JE.14206
47. Австралийский институт управления проектами. Национальный стандарт компетентности в области управления проектами (AIPM) – Руководящие принципы, 2021.С. 23-27.
48. Советова Е.А. Сущность риска как экономической категории // Бизнес информ – 2012 - № 3.
49. Руководство к своду знаний по управлению проектом (Руководство PMBOK)- Седьмое издание. – М: PMI, 2021, с. 65-83.

50. ГОСТ 58969-2020 Менеджмент риска. Управление технико-производственными рисками промышленного предприятия, 2020.
51. 79. Обзор рынка РЗМ и технологий переработки редкоземельного сырья / Т.И.Юшина, И.М. Петров, С.И. Гришаев, С.А. Черный // Горный информационно-аналитический бюллетень (научно-технический журнал). – 2015. – S1. – С. 577 – 608.
52. Фомичев Е.С. Риски в сфере основной деятельности горнодобывающих предприятий / Е.С. Фомичев // Горная промышленность. – 2003. – № 6.
53. Боярко Г. Ю. Управление рисками проектов недропользования / Г. Ю. Боярко // Известия Томского политехнического университета. – 2002. – Т. 305. – № 8. – С. 257-266.
54. Анализ рисков в горнодобывающей промышленности, связанных с безопасностью работы / В. Кубиньски, Е. Кубиньска-Ябzon, А. Петров, Д. Сала, Д.Ю.Савон. // Горный информационно-аналитический бюллетень (научно-технический журнал). – 2017. – № 11. – С. 168-176.
55. Ловчиков А.В Изменение представлений о механизме горных и горнотектонических ударов в рудниках на современном этапе / А.В. Ловчиков // Записки Горного института. – 2010. – Т. 188. – С. 63-65.
56. Горный удар произошел на одной из шахт Кузбасса после землетрясения в Туве // Российская газета. 2011. URL: <https://rg.ru/2011/03/28/reg-sibir/udar-anons.html>. (дата обращения: 19.07.2021).
57. Сидоров Д.В., Пономаренко Т.В. Применение цифровых геомеханических двойников для прогнозирования и оценки рисков потери запасов в проектах разработки рудных месторождений. //Горная промышленность – 2022 - 3. <https://doi.org/10.30686/1609-9192-2022-3-00-00>
58. Ponomarenko T., Nevskaya M., Marinina O. An assessment of the applicability of sustainability measurement tools to resource-based economies of the commonwealth of independent states //Sustainability. – 2020. – No 12 (14). –C.55-82.
59. By T.D, Ларионова И.А. Оценка состояния экономической безопасности на угледобывающих предприятиях Винакомин (Вьетнам) //Russian Journal of Industrial Economics. - 2020. –No 13 (1). - С. 58-66. DOI: 10.17073/2072-1633-2020-1-59-66
60. Гендлер С. Г., Нгуен Тхе Ха. Обоснование рациональных способов обеспечения воздухом выемочных участков действующих угольных шахт Вьетнама при углублении горных работ // Записки Горного института. – 2018. - № 6.
61. Ле Б.З. Воздействие угледобывающих предприятий Вьетнама на гидросферу // Известия ТулГУ // Науки о Земле. - 2015.- №1.
62. Постановление №: 880/QD-TTg от 9 июня 2014 г. Об утверждении генерального плана промышленного развития Вьетнама до 2020 г., концепции до 2030 г. URL: <https://thuvienphapluat.vn/van-ban/Doanh-nghiep/Quyet-dinh-880-QD-TTg-2014-Quy-hoach-tong-the-phat-trien-cong-nghiep-den-2020-tam-nhin-2030-234519.aspx>
63. “Стратегия развития минерально-сырьевого комплекса Монголии”, ОХУ, 2007 он
64. П. Очирбат. Когда закончится угольное царство? Россия и Монголия: результаты и перспективы научного сотрудничества Труды Международной научной конференции Иркутск, 6–8 апреля 2022 г.
65. П.Очирбат. Дэлхийн алтан хэвлий. 2022 он. Золотой недр земли. 2022 г.

66. Байсаров Р.С. Комплексное освоение Элегестского месторождения коксующегося угля на основе государственно-частного партнерства //Новокузнецк, НФИ КемГУ: Антикризисное управление: производственные и территориальные аспекты - 2015–7-17 с.
67. Дубовик Н.Е. Элегестское месторождение каменного угля – новая сырьевая база коксующихся углей / Дубовик Н.Е., Вертель А.Э.
URL: <https://www.vnedra.ru/krupnejshie-mestorozhdeniya/elegestskoe-mestorozhdenie-kamennogo-120/> (дата обращения 23.01.2022).

ХАВСРАЛТ

Хавсралт 1. ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРИЙН ӨНӨӨ БА ИРЭЭДҮЙН ҮҮРЭГ ОРОЛЦОО

(Үндэсний болон бүс нутгийн хөгжил дэх оролцоо)

Очирбат Пунсалмаа*

Чинзориг Бавуу*

*-Монгол Улсын Шинжслэх Ухаан Технологийн Их Сургууль

pobmongolia@gmail.com, Chinzorigb@must.edu.mn

Хураангуй

Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын дийлэнх хувийг бүрдүүлж байгаа уул уурхайн салбарын эдийн засаг дахь бодит оролцоог тодорхойлох зорилгоор энэхүү судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ. Ажлын үр дүнд уул уурхайн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, түүний борлуулалтын хэмжээ дотоодын нийт бүтээгдэхүүнд төдийгүй эдийн засгийн бүсүүдэд хэрхэн нөлөөлж байгааг нарийвчлан судаллаа.

Мөн олборлох үйлдвэрийн ирээдүйн үүрэг оролцоог одоогоор дагаж мөрдөж байгаа хууль эрхзүйн орчны бодлого, хөтөлбөрт тулгуурлан тодорхойлох судалгаа хийсэн болно. **Түлхүүр үг:** дотоодын нийт бүтээгдэхүүн, уул уурхайн салбар, бодлого, хөгжил

Оршил

Судалгааны баг Монгол Улсын эдийн засгийн хөгжилд уул уурхайн салбарын өнөөгийн байдлын судалгааг улсын болон бүс нутгийн хэмжээнд хийж, уул уурхайн салбараас оруулах хувь нэмрийг макро болон микро орчинд авч үзлээ. Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ), аж үйлдвэрийн бүтээгдэхүүн, экспортын бүтцэд уул уурхайн бүтээгдэхүүн зонхилох байр суурийг эзэлж байгаа боловч хатуу дэд бүтэц ба аж үйлдвэрийн хөгжлийг хангах, эдийн засгийн бусад материаллаг салбаруудыг хөгжүүлэх, гадаад өрийг бууруулах, ард иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах зэрэг нэн тэргүүний шаардлагуудын наад захын хэрэгцээг ч хангаж чадахгүй байна. Иймд эдийн засгийн хөгжлийн дунд болон урт хугацааны бодлогыг хэрэгжүүлэхэд нэгэн томоохон гарц болох энэхүү судалгаагаар уул уурхайн бэлтгэгдсэн төслүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар уул уурхайн үйлдвэрлэлийг 5-6 дахин нэмэгдүүлбэл 2050 он гэхэд дээрх хэрэгцээг хангах нөхцөл бүрдэх ирээдүйн таамаглал гарч байна.

Энэхүү илтгэлээр уул уурхайн салбарын эдийн засаг дахь өнөө ба ирээдүйн оролцоог тодорхойлсон ба Монгол Улсын БШУЯ-ны захиалгат ШуГх/ОХУ/-2019/03 гэрээгээр батлагдсан “Эрдэс түүхий эдийн цогцолборын үнэлгээний аргачлалыг тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан боловсруулах онолын судалгаа”, ОХУ-ын Суурь Судалгааны сан (РФФИ)-ийн захиалгат РФФИ №19-510-44013/19 тоот гэрээгээр батлагдсан “Разработка концепции формирования ценности минерально-сырьевых ресурсов в контексте устойчивого развития в странах с ресурсно-ориентированной экономикой” төслүүдийн хүрээнд бичлээ.

1. Монгол улсын эдийн засагт уул уурхайн салбараас үзүүлэх нөлөөллийн судалгаа

Монгол улсын эдийн засагт уул уурхайн салбар томоохон байр суурийг статистикиас үзэхэд зөвхөн Уул уурхай, олборлолт борлуулалтаар сүүлийн 5 жилд ДНБ-ний 20-иос

дээш хувийг эзэлж, улсын төсвийн бүрдүүлэлт, экспортын бүтээгдэхүүнд голлох үүргийг гүйцэтгэж байна. 2019, 2020 онд олон улсыг хамарсан цар тахлын улмаас уул уурхайн бүтээгдэхүүний экспорт бага хэмжээгээр буурсан ч эдийн засгийн хүнд үеийг уул уурхайн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд тулгуурлан даван туулах нь нэгэнт тодорхой болж байна.


Өнгөрсөн таван жилийн хугацаанд уул уурхайн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь харьцангуй тогтвортой байгааг дараах хүснэгт, графикаас харж болно.

1-р хүснэгт

Дотоодын нийт бүтээгдэхүүнд уул уурхайн салбарын оролцоо

№	Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020
1.	ДНБ, тэрбум ₮	23,942.9	27,876.3	32,411.2	37,280.8	36,958.6
2.	Уул уурхай, олборлолт, тэрбум ₮	4,817.3	6,543.4	7,721.0	8,642.6	7,994.0
2.	ДНБ үйлдвэрлэлд эзлэх хувь, %	20.12	23.47	23.82	23.18	21.63
3.	Боловсруулах үйлдвэрлэл, тэрбум ₮	1,753.7	2,516.3	3,063.6	3,508.5	3,946.8
3.	ДНБ үйлдвэрлэлд эзлэх хувь, %	7.32	9.03	9.45	9.41	10.68

ДНБ үйлдвэрлэлийн өсөлт, тэрбум төгрөгөөр



1-р зураг. ДНБ үйлдвэрлэлийн хэмжээ, оны үнээр (тэрбум төг.)

Дээрх судалгаанаас үзэхэд улсын дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ, уул уурхайн салбараас шууд хамааралтай байна.

Үндэсний хөгжлийн газраас 2018 онд Монгол Улсын “Макро эдийн засгийн өнөөгийн байдал, хэтийн төсөөлөл”-ийг 2022 он хүртэл гаргасан байдаг (2-р хүснэгт).

2-р хүснэгт.

ДНБ үйлдвэрлэлийн хэмжээ, өсөлт

ДНБ, Төсөөлөл	2019	2020	2021	2022
ДНБ, Оны үнээр /тэрбум төгрөг/	36,310.6	40,681.2	45,826.2	51,636.6
ДНБ, өсөлт /хувь/	8.0	6.0	6.0	6.0

Эх сурвалжс: Сангийн Яам

Дээрх төсөөллийг 2019 оны гүйцэтгэлээр давж биелэсэн бол 2020 онд тооцоолсон хэмжээнд хүрээгүй байгаа нь 2020 онд уул уурхайн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ 9.4%-аар буурсантай шууд холбоотой гэж үзэж байна.


Дэлхийн банкны 2019 оны тайланд “...бага орлоготой орнуудын эдийн засаг тогтвортгүй, нэлээд хэлбэлзэлтэй байгаа бол дундаас дээш орлоготой орнуудын эдийн засаг харьцангуй тогтвортой байгаа нь ажиглагдаж байна. Хэдийгээр Монгол Улс дундаж орлоготой орны тоонд багтдаг ч гэсэн уул уурхайгаас хэт хамааралтай учир эрдэс бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнийн өөрчлөлтөөс шалтгаалан эдийн засаг хэлбэлздэг...” гэж мэдээлсэн байдаг.

Монгол Улсын эдийн засгийн өсөлт бууралтыг нарийвчлан эдийн засгийн бүсчлэл тус бүрээр сүүлийн арван жилээр судалсан ба энэхүү илтгэлт таван жилийн үзүүлэлтийг орууллаа (3-р хүснэгт).

3-р хүснэгт.

ДНБ-ий өсөлт, бууралт (тэрбум төгрөг)

Аймаг	2015	2016	2017	2018	2019
Баруун бүс	1,511.1	1,459.8	1,549.7	1,823.9	1,982.7
Хангайн бүс	3,053.9	3,001.5	3,794.3	4,158.5	4,855.5
Төвийн бүс	2,348.2	2,439.0	2,870.8	3,155.9	3,777.5
Зүүн бүс	1,272.4	1,339.4	1,556.2	1,763.2	1,981.5
Улаанбаатар	14,964.7	15,703.1	18,105.3	21,509.8	24,683.7
Улсын хэмжээнд	23,150.4	23,942.9	27,876.3	32,411.2	37,280.8



2-р зураг. ДНБ үйлдвэрлэлийн өсөлтөд бүсүүдийн оролцоо

Бүсүүдийн ДНБ үйлдвэрлэлийн өсөлтийг эдийн засгийн салбаруудаар авч үзвэл, баруун болон хангайн бүсийн салбаруудын өсөлт тогтвортой биш, өсөлтийг бүрдүүлж байгаа салбарууд нь жил бүр өөр өөр байна. Судалгааны үр дүнгээс үзэхэд баруун бүс 2012 оноос бусад жилүүдэд үйлдвэрлэлийн салбарын өсөлтийн хувь өндөр байгаа хэдий ч нийт бүсийн өсөлтийн 30-аас доош хувийг бүрдүүлжээ. Эдгээр бүсийн өсөлт нь хөдөө аж ахуй, үйлчилгээний салбараас түлхүү хамааралтай байна.

Харин төвийн болон зүүн бүсийн хувьд эдийн засгийн нөхцөл байдал үйлдвэрлэлийн салбараас ихээхэн хамааралтай дүр харагдаж байна. 2015 онд үйлдвэрлэлийн салбар бууралттай гарснаар эдийн засаг бууралттай гарсан байна. Эндээс үзэхэд "...бүсийн хөгжил нь төрөлжөөгүй, тухайн жилийн тэргүүлэх чиглэл, хөрөнгө оруулалт, уул уурхайн салбарын үйлдвэрлэл, давагдашгүй хүчин зүйл болох байгаль, цаг агаарын байдал зэргээс шууд хамааралтай хэвээр байна..." гэж дүгнэж болохоор байна.

Гаалийн ерөнхий газрын мэдээллээс үзэхэд 2020 оны эхний 11 сарын гүйцэтгэл өнгөрсөн оны мөн үеэс 3%-иар буюу 200 сая ам.доллараар буурчээ. Үүнд мал аж ахуй болон аж үйлдвэрийн бүтээгдэхүүний экспорт багассан нь нийт экспортыг 3 нэгж хувиар бууруулахад нөлөөлсөн гэж дүгнэжээ.

4-р хүснэгт

Экспортын зарим гол нэрийн барааны үнийн дүн, жилээр (мян.ам.долл)

Гол нэр төрлийн бараа	2016	2017	2018	2019	2020
Алт	758,408.7	595,354.08	144,499.1	418,394.4	1,787,652.2
Зэсийн баяжмал	1,607,754.3	1,613,117.2	2,012,194.4	1,795,868.4	1,778,001.9
Молибдены хүдэр ба баяжмал	26,446.8	37,358.65	49,939.4	49,012.2	40,703.5
Жоншины хүдэр,	58,969.8	84,218.41	189,857.6	205,258.2	156,323.

баяжмал					
Гянтболдын хүдэр, баяжмал	10,514.6	8,078.6	8,824.2	6,502.2	712.1
Төмрийн хүдэр, баяжмал, пирит	249,890.5	313,354.5	342,181.2	576,576.5	639,696.9
Цайрын баяжмал	145,412.7	180,809.22	197,806.4	189,004.6	167,680.5
Тунгаасан зэс ба хайлш	74,188.5	92,734.62	82,449.1	68,903.9	59,319.5
Хар төмрийн хаягдал	285.6	322.93	309.59	211.2	208.3
Нүүрс	973,072.76	2,267,642.2	6	2,802,517.	5
Боловсруулаагүй нефть	337,180.6	374,071.43	391,987.8	366,665.8	7
					8
					150,853.2

Судалгаанаас дүгнэхэд уул уурхайн зарим бүтээгдэхүүний экспортын орлого бага зэрэг буурсан ч алтны борлуулалтын орлого бараг дөрөв дахин нэмэгдсэн нь дээрх бүтээгдэхүүний нийт борлуулалтын 26% орчмыг дангаараа бүрдүүлсэн байна. [2].

Эндээс бүс нутгийн эдийн засгийн хувьд уул уурхайн салбарын оролцоо өндөр байгаа төдийгүй ойрын жилүүдэд ч энэ байдал хадгалагдахаар байна. Үүнийг Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны сүүлийн үеийн мэдээллээс бататган харж болно.

2. Бүс нутгийн эдийн засагт уул уурхайн салбараас үзүүлэх нөлөөллийн судалгаа

Өмнөх хэсэгт Монгол Улсын ДНБ үйлдвэрлэлд уул уурхайн эзлэх хувь болон бүс нутгуудаас үзүүлэх нөлөөллийг ерөнхий байдлаар авч үзсэн бол энэ хэсэгт бүс нутгийн эдийн засагт уул уурхайн бүтээгдэхүүн хэрхэн нөлөөлөхийг судаллаа.

Монгол улсын хувьд эдийн засгийн үндсэн дөрвөн бүсчлэлбайdag. Үүнд:

1. Баруун бүс
2. Хангайн бүс
3. Төвийн бүс
4. Зүүн бүс

Үүнээс гадна хүн амын нягтрал суурьшлаас шалтгаалж, хамрах газар нутгийн хэмжээ бага ч Улаанбаатарын бүс гэж нэмж оруулаад байна.


ШУТИС-ийн Геологи, уул уурхайн сургуулийн судалгааны баг Монгол Улсын бүс нутаг тус бүрийн нийгэм эдийн засагт геологи, уул уурхайн салбараас үзүүлэх нөлөөллийн судалгааг 2019-2021 онуудад хийж байна. Судалгааны үр дүнгээс харахад, уул уурхайтай сумдыг уул уурхайгүй сүмтай харьцуулбал өрхийн бодит орлого 7.3%-аар өндөр, хэрэглээ 10.9%-аар өндөр, ядуурал 7.5%-аар бага, өрхийн өвдсөн хүний тоо 0.22-оор илүү байгааг статистик үзүүлэлттэй байна.

Үүнийг үргэжлүүлэн уул уурхайн салбараас эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцоолж, салбарын ажлын байрны хангалтын судалгаануудыг хийхэд дараах үр дүн гарлаа [3].

2.1. Эдийн засгийн баруун бүс:

Баруун бүсийн ДНБ үйлдвэрлэлд уул уурхайн бүтээгдэхүүн эзлэх хувь 5.6%, аймаг, орон нутгийн төсөвт оруулж буй орлого 0.7-6.0%, Төрийн байгууллагуудад олгосон хандив тусламж 1.3 тэрбум төгрөг, уул уурхайн салбарт ажиллаж буй хүний тоо 506

байна. Эндээс тухайн бүс нутагт бэлтгэгдсэн тухайн салбарын томоохон төслүүдийг хэрэгжүүлснээр дээр нийгэм-эдийн засгийн нөлөөлөл эрс нэмэгдэх боломж байна. Үүний тулд нэн тэргүүнд энэхүү бүсийн хатуу дэд бүтцийн хөгжлийг түргэтгэх, улмаар ашигт малтмалын ордуудын нөөцийг эдийн засгийн эргэлтэнд оруулах нь хөгжлийн адил түвшинд хүрэх боломжтой гэж үзлээ.




4-р зураг. Баруун бүсийн ДНБ үйлдвэрлэлийн бүтэц, өсөлт, бууралт (эдийн засгийн салбараар)

Судалгаанаас нэгтгэн дүгнэхэд баруун бүсийн ДНБ үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн салбарт зонхицж 2015 онд уул уурхайн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлээс 2.5 дахин өндөр байсан бол 2019 онд хоёр дахин өндөр байна. Өөрөөр хэлбэл уул уурхайн бүтээгдэхүүни үйлдвэрлэлийн хэмжээ дээрх хугацаанд 1.5 дахин өсчээ.

2.2. Эдийн засгийн Хангайн бүс:

Хангайн бүсийн уул уурхайн бүтээгдэхүүн ДНБ үйлдвэрлэлд эзлэх хувь 38%, аймаг, орон нутгийн төсөвт оруулж буй уул уурхайгаас оруулж буй орлого 0.3- 72.6%, Төрийн байгууллагуудад олгосон хандив тусlamж 2.6 тэрбум төгрөг, уул уурхайн салбарт ажиллаж буй хүний тоо 13935 байна. Баруун бүстэй харьцуулахад энэ нь өндөр үзүүлэлт боловч Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ зонхилох хувийг эзэлсэн байна. Эндээс эрдэс баялгийн цогцолборын томоохон нэг төслийг үр ашигтай хэрэгжүүлснээр бүс нутгийн төдийгүй улс орны эдийн нийгэм-эдийн засагт онцгой нөлөө үзүүлдгийг илтгэнэ. Хангайн бүсийн ДНБ үйлдвэрлэлд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ийн бүтээгдэхүүний экспорт голлох үүрэг гүйцэтгэж байна.




5-р зураг. Хангайн бүсийн ДНБ үйлдвэрлэлийн бүтэц, өсөлт, бууралт (эдийн засгийн салбараар)

Судалгааны үр дүнгээс сүүлийн таван жилд уул уурхайн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрс өсч хөдөө аж ахуй салбараас бараг хоёр дахин илүү болжээ.

2.3. Эдийн засгийн төвийн бүс:

Сүүлийн таван жилийн хугацаанд төвийн бүсийн ДНБ үйлдвэрлэлд уул уурхай, олборлох салбарын эзлэх хувь тасралтгүй өсч 12% - 17% болсон. 2018 оны байдлаар төвийн бүсийн уул уурхайн салбар нийт 541 тэрбум төгрөг буюу бүсийн ДНБ-ий 17%-ийг бүрдүүлсэн байна. 2018 оны байдлаар тус бүсийн эдийн засгийн 70% орчмыг мал аж ахуй, уул уурхай, боловсруулах болон бусад үйлчилгээний салбартууд бүрдүүлж байна. Тухайлбал мал аж ахуйн салбар 24% (776.9 тэрбум төгрөг), уул уурхай, олборлох салбар 17% (541.1 тэрбум төгрөг), боловсруулах салбар 15% (466.3 тэрбум төгрөг), бусад үйлчилгээний салбар 14% (431.3 тэрбум төгрөг), санхүү бизнесийн үйл ажиллагаа 9%, бусад салбартууд 6%-аас бага хувийн хувь нэмэр оруулжээ.




6-р зураг. Төвийн бүсийн ДНБ үйлдвэрлэлийн бүтэц, өсөлт, бууралт (эдийн засгийн салбараар)

Графикаас үзэхэд, төвийн бүсийн ДНБ үйлдвэрлэлийн бүтэц харьцангуй тэнцвэртэй байгаа мэт боловч компанийн ерөнхий удирдлага нь Улаанбаатар хотод харьяалтай,

Үйлдвэрлэл нь тус бүс нутагт хэрэгждэг аж ахуйн нэгжийн статистик үзүүлэлтийг оруулдаггүй болохыг анхаарах нь юм.

2.4. Эдийн засгийн зүүн бүс:

Зүүн бүсийн уул уурхай, олборлох салбар (688 тэрбум төгрөг) Монгол улсын нийт ДНБ-ий 10.2%, хөдөө аж ахуйн салбар (443.4 тэрбум төгрөг) нь 15.7%-ийг бүрдүүлж байна. Зүүн бүсийн ДНБ үйлдвэрлэлд уул уурхайн салбарын оруулж буй дундаж сүүлийн таван жилийн хугацаанд 30- 40% хэлбэлзэлтэй байана. 2018 оны байдлаар Зүүн бүсийн ДНБ-ий 38%-ийг уул уурхайн салбар дангаараа бүрдүүлжээ.



6-р зураг. Зүүн бүсийн ДНБ үйлдвэрлэлийн бүтэц, өсөлт, бууралт (эдийн засгийн салбараар)

Дээрх судалгаанаас дүгнэхэд уул уурхай, үйлдвэрлэлийн салбарын өсөлт хангайн, төвийн, зүүн бүсэд бусад салбарыг бодоход харьцангуй өндөр, тасралтгүй өсөлттэй байна.

3. Монгол Улсын эдийн засаг дахь уул уурхайн салбарын ирээдүйн оролцооны судалгаа

Монгол Улсын Эрдэс баялгийн салбараас нийгэм-эдийн засагт нөлөөлөх ирээдүйн судалгааг уул уурхайн салбарт дагаж мөрдөх эрхзүйн орчны судалгаатай холбож үзэх нь илүү үр дүнтэй гэж үзлээ.

Тухайлбал, манай улсын хувьд цаашид ашигт малтмалыг баяжуулах, боловсруулах замаар экспортын орлогыг нэмэгдүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд төрийн бодлого чиглэгдэж ирсэн. Энэ асуудлыг амьдралд хэрэгжүүлэх үүднээс томоохон орд газар, баяжуулах үйлдвэрийг түшиглэн боловсруулах аж үйлдвэрийг хөгжүүлэх замаар эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилтыг тавьж байна.

Энэ чиглэлээр эрэлт нийлүүлэлтийн судалгааг үндэслэн улсын өрсөлдөх чадварыг дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:

Боловсруулах аж үйлдвэрийн ган туйван, ган бөмбөлөг, катодын зэс, зэс утас, цемент, шохой, тээврийн хэрэгсэл угсрах болон металл хийцийн зарим үйлдвэрүүд ажиллаж байгаа хэдий ч ихэнх үйлдвэрийн түүхий эд, сэлбэг, хэрэгсэл импортоос хараат, хүний нөөц дутагдалтай, зах зээлийн багтаамж бага, эргэлтийн хөрөнгө дутагдалтай, шинэ

техник, технологи, тоног төхөөрөмж нэвтрүүлэх боломж хомс, эрчим хүч, дэд бүтэц, тээвэр ложистикийн нэгдсэн сүлжээ бий болоогүй зэргээс дотоодын үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүн импортын бараатай өрсөлдөх боломж хязгаарлагдмал байна [8].

Боловсруулах аж үйлдвэрт шаардлагатай хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, дадлагажуулах арга хэмжээ авч, хүнд үйлдвэрийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа суурьшлын бүсүүдэд хөрөнгө оруулалтыг татах, тэдгээрийн дэд бүтцийн барилга байгууламжуудыг барьж байгуулахад төрөөс татварын болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх, Монгол Улсын хүнд үйлдвэрийн бүтээгдэхүүний экспортын худалдаанд импортлогч орноос тавьж байгаа тарифын болон тарифын бус хориг саадыг багасгах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна [6].

2019 оны байдлаар “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Оюутолгой” ХХК 1.4 сая тн зэсийн баяжмал экспортолсон статистик үзүүлэлттэй байна. Мөн Оюутолгойн ордын далд уурхай, Цагаансуваргын зэсийн орд ашиглалтанд орсноор зэсийн баяжмалын олборлолт, экспортын хэмжээ 2 дахин нэмэгдэх төлөв ажиглагдсан. Цаашид зэсийн баяжмалд тулгуурлан баяжмалыг боловсруулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, цэвэр зэс экспортлогч орон болох боломж Монгол Улсад байгаа гэж үзжээ [6].

Дэлхийн улс орнуудын туршлагаас үзэхэд зах зээлд өрсөлдөх чадвартай, экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, шинэ үйлдвэрлэл, менежментийг нэвтрүүлэх, бүтээн байгуулалтад гадаадын хөрөнгө оруулалтыг татах зорилгоор үйлдвэрүүдийг том хотуудаас орон нутагт шилжүүлэн байршуулах, бүс нутгийг хөгжүүлэх, хөдөөд ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, дэд бүтцийг болон нийгмийн асуудлуудыг давхар уялдуулан шийдвэрлэх замаар парк байгуулагдсан байdag.

Иймд Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 214 дүгээр тогтоолоор “БОЛОВСРУУЛАХ АЖ ҮЙЛДВЭРИЙН ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР”-ийг баталсан байна. Тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг УУХҮС-ын 2018 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн А/180 тушаалаар баталж, тус төлөвлөгөөний 7.3.3-д “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэн байгуулах уул уурхай, металург, химийн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк байгуулах асуудлыг судлах, судалгааны нэгжийг байгуулж ажиллуулах, 7.3.4-т судалгаанд үндэслэн “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэн үйлдвэрлэл, технологийн парк байгуулах асуудлаар санал боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар тусгажээ.

Боловсруулах аж үйлдвэрийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд хүнд үйлдвэрт эхний ээлжид металлурги, машин байгууламж, газрын тос, нүүрс боловсруулах болон химийн үйлдвэрийг хамруулах бөгөөд цаашид уран, цайр, жонш, бусад төрлийн эрдэсийг боловсруулах үйлдвэрлэлийг үе шаттайгаар байгуулж хөгжүүлэх бэлтгэлийг хангахаар заажээ.

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хувьд Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 06 сарын 05-ны өдрийн 224 дүгээр тогтоолоор “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоолоор парк байгуулах боломжийг судалж санал боловсруулж танилцуулахыг дараах байдлаар баталгаажуулсан байна. Үүнд:

- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг түшиглэн уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолборыг барьж байгуулах боломжийг судлан санал боловсруулах;
- “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ болон уул уурхай, боловсруулах аж үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд хамтарч шаардлагатай дэд бүтцийг бий болгох, байгаль орчныг хамгаалах чиглэлээр

хамтран ажиллахад төрийн бодлогын хэмжээнд дэмжлэг үзүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын, Барилга, хот байгуулалтын, Зам, тээврийн хөгжлийн яамдад хариуцуулжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 224 дүгээр тогтоолын 1 дүгээр заалтаар “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ыг 2031 он хүртэл хугацаанд хөгжүүлэх үндсэн чиглэлийг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт үүрэг болгон, ТӨБЗГ-ын 262 дугаар тогтоолын 1 дүгээр заалтаар үндсэн чиглэлийг баталсан.

Хөгжлийн үндсэн чиглэлд хэрэгжүүлэхээр дараах төслүүдийг тусгасан байна.

а). Хүдрийн нөөцийг нэмэгдүүлэх, өртөг зардлыг бууруулах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор техник, технологийн шинэчлэл хийх, хүчин чадлыг өсгөх төслүүд:

- Эрдэс баялгийн нөөц өсгөх.
- Ил уурхайд мөчлөгт ургалт тээврийн технологийг нэвтрүүлэх.
- Баяжуулах үйлдвэрийн өргөтгөх, шинэчлэх.

б). Нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх төслүүд:

- Засвар механикийн заводыг өргөтгөх, шинэчлэх.
- Уусган баяжуулах SX/EW технологиор исэлдсэн худэр боловсруулах үйлдвэр барих.
- Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр барих.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 4.1-ийн хүрээнд “Хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлсэн байна.”, зорилт 4.2-ын хүрээнд “Боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хэмжээ нэмэгдсэн байна.”, “Үндэсний тээвэр, логистикийн тогтолцоог хөгжүүлсэн байна.”, зорилт 9.5-ын хүрээнд “Аж үйлдвэрийн бүсүүдийг салбар чиглэл бүрд төлөвлөн, кластер байдлаар дагуул хотуудыг хөгжүүлнэ.” гэсэн зорилтыг дэвшүүлсэн байна.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд “Малын гаралтай түүхий эд боловсруулах, экспортлох үйлдвэр, технологийн парк байгуулж, ажлын байрыг шинээр бий болгож, малчдын орлогыг өсгөнө.”, “Дагуул хотуудад дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл, технологийн паркуудыг байгуулж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.” гэж тодорхойлсон.

Өөрөөр хэлбэл дээрх эрхзүйн орчны хүрээнд шаардлагатай түүхий эдийн нөөц, ажиллах хүч, эдийн засгийн боломжийг судалж гадаад зах зээлд өрсөлдөх үйлдвэрлэлийн хүчин чадлыг тодорхойлох үндсэн зорилгыг агуулж байна.

Үүний тулд,

- ✓ Эрдэс баялгийн салбарын хөгжлийн чиглэлийг тодорхойлж, нийгэм эдийн засгийн хэрэгцээ шаардлагыг судлах, материаллаг болон бусад нөөцүүдэд хийсэн судалгааг үндэслэх;
- ✓ Гадаадад өрсөлдөх чадвартай, оюуны багтаамжтай экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлж, Монгол улсын болон бүс нутгийн тогтвортой хөгжлийг хангах эрдэс баялгийн цогцолборын урьдчилсан судалгаа, шинжилгээ, эдийн засгийн үр ашгийн тооцооллыг үндэслэх;

- ✓ Уул уурхайн тогтвортой хөгжил, найдвартай үйл ажиллагааг хангах, байгальд ээлтэй шинэ дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх зорилгоор хөгжлийн үзэл баримтлал боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх замаар уул уурхайн салбарын эдийн засагт үзүүлэх ирээдүйн үүрэг оролцоог өндөржүүлэх боломжийг илэрхийлэх баталгаа гэж дүгнэж болохоор байна.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд "Үндэсний хөрөнгө оруулагчдын эдийн засаг дахь хувь, оролцоог нэмэгдүүлэх, хамгаалах бодлого хэрэгжүүлж, бизнесээ өргөжүүлэх, олон улсын тавцанд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх, улмаар улс орны эдийн засгийн аюулгүй байдал, хөгжил дэвшилд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх боломжийг бүрдүүлнэ" гэж;

Улсын Их Хурлын 2015 оны 62 дугаар тогтоол "Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичигт "Аж үйлдвэрийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлж, үйлдвэрийн кластер, чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн парк, тээвэр логистикийн сүлжээг цогцоор нь төлөвлөн хэрэгжүүлэх", "Дэвшилтэт техник, технологи, өндөр технологи, инновацид суурилсан, нийгэм, эдийн засгийн үр ашиг бүхий үндсэн материалын, машин, тоног төхөөрөмжийг угсрах, болон бусад боловсруулах, дахин боловсруулах бүтээлч аж үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт санхүүгийн бодлогоор дэмжих" зорилтууд тус тус дэвшүүлсэн,

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд бүсчилсэн хөгжлийг төрөөс дэмжих гол чиглэлд:

- "Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот, тэдгээрийн орчмын нутгийн хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний хэт бөөгнөрөл, удирдлагын төвлөрөл, экологийн тэнцлийн алдагдлыг сааруулж, бүсүүдийн хөгжлийн түвшнийг эрэмбэ дараатай дээшлүүлэх явдал юм",
- "хангайн бүсэд: бэлчээрийн мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал, амралт, сувилал, жижиг дунд үйлдвэр, уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр; мод боловсруулах үйлдвэрийг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлнэ" гэж заасан байна.

УИХ-ын 2014 оны №18 тоот тогтоолоор батлагдсан "Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого"-оос гадна сүүлийн жилүүдэд батлагдаад байгаа Боловсруулах аж үйлдвэрлэлийн чиглэлээр баримтлах бодлого, хөтөлбөр, бүс нутгийн хөгжлийн алсын хараа зэрэг баримт бичгүүдэд хийсэн судалгаанаас үзэхэд Монгол орны эдийн засгийн макро микро түвшинд уул уурхайн салбарын оролцоо тулгуур хүчин зүйл байх нь нотлогдож байна.

Орчин үеийн Монголын эрдэс баялгийн эрхзүйн институционал хөгжлөөс үзэхэд олборлох боловсруулах аж үйлдвэрийн салбарын хөгжлийн эрхзүйн орчин баталгаатай байна.

4. Уул уурхайн салбараас байгаль орчинд үзүүлсэн нөлөөллийн тойм

Уул уурхайн салбарын хувьд бүс нутгуудийн нийгэм-эдийн засагт үзүүлэх эрөг нөлөөллөөс гадна байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг дэвэргэсэн таагүй мэдээлэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээмэл тархаж байгаа ч үнэн бодит байдлыг судлахад дараах үр дүн гарчээ.

Философиийн хүрээлэнгийн судлаач доктор Б.Батхишигийн “Монголын мал аж ахуй, газар тариалан, уул уурхай, боловсруулах аж үйлдвэрийн салбаруудын зохистой хамаарал, харьцааны асуудал” судалгаанд “...уул уурхайн эдэлбэр газрын хэмжээ, газрын нэгдмэл сангийн 0.15 хувийг эзэлж байна. 2018 оны эцсийн байдлаар манай улсын хэмжээнд хайгуулын 1405, ашиглалтын 1673, нийт 3078 тусгай зөвшөөрөл олгосон байна. Эдгээр зөвшөөрөлд хамрагдах талбай нь манай улсын газар нутгийн 5.5%-ийг эзэлж байна. Улсын хэмжээгээр 2018 оны байдлаар 7 сая га бэлчээрт хохирол учирсан нь нийт бэлчээрийн газрын 6.3% бөгөөд өмнөх оныхоос 3.8 сая га-гаар илүү байна. Үүний 21.4% нь талхлагдсан, 5% нь цөлжсөн, 2% нь элсний нүүлтэд орсон, 0.7% нь уул уурхайн олборлолтод өртсөн байна...” гэсэн үр дүн гарчээ [1].

Эндээс хараад эрдэс баялгийн салбар хөдөө аж ахуй, газар тариалангийн салбараас харьцангуй бага газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулж, экспортын бүтээгдэхүүний зонхилох хувийг үйлдвэрлэж байна. Ямарч нөхцөлд ашигт малтмалыг нөхөн сэргээх, хаалтын менежментийг төгөлдөржүүлэх нь уул уурхайн салбарынхны үүрэг байх ёстой.

Дүгнэлт

Үндэсний болон бүс нутгийн эдийн засгийн хөгжил дэх олборлох үйлдвэрийн өнөө ба ирээдүйн үүрэг оролцоог эдийн засгийн статистикийн мэдээ, түүнд тулгуурласан судалгаа, УИХ, засгийн газрын тогтоол шийдвэрт тулгуурлан хийж дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Зах зээлийн харилцаанд шилжсэн тогтолцооноос өнөөг хүртэл уул уурхайн салбарын ДНБ үйлдвэрлэлд эзлэх хувь нэрлэсэн өртгөөр тасралтгүй өсч байна.
2. Эдийн засгийн баруун бүсээс бусад бүсэд уул уурхайн салбар, түүнийг дагасан үйлдвэржилтийн хэмжээ бусад салбараас илүү өндөр байна.
3. УИХ, засгийн газрын тогтоол шийдвэр, алсын хараа зэрэг бодлогын баримт бичигт шинжилгээ хийж үзэхэд бүс нутгийн болон улсын нийгэм – эдийн засгийн хөгжлийн тодорхойлох гол хүчин зүйл нь уул уурхайн салбар хэвээрээ байна. Уул уурхайн салбарт түшиглэн хөрөнгө оруулалтын багтаамжийг нэмэгдүүлж, боловсруулах аж үйлдвэр хөгжүүлэх замаар экспортын орлогыг нэмэгдүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх шаардлага бодлогын хүрээнд идэвхиж байна. Үүгээр уул уурхайн салбарын эдийн засагт үзүүлэх ирээдүйн оролцоог тодорхойлж болохоор байна.
4. Байгаль орчинд уул уурхайн салбараас үзүүлэх нөлөөлөл газар нутгийн хувьд харьцангуй бага талбай эзэлж байгаа нь судалгаагаар тогтоогдсон байна.
5. Судалгаанаас үзэхэд олборлох аж үйлдвэрийн өнөөгийн болон хэтийн төлөв нь Монгол Улсын баялгийн баримжаатай эдийн засгийн үнэ цэнэ нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай уялдаж байна гэсэн дүгнэлтэд хургэж байна.

Ашигласан материал:

1. Б.Батхишиг “Монголын мал аж ахуй, газар тариалан, уул уурхай, боловсруулах аж үйлдвэрийн салбаруудын зохистой хамаарал, харьцааны асуудал”, Философиийн хүрээлэн., УБ хот 2019 он

2. Импортын барааны гаалийн татварын хувь, хэмжээ., Гаалийн ерөнхий газар., (<https://www.customs.gov.mn/news>)
3. П.Очирбат нарын “Бүс нутаг тус бүрийн нийгэм эдийн засагт, уул уурхайн салбараас үзүүлэх нөлөөллийн судалгаа”, УБ хот., 2020 он
4. “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”, УИХ-ын 2014 оны 01 сарын 16 өдрийн №18 тоот тогтоол.
5. Үндэсний хөгжлийн газар., Макро эдийн засгийн тойм мэдээлэл., 2018 он
6. “Хүнд үйлдвэрийн хөгжлийн үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын 2019 оны 214 дүгээр тогтоол.
7. Үндэсний статистикийн хорооны мэдээлэл., /<https://www.1212.mn/>
8. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ТЭЗҮ, Эрдэнэт-УБ хот., 2020 он

ХАВСРАЛТ 2 ХӨГЖИЖ БУЙ ОРНУУДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦИЙН ҮНЭЛГЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ ШИЙДЛИЙН БОЛОВСРУУЛАЛТ (МОНГОЛ УЛСЫН)

Татьяна Владимировна Пономаренко,

Кристина Николаевна Курякова

*Санкт-Петербургийн уулын их сургууль,
ОХУ, 199106, Санкт-Петербург хот, 21-р шугам, 2-р байр*

Очирбат Пунсалмаа,

*Монгол Улсын Шинжслэх Ухаан Технологийн Их Сургууль,
Монгол улс, Улаанбаатар хот, п/я 520, п/о 46*

Хөгжиж буй орнуудын эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах ашигт малтмалын нөөцийн үнэлгээг нэмэгдүүлэх шийдлийн боловсруулалт (Монгол улсын)

Өмнөтгөл

Байгалийн баялагт сууринсан эдийн засгтай орнуудад эрдэс баялгийн салбар нь ДНБ болон экспортын орлогын нилээд хувийг бүрдүүлж, улс орны тогтвортой хөгжил, нийгэм, хүрээлэн буй орчны салбарт томоохон нөлөөлөл үзүүлдэг. Монгол Улсын уул уурхайн салбарын нөөцийн ашиглалт, хөгжлийн үзүүлэлтэд хийсэн дүн шинжилгээний үр дүнгээр Монгол улсыг уул уурхайн салбараа түшиглэсэн, эрдэс баялгаас хамааралтай эдийн засгтай улс болохыг харуулж байна. Шууд болон шууд бус нөлөөлөл тус улсын эрдэс баялгийн салбарын эдийн засгийн ач холбогдол хоёр дахин нэмэгдэж байгааг харуулж байна. Баялагт төвлөрсөн эдийн засгийн тогтвортой хөгжлийн үзүүлэлтүүдийг системчилэн боловсруулж, улс орны тогтвортой хөгжлийн ололт амжилтыг цогцоор үнэлэх боломжийг эрэлхийлж, уул уурхайн салбарыг хөгжүүлэлтийн эдийн засгийн үр нөлөөний тогтвортой хөгжлийн макро эдийн засгийн үзүүлэлтүүдэд үзүүлэх нөлөөллийг харьцуулах шинжилгээг Монгол улсын жишээг ашиглан хийж байна. Уул уурхайн салбарын эрэг динамик өсөлт нь нарийн төвөгтэй тогтвортой хөгжлийн зарим үзүүлэлтүүд болох хүний хөгжлийн индекс, байгаль орчны гүйцэтгэлийн индекс зэргийг сайжруулдаг болох нь нотлогдсон.

Түлхүүр үгс: тогтвортой хөгжил, эрдэс баялгийн салбар, эрдэс баялагт суурилсан эдийн засаг, үржүүлэгч индикатор, макро эдийн засгийн үзүүлэлтүүд.

Tatiana V.Ponomarenko

Krystsina N. Kurakova

St-Petersburg Mining University, 2, Line 21, St Petersburg, 199106,

Punsalmaa Ochirbat

Mongolian State University of Sciences and technology,

Mongolia, Ulan-Bator, box 520, post-office 46

Assessment of the impact of the mineral sector on the sustainable development of resource-based countries (on the example of Mongolia)

Abstract

In resource-oriented economies, the mineral sector forms a significant share of GDP and export earnings, affecting the social and environmental spheres of sustainable development of the country. The analysis of the state and efficiency of the use of mineral resources and the analysis of indicators of the mining industry development in Mongolia shows that this is a country with a resource-oriented economy. It is shown that taking into account indirect and induced effects, the economic value of the mineral resource sector increases by 2 times. Indicators of sustainable development for a resource-oriented economy are systematized in this work, allowing a comprehensive assessment of the country's achievements in the field of SD. Also there is a correlation analysis of the impact of economic results of mining development on the macroeconomic indicators of SD on the example of Mongolia. It is proved that the positive dynamics of the mining industry leads to improvement of complex aggregate indicators of sustainable development, including the human development index and the environmental performance index.

Keywords: sustainable development, mineral resources sector, resource-oriented economy, multiplier, macroeconomic indicators.

Оршил

Эрдэс баялгийн нөөцийг түшиглэсэн эдийн засгтай орнуудын хөгжлийн онцлог, хөгжлийн боломжуудыг шинжлэх ухааны судалгаа, ном товхимолуудад хэдэн арван жилийн турш бичиж тэмдэглэсээр ирсэн. 1960-аад оноос байгалийн баялаг нь ашигт малтмалын нөөцөд суурилсан эдийн засгтай улс орны хурдацтай, үр дүнтэй өсөлтөд хувь нэмэр оруулдаг гэж үздэг байсан боловч, 1970-аад оноос хойш байгалийн баялгийг эдийн засгийн амжилттай хөгжлийн саад тогтор гэж үздэг "баялгийн хараал" гэсэн ойлголт бий болсон байна. [10, Sachs, Warner, 2001] 1980-аад оноос хойш үзэл баримтлалын түвшинд бий болсон тогтвортой хөгжлийн үзэл санаанд нийгмийн болон байгаль орчны нэмэлт хязгаарлалтууд бий болж, үүний үр дүнд эрдэс баялгийн нөөцийг түшиглэсэн эдийн засгийн өсөлтийн асуудал улам бүр хурцаар тавигдаж эхэлсэн. [8, Gylfason, 2004]

2005 онд НҮБ-ын судалгаагаар [7, Ахренд, 2005] байгалийн ашигт малтмалын олборлолт ашиглалтанд төрийн зохицуулалтын тодорхой дэглэм, механизмыг бий болгосноор улс

орны байгалийн баялгаас хамаарч үүсч болзошгүй бэрхшээлийг ухаалгаар даван туулах боломжтой болох нь нотлогдсон. Үүний бодит амьдрал дээрх жишээн дээр Австрали, Канад, Скандинавын орнуудыг дурдаж болно.

Орчин үеийн ард иргэдийн амьдралын эрэлт хэрэгцээн хангамж нь ирээдүй хойч үеийнхний эрэлт хэрэгцээг хангахад сөргөөр нөлөөлөхөөргүй байлгах тогтвортой хөгжлийн талаар нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн онол нь эрдэс баялагийг түшиглэсэн улс орнуудын хувьд нэмэлт тодотгол бүхий бодлогыг боловсруулахыг шаарддаг. Энэ нь ирээдүйд нөөц хомдох үед өнөөгийн хэрэгжүүлж буй бодлогын нөлөөг хамгийн үр өгөөжтэй байхаар тусгах ёстой. Гэсэн хэдий ч ашигт малтмалын үнэ цэнийг өсгөх үр дүнтэй стратеги нь өнөөгийн болон ирээдүйн макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн сайжруулалтыг хангах ёстой бөгөөд энэ нь яваандаа нөөцөд суурилсан эдийн засгаас инновацид суурилсан эдийн засагт шилжих шилжилтэд хүргэх хэтийн зорилготой.

Судалгааны зорилго нь нөөцийг түшиглэсэн улс орны уул уурхайн салбарын хөгжил ба эдийн засгийн өсөлт хоорондын уялдаа холбоог тодорхойлох, үнэлэх, мөн энэ үйл явцын тогтвортой хөгжлийн макро эдийн засгийн үзүүлэлтүүдэд үзүүлэх нөлөөллийг Монгол Улсын жишээг ашиглан тодорхойлоход оршино.


Үүний зэрэгцээ дараахь асуудлуудыг тусган авч үзсэн:

1. Монгол Улсыг нөөцийн чиг баримжаа бүхий орны жишигт нийцэж байгааг үндэслэлтэйгээр тодорхойлох;
2. Улс орны тогтвортой хөгжлийн макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд уул уурхайн салбарын нөлөөллийг үнэлэх арга зүйд дүгнэлт хийж тодорхойлох;
3. Тогтвортой хөгжлийн үзүүлэлтүүдийг үнэлэх, хамаарлыг тодорхойлох. Судалгааны арга: мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, системчлэх, статистик мэдээллийг нэгтгэх, хамаарлын шинжлэх.

Үндсэн үр дүн ба хэлэлцүүлэг

Нөөцт суурилсан эдийн засгтай улс орнуудад дараахь улсуудыг хамааруулна: ДНБ-ий 10-аас дээш хувь болон экспортын 40 хувийг байгалийн баялгаас бүрдүүлдэг байх. [7, Ahrend, 2005].

10 жилийн хугацааны үр дунгээс харахад уул уурхайн салбарын эдийн засагт эзлэх хувь 15-20%, экспортод байгалийн баялгийн эзлэх хувь 90%, төсвийн орлогод экспортын орлого 60%-иас ихийг бүрдүүлж, салбар дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт жилийн нийт гадаадын хөрөнгө оруулалтын 75% -ийг эзэлж байна.



Зураг. 1. Уул уурхайн салбараас ДНБ-ний эзлэх хувь нь Монгол Улсын нийт ДНБ-д эзлэх хувь

Одоогийн байдлаар Монгол улсад 34 төрлийн ашигт малтмалын нийт 1900 ордын нөөц тогтоогдсон байна. 2018 оны 12-р сарын 31-ний байдлаар улсын хэмжээнд 3,185 лиценз хүчин төгөлдөр байсан бөгөөд үүний 54% нь ашиглалтын лиценз, 46% нь хайгуулын лиценз байна. Хамгийн их олгогдсон ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг алтны (551 лиценз), нүүрсний болон барилгын материалын ордууд (314 тусгай зөвшөөрөл) эзэлж байна. Түүнчлэн Монгол улсын нөөцийн судалгаанаас харахад цөөнгүй ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг жоншны (181 лиценз) болон төмрийн (69 лиценз) ордууд дээр олгожээ. [3, Очирбат, 2017; 6, Энхтөр, 2017].

Монгол Улсын нийт ашигт малтмалын нөөцөд: 150 орчим тэрбум тонн нүүрс; ойролцоогоор 20 сая тонн флюорит; 3050 тонн алт; 2 тэрбум тонн зэс; 7.35 сая тонн цайр; ойролцоогоор 5 тэрбум баррель газрын тос гэх мэтчилэн нөөцүүд бүртгэгдсэн байна. [4, Самбуу-Yongdong, 2017]. Түүнчлэн Монгол Улс газрын ховор элементийн нөөцөөрөө дэлхийд тэргүүлэх байр суурийг эзэлдэг бөгөөд энэ нь эдийн засагт өндөр технологийн салбаруудыг байгуулах үндэс суурийг тавьж болох юм.


Монгол Улсын нөөцөд тулгуурласан чиг баримжаа нь тус улсын эдийн засагт болон тогтвортой хөгжлийн үзүүлэлтүүдэд уул уурхайн салбарын үзүүлэх нөлөөлөл ихээхэн байгааг илтгэж байна.

Судалгааны ном, нийтлэл, статистикийн мэдээллийн дүн шинжилгээний дүнгээс харахад [1, Заводов, 2017; 2, Ксенофонтов, 2018; 5, Широв, 2011] тогтвортой хөгжлийн эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчны үзүүлэлтүүдэд салбарын үзүүлэх нөлөөллийг үнэлэхэд янз бүрийн аргыг ашиглаж болно.

1. салбарын эдийн засгийн нөлөөллийг үнэлэхэд янз бүрийн хэлбэрийн хүчин зүйлсийг тодорхойлох, үржүүлэгч индикаторын үр нөлөөллийг тооцох;
2. тогтвортой эдийн засгийн үзүүлэлтүүдийг маクロ түвшинд үнэлэх.

Эхний аргачлал шууд болон шууд бус нөлөөллийг хамруулан ерөнхийлөн нэгтгэсэн байдлаар шинжилдгээрээ онцлогтой. Шууд эфект гэдэгт дараах үзүүлэлтүүд ордог: уул уурхайн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн гаргалт ба ажил эрхлэлт; нэмүү өртөг; цалин хөлс, хөрөнгө оруулалт; улсад төлөх татвар гэх мэт. Шууд бус нөлөө нь уул уурхайн салбарт бараа, ажил үйлчилгээ үзүүлдэг компаниудад бий болгосон нэмүү өртөг, түүнчлэн худалдан авагчдад үзүүлэх нөлөөлөл юм. Шууд болон шууд бус н үр дүнд урган гарч ирэх өөр нэг нөлөө нь өрхийн орлого нэмэгдсэнтэй холбоотой үсэх эдийн засгийн үйл ажиллагааны хувьсал өөрчлөлт юм.

Энэ аргачлалын гол онцлог нь олон талын үр нөлөөллийг үнэлэх явдал юм. Аргачлал нь мэдээлэл дээр суурилсан нарийн төвөгтэй, цаг хугацаа шаардсан үйл ажиллагаанд суурилдаг шинжилгээнд үндэслэн боловсруулагддаг. Жишээлбэл 2011 оны Оросын зарлага-бүтээгдэхүүн гаргалтын дүн шинжилгээнд зориулсан үндсэн хүснэгтүүдийг, 2017 онд Росстат нийтлүүлсэн. Үүний адил тооцоо гаргах оролдлого 2010-2014 онуудад Монгол Улсын жишээн дээр хийгдсэн байдаг.



Зураг 2. 2010-2014 онуудын Монгол Улсын орлогын уул уурхайн үйлдвэрлэлийн шууд, шууд бус нөлөөлөлтэй хамааруулан үзсэн өсөлт. Эх сурвалж: [12, ULAANBAATAR CITY GROUP]

Эндээс авсан шууд бус болон урган гарсан үр нөлөөний үр дүнгээс харахад уул уурхайн салбарын үүрэг роль ихээхэн нэмэгдэж, зарим жилийн үзүүлэлтээр Монгол Улсын орлогын бараг тал хувийг бүрдүүлсэн байна. Тиймээс бид энэ аргын өндөр үр ашиг, ач холбогдлын талаар хөрөнгө оруулалтын үед болон томоохон төслүүдийг авч хэлэлцэх тохиолдолд дурьдах боломжтой. Эдийн засгийн ийм үнэлгээ нь бүх үр нөлөөг нийгмийн болон хүрээлэн буй орчны аль алиныг нь хамруулан илүү нарийвчлан авч үзэх боломжтой болгож өгдөг.

